



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ

ШҮҮГЧИД САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, СУБЪЕКТ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

(ХАРЬЦУУЛСАН, ПРАКТИК СУДАЛГАА)

Улаанбаатар хот
2025 он

Хянасан: Б.Дөлгөөн, Шүүхийн академийн судалгааны төвийн дарга (Ph.D)
Боловсруулсан: Б.Дөлгөөн, Шүүхийн академийн судалгааны төвийн дарга (Ph.D)
Н.Хулан, Шүүхийн академийн Захиргааны эрх зүйн секторын
эрхлэгч (LL.M)
М.Ананд, Шүүхийн академийн судлаач
Р.Ануурад, Шүүхийн академийн судлаач
Л.Жавхлант, Шүүхийн академийн судлаач
С.Жансая, Шүүхийн академийн судлаач (LL.M)
О.Тэнхлүүн, Шүүхийн академийн судлаач (LL.M)
П.Чинунар, Шүүхийн академийн судлаач (LL.M)
Л.Энхсайхан, Шүүхийн академийн судлаач

Цаасны хэмжээ: 176×250

Хэвлэлийн хуудас: 15.1

© Шүүхийн академи, 2025.

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул энэхүү бүтээлийг зөвшөөрөлгүй хэвлэх,
нийтлэх, олшруулах, хуулбарлахыг хориглоно.

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	6
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	6
ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ.....	7
ӨМНӨХ ҮГ.....	9
ОРШИЛ	11

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГЫН ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО

15

1.1. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ТҮҮХЭН ХӨГЖИЛ.....	15
1.2. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БОЛОН "ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО"	21
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	24

ХОЁР. САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН МАГАДЛАЛ, ТОГТООЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....

25

2.1. САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ	25
2.1.1. ӨРГӨДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ.....	25
2.1.2. САХИЛГЫН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ	27
2.1.3. ГОМДОЛ ГАРГАГЧ, ИЛТГЭГЧ ГИШҮҮН, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ ХООРОНДОО НИЙЦЭЖ БҮЙ ЭСЭХЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	29
2.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	42
2.2.1. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	42
2.2.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТТАЙ ТӨСӨӨ БҮХИЙ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ УЛСЫН ЖИШЭЭ	46

2.3. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	58
2.3.1. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.1 ДЭХ ЗААЛТ	58
2.3.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.18 ДАХЬ ЗААЛТ	59
2.3.3. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.20 ДАХЬ ЗААЛТ	64
2.3.4. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.26 ДАХЬ ЗААЛТ.....	67
2.3.5. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.27 ДАХЬ ЗААЛТ.....	69
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	71
ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	78
3.1. ШҮҮХЭЭС САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛАХ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД.....	78
3.1.1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС	78
3.1.2. ДАНИЙН ХААНТ УЛС	87
3.2. МЭРГЭШСЭН БАЙГУУЛЛАГААС САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛАХ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД	92
3.2.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС.....	92
3.2.2. БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС.....	103
3.2.3. ИСПАНИЙН ХААНТ УЛС	114
3.2.4. БҮГД НАЙРАМДАХ МОЛДАВ УЛС	121
3.2.5. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС	128
3.2.6. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС.....	133
3.2.7. ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС	141
3.3. ХОЛИМОГ ТОГТОЛЦООТОЙ УЛС.....	153
3.3.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	153
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	169
НОМ ЗҮЙ.....	172

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
Дани Улс	Данийн Хаант Улс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
Испани Улс	Испанийн Хаант Улс
Итали Улс	Бүгд Найрамдах Итали Улс
Комисс	Шүүгчийн ёс зүйн комисс
Латви Улс	Бүгд Найрамдах Латви Улс
Молдав Улс	Бүгд Найрамдах Молдав Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
Сахилгын танхим	Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын танхим
Тусгай шүүх	Сахилгын давж заалдах тусгай шүүх
УДШ	Улсын дээд шүүх
Франц Улс	Бүгд Найрамдах Франц Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ШСХтХ	Шүүхийн сахилга, хариуцлагын тухай хууль
Шүүхийн академи	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи
Шүүхийн зөвлөл	Холбооны тойргийн шүүхийн зөвлөл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Шүүгчийн сахилгын зөрчлийн ангилал	49
Хүснэгт №2	Сахилгын давж заалдах тусгай шүүхийн статистик	91
Хүснэгт №3	2006 оны №109 дугаартай хуулийн 2 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил	108
Хүснэгт №4	2006 оны №109 дугаартай хуулийн Хоёрдугаар бүлгийн 3 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил	108
Хүснэгт №5	2006 оны №109 дугаартай хуулийн Гуравдугаар бүлгийн 4 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил	109
Хүснэгт №6	Испани улсын Шүүхийн тухай хуулийн 417,418 болон 419 дүгээр зүйл	117
Хүснэгт №7	2014 оны Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуульд заасан сахилгын зөрчил	125
Хүснэгт №8	Холбооны болон муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцооны ялгаа	160
Хүснэгт №9	Америкийн хуульчдын холбооны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэмд заасан зарим сахилгын зөрчил	162
Хүснэгт №10	Шүүгчийн ёс зүй, зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх журамд заасан зарим зөрчил	163

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График №1	ШСХ-ны шийдвэрлэсэн өргөдөл, мэдээллийн тоо, шийдвэрлэсэн байдал	25
График №2	Магадлалд гомдол гаргасан байдал	26
График №3	ШСХ-ны тогтоолд гомдолд гаргасан байдал	26
График №4	ШСХ-ны шийдвэрлэсэн магадлал, илтгэгч гишүүний санал	28
График №5	ШСХ-ны шийдвэрлэсэн тогтоол	28
График №6	УДШ-ийн шийдвэрлэсэн тогтоол	29
График №7	Өргөдөл, гомдол гаргагч, илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн МУШТХ-ийг эшилсэн байдал	30
График №8	Өргөдөл, гомдол гаргагчийн хууль зүйн үндэслэл	31
График №9	Илтгэгч гишүүний хууль зүйн үндэслэл	32
График №10	Бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл	33
График №11	Өргөдөл гаргагч болон илтгэгч гишүүний хууль зүйн үндэслэл	34
График №12	Илтгэгч гишүүний болон бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл	38

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ №1	Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдсан МУШТХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшилсэн жишээ	35
Шигтгээ №2	Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдсан МУШТХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшлээгүй жишээ	36
Шигтгээ №3	Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдаагүй МУШТХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшилсэн жишээ.....	37
Шигтгээ №4	Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдсан МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшилсэн жишээ	38
Шигтгээ №5	Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдсан МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшлээгүй жишээ.....	40
Шигтгээ №6	Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдаагүй МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшилсэн жишээ.....	41
Шигтгээ №7	МУШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн ХЗБХ-ны хуралдааны тэмдэглэл	43
Шигтгээ №8	Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 27/9 дугаар шийдвэр.....	47
Шигтгээ №9	Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 13/4 дүгээр шийдвэр.....	48
Шигтгээ №10	Испани Улсын Сахилгын хорооны 2020 оны 9-р сарын 29-ний өдрийн шийдвэр.....	52
Шигтгээ №11	Испани Улсын Сахилгын хорооны 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн шийдвэр	52
Шигтгээ №12	ХБНГУ-ын Холбооны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 4 StR 149/22 дугаартай шийдвэр	54
Шигтгээ №13	Нью-Йорк мужийн Шүүхийн ёс зүйн комиссын Saratoga County-ийн Гэр бүлийн шүүхийн шүүгч GILBERT L. ABRAMSON-д холбогдох шийдвэр	56
Шигтгээ №14	Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7-р сарын 15 өдрийн C-791/19 дугаартай шийдвэр	57
Шигтгээ №15	ХБНГУ-ын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	86
Шигтгээ №16	Дани Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	91
Шигтгээ №17	ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль	94
Шигтгээ №18	ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль	97
Шигтгээ №19	ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль	101

Шигтгээ №20	ОХУ-ын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	102
Шигтгээ №21	Силвио Роберто Винсетийн "Шүүхийн сахилгын зөрчил дэх стандартчилал, бүрэн эрх: Итали, Ирланд улсуудын туршлага" өгүүлэл	104
Шигтгээ №22	Симон Бэнбэнутийн "Итали дахь шүүгчийн хариуцлагын тогтолцооны улс төржилт: Тэнцвэрийг шилжүүлэх нь" өгүүлэл	105
Шигтгээ №23	Шүүхийн суурь хууль (Act (regio decreto legislativo) Nr. 511, 31 May 1946)	107
Шигтгээ №24	Итали Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	111
Шигтгээ №25	Испани Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	120
Шигтгээ №26	Молдав Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	128
Шигтгээ №27	Латви Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	133
Шигтгээ №28	Франц Улсын Үндсэн хууль, VIII гарчиг	134
Шигтгээ №29	Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль	137
Шигтгээ №30	Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль, 45-р зүйл.....	138
Шигтгээ №31	Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль	139
Шигтгээ №32	Франц Улсын шүүгчид хариуцлага оногдуулсан тохиолдол	140
Шигтгээ №33	ИБУИНХУ-ын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн шүүгчийн сахилгын шийтгэлтэй холбоотой зарим заалт	143
Шигтгээ №34	ЈСЮ-д гомдол гаргах болон гаргаж болохгүй асуудлын жагсаалт	146
Шигтгээ №35	Сахилгын шийтгэлийн ноцтой байдлын түвшин.....	147
Шигтгээ №36	ЈСЮ-ийн албан ёсны зөвлөгөө өгсөн шийтгэлийн жишээ	150
Шигтгээ №37	ЈСЮ-ийн албан ёсны сануулга өгсөн шийтгэлийн жишээ	151
Шигтгээ №38	Анхааруулга өгсөн шийтгэлийн жишээ	152
Шигтгээ №39	Огцруулсан шийтгэлийн жишээ	153
Шигтгээ №40	АНУ-ын холбооны шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	167
Шигтгээ №41	АНУ-ын муж улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол.....	168

ӨМНӨХ ҮГ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь Шүүхийн тухай хуульд заасны дагуу шүүн таслах ажиллагааг судалгаа мэдээллээр хангах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход шаардагдах судалгаа хийж олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Шүүхийн академи нь байгуулагдсан цагаасаа эхлэн шүүх, шүүгчийн захиалгаар нийт 213 судалгаа хийж, үүнээс гадна эрх зүйн ач холбогдол бүхий сэдвээр бие даан судалгаа хийдэг. Энэ удаагийн судалгаа нь бидний бие даан хийсэн 25 дахь судалгаа бөгөөд тус академийн Захиргааны эрх зүйн секторын судлаачид хамтран Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны нийт 559 шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах үндэслэл, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг нийт 10 орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судаллаа.

Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт дүн шинжилгээ хийх судалгааг анх 2022 онд Шүүхийн сургалтын хөтөлбөрийн хорооны захиалгаар Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хийсэн бөгөөд тухайн үед ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан 133 магадлалд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулж байсан билээ.

Шүүхийн сахилгын хороог Үндсэн хуулийн байгууллага байхаар анх удаа Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөд хуульчилж, эрх зүйн байдлыг МУШТХ-д дэлгэрэнгүй зохицуулж, улмаар тус хууль 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжсэнээс хойш төдийлөн урт хугацаа өнгөрөөгүй байна. Тиймээс Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт дүн шинжилгээ хийсэн, энэ чиглэлээр гүйцэтгэсэн судалгаа, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл төдийлөн байхгүй тул тус академийн судалгааны багийн гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь ШСХ-ны шийдвэрийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, цаашид мөн асуудлаар гүнзгийрүүлэн тогтмол судалгаа хийх, шүүгчийн сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам эрэлхийлэхэд дөхөм болно гэдэгт итгэлтэй байна.

ШСХ-ны судалгааг төлөвлөж удирдсан тус академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн, боловсруулсан судлаач Н.Хулан,

О.Тэнхлүүн, С.Жансая, Р.Ануурад, М.Ананд, П.Чинунар, Л.Энхсайхан, Л.Жавхлант нартаа талархал илэрхийлье. Энэхүү судалгаа нь эдгээр судлаач нарын оюуны хөдөлмөрийн үр дүн гэдгийг онцолмоор байна.

Судалгааны үр дүнг цахим болон хэвлэмэл хэлбэрээр эмхэтгэн хүргэж байгаа нь шүүгч, хуульч, судлаач та бүхний өдөр тутмын ажлын хэрэглээнд ойртуулж, судалгааны эх сурвалжийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд Шүүхийн тухай хуулийг нэгдмэл байдлаар ойлгож, хэрэглэхэд болон шүүхийн практик судлал хөгжихөд чухал хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИЙН ЗАХИРАЛ
ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР, Д.ЭРДЭНЭЧИМЭГ

ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Дөчин есдүгээр зүйлийн 1-т "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэж, тус зүйлийн 2-т "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй." гэж заасныг бэхжүүлж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах тогтолцоог Монгол Улсын шүүхийн тухай хуулиар бүрдүүлсэн. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн явуулж, маргааныг шударгаар шийдвэрлэдэгт итгэх олон нийтийн үнэлэмж нь шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахад чухал нөлөө үзүүлдэг. Тогтолцооны энэ зохист тэнцлийг хангахын тулд "шүүгч" нь гагцхүү эрх зүйт төрийн зарчмыг агуулсан хуульд захирагдаж, шударга байж, хараат бусаар шийдвэр гаргах мэргэшлийн ур чадвараас гадна "мэргэжлийн ёс зүй"-г чанд баримталж, шүүх эрх мэдэлд төдийгүй олон нийтэд үлгэр дуурайлал болохуйцаар зан суртахуун, үйлээ удирддаг байх шаардлагатай. Энэ ч утгаараа дэлхийн улс орнууд шүүгчид хориглох үйлдэл, хязгаарлалтуудыг тухайлан хуульчилдаг байна. Гэхдээ шүүгчид хариуцлага оногдуулах босго нь сул, хариуцлага оногдуулах байгууллага нь аливаа институтын нөлөөн дор, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тодорхой бус байвал шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ айдаст автаж, шүүгчийн хараат бус байдал алдагдах эрсдэлтэй. Тийм ч учраас шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл нь тодорхой, хэт сул биш байх, хариуцлага оногдуулах субъектэд тавигдах шаардлага нь өндөр байх шаардлагатай.

Монгол Улсад 1993², 2002³, 2012⁴ онд батлагдсан Шүүхийн тухай хуулиудад шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагууд үйл ажиллагаа явуулж ирсэн. Тодруулбал 1993-2002 оны хооронд Шүүгчийн сахилгын хороод Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэд тус тус байгуулагдаж

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992) №01.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (1993) №02.

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002) №19.

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2012) №11.

ажиллаж байсан⁵ бол 2002–2013 онд Шүүхийн сахилгын хороо нь Улсын хэмжээнд нэг байгууллага болон өөрчлөгдсөн.⁶ Харин 2013-2019 оны хооронд Шүүгчийн ёс зүйн хороо гэх нэртэй байгууллага болон ажиллаж байжээ. Эдгээр байгууллагууд нь бүтэц, бүрэлдэхүүн, сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл, хянан шийдвэрлэх ажиллагаа зэргээсээ хамаараад ялгаатайгаар хөгжиж ирсэн. Гэвч түүхэн үйл явц дахь эдгээр тогтолцоо нь шүүгчийн хараат бус байдлыг хангах тогтолцоо болж чадаж байгаа нь эргэлзээтэй байв. Үүнээс улбаалан шүүгчид сахилгын хариуцлага оноох тогтолцоог Үндсэн хуулийн эрх зүйн түвшинд авч үзэх шаардлага үүссэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт *"Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно"* гэж нэмсэн. Ийнхүү Шүүхийн сахилгын хороо (цаашид "ШСХ" гэх)-г бие даасан Үндсэн хуулийн байгууллага болгон хуульчилсантай уялдуулан Монгол Улсын шүүхийн тухай хууль (цаашид "МУШТХ" гэх)⁷-ийн 95–116 дугаар зүйлд эрх зүйн байдлыг нь дэлгэрүүлэн хуульчилсан. Мөн тус хуульд шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах 40 үйлдлийг хуульчилж, тус хориглох үйлдэлд оногдуулах хариуцлагын төрлүүд, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар дэлгэрэнгүй зохицуулсан юм.

ШСХ-ны анхны магадлал гарсан 2022 оны 01 сарын 10-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх байдлаар ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан нийт **559** магадлал, **39** тогтоол⁸, мөн УДШ-ийн цахим хуудаст нээлттэй байршуулсан УДШ-ээс хяналтын журмаар хянасан **11** хэргийн тогтоол⁹ байна. ШСХ-ны тайлан мэдээллээс харахад, тус хороонд гаргаж буй гомдол, өргөдлийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Шүүгчид холбогдох сахилгын хэргийн тоо их байх нь шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, зан хандлагын талаар нийгэмд эргэлзээ төрүүлэх боломжтой. Нөгөөтээгүүр, шүүгчид холбогдох сахилгын хэрэг үүсгэх ажиллагааны босго бага

⁵ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, 2019, 123 дахь тал.

⁶ Мөн тэнд. 126 дахь тал.

⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021) №05.

⁸ Шүүхийн сахилгын хорооны цахим хуудас, <https://judiscom.mn/>.

⁹ Улсын дээд шүүхийн цахим хуудас, <https://www.supremecourt.mn/mn/>.

байх нь иргэн, шүүхээр үйлчлүүлэгч, хэргийн оролцогчийн хувьд шүүгчийн үйл ажиллагаанд аливаа байдлаар нөлөөлөх, сүрдүүлэх, залхаах арга хэрэгсэл болгон ашиглах эрсдэлтэй.

Энэхүү бүтээлээр хоёр асуудлыг судлан, хариулт өгөхийг зорилоо. Нэгдүгээрт, МУШТХ батлагдаж ШСХ үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших сахилгын хэргийн шийдвэрлэлтэд холбогдуулж дараах асуудлыг тодруулах:

- Сахилгын хэрэгт холбогдох статистик мэдээллүүдийг гаргах;
- Гомдол гаргагч, илтгэгч гишүүн болон гомдлыг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл хоорондоо нийцэж буй эсэхийг судлах;
- МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь хэсгийн үзэл баримтлал, ижил төсөөтэй хуулийн зохицуулалттай улсуудын жишгийг харьцуулан судлах;
- МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн бусад заалтад дүн шинжилгээ хийх.

Хоёрдугаарт, хууль дээдлэх ёсны индексээр тэргүүлж буй эх газар, жишгийн эрх зүйн бүлийн улсууд болон пост социалист улсын төлөөлөл нийт 10 улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл, субъект, хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохицуулалт, практикийг харьцуулан судална.

НЭГ | МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГЫН ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО

Монгол Улсын Их Хурлаас баталсан 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно" хэмээн хуульчилснаар шүүгчийн ёс зүй, сахилгын хариуцлагыг шийдвэрлэх эрх бүхий бие даасан Үндсэн хуулийн байгууллага болох "Шүүхийн сахилгын хороо (цаашид "ШСХ" гэх)" байгуулагдсан.

Дээрх нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 01 сарын 15-ны өдөр батлан, уг хуулийн Арван тавдугаар бүлэгт Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдал, тодруулбал шүүгчийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг, ШСХ-ны бүрэлдэхүүний бүтэц, орон тоо, гишүүдэд тавигдах шаардлага,¹⁰ бүрэн эрх,¹¹ үүрэг, хариуцлагын¹² талаар нарийвчлан хуульчилсан.

Монгол Улсын хувьд шүүгчийн ёс зүй, сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоо нь тухайн үеийн төрийн тогтолцоо, эрх зүйн хөгжлөөс хамаарч өөрчлөгдсөөр ирсэн. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ШСХ нь Үндсэн хуулийн байгууллага болон байгуулагдсан нь Монгол Улсын хувьд анх удаа шүүхээс гадуур шүүгчийн сахилгын хариуцлагын асуудлыг шийдвэрлэх эрх бүхий, бие даасан байгууллагын загварыг сонгосон явдал болсон юм.¹³

¹⁰ Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021)-ийн 95 дугаар зүйл.

¹¹ МУШтХ (2021)-ийн 97 дугаар зүйл.

¹² МУШтХ (2021)-ийн 98 дугаар зүйл.

¹³ Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, "Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдал (харьцуулалт)", *legaldata.mn*, 2020, 1 дэх тал.

1.1. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ТҮҮХЭН ХӨГЖИЛ

1954 оны Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм: "Шүүгчдийн сахилга батын хэргийн коллеги"

Монгол Улсад шүүгчийн ёс зүй, сахилгын асуудлыг хянан шийдвэрлэх эрх бүхий субъект анхлан байгуулагдсан түүхээс харвал Бүгд Найрамдах Монгол Ард Улс (цаашид "БНМАУ" гэх)-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм"-ийг батлах тухай 95 дугаар зарлигийн хавсралтаар Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрмийг баталснаар¹⁴ БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэд сахилга батын хэргийн коллегийг байгуулсан. Сахилга батын хариуцлагад татах зөрчилд:

- Хөдөлмөрийн сахилга батыг гажуудуулсан,
- Шүүхийн ардчилсан зарчмыг зөрчсөн, удирдлагын тушаал, даалгаврыг шуурхай биелүүлээгүй буюу шүүгчийн нямбай биш ажиллагаа хийгээд сахилга батгүй явдлын улмаас шүүх таслах ажилд гарсан дутагдал,
- Шүүгчийн алдар хүндэд зохимжгүй явдлуудыг үйлдсэн нь хамаарч байв.

Дээрх зөрчлийг гаргасан тохиолдолд дараах хариуцлагыг оногдуулахаар заажээ:

- Сануулах;
- Донгодох;
- Хатуу донгодох;
- Огцруулах асуудлыг тавих¹⁵

1970 оны БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэм: "Шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллеги"

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар зарлигийн хавсралтаар "БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэм"-ийг баталсан.¹⁶ Үүний дагуу БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн

¹⁴ Дам эшлэв: Ерөнхий редактор Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 4 дүгээр боть, 2010, 472 дахь тал.

¹⁵ Баясахын Сугар, "Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны түүхэн хөгжил", Монголын төр, эрх зүй сэтгүүл 2024№1 (107), 53 дахь тал.

¹⁶ Дам эшлэв: Ерөнхий редактор Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 5 дүгээр боть, 2010, 583 дахь тал.

1970 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн "Шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллеги байгуулах тухай" 72 дугаар зарлигаар БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх Шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийг 4 жилийн хугацаагаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.¹⁷

БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэмд сахилгын хэргийг албан тушаалтан болон иргэний гомдол, мэдээллийн дагуу үүсгэх талаар тусгайлан заагаагүй байна. Харин тус дүрмийн 6-д "БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид Улсын Дээд шүүхийн гишүүд, аймаг, хот, тусгай шүүхийн дарга, орлогч дарга нарт холбогдох сахилга батын хариуцлагын талаар үүсгэсэн хэргийг хэлэлцэнэ. Аймаг, хотын шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид нүүдлийн шүүгчид, хот /аймгийн харьяа/ районы шүүхийн дарга, шүүгчид, аймаг, хотын шүүхийн гишүүдийн талаар үүсгэсэн сахилга батын хэргийг хэлэлцэнэ" гэж заасан. Энэ нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоосон онцлогтой байжээ.¹⁸

Мөн дүрмийн 18 дугаар зүйлд "Аймаг, хотын шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийн тогтоол гарсан өдрөөс эхлэн арга хэмжээ авагдсан этгээд өөрийн гомдлыг 7 хоногийн дотор уг коллегior дамжуулан БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид гаргаж болно. Уг гомдлыг хэргийн хамт 3 хоногийн дотор БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид явуулна. БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегior эцсийн шийдвэр гаргах тул түүнийг давж заалдах эрхгүй" гэж заасан байна. Энэ нь сахилгын хэргийг Дээд шүүхийн дэргэдэх сахилга батын хэргийн коллеги эцэслэн шийдвэрлэж байсныг харуулж байна.¹⁹

1993 оны Монгол Улсын Шүүхийн тухай хууль: "Шүүгчийн сахилгын хороо"

1990 он гарч төр, нийгмийн байдал шинэчлэгдэн 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдаж, шинэ үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийн системчлэл хийгдэж эхэлсэн. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана" гэж зааснаар

¹⁷ Баясахын Сугар, "Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны түүхэн хөгжил", *Монголын төр, эрх зүй сэтгүүл* 2024№1 (107), 55 дахь тал.

¹⁸ Мөн тэнд, 56 дахь тал.

¹⁹ Мөн тэнд, 56 дахь тал.

шүүхийн тогтолцоонд шүүгчийн ёс зүйн асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага ажиллахаар болсон юм. Ийнхүү Улсын Их Хурлаас 1993 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг баталж, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэх болов.

1993 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Шүүгчийн сахилгын хорооны талаар хуульчилж, уг хорооны дүрмийг Шүүхийн ерөнхий зөвлөл батлахаар зохицуулсан байдаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1993 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор "Шүүгчдийн сахилгын хорооны дүрэм"-ийг баталж, 1993 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Шүүгчийн сахилгын хороог байгуулсан. Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Шүүгчийн сахилгын хороог байгуулж, дүрмийг батлах, сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох, сахилгын хорооны шийдвэрийг хянах, сахилгын шийтгэл ногдуулах эрх хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн холбогдох заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон байдаг.²⁰

Улмаар хуульд өөрчлөлт оруулж сахилгын зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэх Шүүгчийн сахилгын хороо Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэд тус тус ажиллахаар, харин Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг Ерөнхийлөгч батлахаар болсон. Гэвч тухайн үеийн зохицуулалт нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх харьяаллыг нарийвчлан тогтоосон шинжтэй боловч энэ нь шүүхэд босоо тогтолцоо, удирдлагын шинжийг хадгалсан гэх шүүмжлэлийг дагуулж байсан байна.²¹

2002 оны Шүүхийн тухай хууль: "Шүүхийн сахилгын хороо"

2002 оны Шүүхийн тухай хуулиар шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарчмын шинжтэй өөрчлөлт орсон. Шүүгчийн ёс зүйн дүрмийг Шүүхийн ерөнхий зөвлөл биш Шүүгчдийн зөвлөл баталдаг болсон. 2003 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Шүүгчдийн зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан ба Шүүгчийн сахилгын хороог Шүүхийн сахилгын хороо гэж нэрлэсэн.²²

²⁰ Мөн тэнд, 58 дахь тал.

²¹ Мөн тэнд, 59–60 дахь тал.

²² Одонхүүгийн Мөнхсайхан, "Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан

2002 оны Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.4 дахь хэсэгт зааснаар Шүүхийн сахилгын хорооны гишүүнд Улсын ерөнхий прокурор, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс тус бүр 2, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн хуралдаанаас 5, Шүүгчдийн зөвлөл бүх шатны шүүхээс тус бүр 2 хүний нэрийг дэвшүүлж Ерөнхийлөгч батлахаар заасан. Шүүхийн сахилгын хорооны нийт 15 гишүүдийн олонх буюу 9 (60 хувь) нь шүүхээс бусад байгууллагаас нэр дэвшиж Ерөнхийлөгчөөр томилогдох болсон нь ач холбогдолтой шинэчлэл болсон²³ гэж судлаачид дүгнэдэг.

2012 оны Шүүхийн захиргааны тухай хууль: "Шүүхийн ёс зүйн хороо"

2002 оны Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд "Шүүхийн сахилгын хороо"-г улсын хэмжээнд нэг байхаар ахин тусгаж байсан ч Шүүхийн тухай багц хуулийг²⁴ 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зохион байгуулалтын чиглэлийг заасан. Ингэснээр Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлд Шүүхийн ёс зүйн хорооны талаар зохицуулж, тус хороо нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх болсон.

2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ёс зүйн хороо нь нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гурван шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр 1, Хуульчдын холбооноос 3, Хууль зүйн яамнаас 3 хүний нэр дэвшүүлнэ. Бүрэлдэхүүнд нь шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн захиргааны ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглосон. Үүний үр дүнд шүүгчийн ёс зүйн асуудлыг харьцангуй хөндлөнгийн шинжтэй бүрэлдэхүүн хянан шийдвэрлэх 2002 оны өмнөх тогтолцоог хэвээр хадгалсан.²⁵

шийдвэрлэх ажиллагаа: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам", *legaldata.mn*, 2016, 19 дэх тал.

²³ Мөн тэнд.

²⁴ Шинээр мөрдөгдсөн шүүхийн багц хууль дотор Монгол Улсын шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Хуульчийн эрх зүйн байдлыг тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиуд багтсан.

²⁵ Одонхүүгийн Мөнхсайхан, "Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам", *legaldata.mn*, 2016, 22 дахь тал.

2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 2012 оны Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн Шүүгчийн ёс зүйн дүрэм (цаашид "ШЁЗД")-ийг баталсан боловч ШЁЗД-д зарчмын болон зан үйлийн түвшинд бичигдсэн, олон чухал заалтууд нь ерөнхий утгатай байсан талаарх шүүмжлэлийг дагуулдаг байв. Тухайлбал, ШЁЗД-ийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *"Шүүгч энэхүү дүрмийг зөрчсөн бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээнэ"* гэж тун ерөнхий хуульчилсан бөгөөд шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, татгалзлыг шийдвэрлэх, хичээл зүтгэл гаргах, мэргэжлийн үүргээ чухалчлах, мэргэжлийн шаардлага хангасан байх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, хэлэлцүүлэх эрхийг хангах, хэрэг, маргааныг заавал шийдвэрлэх, биеэ зөв авч явах үүргүүд зэрэг маш олон чухал асуудлыг ШЁЗД огт тусгаагүй.²⁶

ШЁЗД-д шүүгчийн ёс зүйн олон улсын стандартад төдийлөн нийцэхгүй заалтууд орсон гэж судлаачид шүүмжилдэг. Жишээлбэл, шүүгчийн ёс зүйн материаллаг харилцааг зохицуулсан дүрэмд шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх хөөн хэлэлцэх хугацааг тусгадаггүй. Гэтэл хуульд байхгүй хөөн хэлэлцэх хугацааг ШЁЗД-ээр тогтоосон бөгөөд ингэхдээ 6 сар гэсэн хэт богино хугацаа тавьсан нь маргаантай.²⁷

ШЁЗД-д хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг зөрчсөн шинжтэй заалтууд мөн туссан талаар дурдагдаж байв. Жишээлбэл, шүүгч маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг хатуу хориглодог нь хууль дээдлэх ёс төлөвшсөн олон улсад тогтсон зарчим. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-дэх хэсэгт *"хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"*-ыг шууд хориглосон. Гэтэл, ШЁЗД-ийн 3.2-р зүйлийн 4-т *"Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана"* гэж зааж хуучин зохицуулалтаа сэргээсэн нь хуулийн дээрх заалттай зөрчилддөг²⁸ гэх зэрэг асуудлууд байв.

²⁶ Одонхүүгийн Мөнхсайхан, "Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал", *legaldata.mn*, 2020, 107 дахь тал.

²⁷ Мөн тэнд, 108 дахь тал.

²⁸ Мөн тэнд, 109 дэх тал.

1.2. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БОЛОН "ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО"

2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд орсон шүүх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад, сахилгын хэрэгүүсгэн шийдвэрлэж байгаа практик хангалттай боловсронгуй бус байгааг анхаарч Шүүхийн ёс зүйн хорооны үйл ажиллагааг үр нөлөөтэй, бодитой хэрэгждэг болгох шаардлагатай²⁹ гэж үзсэн байдаг. Тухайн үед практикт ёс зүйн зөрчлийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн ёс зүйн хороо болон Монголын хуульчдын холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хороонд хандан шийдвэрлүүлэх боломжтой байсан нь маргаан хянан шийдвэрлэх давхардлыг үүсгэж байв. Иймээс уг давхардлыг арилгаж, бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороогоор шийдвэрлэж байхаар тусгасан³⁰ гэжээ.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2020 онд баталсан 02 дугаар тогтоолоор "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь"-ийг баталсан бөгөөд түүний 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт:

"3.2. Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

3.2.1. хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороог байгуулах, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтоох;

3.2.2. Шүүхийн сахилгын хороо нь хөндлөнгийн нөлөөллөөс ангид байж, төвийг сахиж хараат бусаар шийдвэр гаргаж, шүүгчийг сахилгын шийтгэлийн журмаар албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, сахилгын бусад шийтгэл ногдуулах замаар шүүгчийн ёс зүй, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.2.3. Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институтээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг

²⁹ *Дам эшлэв:* Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

³⁰ *Ганхуягийн Цэрэндэжид, "Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэлдэхүүн ба шүүгчийн хараат бус байдал", legaldata.mn, 2021, 3 дахь тал.*

хуульчлах" гэжээ.

Тодруулбал, хууль тогтоогчийн зүгээс шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагын эрх зүйн орчныг шинээр хуульчлан тогтоохдоо дээр дурдсан үзэл баримтлалыг хатуу баримтлах учиртайг зааж өгчээ.³¹

Ийнхүү 1993 оноос хойш Шүүгчийн сахилгын хороо, Шүүхийн ёс зүйн хороо гэсэн нэрээр ажиллаж, хорооны ажлын алба, төсөв нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд байжирсан ч 2021 оны Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-аар бие даасан байгууллага болсон юм. Мөн энэ талаар "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ байгууллагыг Үндсэн хуулийн түвшинд бие даан байгуулсан тул цаашид Шүүхийн сахилгын хороо бие даасан төсөвтэй болж, ажлын алба нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тусдаа байна. Шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх, шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой нотлох баримт цуглуулах гэх мэт бүх ажлаа бие даан, үр нөлөөтэйгөөр, хараат бусаар хэрэгжүүлдэг боллоо"³² гэжээ.

Шүүхийн сахилгын хороо орон тооны 9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд шүүгч гишүүд болон шүүгч бус гишүүд орох юм. Шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн 5 жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээн байгаагүй Монгол Улсын иргэн байна.³³ Үүний дагуу ШСХ-ны шүүгч гишүүдийг 2021 оны "Нийт шүүгчдийн чуулган"-аар сонгож тус оны 10 дугаар сарын 11-ний өдөр, шүүгч бус гишүүдийг УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 92 дугаар тогтоолоор томилсноор ШСХ-ны бүрэлдэхүүн бүрдэж, бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн байдаг³⁴.

Шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Шүүхийн сахилгын хороонд хүн, албан тушаалтан, хуулийн этгээдээс өргөдөл, мэдээлэл гарган илтгэгч гишүүнд хуваарилж,

³¹ Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, "Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдал (харьцуулалт)", *legaldata.mn*, 2020, 2 дахь тал.

³² "Шүүгчдийг илүү хариуцлагажуулсан Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэллээ", 2021, <https://gogo.mn/r/g601w?fbclid=IwAR1M-IJrFvcoXeeCjmbwtdduOInTo8h0cTuLkKLpr5Ekp-KyPQubyzgMkv8>, (Сүүлд үзсэн: 2025.08.15).

³³ МУШтХ (2021)-ийн 95 дугаар зүйлийн 95.3.

³⁴ Шүүхийн сахилгын хороо, "Үйл ажиллагааны тайлан", 2022 он, 5-6 дахь тал, https://judiscom.mn/site/status_page/11.

тэрээр сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж гаргаснаар эхэлнэ.³⁵ Хуульд заасан бусад шаардлагатай ажиллагааг хийж гүйцэтгэсний дараа Сахилгын хорооны хуралдааныг хуралдуулах ба хуралдааны бүрэлдэхүүний хоёр нь шүүгч бус гишүүн, нэг нь шүүгч гишүүн байх бөгөөд илтгэгч гишүүн орохыг хориглодог байна.³⁶ Сахилгын хорооны хуралдаанаас шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэж магадлал, тогтоол гаргах ба магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч гомдол, илтгэгч гишүүн эсэргүүцэл Сахилгын хороонд гаргах эрхтэй.³⁷ Улмаар гомдол, эсэргүүцлийн дагуу Сахилгын хорооны хянан үзэх хуралдааныг хуралдуулж хяналтын тогтоол гаргана. Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болдог байна.³⁸

Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд судлаачдын өгсөн саналаас дурдвал "Шүүгчийн ёс зүйн зөрчил нь шүүгчийн сахилгын зөрчлөөс өргөн хүрээтэй. Өөрөөр хэлбэл, шүүгчийн ёс зүйн зөрчил бүхэн сахилгын зөрчил биш харин сахилгын зөрчил бүхэн шүүгчийн ёс зүйн зөрчил болдог. Иймд, МУШТХ-ийн төсөл дэх "ёс зүйн зөрчил" гэдэг нэр томъёог "сахилгын зөрчил" гэж өөрчлөх нь зүйтэй"³⁹ "хэтэрхий бүрхэг агуулгатай ерөнхий тодорхойлолт өгөхөөс илүү сахилгын тодорхой зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах нь олон улсын стандартад нийцсэн сайн туршлага юм" гэжээ.

Ийнхүү шүүгчид хориглосон хэм хэмжээ, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын тухайд Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 50 дугаар зүйлд 40 үйлдлийг сахилгын зөрчилд хамааруулахаар хуульчилсан байна. Эдгээр зөрчлийг сахилгын зөрчлийн шинж чанар, хэр хэмжээ, зөрчлийн хүнд, хөнгөн, үр дагавар, шүүгчийн хувийн зан байдал болон бусад нөхцөл байдлын хувьд ялгаж хуульчилжээ. Тухайлбал МУШТХ-ийн 50.1.5, 50.1.21, 50.1.34-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах шийтгэл, 50.1.3, 50.1.4-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, 50.1.1, 50.1.2-д заасан зөрчилд огцруулах шийтгэл оноосон нь тун онцлогтой байна.

³⁵ МУШТХ (2021)-ийн 104 дүгээр зүйл.

³⁶ МУШТХ (2021)-ийн 111 дүгээр зүйлийн 111.2.

³⁷ МУШТХ (2021)-ийн 112 дугаар зүйлийн 112.8.

³⁸ МУШТХ (2021)-ийн 114 дүгээр зүйлийн 114.1.

³⁹ Мөн тэнд, 112 дахь тал.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1990 оноос өмнөх социалист тогтолцооны үед шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх байгууллага нь Дээд шүүхийн дэргэдэх сахилгабатын хэрэг эрхлэх коллеги байж, уг байгууллагань удирдлагын болон босоо харьяаллын шинжтэйгээр ажиллаж, сахилгын шийтгэл ногдуулах, эцсийн шийдвэр гаргах бүрэн эрхийг төвлөрүүлж байсан. Энэ нь тухайн үеийн төрийн удирдлагын тогтолцооны онцлогийг тусгасан хэдий ч, шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангахад сул талтай байв. Сахилгын зөрчилд тооцогдох үндэслэл нь өргөн, тодорхой бус бөгөөд гол төлөв "удирдлагын тушаал, даалгаврыг шуурхай биелүүлээгүй", "шүүгчийн нэр хүндэд зохимжгүй үйлдэл гаргасан" гэх мэт субъектив шинжтэй байжээ.

Харин ардчилсан шинэ Үндсэн хууль (1992) батлагдсанаас хойш шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах зорилгоор Шүүхийн сахилгын хороо нь сахилгын асуудлыг шийдвэрлэж эхэлсэн боловч уг зохицуулалт нь практикт олон давхардал, маргаан дагуулж байв. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүгчийн сахилгын асуудлыг хянан шийдвэрлэх бие даасан, Үндсэн хуулийн түвшинд баталгаажсан байгууллага болох Шүүхийн сахилгын хороог байгуулсан нь томоохон өөрчлөлт болсон. Ингэснээр шүүгчийн ёс зүйн болон сахилгын зөрчлийн асуудлыг төвлөрсөн, хараат бус, бие даасан бүтэц шийдвэрлэх эрх зүйн үндэс бүрдсэн бөгөөд олон улсын стандартад нийцсэн институцийн баталгааг бий болгожээ.

Өдгөө Шүүхийн сахилгын хороо нь хүн, албан тушаалтан, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэлд үндэслэн шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэн 4 дэх жилдээ ажиллаж байна.

ХОЁР | САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН МАГАДЛАЛ, ТОГТООЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ


2.1. САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

2.1.1. ӨРГӨДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ШСХ нь 2022 оны 01 сарын 10-ны өдрөөс эхлэн анхны өргөдөл, гомдлыг МУШТХ-д заасны дагуу хянан шийдвэрлэж эхэлжээ. ШСХ-ны албан ёсны цахим хуудсан дахь 2022–2024 оны тайланг үзвэл тухайн онуудад ШСХ-нд нийт **1134** өргөдөл, мэдээлэл ирсэн бөгөөд тэдгээрийн **609 буюу 54%-д** нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, **477 буюу 42%-д** нь сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ⁴⁰. Харин ШСХ-ны цахим хуудсан дахь магадлал болон өргөдөл, мэдээллийн жагсаалтаас харвал 2025 оны 07 сарын 05-ны байдлаар **183** (өмнөх оны үлдэгдэл ороод) өргөдөл, мэдээлэл ирсэн байх бөгөөд тэдгээрийн **86 буюу 47%-д** нь сахилгын хэрэг үүсгэж, **97 буюу 53%-д** нь сахилгын хэрэг үүсгээгүй байна.


График №1. ШСХ-ны шийдвэрлэсэн өргөдөл, мэдээллийн тоо, шийдвэрлэсэн байдал⁴¹

2022–2024 он



- Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан
- Сахилгын хэрэг үүсгэсэн
- Шийдвэрдээгүй үлдсэн

2025 оны 07 сарын 05-ны өдрийн байдлаар



- Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан
- Сахилгын хэрэг үүсгэсэн

График №1 дэх тоо, баримтуудаас үзвэл 2022–2024 он болон 2025 оны 07 сарын 05-ны байдлаар ШСХ-нд гаргасан өргөдөл, мэдээллүүдийн ихэнх буюу **53–54%-д** нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн бол бусад тохиолдолд илтгэгч гишүүний


⁴⁰ Тухайн 3 жилийн хувьд нийт өргөдөл, мэдээллийн 48 буюу 4%-д үлдэгдэлтэй байсан байна.

⁴¹ Шүүхийн сахилгын хороо, "Үйл ажиллагааны тайлан", 2022 он, 6 дахь тал, 2023 он, 5–6 дахь тал, 2024 он, 8 дахь тал, https://judiscom.mn/site/status_page/11.

саналыг үндэслэн ШСХ бүрэлдэхүүнээрээ сахилгын хэргийг шийдвэрлэж байна.


ШСХ-ны магадлалыг илтгэгч гишүүн, хэргийн оролцогчид хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ШСХ-ны хянан үзэх хуралдаанд, ШСХ-ны хянан үзэх хуралдааны тогтоолыг үл зөвшөөрвөл УДШ-д хяналтын журмаар гомдол гаргаж хянан шийдвэрлүүлэх боломжтой. Тус журмаар 2022–2024 оны хооронд сахилгын хэрэг үүсгэж, гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн нийт **477** магадлалын **37-д** нь илтгэгч гишүүн, хэргийн оролцогчид гомдол, эсэргүүцлийг ШСХ-ны хянан үзэх хуралдаанд гаргасан байна.⁴²

График №2. Магадлалд гомдол гаргасан байдал



Дээрх графикаас үзэхэд ШСХ-ны нийт шийдвэрлэсэн хэргийн **7.7%-д** хэргийн оролцогч, илтгэгч гишүүн гомдол, эсэргүүцэл гаргасан байна.

График №3. ШСХ-ны тогтоолд гомдолд гаргасан байдал



Харин ШСХ-ны хянан үзэх хуралдааны гаргасан **37** тогтоолын **17-д** буюу **46%-д** нь хяналтын гомдол гаргасан байна.⁴³ Энэ нь дээр дурдсан ШСХ-ны 2022–2024 оны хооронд сахилгын хэрэг үүсгэж, гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн нийт **477** магадлалын **17**

⁴² Мөн тэнд.

⁴³ Мөн тэнд.

буюу **3.6%-д** хэргийн оролцогчид УДШ-д хяналтын журмаар гомдол гаргаж, маргасныг харуулж буй юм.


2.1.2. САХИЛГЫН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ШСХ-ны хянан шийдвэрлэсэн 559 магадлалаас 1 магадлалыг нууцалсан байх ба үлдэх **558** магадлалын хувьд илтгэгч гишүүн **488 буюу 87.5%-д** нь сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргасан бол **70 буюу 12.5%-д** нь нотлох дүгнэлт үйлдэж сахилгын хэргийг бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлэхээр санал гаргажээ (График №4-ийн 1-ээс үзнэ үү).


Харин тухайн саналыг сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс дараах байдлаар шийдвэрлэсэн байна (График №4-ийн 2-оос үзнэ үү). Үүнд:

- Сахилгын хэргийг **хэрэгсэхгүй болгосон – 515** буюу **92.3%**;
 - Нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон – **29**;
 - Саналыг хүлээн авч, хэргийг хэрэгсэхгүй болгосон – **486**;
- Шүүгчид сахилгын **шийтгэл оногдуулсан – 41** буюу **7.3%**;
 - Нотлох дүгнэлтийг хүлээн авч, сахилгын шийтгэл оногдуулсан – **37**;
 - Нотлох дүгнэлтийн зарим хэсгийг хүлээн авч, сахилгын шийтгэл оногдуулсан – **4**;
- Олон шүүгчид холбогдох сахилгын хэргийн тухайд илтгэгч гишүүний саналыг хүлээн авч, зарим шүүгчийн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, нэг шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан **2** буюу **0.35%**;

Жич: Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох илтгэгч гишүүний саналыг хүчингүй болгосон магадлал байхгүй байна.

График №4. ШСХ-ны шийдвэрлэсэн магадлал, илтгэгч гишүүний санал1. Илтгэгч гишүүний санал, дүгнэлт
/2022.01.01-2025.07.05/

■ Хэргийг хэргэсэхгүй болгох санал
■ Нотлох дүгнэлт

2. ШСХ-ны магадлал
/2022.01.01-2025.07.05/


■ Сахилгын хэргийг хэргэсэхгүй болгосон
■ Сахилгын шийтгэл оногдуулсан
■ Бусад

Мөн дээрх тоон мэдээллээс илтгэгч гишүүн 70 тохиолдолд сахилгын хэрэгт нотлох дүгнэлт үйлдсэнээс сахилгын хорооны бүрэлдэхүүн **27 магадлалд** буюу нийт илтгэгч гишүүний нотлох дүгнэлтийн **4.8%**-д нь өөрчлөлт оруулж (нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэргэсэхгүй болгож) шийдвэрлэжээ.

ШСХ-ны магадлалаар сахилгын шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн тохиолдлуудаас 31 тохиолдолд хянан үзэх хуралдаанд гомдол гаргаж, хянан шийдвэрлэсэн 31 тогтоол ШСХ-ны цахим хуудсанд байна. Үүнд:

- Магадлалыг бүхэлд нь хүчингүй болгосон **5** буюу **16.1%**;
- Магадлалд өөрчлөлт оруулсан **7** буюу **22.58%**;
- Магадлалыг хэвээр үлдээсэн **16** буюу **51.6%**;

Дахин хэлэлцүүлэхээр буцаасан **3** буюу **9.67%**.

График №5. ШСХ-ны шийдвэрлэсэн тогтоолХянан үзэх хуралдааны тогтоол
/2022.01.01-2025.07.05/

■ Бүхэлд нь хүчингүй болгосон
■ Магадлалд өөрчлөлт оруулсан
■ Магадлалыг хэвээр үлдээсэн
■ Дахин хэлэлцүүлэхээр буцаасан


ШСХ-ны хянан үзэх хуралдаанаас гаргасан тогтоолд гомдол гаргаснаар УДШ хяналтын журмаар хянан шийдвэрлэж 11 тогтоол

гаргасан бөгөөд дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

- Хянан үзэх хуралдааны тогтоолыг хэвээр үлдээсэн **5** буюу **45.4%**;
- Магадлал, тогтоолыг хүчингүй болгосон **1** буюу **9.09%**;
- Магадлал, тогтоолыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан **3** буюу **27.27%**;
- Тогтоолыг хүчингүй болгож, хянан үзэх хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр буцаасан **2** буюу **18.18%**.

ШСХ-ны нийт магадлалын **5.5%** нь хянан үзэх хуралдаанаар, **1.9%** нь УДШ-ээр шийдвэрлэгджээ.


График №6. УДШ-ийн шийдвэрлэсэн тогтоол



2.1.3. ГОМДОЛ ГАРГАГЧ, ИЛТГЭГЧ ГИШҮҮН, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ ХООРОНДОО НИЙЦЭЖ БҮЙ ЭСЭХЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд ШСХ-ны цахим хуудсанд **558** магадлалыг нээлттэй байршуулжээ. Эдгээрээс **162** буюу **29%-д** нь **магадлалыг гаргахдаа МУШШЁЗД-ийг баримталж, эсхүл МУШТХ-ийг эшлэлгүйгээр** хэргийн үйл баримтыг үнэлэх зэргээр сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд хэргийн оролцогч, илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн аль аль нь МУШТХ-ийг дурдаагүй байна. Харин үлдэх **396** буюу **71%-д** нь хэргийн оролцогчид ямарваа нэг байдлаар МУШТХ-ийг эшилжээ. Иймд тухайн 396 магадлалын хууль хэрэглээнд дүн шинжилгээ хийлээ.

График №7. Өргөдөл, гомдол гаргагч, илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн МУШтХ-ийг эшилсэн байдал



Дээрх графикаар үзүүлсэн нийт 396 магадлалын хувьд өргөдөл гаргагч, илтгэгч гишүүн эсхүл сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний аль нэг эсхүл хэд хэдэн талууд МУШтХ-ийн 50 дугаар зүйлд заасан тодорхой заалтыг үндэслэн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна.

Өргөдөл, гомдол гаргагчийн зүгээс МУШтХ-ийн 50 дугаар зүйлд заасан 40 үндэслэлээс **50.1.1, 50.1.20, 50.1.23** дахь заалтыг түгээмэл ашиглаж ШСХ-нд хандаж байх бөгөөд илтгэгч гишүүн болон гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн тухайн заалтуудыг тайлбарлан хэрэглэх байдлаар хэргийг шийдвэрлэж байна. Зарим тохиолдолд илтгэгч гишүүн болон гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн нь сахилгын шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэхдээ МУШтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1–50.1.40-д заасан үндэслэлийг бус **МУШтХ-ийн 50–55 дугаар зүйлийг ерөнхийлөн бичиж** хэргийг шийдвэрлэж байна. Хэргийн оролцогч, ШСХ-ны илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн гэсэн 3 субъектийн үндэслэл болгож буй МУШтХ-ийн зүйл, заалтын тоо, хэмжээг тус бүрээр нь графикаар үзүүлбэл:




График №8. Өргөдөл, гомдол гаргагчийн хууль зүйн үндэслэл

График №8-аас үзвэл ШСХ-нд өргөдөл гаргагч иргэн өргөдөл, гомдол гаргахдаа МУШтХ-ийг эшлээгүй **307** буюу **77.5%-д** нь МУШтХ-ийг дурдаагүй байгаа юм. Харин үлдсэн **89 магадлал** буюу **22.5%-д** нь өргөдөл гаргагч МУШтХ-ийн зүйл заалтыг өргөдөлдөө эшилсэн байна.

График №9. Илтгэгч гишүүний хууль зүйн үндэслэл

Илтгэгч гишүүний хувьд өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх санал, дүгнэлтдээ нийт тогтоолын **219**-д нь буюу **55.3%-д** МУШТХ-ийн үндэслэлийг заагаагүй байна. Харин **177** буюу **44.7%-д** нь МУШТХ-ийн зүйл, заалтыг дурдаж дүгнэлт, саналаа гаргажээ.

График №10. Бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл

Сахилгын хэргийг хянан шийдвэрлэж буй бүрэлдэхүүн нь нийт магадлалын **232** буюу **58.6%-д** нь МУШтХ-ийг эшлээгүй байна. Харин **164** буюу **41.4%-д** нь МУШтХ-ийн зүйл, заалтыг тайлбарлах байдлаар хэргийг шийдвэрлэжээ.

Энэхүү өргөдөл, гомдол гаргагч, илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний МУШтХ-ийн эшилсэн байдалд үндэслэн **гомдол гаргагч болон илтгэгч гишүүний үндэслэл** болон **илтгэгч гишүүний үндэслэл, бүрэлдэхүүний үндэслэл** хоорондоо нийцдэг эсэх, холбоо хамаарлын талаар авч үзье.

а. Гомдол гаргагчийн үндэслэл болон илтгэгч гишүүний үндэслэлийн холбоо хамаарал

Дээр дурдсанчлан өргөдөл гаргагч өргөдөлдөө МУШтХ-ийн тодорхой заалтыг дурдсан (эшилсэн) нийт **89** магадлалын хувьд түүнийг шийдвэрлэсэн илтгэгч гишүүний хууль зүйн үндэслэлийг харьцуулан харвал:

График №11. Өргөдөл гаргагч болон илтгэгч гишүүний хууль зүйн үндэслэл




График №11-ээс харвал өргөдөл гаргагчийн үндэслэлтэй, илтгэгч гишүүний үндэслэл ижил байгаа нь нийт магадлалын **47** буюу **52.8%**-г эзэлж байна. Үүнээс үзэхэд ихэнх тохиолдолд илтгэгч гишүүн өргөдөл гаргагчийн үндэслэсэн МУШтХ-ийн 50 дугаар зүйлд заасан үндэслэлтэй адил үндэслэлээр хэргийг шийдвэрлэжээ. Харин нийт магадлалын **19** буюу **21.3%**-д нь өргөдөл гаргагчийн үндэслэсэн МУШтХ-ийг эшлэлгүйгээр, өргөдөл, гомдол гаргагчийн дурдсан хэргийн үйл баримтад үндэслэн хэргийг хянан шийдвэрлэж буй бол **23** буюу **25.9%**-д нь өргөдөл, гомдолд дурдаагүй зүйл, заалтад үндэслэсэн эсхүл МУШтХ-ийн зарим өөр зүйл, заалтыг нэмж үндэслэл болгон дүгнэлт, саналыг гаргасан байна. Тухайн 3 тохиолдол бүрт жишээ авч үзье.

Шигтгээ №1. Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдсан МУШТХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшилсэн жишээ

ШСХ-ны 2024.12.05-ны өдрийн 120 дугаартай магадлал⁴⁴

Өргөдөл гаргагч өргөдөлдөө "шүүх шийдвэрлэхдээ гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан нь хуульд нийцээгүй гэх утгатай үндэслэлээр хэрэгсэхгүй болгосноос үзвэл өнгөрсөн хугацаанд биднийг төөрөгдүүлж, гаргасан шаардлагыг маань хуульд нийцсэн мэтээр ойлгуулж захирамж гаргачхаад биднийг үүнтэй холбоотой ямар нэгэн хүсэлт, гомдол гаргах, шаардлагатай баримт гаргах боломжийг хааж нэхэмжлэгч талд давуу байдал бий болгосон, шүүгч хуулийн хугацаанд хэргийг шийдвэрлэх журмыг зөрчиж, үзлэг хийлгүй 2 жил хэргийг дарсныхаа дараа гэнэт шүүх хуралдаан явуулж, холбогдох баримтуудтай танилцуулалгүй хэргийг хүчээр шийдвэрлэсэн нь нэхэмжлэгч талд ашигтай байдал бий болгосон буюу **шүүгч Т.Б нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.23, 50.1.35-д** заасныг зөрчсөн" гэж маргасан байдаг.

Илтгэгч гишүүн саналдаа "... хариуцагчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаар ирээгүй болохоо холбогдох баримтаар нотлоогүйгээс шүүх хуралдааныг үргэлжлүүлсэнд шүүгчийн буруутгахгүй буюу **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.35-д** заасан шүүгчид хориглосон зөрчил гаргасан гэж үзээгүй болно, ... өргөдөл гаргагчийн "...миний ах Д.Н нь маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр шүүгчийн захирамж гарсны дагуу оролцож байгаа ба бие даасан шаардлага гаргасныг шүүх хүлээн авч холбогдох ажиллагаа хийгдсэн байдаг..." гэх өргөдөл үгүйсгэгдэж байх тул шүүгч Т.Б-г **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д** заасныг зөрчөөгүй, ... дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, 71.2, 71.3 дахь хэсэгт тус тус заасныг зөрчсөн болох нь шалгах ажиллагааны явцад нотлогдсон тул **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т** заасныг зөрчсөн сахилгын зөрчил гаргасан" гэжээ.

Шигтгээ №1 дэх хэргийн үйл баримтаас үзвэл өргөдөл гаргагч иргэн нэр бүхий шүүгчийг МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.23, 50.1.35 дэх хэсгийг зөрчсөн гэх өргөдлийг гаргасан. Илтгэгч гишүүний хувьд хэргийн үйл баримттай, МУШТХ-ийн 50.1-д заасан нөхцөлтэй нийцэж буй эсэх талаар дүгнэж, сахилгын хэргийг хянан шийдвэрлэжээ.

⁴⁴ ШСХ-ны 2024 оны 12 сарын 05-ны өдрийн 120 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/602.

Шигтгээ №2. Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдсан МУШТХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшлээгүй жишээ

ШСХ-ны 2022.03.11-ний өдрийн 112 дугаартай магадлал⁴⁵

Өргөдөл гаргагч өргөдөлдөө "... шүүх хуралдааныг 2021 оны 01 дүгээр сарын 25-нд цахим хэлбэрээр явуулахдаа хуулиар олгосон эрхийг хязгаарлаж, шүүх хуралдааны мэтгэлцэх зарчмыг алдагдуулан, шүүх хуралдаанд оролцож миний хууль ёсны эрх ашгийг хамгаалж байгаа өмгөөлөгч болон миний зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр нэхэмжлэл гаргаж буй иргэн миний шүүхэд гаргаж буй тайлбарыг удаа дараа тасалдуулан зогсоож, шүүх хуралдааны эцсийн шийдвэр гаргахын өмнө иргэн миний тайлбарыг хэлүүлэлгүй шүүх хуралдааныг явуулсан. Тайлбарыг удаа дараа таслан хязгаарлаж, улмаар шүүх хуралдааны төгсгөлд нэхэмжлэгч миний бие тайлбар гаргах гэсэн боловч цахимаар явагдаж буй хуралдааныг шууд зогсоон шүүхэд тайлбар гаргах миний эрхийг зөрчсөн. Түүнчлэн шүүх хуралдаан даргалагч Ч.Т нь тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ ... танхимын шүүгч байсан атал 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ... дугаар тогтоолд хуралдаан даргалагч, танхимын тэргүүн Ч.Т гэж бичиж, олгогдоогүй албан тушаалыг өөртөө давуу байдал олгон бичсэн нь Шүүгчийн ёс зүйг ноцтой зөрчсөн үйлдэл юм. Дээрх үйлдлүүд нь **МУШТХ-ийн 50.1.1, 50.1.23, МУШШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1-ийг** тус тус зөрчсөн болно..." гэжээ.

Илтгэгч гишүүн саналдаа "...Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн дүгээр зарлигаар шүүгч Ч.Т-ийг ... танхимын тэргүүнээр томилсон байх тул тухайн шүүх хуралдааныг даргалсан нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн /2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан/ 14 дүгээр зүйлийн 14.1-д "Танхимын тэргүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.1.3 "хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах" гэж заасантай нийцсэн байна. **Иймд өргөдөлд дурдагдсан "... танхимын шүүгч байсан атал тогтоолд хуралдаан даргалагч, танхимын тэргүүн Ч.Т гэж бичиж, олгогдоогүй албан тушаалыг өөртөө давуу байдал олгон бичсэн" гэх гомдол үгүйсгэгдэнэ.** Түүнчлэн, ... шүүхийн Тамгын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн ... дугаар албан бичигт хавсарган ирүүлсэн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн шүүх хуралдааны дуу, дуу дүрсний бичлэгээс үзэхэд 00:29:57-00:43:28 минут хүртэл нэхэмжлэгчийн өмгөөлөгч Л.М, 00:43:29-00:59:49 минут хүртэл нэхэмжлэгчийн өмгөөлөгч О.Д нар хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлын үндэслэлээ тайлбарлаж, 01:00:05-01:14:33 минут хүртэл нэхэмжлэгч Н.Э гомдлын үндэслэлд нэмж тайлбар хэлж байх бөгөөд даргалагч шүүгч нь нэхэмжлэгч, болон түүний өмгөөлөгч нарын тайлбар гаргах эрхийг хязгаарласан зөрчил гаргаагүй ... **Иргэн Н.Э өргөдөлтэй ... танхимын тэргүүн шүүгч Ч.Т-т холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай**" гэжээ.

Шигтгээ №2 дахь хэргийн үйл баримтаас үзвэл өргөдөл гаргагч иргэн нэр бүхий шүүгчийг МУШТХ болон МУШШЁЗД-ийг зөрчсөн гэх агуулгаар өргөдөл гаргажээ. Харин илтгэгч гишүүний хувьд МУШТХ-ийг эшлэлгүйгээр хэргийн үйл баримтыг тайлбарлаж, түүнд үндэслэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргажээ.

⁴⁵ ШСХ-ны 2022 оны 03 сарын 11-ний өдрийн 112 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/130.

Шигтгээ №3. Өргөдөл гаргагчийн өргөдөлд дурдаагүй МУШтХ-ийн заалтыг илтгэгч гишүүн эшилсэн жишээ**ШСХ-ны 2022.03.11-ний өдрийн 112 дугаартай магадлал⁴⁶**

Өргөдөл гаргагч өргөдөлдөө "...миний бие 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр ... аймгийн ...сумын нутаг дэвсгэр "Г" гэх газрын ойролцоо зам тээврийн осолд өртөж, тухайн асуудлыг ...аймгийн Цагдаагийн газраас шалгаж нөгөө талын 100 хувийн буруутай үйлдлийн улмаас осол гарсныг тогтоосон. Улмаар тухайн ослын улмаас учирсан эмчилгээний зардал болон автомашины хохирлыг төлүүлэхээр хариуцагчийн оршин суух гэрийн хаягийн дагуу ...дүүргийн иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл 2022 оны 10 дугаар сард /сарыг андуурсан байж болзошгүй/ нэхэмжлэл гаргасан боловч анх хуваарилагдсан шүүгч нь солигдож дараагийн шүүгч болох Гончигсумлаад иргэний хэрэг шилжиж очсоноос хойш 10 сар орчмын хугацаа өнгөрч байна. Иргэний хэргийн маргаантай учир зам тээврийн осолд өртсөн автомашин жил гаруй хугацаанд ...дүүрэг дэх журмын хашаанд өнөөдрийг хүртэл байна. Иргэн миний гомдол, хохирлыг зам тээврийн осол өртсөнөөс хойш 1 жил 3 сарын хугацаанд шийдвэрлэхгүй **МУШтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26 дахь заалтыг зөрчиж байгаа Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн шүүхийн шүүгч Б.Гончигсумлаагийн энэ үйлдлийг шалгаж өгнө үү**" гэжээ.

Илтгэгч гишүүн дүгнэлтдээ "...Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамжийн заалт биелэгдэх боломжгүй нөхцөл байдалтай холбогдуулан нэхэмжлэгчээс 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр болон 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр дахин шинжээч томилуулах хүсэлтийг гаргасаар байтал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх ямар нэг ажиллагааг хийхгүй, хэргийг түдгэлзүүлсэн хэвээр дарагдуулж, хугацаа алдаж байгааг зөрчилд тооцох үндэслэл болно. Шүүгч Б.Гончигсумлаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих үүргээ биелүүлээгүй, хэрэгт ямар ажиллагаа явуулсан нь тодорхой бус, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаан хугацаагаар зогсоож, нэхэмжлэгчийн шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийг ноцтойгоор зөрчсөн үйлдэл нь хариуцагч талд давуу байдал бий болгосон тул **МУШтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д "албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох", 50.1.23-т "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой зөрчсөн..." зөрчил гаргасан гэж үзэж, нотлох дүгнэлт үйлдэв**" гэжээ.

Шигтгээ №3 дахь хэргийн үйл баримтаас үзвэл өргөдөл гаргагч иргэн нэр бүхий шүүгчийг МУШтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26 дахь хэсгийг зөрчсөн учраас шалгуулах өргөдлийг гаргасан. Харин илтгэгч гишүүний зүгээс нэр бүхий шүүгчийг МУШтХ-ийн 50.1.23, 50.1.26-г зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулжээ. Өөрөөр хэлбэл өргөдөлд дурдаагүй үндэслэлээр илтгэгч шүүгч сахилгын хэргийг шийдвэрлэсэн байна.

б. Илтгэгч гишүүний үндэслэл гомдлыг шийдвэрлэх бүрэлдэхүүний үндэслэлтэй нийцдэг эсэх

Дээр дурдсанчлан нийт **177** тохиолдолд илтгэгч гишүүн МУШтХ-ийн зүйл заалтыг дурдсан байна. Үүнийг графикаар харуулбал:

⁴⁶ ШСХ-ны 2024 оны 12 сарын 24-ны өдрийн 129 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision full/603>.


График №12. Илтгэгч гишүүний болон бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл

График №12-оос харвал илтгэгч гишүүний үндэслэлтэй, бүрэлдэхүүний үндэслэл нийт магадлалын **89** буюу **50.3%-д** адил байгаа юм. Үүнээс харвал ихэнх тохиолдолд гомдол шийдвэрлэж буй бүрэлдэхүүн өргөдөл гаргагчийн өргөдөл, илтгэгч гишүүний саналд буй МУШТХ-ийн 50 дугаар зүйлд заасан үндэслэлтэй адил үндэслэлээр хэргийг шийдвэрлэж байна. Харин нийт магадлалын **49** буюу **27.7%-д** нь илтгэгч гишүүний үндэслэсэн МУШТХ-ийг эшлээгүй бол **39** буюу **22%-д** нь илтгэгч гишүүний саналд дурдаагүй зүйл, заалтад үндэслэсэн эсхүл МУШТХ-ийн зарим өөр зүйл, заалтыг нэмж үндэслэл болгон дүгнэлт, саналыг гаргасан байна. Тухайн 3 тохиолдол бүрт жишээ авч үзье.

Шигтгээ №4. Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдсан МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшилсэн жишээ

ШСХ-ны 2025.01.07-ны өдрийн 04 дугаартай магадлал⁴⁷

Илтгэгч гишүүн дүгнэлтдээ "...зохигч нь нэхэмжлэл гардан авсан, тайлбар гаргах зэрэг ажиллагаа хийгдэж байсан нь шүүх хуралдаан товлох нөхцөл бүрдээгүй байсан гэж үзэх үндэстэй байх тул "...иргэний хэрэг үүсээд 1 сар 27 хоногийн хугацаа өнгөрөхөд шүүх хуралдааныг огт товлоогүй..." гэх өргөдөл үндэслэлгүй байна; ...шүүгчийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн .../Ш32023/...2 дугаар захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх заалтыг удирдлага болгожээ. Гэтэл эдгээр заалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримт гаргуулах, олж авахтай холбоотой өөр өөр ойлголтыг зохицуулдаг болно. ...Түүнчлэн өөр этгээдээс нотлох баримт гаргуулах, шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх гэсэн өөр өөр агуулгатай, практикт хэдийнээ тогтсон ойлголтыг хольж хутган, бичмэл баримтыг хэргийн оролцогч биш хуулийн этгээдээс гаргуулахаар өөр шүүхэд даалгасан нь дээрх хуулийн 38.6 болон 41 дэх заалтын аль алинд хамаарахгүй агуулгыг тусгажээ...

⁴⁷ ШСХ-ны 2025 оны 01 сарын 07-ны өдрийн 04 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision full/579>.

Энэхүү хүсэлт шийдвэрлэн захирамж гаргасан, тус захирамжийг хянасан ажиллагааны үр дагаварт хэргийг... 52 хоног саатуулж удаашруулсан нь ноцтой гэж үзэх үндэслэлд хамаарна... Иймд холбогдох шүүгч нар **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасныг зөрчсөн болох нь тогтоогдож байх ба харин өргөдөлд дурдсанаар 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасныг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна...; шүүгч Б.Б нь 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн .../ШЗ2023/...5 дугаар захирамждаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.3 заалтыг үндэслэл болгосон нь мөн хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт хамаарч байх тул зөрчил гэж үзэхгүй..."** гэжээ.

Бүрэлдэхүүн магадлалдаа "...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт "Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, ...шийдвэрлэнэ", мөн зүйлийн 71.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно" гэж зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр дуусаж, хуульд зааснаар тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн .../ЗТ2023/...4 дүгээр тогтоолоор 30 хоногоор сунгахад, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа 2023 оны 3 дугаар сарын 12-ны өдөр дуусах байжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт "Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, ...шийдвэрлэнэ" гэж зааснаас үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацаа 60 хоног байх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснийг "ноцтой зөрчил"-д хамааруулах боломжгүй байна. **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т зааснаар хуулийн илт тодорхой заалтыг зөрчсөн нь "ноцтой" эсхүл "удаа дараа" зөрчсөн байхыг шаардах бөгөөд шүүгч, шүүх бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан дээрх эрхийн актуудыг "ноцтой" зөрчилд тооцохгүй.**" гэжээ.

Шигтгээ №4 дэх хэргийн үйл баримтаас үзвэл илтгэгч гишүүн нь нэр бүхий шүүгчийг МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.23 дугаар хэсгийг зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын шийтгэл оноох нь зүйтэй гэж үзжээ. Харин бүрэлдэхүүний хувьд илтгэгч гишүүнтэй адил зүйл, заалтыг үндэслэсэн боловч үйл баримтад тулгуурлан хуулийн заалтыг өөрөөр тайлбарлан шийдвэрлэсэн байна.

Шигтгээ №5. Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдсан МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшлээгүй жишээ

ШСХ-ны 2025.02.05-ны өдрийн 20 дугаартай магадлал⁴⁸

Илтгэгч гишүүн дүгнэлтдээ "... Гэрчүүдийн мэдүүлгээр н.Э нь "Ш" ХХК-д борлуулалт хариуцсан менежерээр ажиллаж байхдаа Э-тай уулзаж санал гаргасны үндсэн дээр талууд маргаан бүхий 19 тоотыг худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байх бөгөөд компанийг төлөөлөх этгээдийн хувьд З.Г гэрээг баталгаажуулж гарын үсэг зурсан, энэ тохиолдолд холбогдох шүүгчийг буруутгах үндэслэлгүй. Дээрх үндэслэлээр **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.28-д** заасан албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон, хуульд заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй гэх **нөхцөл байдал тогтоогдоогүй тул ... шүүхийн шүүгч Э-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргав.**" гэжээ.

Бүрэлдэхүүн магадлалдаа "... Дээрх **шүүгчийн тайлбар, гэрчийн мэдүүлгүүдээс үзвэл** шүүгч Э нь "Ш" ХХК-ийн удирдлагуудтай хувийн харилцаа холбоо байхгүй болох нь тогтоогдож байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэг хүлээхгүй. Энэ талаар илтгэгч гишүүний "Холбогдох шүүгч нь иргэнийхээ хувьд "Ш" ХХК-ийн барьж буй барилгаас орон сууц худалдан авахаар тохирч гэрээ байгуулсан, энэхүү гэрээ байгуулахыг хуулиар хориглоогүй, энэ тохиолдолд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үндэслэл болохгүй" гэж дүгнэсэн нь үндэслэл бүхий байна. **Дээрхээс нэгтгэн үзвэл илтгэгч гишүүний сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хүлээн авч, ... шүүгч Э-д холбогдох сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж бүрэлдэхүүн үзлээ.**" гэжээ.

Шигтгээ №5-д буй сахилгын хэргийн үйл баримтаас үзвэл илтгэгч гишүүн нэр бүхий шүүгчийг хэргийн үйл баримт, өргөдөл гаргагчийн өргөдөл зэрэгт үндэслэн МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.28 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэжээ. Харин бүрэлдэхүүний хувьд илтгэгч гишүүний саналыг хүлээн авсан. Ингэхдээ МУШТХ-ийн зүйл, заалтыг эшлэлгүйгээр хэргийн үйл баримтад дүн шинжилгээ хийсэн байгааг харж болно.

⁴⁸ ШСХ-ны 2025 оны 02 сарын 05-ны өдрийн 20 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision/full/620>.

Шигтгээ №6. Илтгэгч гишүүний дүгнэлтэд дурдаагүй МУШТХ-ийн заалтыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн эшилсэн жишээ**ШСХ-ны 2024.03.21-ний өдрийн 33 дугаартай магадлал⁴⁹**

Илтгэгч гишүүн дүгнэлтдээ "... Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй бөгөөд гэрч Н.3-ийн "шүүгч хяналт тавьж, байнга асууж хэргүүдээ явуулсан уу гэж анхаарч, асууж байсан. Явуул гэж намайг шаардаж байсан. Би тухайн үед асуудлаа хэлээд явж байсан" гэх мэдүүлгээс үзэхэд шүүгч Б.Б дээрх үүргээ биелүүлсэн гэж үзэхээр байна. Иймд, хэргийг прокурорт хүргүүлэх ажиллагаа нь шүүгчийн туслахын ажил үүрэгт хамаарах асуудал байхаас гадна **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан "албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон" гэх зөрчлийг гаргасан гэж үзэх үндэслэлгүй байх тул** ... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Б-т үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргав" гэжээ.

Бүрэлдэхүүн магадлалдаа "... МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д "албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох" гэж заасныг шүүгчийн албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг, 50.1.23-т "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах" гэж заасныг хэнд ч илэрхий ойлгомжтой төдийгүй шүүхийн практикт нэг мөр ойлгож хэрэгжүүлдэг хуулийн зохицуулалтыг санаатайгаар гуйвуулан тайлбарлаж өөрөөр хэрэглэсэн, хуульд захирагдах зарчмыг зөрчсөн ноцтой үйлдлийг, эсхүл олон удаагийн давтамжаас хамаарч сахилгын зөрчилд тооцох эсэхийг тогтоохоор хуульчилсан гэж тус тус ойлгоно.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс дээрх 2 хэргийг прокурорт хүргүүлээгүй үйлдэлтэй холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Нийслэлийн Прокурорын газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 290 дугаартай прокурорын тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан үндэслэлээр хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байх тул **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан зөрчил үгүйсгэгдэж байна...** Энэ тохиолдолд нэр бүхий шүүгчийг зөрчилд шууд гэм буруутай, үйлдэл гэм буруугийн хооронд шууд шалтгаант холбоотой гэж үзэхээргүй бөгөөд **МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасан "ноцтой", "удаа дараа" байх урьдач нөхцөл хангагдаагүй** тул илтгэгч гишүүний саналыг хүлээн авч сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв." гэжээ.

Шигтгээ №6-д буй сахилгын хэргийн үйл баримтаас үзвэл илтгэгч гишүүн нэр бүхий шүүгчтэй холбоотой дүгнэлтийг гаргахдаа МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх хэсгийг зөрчөөгүй учраас сахилгын хэрэг оноох ёсгүй гэж дүгнэсэн. Харин бүрэлдэхүүний хувьд хэргийн үйл баримтуудад үндэслэн сахилгын шийтгэл оноох ёсгүй гэдгийг

⁴⁹ ШСХ-ны 2024 оны 03 сарын 21-ний өдрийн 33 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/471.

тайлбарлаж, түүнчлэн МУШТХ-ийн 50.1.1 дэх заалт дээр нэмж 50.1.23 дахь заалтыг хэргийг шийдвэрлэх үндэслэл болгожээ.

2.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын нэр бүхий иргэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.23 дахь зохицуулалтыг Үндсэн хууль зөрчсөн байна гэх агуулгаар мэдээлэл гаргаж байсан бөгөөд Үндсэн хуулийн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дунд суудлын хурлаар тус зохицуулалтыг Үндсэн хуульд нийцсэн гэж дүгнэсэн. Энэхүү дүн шинжилгээний 2.2 дахь хэсэгт дурдсанчлан МУШТХ-ийн 50.1.23 дахь заалт нь ШСХ-ны хянан шийдвэрлэж буй магадлалын хамгийн түгээмэл үндэслэл болж буй юм. Түүнчлэн тус зохицуулалтын талаар эрдэмтэн, судлаачид шүүмжлэлт байр сууринаас ханддаг.

Иймд дээр дурдсан шалтгааны үндсэн дээр МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23. *"хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах"* гэх зохицуулалтын үзэл баримтлал, төсөө бүхий зохицуулалттай гадаад улсуудын туршлагыг онцгойлон судлалаа.

2.2.1. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтад *"албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох"*, 50.1.23 дахь заалтад *"хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах"* гэх үйлдлийг шүүгчид хориглохоор зохицуулжээ.

Дээрх хуулийн төслийг санаачилсан Монгол Улсын Ерөнхийлөгч болон Монгол Улсын Засгийн Газрын бэлтгэсэн үзэл баримтлал, мөн хэлэлцүүлгийн үеэр хууль тогтоогч, ажлын хэсгийн шүүгч, судлаач нар тус зохицуулалтуудыг хэрхэн ойлгож, баталсан болохыг судалж, дүн шинжилгээний энэ хэсэгт оруулахыг зорилоо.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ө.Шижир нь МУШТХ-ийн төсөл, үзэл баримтлалын талаарх танилцуулга илтгэлийг Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар⁵⁰ хэлэлцүүлсэн ба илтгэлд:

⁵⁰ УИХ-ын ХЗБХ, 2020.04.28-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, <https://www.parliament.mn/nn/10731/>, (Сүүлд үзсэн: 2024.06.17).

"Шүүгчийн мэргэжлийн болон ёс зүйн сахилгын хариуцлагын ялгаа заагийг тогтоох, ёс зүй болон сахилгын хариуцлагаас гадна үлддэг шүүгчийн мэргэжлийн алдаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хариуцлага тооцох, ажил хэргийн чадвар мэргэжлийн түвшнийг нь үнэлэх буюу дүгнэх чиг үүргийг давхардуулахгүйгээр тусгаарлан зохицуулав" гэх зарчмын шинжтэй зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан талаар дурдсан байна.

- МУШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн анхны бүрэн хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар⁵¹ хийсэн ба МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.26 дахь заалтуудтай холбоотой ямар нэгэн санал гишүүдээс гараагүй байна. Харин 50.1.23 дахь заалтад холбогдох асуудлаар дараах зүйлс хуралдааны явцад хэлэлцсэн байгааг түүвэрлэв:

Шигтгээ №7. МУШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн ХЗБХ-ны хуралдааны тэмдэглэл

Д.Мөнхтуяа: ... хуулийн ил тодорхой маргаангүй заалт гээд байгаа юм. Шүүхэд бол ийм заалт байхгүй шүү дээ. Яг юу, яг ямар заалтыг илт заалт тодорхой заалт маргаангүй заалт гээд байгаа юм. Одоо жишээлбэл, торгох, одоо жишээлбэл торгох ял өгөх ёстой юмыг хорих ял өгчихсөн гээд байгаа юм. Энэ бол маргаангүй заалт биш. Энэ бол тэр гэмт хэргийн зүйлчлэлийг зөв буруу хийсэн л асуудал. Өөрөөр хэлбэл нэгийн хоёроор хорих биш, нэгийн нэгээр зүйлчлээд торгох байсан юм байна. Энэ маргаан өөрөө дээд шүүх дээр ч байдаг. Энэ ерөөсөө илт тодорхой асуудал бол биш. Хүний нас хүртэл одоо арван найман нас гээд заачихсан юм мөртөө шүүх дээр маргаантай байдаг юм. Шүүхээр шийдэгддэг асуудал;

О.Мөнхсайхан: ... Энэ дээр бол нэгдүгээрт бол 52.1.23-т хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг ноцтой, эсвэл удаа дараа зөрчсөн бол одоо сахилгын зөрчил болохоор хориглож өгч байгаа юм. Энэ бол юу вэ гэхээр Үндсэн хуульд бол шүүх зөвхөн хуульд захирагдана гэж байгаа юм. Тэр захирагдахын хамгийн маргаангүй, илэрхий утгыг энэ чинь бүр мэргэжлийн алдаа энэ бол ерөөсөө биш. Ямар ч мэргэжлийн мэдлэг чадвар шаардахгүй илэрхий ингээд хуулийг уландаа гишгээд давж шийдээд байгаа юм чинь бол сахилгын зөрчил гэж;

Б.Дэлгэрсайхан: ... Сая шүүгч маш тодорхой хэллээ шүү дээ. Ямар нэгэн заалт бичиж байж, тэгээд энэ заалт, заалтыг баримталж, одоо би ийм одоо шийдвэр гаргаж байна л гэж гаргаж таараа. Тийм учраас ялангуяа тавин хоёрын нэгийн хорин гурав дээр бол энийг эргэж харахгүй бол ямар энэ маргаангүй заалт тодорхой маргаангүй заалт гэж яг юу хэлэх гээд байгаа юм. ... Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх үзээд энэ хуулийг буруу, одоо юу ял шийтгэл нь буруу байна, зөв байна гэж заагаад дээд шат нь бол энэ хуулийг буруу хэрэглэж гэдэг ч юм уу ингэж зөрчлийг засдаг л байх гэж бодож байгаа юм;

⁵¹ УИХ-ын ХЗБХ, 2021.01.05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, <https://www.parliament.mn/nn/13622/>, (Сүүлд үзсэн: 2024.06.17).

Х.Нямбаатар: ... Энийгээ маш тодорхой болгомоор байна. Жишээлэхэд, тавин хоёрын нэгийн хорин гурав дээр юуг илт алдаатай, юуг тодорхой заалтыг, юуг тодорхой заалт, юуг маргаангүй заалт, юуг ноцтой одоо алдсан заалт гэж үзэх юм. Энийгээ хэдүүлээ бүр задлаад ингээд маш тодорхой биччихвэл. Ингээд цаашаагаа явчихъя.

... Хуулийн илт заалт гэж юуг хэлдэг юм. Хуулийн тодорхой заалт гэж юу хэлэх юм. Маргаангүй заалт гэж юуг хэлэх юм. Яг энийгээ эсвэл тодорхойлчихмоор байна. Тэгээд хэдүүлээ цаашаа явъя;

Ц.Мөнхцэцэг: ... Тэгээд ер нь олон улсын практик ч гэсэн яг энэ тавин хоёрын нэгийн хорин гурав, тавин хоёрын нэгийн хорин долоо бол угаасаа байдаг заалт байна. Жишээлбэл энэ Америкийн одоо мужууд, Герман, Молдова зэрэг улсад бол энэ хэрэг хянан шийдвэрлэх тухай, эсвэл бусад хуулийг заавал биелүүлэх шинжтэй, илэрхий тодорхой заалтыг шууд санаатай, эсвэл хэт болгоомжгүйгээр зөрчих бол сахилгын зөрчилд орж байна.

... Хоёрдугаарт нь одоо илт мэдэгдэхүйц, одоо санаатайгаар гэдэг юм уу, хуулийг одоо үл хэрэгсэх. Мөн одоо хуулийн заалтыг одоо ямар нэгэн одоо дарамт гэдэг юм уу, эсвэл нөлөөн дор одоо санаатайгаар мушгин хэрэглэх явдлаас хамгаалж байгаа. Ер нь тэгээд олон улсын одоо шүүхийн байгууллагууд, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны нийгэмлэг, Венецийн комисс энэ тэр бол ерөөсөө энэ шүүхийн сахилгын зөрчлийг одоо иймэрхүү дэлгэрэнгүй байдлаар оруулах нь зөв гэдгийг бол зөвлөж ирсэн.

... Энэ чинь угаасаа олон улсын практик. Тэгээд бид нар одоо шүүхийн реформыг хийх гэж байгаа бол яг л одоо шинэчлэл чигээр нь байдаг юм уу, энэ дэвшлийг бол зайлшгүй хийх шаардлагатай;

Д.Лүндээжанцан: Ажлын дэд хэсгийн хуралдаан дээр энэ 40 асуудал гарч ирэхэд хэчнээн юм болж байж гарч ирсэн бэ. Тэгээд бол би яагаад байна шүү дээ энэ дэд хэсэг гэсэн энэ асуудал орж ирсэн бэ гэж ойлгоход бол би юу гэж ойлгосон бэ гэхээр эхнийх нь бол тэр 52.1.23 дээр хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг гэж. Маргаангүй заалт гэж ер нь ямар юмыг хэлдэг юм бэ энэ тэр гээд л ярих байх. Энийг бол найруулгаар бол авчхаж болох юм гэж ингэж бодож байгаа юм. Заалтыг ноцтой энэ ноцтой гэдэг үг дээр нь бол би энэ бол сахилгын энэ бол зүгээр мэргэжлийн алдаа гэж үзэж болохгүй. Сахилгын зөрчил байх ёстой юм байна. Ноцтой зөрчиж байж сахилгын зөрчил болно гэж. Тэгэхээр энийг бол дараа нь тайлбарлаж болох юм гэж ингэж ойлгож байгаа.

2 дахь нь удаа дараа гэж. Ер нь бол ажлаа удаа дараа таслах энэ тэр гээд Хөдөлмөрийн хууль дээр бол удаа дараа таслах энэ тэр гэж бараг ойлголт байхгүй шахуу юм байна лээ. Харин шүүхийн юм дээр байлаа гээд ингээд тал талаасаа ярилцсан юм. Тэгэхээр ийм алдааг удаа дараа зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг гаргах гээд. Ийм ноцтой удаа дараа гэдэг 2 юм дээр нь бол одоо бид ач холбогдол өгөөд энэ бол мэргэжлийн алдаа гэж хэлэхэд бол хэцүү юм. Сахилгын зөрчил гэж үзэхээс аргагүй юм гэдэг л ойлголтод хүрсэн.

... бид бол сүүлийн хэдэн жил бол их том хийдэл гаргалаа. Энийгээ хүлээн зөвшөөрөхөөс өөр арга алга. Норматив тайлбар гаргахаа байсан. Үндсэн хуулиас бусад хуулийг Улсын дээд шүүх албан ёсны тайлбар гаргана гэдэг Үндсэн хуулийн заалт байсаар байтал ерөөсөө тогтоолоор тайлбарлахаа байсан. Ийм учраас энэ заалтыг нээж өгснөөрөө одоо ингээд Улсын дээд шүүхийн тогтоолууд гарч жишээ нь энэ 52.1.23 ноцтой гэж энийг ийм зүйлийг ойлгоно. Удаа дараа зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй гэж ийм зүйлийг ойлгоно. Огт бичээгүй гэдгийг ийм зүйлийг ойлгоно гээд энэ одоо хуулийг бол тайлбарлах боломж нээгдэж байгаа юм;

Х.Нямбаатар: Сая Лүндээжанцан дарга бол шийдэл хэлсэнгүй. Бид нар хэдүүлээ нэг ийм юм дээр зөвшилцөлд хүрээд цаашаагаа явчихмаар байна. Жишээлбэл 52.1.23 дээр хуулийн илтэд тодорхой заалтыг ноцтой зөрчсөн гээд ингээд найруулаад явчихвал цаашаа явъя;

С.Бямбацогт: Одоо би саналын томьёоллыг уншаад танилцуулъя. Сая бол ерөнхийдөө Нямбаатар гишүүний гарч байгаа санал Лүндээжанцан зөвлөхийн бас хэлсэн санал үндсэндээ бол агуулгын хувьд нэг байна. Одоо би томьёоллыг та бүхэнд уншаад танилцуулъя. Өөр сайжруулах шаардлагатай бол 2 дахь хэлэлцүүлгийн явцад сайжруулж болно. Ингээд 52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах; санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Маргаангүй л хасаж байгаа юм. Дахиад бас ярилцъя. Ямар ч байсан ингээд явж байя. Чуулганы хуралдаанд орохоос өмнө бас манайхан дахиад нэг сайн ярилцаарай. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. МУШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцсэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны⁵² тэмдэглэлд:

Д.Лүндээжанцан: Энэ юуны Байнгын хороо болон ажлын хэсэг дээр хэлэлцэх явцад алийг нь мэргэжлийн алдаа гэж үзэх юм бэ, аль зөрчлийг бол одоо сахилгын зөрчил гэж үзэх юм бэ гэдгийг бол ялгаж зааглах асуудал бол маш төвөгтэй юм байна лээ. Тэгж байгаад бол гарцаагүй мэргэжлийн алдааг байнга л гаргаад байна гэж үзэж болохгүй. Үнэхээр одоо энэ бол сахилгын зөрчил байхаас аргагүй. Зарим зүйлийг нь бол хоёр зүйлийг бол тэр сахилгын зөрчилд хамааруулсан. Хууль зүйн байнгын хорооны гишүүд бол энэ дээр олон талаас нь ул суурьтай ярина лээ. Тухайлбал тавин хоёрын нэгийн хорин гурав дээр хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах гэж.

Тэгэхээр хуулийн илт тодорхой заалтыг ноцтой зөрчсөн гэж. Энэ бол ноцтой. Зөрчсөн үед нь л энийг бол мэргэжлийн алдаа гэж хэлж болохгүй. Ийм ноцтой зөрчил заримдаа гаргачихдаг юм байна л даа. Ганцхан торгох заалт ялтай ийм зүйл дээр хорих ял нэг жилээр хорих ял оноосугай гээд заачихсаныг чинь ямар мэргэжлийн алдаа гаргалаа гэлтэй биш. Энэ бол сахилгын зөрчил болж байгаа юм гэж ингэж ийм тайлбарууд яригдаад орсон.

⁵² УИХ-ын намрын ээлжит чуулган, 2021.01.07-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, <https://www.parliament.mn/nn/13511/>, (Сүүлд үзсэн: 2024.06.17).

Дээрх тэмдэглэлүүдээс үзвэл, МУШТХ-ийн 50.1.23 дахь заалтад холбогдох хуулийн төслийг хэлэлцэх явцад Хууль зүйн байнгын хорооны гишүүд нэгдсэн ойлголтод хүрээгүй болох нь ажиглагдаж байна. Харин гишүүд тус тусын саналыг жишээтэйгээр дурдсан байх ба "Хуулийн илт тодорхой заалт" гэж юуг хэлэх, "Ноцтой зөрчсөн" гэдэгт ямар үйлдэл, эс үйлдэхүй хамаарах талаар тодорхой зохицуулах шаардлагатай гэдгийг сануулж, ШСХ дээрх хуулийн заалтад холбогдох хэргийг шийдвэрлэхдээ "үзэмж"-ээр хандах аюултайг дурдсан байна.

Мөн хуралдаанд оролцсон гишүүд нэгдсэн байдлаар санал нийлсэн зүйл байхгүй боловч нийтлэг байдлаар "хуульд тодорхой заасан" зохицуулалтыг өөрөөр хэрэгжүүлэх нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-д заасан зөрчилд хамаарах ёстой гэх агуулгаар өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байна.

Дээрхээс үзвэл тухайн зохицуулалтыг хэрхэн ойлгох талаар хууль тогтоогчид нэгдсэн нэг үзэл баримтлалтай байгаагүй нь харагдаж буй юм. Иймд тус зохицуулалтын агуулгыг ойлгохын тулд ижил, төсөөтэй хууль, тогтоомжтой гадаад улсуудын жишээг судалж үзэх нь зүйтэй байна.

2.2.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.23 ДАХЬ ЗААЛТТАЙ ТӨСӨӨ БҮХИЙ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ УЛСЫН ЖИШЭЭ

А. МОЛДАВ УЛС

Молдав Улсын Шүүгчийн хариуцлагын тухай хууль (англ. *the Disciplinary Liability of Judges*)-ийн 4 дүгээр зүйлийн (1)-д шүүгчийн 13 төрлийн сахилгын зөрчил (2023 оны 02 дугаар сарын 02-нд нэмэлт өөрчлөлт орсны дараах байдлаар)-ийг тусгажээ. Тус 13 төрлийн сахилгын зөрчлөөс Монгол Улсын шүүхийн тухай хууль (цаашид "МУШТХ" гэх)-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасан "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах" гэж заасан зөрчилтэй төстэй нь Молдав Улсын Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (1) i-д "шүүн таслах ажиллагааны явцад хууль тогтоомжийн зайлшгүй хэм хэмжээг зөрчсөн"⁵³ гэх зохицуулалт байна.

Молдав Улсын Сахилгын зөвлөл (рум. *Colegiului disciplinar*)-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд дурдсан нийт 20 сахилгын хэргээс энэхүү судалгаанд ач холбогдолтой 4(1) i буюу "шүүн

⁵³ Violation of the imperative norms of the legislation in the process of administration of justice;

таслах ажиллагааны явцад хууль тогтоомжийн зайлшгүй хэм хэмжээг зөрчсөн" гэж хэрэг үүсгэн шалгасан 11 тохиолдол байна. Үүнээс 3 тохиолдолд зөвхөн 4(1) i-д заасан зөрчилд хамааруулан сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн бол үлдэх 8 тохиолдолд бусад заалтуудтай хамтад нь шийдвэрлэжээ. Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (1) i-д заасан зөрчлийг дангаар нь хянан шийдвэрлэсэн 3 тохиолдлоос 1 тохиолдлыг сахилгын зөрчил мөн гэж шийдвэрлэж хариуцлага ногдуулсан бол, 4(1) i-д заасан зөрчлийг бусад зөрчилтэй хамтад нь хянан шийдвэрлэсэн 8 тохиолдлоос 4 тохиолдлыг хэрэгсэхгүй болгосон бөгөөд үлдэх 4 тохиолдлын тухайд 2 шүүгч, тус бүр 2 удаа сахилгын зөрчилд холбогдож, Сахилгын зөвлөлөөс сахилгын зөрчил мөн гэж үзэж хариуцлага оногдуулжээ.

Энд 4(1) i-д заасан зөрчил мөн гэж үзсэн 3 хэргийг дэлгэрүүлэн авч үзвэл:

Шигтгээ №8. Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 27/9 дугаар шийдвэр⁵⁴

Молдав Улс тусгаар тогтносны 30 жилийн ойг тохиолдуулан баталсан Өршөөл үзүүлэх тухай хуульд Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд заасан хорих ялын үндсэн хэмжээ нь 7 жилээс илүүгүй гэмт хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийг хамааруулж, харин насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт хамаарахгүй гэж заасан байна. Гэтэл тус улсын шүүгч Mițu Ghenadie нь насанд хүрээгүй хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн Preida Maxim-ыг өршөөлөөр сулласан байх тул 4(1) i-д заасан зөрчил гаргасан гэж хэрэг үүсгэсэн байна.

Сахилгын зөвлөлөөс хэргийг хянаад тус тохиолдолд шүүгч нь шүүгчийн үйл ажиллагаандаа ноцтой хайхрамжгүй хандсан бөгөөд үүнийг мэргэжлийн хүний үүднээс зөвтгөх боломжгүй гэж үзэж 4(1) i-д заасан зөрчил мөн буюу "шүүн таслах ажиллагааны явцад хууль тогтоомжийн зайлшгүй хэм хэмжээг зөрчсөн" гэж үзжээ.

Ийнхүү шийдвэрлэхдээ "Зайлшгүй хэм хэмжээ нь үйл ажиллагааны хазайж болохгүй хүрээ хязгаар бөгөөд зайлшгүй хийж гүйцэтгэхийг эсхүл аливаа үйлдлийг хийхээс татгалзахыг албадсан байдаг. Иймд, зайлшгүй хэм хэмжээ гэдэг нь үүрэг хүлээлгэсэн, хориглосон, хатуу тогтоосон хэм хэмжээ юм. 4(1) i-д заасан зөрчил мөн эсэхийг тогтоохын тулд шүүгч тус зөрчлийг гаргах санаатай үйлдэл байгаа эсэхийг тогтоох шаардлагатай" гэжээ.

⁵⁴ Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 27/9 дугаар шийдвэр https://www.csm.md/files/Hotarirele_CDisciplinar/2022/Sesizari/09/27-9.pdf. (Сүүлд үзсэн: 2024.12.04).

Шигтгээ №9. Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 13/4 дүгээр шийдвэр

Тус тохиолдолд Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 4(1) i-д заасан хэд хэдэн зөрчилд холбогдуулан сахилгын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэжээ. Үүнээс 4(1) i-д заасан зөрчилтэй холбогдуулан Сахилгын зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг авч үзвэл:

- 4(1) i-д заасан зөрчил нь шүүгчийн хууль тогтоомжийг хэрэглэх, тайлбарлах эрх чөлөөтэй хамааралтай. Шүүгч хэргийг хянан шийдвэрлэхэд 2 үндсэн зарчим баримтална. Нэгд, шүүгч зөвхөн хуулийг баримтална. Хоёрт, нотлох баримтыг үнэлэх болон хэргийг шийдвэрлэхдээ хуулийг удирдлага болгон өөрийн дотоод итгэл үнэмшилээр үнэлнэ. Шүүгчийн дотоод итгэл үнэмшил нь хуульд захирагдах бөгөөд энэ нь хязгааргүй ойлголт биш. Шүүгчийн дотоод итгэл үнэмшил нь хууль тогтоомжийн тайлбарт нийцэх учиртай.
- "Зайлшгүй" гэсэн үг нь "шүүх боломжтой", "шүүх болно" гэсэн ойлголтыг "шүүх ёстой" гэснээс ялгах зорилготой. Хуулийн ямар ч зохицуулалтыг заавал дагаж мөрдөнө. Гэвч зарим зохицуулалт нь шүүгчид хэргийг шийдвэрлэх хэд хэдэн хувилбарыг заасан байдаг бол зарим зохицуулалт шүүгчид шууд нэг арга замыг үүрэг болгосон, түүнээс татгалзах боломжгүй байдаг. Зайлшгүй гэдэг нь хоёр дахь агуулгад хамаарна.
- 4(1) i-д заасан зөрчлийг тогтоохдоо шүүгчийн санаа зорилгыг нотлох шаардлагагүй. Харин хуулийг хэрэглэхдээ санаатай эсхүл хайнга хандсан эсэхийг тогтооход хангалттай. Шүүгч хуулийг заавал мэдэх ёстой гэж үзнэ.

Дээрх шийдвэрүүдээс үзвэл сахилгын зөрчил нь хэдийгээр гэмт хэрэг биш ч гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын дагуу гэм буруугийн хэлбэр, шалтгаант холбоо, үр дагавар зэргийг харгалзан үзэж сахилгын зөрчил мөн эсэхийг тогтоож байна. Түүнчлэн, "зайлшгүй хэм хэмжээ" гэдэг нь хуульд байгаа хатуу (императив) хэм хэмжээг хэлж байх бөгөөд диспозитив буюу сонгох санкцтай хэм хэмжээг хамааруулахгүй байна.

В. ИСПАНИ УЛС

Испани Улсын хувьд шүүгчийн сахилга хариуцлагатай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх, сахилгын шийтгэл ногдуулах бүрэн эрхийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл (англ. *The General Council of the Judiciary*)-ийн Сахилгын хороо (англ. *The Disciplinary Committee*) хэрэгжүүлдэг.⁵⁵ Шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой харилцааг Шүүхийн органик хууль⁵⁶ (англ. *Organic Law 6/1985, of 1 July, on*

⁵⁵ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, art. 604 (1) "The Disciplinary Committee shall have the authority to resolve disciplinary cases instigated as a result of serious and very serious infractions, and shall, where appropriate, impose such penalties as correspond to Judges and Magistrates, with the sole exception of circumstances in which the proposed penalty involves removal from office"

⁵⁶ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/DOCUMENTACI%C3%93N%20DEL%20CPJ/COMPENDIO%20DE%20DERECHO%20JUDICIAL/FICHERO/20160125%20LOPJ%20ingl%C3%A9s%2012-2015>.

the Judiciary)-ийн 414–427 дугаар зүйлүүдэд хуульчилжээ. Уг хуульд шүүгчийн сахилгын зөрчлийг онц хүнд⁵⁷, хүнд⁵⁸, хөнгөн⁵⁹ гэж 3 хувааж зохицуулсан байна. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт №1. Шүүгчийн сахилгын зөрчлийн ангилал

Онц хүнд зөрчил	Хүнд зөрчил	Хөнгөн зөрчил
• Үндсэн хуульд үнэнч байх үүргээ зөрчих • Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлд нэгдэх, тэдэнд үйлчлэх • Шүүгчийн үүргээс бусад шалтгаанаар шүүхийн харьяаллын эрх бүхий байгууллагад ноцтойгоор нөлөөлөхийг оролдох • Бусад шүүгчдийн үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар нөлөөлөх гэж оролдох • Хуулийн дагуу иргэний хариуцлагыг тооцох үндэслэлд үйлдэл, эс үйлдэхүй гаргах • Энэ хуулийн 388 дугаар зүйлд заасан шүүгчийн эрхийг хасах аливаа үйл ажиллагаа явуулах • Энэ хуулийн 391–393 дугаар зүйлд заасан эрхээ хасуулах нөхцөл байдал үүссэн байхад өөр шүүхэд шилжүүлэн ажиллах, эсхүл үргэлжлүүлэн шүүгчээр ажиллах • Нэхэмжлэлийг хуулийн дагуу хүлээн авах боломжгүй байхад татгалзсан хариуц өгөөгүй бол	• Олон нийтийн өмнө шүүхийн дээд шатлалын албан тушаалтны нэрийг дурдаж үл хүндэтгэн буруушаах • Бусад шүүгчдийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх байдлаар хөндлөнгөөс оролцох • Шүүгчийн албан тушаалыг ашиглаж төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг дэмжих, эсхүл шүүмжлэх • Доод шатны шүүхийн шүүгчид өөрт олгогдсон эрх мэдлээс гадуур хууль эрх зүйн тогтолцоонд өөрчлөлт оруулах • Шүүгчийн эрх мэдлээ хэтрүүлж иргэн, байгууллага, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, байцаагч, цагдаа, өмгөөлөгч, улсын яллагч, захиргааны ажилтны нэр төрийг гутаан доромжлох • Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт үндэслэлгүй, илт үл хүндэтгэсэн, доромжилсон утга агуулга оруулах	• Дээд шатлалын албан тушаалтанд хүндэтгэлгүй хандсан нь хүнд зөрчилд тооцогдохгүй бол • Бусад эрх тэгш болон доод шатны шүүх, тэдгээрт хамаарах ажилтан, шүүхийн нарийн бичгийн дарга, иргэн, байгууллага, байцаагч, улсын яллагч, өмгөөлөгч, цагдаа нарыг үл тоомсорлох • Шүүхийн хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны хуулийн хугацааг удаа дараа, үндэслэлгүйгээр зөрчих • Шүүгч үндэслэлгүйгээр 1-ээс дээш 3-аас доош хоногоор чөлөө авсан • Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Дээд шүүхийн Ерөнхийлөгчийн хууль ёсны мэдэгдэл, шийдвэрийг үл тоомсорлох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад саад учруулах

[pdf.](#)

⁵⁷ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, art. 417.

⁵⁸ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, art. 418.

⁵⁹ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, art. 419.

· Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр удаа дараа хойшлуулсан бол · Шүүгчийн албан ажлыг 7 ба түүнээс дээш хоногоор тасралтгүйгээр үндэслэлгүй орхиж явсан бол · Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх явцад олж авсан мэдээллийг задруулах, үүнээс болж хэргийн оролцогчид хохирол учирсан бол · Шүүгчийн эрх мэдлийг урвуулан ашиглаж эрх бүхий албан тушаалтанд давуу эрх олгосон бол · Шүүгчийн үүргээ гүйцэтгэхдээ зөвтгөх боломжгүй алдаа гаргах · Шүүгч давж заалдах гомдол гаргах боломжгүй хэмжээнд үндэслэлгүй шийдвэр гаргасан бол, гэхдээ энэ нь гомдол гаргах шаардлага нь болно. · Энэ хуулийн 427 дугаар зүйлд заасан хугацаанд хүчингүй болголгүй шийдвэрлэсэн нь гэмт хэрэг болсон тохиолдолд	· Шүүхийн хэрэг бүртгэгч болон харьяалах албан тушаалтнуудын ажил үүргээ зөрчсөн үйлдэлд сахилгын хариуцлага оногдуулаагүй тохиолдолд · Энэ хуулийн 417 дугаар зүйлд заасан ноцтой зөрчилд тооцогдохгүй бол шүүгчийн үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллийг гадуур задруулсан бол · Үндэслэлгүйгээр 3-аас дээш, 7-оос доош хоногоор чөлөө авсан тохиолдолд · Шүүх хуралдааны хуваарийг удаа дараа зөрчсөн, нээлттэй зарласан шүүх хуралдаанд оролцоогүй нь онц хүнд зөрчилд тооцогдохгүй бол · Шүүгч хэрэг хянан хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр хойшлуулсан нь онц хүнд зөрчилд тооцогдохгүй бол · Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Дээд шүүхийн Ерөнхийлөгчийн хууль ёсны мэдэгдэл, шийдвэрийг үндэслэлгүйгээр үл биелүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад саад учруулах · Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан шүүхийн нэрийн жагсаалтыг хэлэлцэх үүргийг зөрчсөн	
--	---	--

	· Энэ хуулийн 389 дүгээр зүйлийн 5-д заасан эрх хасуулах үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр буюу хууран мэхэлж хэрэгжүүлэх · Энэ хуулийн 221 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу Удирдах зөвлөлөөс үндэслэлгүйгээр татгалзах · Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тогтоосон жишиг үнэлгээний журмыг дагаж мөрдөлгүй шийдвэр гаргах · Хяналтын үйл ажиллагаанд саад учруулах · Энэ 427 дугаар зүйлд заасны дагуу хүчингүй болгоогүй байхад, холбогдох бичилтүүдийг хүчингүй болгох	
--	---	--

Шүүхийн органик хуулийн 417 дугаар зүйлийн 14 дэх заалт⁶⁰ нь МУШтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасан "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах" зөрчилтэй адил агуулга бүхий зохицуулалт байна. Иймд Сахилгын хорооноос Шүүхийн органик хуулийн 417 дугаар зүйлийн 14-т "*Шүүхийн үүргээ гүйцэтгэхдээ зөвтгөх боломжгүй алдаа гаргах*" гэж заасныг баримтлан шийдвэрлэсэн шийдвэрийг дэлгэрүүлж үзвэл:

⁶⁰ Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, art. 417 (14). "Unforgivable ignorance in the discharge of his judicial duties"

Шигтгээ №10. Испани Улсын Сахилгын хорооны 2020 оны 9-р сарын 29-ний өдрийн шийдвэр⁶¹

Хариуцагч шүүгч Х нь эрүүгийн хэрэг маргааныг анхан шатны шатны журмаар хянан шийдвэрлэж байх явцдаа процессын алдаа гаргасан эсэхийг Сахилгын хорооноос шалгажээ. Шүүхийн органик хуулийн 417 дугаар зүйлийн 14-т заасан зохицуулалт нь шүүгч хуулийн илэрхий тодорхой бөгөөд зөвтгөх боломжгүй байдлаар хуулийн зохицуулалтыг зөрчсөн байхыг шаарддаг ба холбогдох нотлох баримттай байх ёстой.

Мөн Испани Улсын дээд шүүх Шүүхийн органик хуулийн 417 дугаар зүйлийн 14-т заасан зохицуулалтыг "тухайн шүүхээс хэрэг маргааныг эрх зүйн үндэслэлгүй, дур зоргоороо, логикгүй байдлаар шийдвэрлэхийг хэлнэ" гэж тодорхойлжээ. Сахилгын хорооноос хэргийн нөхцөл байдлыг олон талаас нь нотлох баримттайгаар үнэлж, сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн байна.

Шигтгээ №11. Испани Улсын Сахилгын хорооны 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн шийдвэр⁶²

Хариуцагч шүүгч нь ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ ажилдаа хайнга хандаж, алдаа гаргасан байж болзошгүй гэх гомдлын дагуу Сахилгын хорооноос шалгажээ. Хариуцагч нь Өршөөлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг буруу хэрэглэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн, засгийн газарт олгогдсон эрхийг хэрэгжүүлж, хоригдлуудыг өршөөлд хамруулсантай холбоотой хэрэг маргаан юм.

Тус хэрэг маргаанд Шүүхийн тухай хуулийн 417 дугаар зүйлийн 14-т заасан зохицуулалтыг дараах үндсэн шинжээр үнэлэн тогтоосон:

- Шүүгч холбогдох журмаар хэрэг маргааныг зайлшгүй шийдвэрлэх ёстой байсан эсэх;
- Хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг процессын журмаар хатуу тогтоосон байсан эсэх;
- Хэрэг маргааныг хуулийн зарчмын дагуу тайлбарлаж, хангалттай үндэслэлтэй шийдсэн эсэх гэжээ.

Дээрх шийдвэрүүдээс үзвэл шүүгч холбогдох хэрэг маргааныг шийдвэрлэхдээ илэрхий тодорхой хэрэглэх ёстой байсан хууль, журмыг хэрэглээгүй, эсхүл холбогдох тодорхой, ойлгомжтой зохицуулалтыг хайхрамжгүйгээр илтэд үндэслэлгүй тайлбарласан бол Сахилгын хорооноос Шүүхийн органик хуулийн 417 дугаар

⁶¹ "Resumen sistematizado de resoluciones en materia disciplinaria", Poder Judicial Espana, <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/ATENCION%20AL%20JUEZ/FICHERO/20210513%20Resumen%20sistematizado%20de%20resoluciones%20CGPJ%20materia%20disciplinaria%2011.2018%2012.2020.pdf>. (Сүүлд үзсэн: 2024.12.03).

⁶² "Resumen sistematizado de resoluciones en materia disciplinaria", Poder Judicial Espana, <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/ATENCION%20AL%20JUEZ/FICHERO/20210513%20Resumen%20sistematizado%20de%20resoluciones%20CGPJ%20materia%20disciplinaria%2011.2018%2012.2020.pdf>. (Сүүлд үзсэн: 2024.12.03).

зүйлийн 14-т заасныг зөрчсөн гэж үзэн сахилгын шийтгэл оногдуулж байна.

С. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх)-ын шүүгчдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Холбооны шүүхийн тухай хууль (англ. *German Judiciary Act*)-ийн дагуу холбооны шүүгчийн сахилгын зөрчлийг зөвхөн шүүгчдээс бүрдсэн Холбооны шүүх (англ. *Federal Court of Justice*)-ийн тусгай шүүх буюу Холбооны албаны шүүх (англ. *Federal Service Court*) хянан шийдвэрлэдэг.⁶³ Ингэхдээ Холбооны сахилгын хууль (англ. *Federal Disciplinary Act*)-ийг хянан шийдвэрлэх ажиллагаандаа удирдлага болгон ашигладаг байна.⁶⁴ Харин муж улсын шүүгчийн сахилгын зөрчил, ёс зүйн асуудлыг тухайлсан хуулиар эсхүл төрийн албан хаагчдад хамаарах процессын хуулиар зохицуулах эсэх нь тухайн муж улсын хууль тогтоогчдын бүрэн эрхийн хүрээнд байна. Мөн Холбооны шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлд зааснаар муж улсын хэмжээнд Холбооны албаны шүүхтэй ижил чиг үүрэг бүхий тусгай шүүхүүдийг байгуулах эрх хэмжээг хуульчилж өгсөн. Холбооны шүүхийн тухай хуулиар нийтлэг харилцааг зохицуулсан бол муж улсын хууль илүү нарийвчилсан зохицуулалттайгаас бусдаар холбооны болон мужийн шүүгчдэд хамаарах хууль нь ижил агуулгатай.⁶⁵

Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх агуулгын хүрээнд судалбал ХБНГУ-ын Эрүүгийн хууль (гер. *Strafgesetzbuch – StGB*)-ийн 339 дүгээр зүйлд *"Шүүгч, төрийн бусад албан тушаалтан, эсхүл арбитрч нь хуулийн асуудал шийдвэрлэх явцад аль нэг талд ашигтай, эсхүл хохиролтойгоор хуулийг гажуудуулсан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хорих ял оногдуулна"* гэж заасан нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь хэсэгтэй агуулгын хувьд төстэй байж болохоор байна. Гэвч шүүгчийн дээрх үйлдэл нь ХБНГУ-д гэмт хэрэгт тооцогдох тул ердийн харьяаллын шүүх хянан шийдвэрлэдэг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 339 дүгээр зүйлд заасан "хуулийг гажуудуулсан" гэх ойлголт нь *шүүгч, эсхүл албан тушаалтан хууль зөрчин, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ санаатайгаар ноцтой алдаа гаргаж, хуулийн дагуу бус өөрийн үзэмжээр шийдвэр гаргасан тохиолдлуудыг хамарч байна*. Түүнчлэн шүүгч, албан тушаалтан

⁶³ German Judiciary Act (1972), sect. 61–62.

⁶⁴ Ibid, sec. 63.

⁶⁵ Hugo Rialland, "Judging the judiciary, responding to judicial misconduct without threatening independence," 2021 Themis competition Semi-final D • Judicial ethics and professional conduct, p. 14.

нь хуульд заасан үүргээс ухарч, аль нэг талд давуу байдал бий болгосон, эсхүл хохиролтой нөхцөл байдлыг зориуд бий болгосон үйл ажиллагаа юм. Ийнхүү **шүүн таслах ажиллагааг гажуудуулах үйлдэл нь процессын хуулийг зөрчих замаар мөн илэрч болно**. Энэ тохиолдолд процессын зөрчил нь талуудын тэнцвэртэй байдлыг алдагдуулсан буруу шийдвэр гаргах **бодит эрсдэлийг бий болгосон байх** шаардлагатай бөгөөд хэргийн оролцогчдод заавал давуу байдал бий болсон эсвэл хохирол учирсан байх албагүй юм.⁶⁶ Иймд Эрүүгийн хуулийн 339 дүгээр зүйлд заасан, хориглосон хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой шүүхээр эцэслэн хянан шийдвэрлэгдсэн хэргийг авч үзье.

Шигтгээ №12. ХБНГУ-ын Холбооны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 4 StR 149/22 дугаартай шийдвэр.⁶⁷

Бүсийн шүүхээс шүүгдэгч (шүүгч)-д шүүхийн үйл ажиллагааг гажуудуулсан гэх үндэслэлээр нийт 10 хэрэгт холбогдуулан гурван жил арван сарын хорих ял оногдуулж шийдвэрлэжээ. Шийтгэх тогтоолын дүгнэлтэд шүүгдэгч нь шүүгчээр ажиллаж байхдаа хурлын тэмдэглэлийг хуурамчаар үйлдэж, мөн хянан шийдвэрлэж байсан эрүүгийн хэргийн шүүгдэгчийг байлцуулалгүйгээр яллаж байсан. Тэрээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 275 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчиж, яллах тогтоолыг хугацаанд нь бичгээр гаргаагүй гэдгээ нуун далдлах зорилгоор ийм үйлдэл хийсэн нь хожим тогтоогдсон. Мөн бусад эрүүгийн хэргийн хувьд тэрээр шийтгэх тогтоолыг цаг тухайд нь бүрдүүлсэн мэтээр далдлах зорилгоор хууль бус тушаал, тэмдэглэл үйлдэж, эсхүл огт бүрдүүлээгүй байна. Үүнээс гадна, гэр бүлийн асуудлаарх хэрэг хянан шийдвэрлэхээс татгалзаж, холбогдох материалыг гэрийнхээ зооринд хадгалсан нь тогтоогдсон.

Тогтоогдсон үйл баримтуудаар шүүгдэгчийн үйлдлүүд нь **Эрүүгийн хуулийн 339 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хууль зөрчсөн гэсэн шаардлагыг бүрэн хангаж байна**. Учир нь **Эрүүгийн хуулийн 339 дүгээр зүйлд заасан үйлдлүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тул ерөнхийдөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай уялдуулан дүгнэх учиртай гэжээ**.

Сенатын⁶⁸ зүгээс шийтгэх тогтоолыг хянах явцад шүүгдэгчийг **"хуулийг гажуудуулах"**, "баримт бичиг хуурамчаар үйлдэх", "хадгалалтын үүргээ зөрчих" гэсэн хэргүүдэд буруутай гэж бүс нутгийн шүүхийн гаргасан дүгнэлт нь үндсэндээ хууль зүйн алдаа гаргаагүй болохыг тогтоосон. Гэсэн хэдий ч холбогдох 6 хэрэг, маргааны хувьд шүүгдэгч хуулийг гажуудуулах зөрчлөө идэвхтэй үйлдлээр бус, харин тодорхой үйлдлийг хийхгүй орхисноор үйлдсэн хэмээн өмнөх шатны шүүхээс ялгаатай дүгнэсэн.

⁶⁶ "BGH 5 StR 39/21 – Judgment of August 18, 2021 (LG Kiel)," hrr-strafrecht.de, (Сүүлд үзсэн: 2024.12.06).

⁶⁷ Bundesgerichtshof Beschluss 4 StR 149/22, <https://juris.bundesgerichtshof.de/cgi-bin/rechtsprechung/document.py?Gericht=bgh&Art=en&nr=133821&pos=0&anz=1>. (Сүүлд үзсэн: 2024.12.06).

⁶⁸ Холбооны шүүхийн шүүх бүрэлдэхүүн.

ХБНГУ-ын хувьд МУШТХ-ийн 50.1.23-т заасан "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн ..." гэх зохицуулалттай ижил шийтгэл оногдуулах үндэслэл байх боловч ХБНГУ-д энэхүү хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнд тооцдогоороо ялгаатай байна. Хуулийн илэрхий алдаа гаргасан тохиолдолд үүнийг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал шаардлагыг зөрчсөн, эсхүл хэргийн оролцогчийн үндсэн эрхийг зөрчсөн эсэхэд голчлон дүгнэлт өгч шийдвэрлэж байна.

D. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх) дахь Шүүхийн ёс зүйн байгууллагуудыг муж болгонд өөрөөр буюу комисс, зөвлөл (англ. *council, board*), шүүх, хороо гэх зэргээр өөр өөрөөр нэрлэдэг (энэ бүлэгт цаашид "комисс" гэх). Хэдий комиссууд бүгд нийтлэг чиг үүрэгтэй ч өөр өөрийн ялгарах онцлогийг агуулдаг. Зарим мужид шүүхийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд шүүхийн үйл ажиллагаанд хохирол учруулсан гэж үздэг бол бусад мужид зөрчил үйлдсэн нь тогтоогдсон ч тухайн үйлдэл нь санаатай байсан, шүүхийн үйл ажиллагаанд хохирол учруулсан эсэхийг нэмэлтээр дүгнэх шаардлагатай болдог байна.⁶⁹

Шүүгчдийг шалгаж, сахилгын арга хэмжээ авах үндэслэлийг хууль, дүрмээр заасан хэдий ч **хууль зүйн алдаатай нь холбоотойгоор сахилгын хэрэг нээн шалгах онцгой нөхцөл бий. Тухайлбал, хууль зүйн алдааг тогтмол, удаа дараа гаргасан эсэх, чухал процессын шаардлагыг үл тоомсорлосон эсэх, эсхүл хэргийн холбогдогчийн үндсэн эрхийг зөрчсөн эсэх зэрэг орно.**⁷⁰ Эдгээр хууль зүйн алдаа, процессын болон хэргийн холбогдогчийн үндсэн эрхийг зөрчсөн алдаа нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь хэсэгт заасан "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн ..." гэх зохицуулалттай ижил агуулгатай байж болохоор байна.

Дээрх хууль зүйн, процессын болон үндсэн эрхийн алдаатай холбоотойгоор Нью-Йорк мужийн Шүүхийн ёс зүйн комиссын шийдвэрийн жишээг дэлгэрүүлэн авч үзье. Нью-Йорк мужийн комиссын эрх хэмжээг мужийн үндсэн хууль болон шүүхийн тухай хуульд нь тусгаж өгсөн байх ба Шүүхийн ёс зүйг зохицуулах дүрэм (англ. *Rules Governing Judicial Conduct*)-ийн дагуу шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан гомдлыг хянан хэлэлцэх чиг үүрэг

⁶⁹ Cynthia Gray, "Judicial Conduct Commissions, How Judicial Conduct Commission work," *The justice system journal*, vol. 28, 2007, p. 406.

⁷⁰ Мөн тэнд, 408.

бүхий төрийн байгууллага юм.⁷¹

Шигтгээ №13. Нью-Йорк мужийн Шүүхийн ёс зүйн комиссын Saratoga County-ийн Гэр бүлийн шүүхийн шүүгч GILBERT L. ABRAMSON-д холбогдох шийдвэр:⁷²

Хариуцагч шүүгчийг ажил үүргээ гүйцэтгэж байх үеийн хугацаан дахь ёс зүйн зөрчлүүдэд хамаарах 2 гомдлын дагуу нийт 10 тохиолдолд холбогдуулан шалгасан. Эхний гомдлын агуулгад хариуцагч шүүгч нийт 6 тохиолдолд хэргийн оролцогчдын хүсэлт, хүндэтгэн үзэх шалтгааныг үл харгалзан сонсголд оролцох боломж олгоогүй, мөн нэг тохиолдолд хэргийн оролцогчид өмгөөлөгч авах эрхийг нь мэдэгдээгүй, уг зөрчлүүдтэй нь холбогдуулан арга хэмжээ авахыг өөрт нь мэдэгдсэн ч аваагүй гэж үзсэн. Удаах гомдлын агуулгад хариуцагч шүүгч нь хэргийн оролцогчийн өмссөн хувцасны талаар бэлгийн шинжтэй зохисгүй үг хэллэг ашигласан, дээр дурдсан мэдэгдэх захидлыг үл харгалзан ахин хоёр өөр тохиолдолд хэргийн оролцогчид өмгөөлөгч авах эрхийн талаар мэдэгдээгүй гэжээ.

Комисс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийг авч үзээд дараах дүгнэлтийг гаргасан байна:

Хариуцагч нь хууль зөрчихөөс зайлсхийх, хууль сахих, шүүхийн шударга байдал, төвийг сахисанд олон нийтийн итгэлийг хадгалахад нийцсэн байдлаар байнга ажиллах үүргээ биелүүлээгүй; шүүгчийн үүргээ төвийг сахисан, чин сэтгэлээсээ гүйцэтгэхэд шаардлагатай хуульд үнэнч байх, мэргэжлийн ур чадварыг хадгалаагүй; мөн хуулийн дагуу оролцогчдод сонсголд оролцох эрхийг хангаагүй. Хариуцагч нь Гэр бүлийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон үндсэн эрх, тэр дундаа өмгөөлөгч авах, шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг удаа дараа зөрчиж, эрх чөлөөг нь хассан. **Дээрх тохиолдлуудад хууль зүйн алдаа болон ёс зүйн зөрчил давхцаж байна.** Өмнө комиссоос эхний гомдлын дагуу сануулга бүхий мэдэгдэл хүргүүлсэн ч хариуцагч 2 жилийн дараа ижил ёс зүйн зөрчил давтан гаргасан. Иймд хариуцагчийг албан тушаалаас нь огцруулах ноцтой нөхцөл байдал үүссэн гэдгийг хүлээн зөвшөөрөв гэжээ.

АНУ-д муж бүр өөрсдийн онцлогт нийцүүлэн шүүгчийн сахилгын хэргийг сахилгын комиссоор дамжуулан хянан шийдвэрлэж байна. Ингэхдээ холбогдох хууль, дүрэмд МУШТХ-ийн 50.1.23-т заасан "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн ..." гэх зохицуулалттай ижил агуулга бүхий зохицуулалт төдийлөн байдаггүй тухай тэмдэглэжээ. Гэвч шүүгчийн хууль зүйн алдаанд холбогдуулан онцгой тохиолдлуудад сахилгын хэрэг нээн шалгаж буй жишиг тогтсон байна. Тухайлбал, чухал процессын шаардлагыг үл

⁷¹ "Overview," New York State Commission on Judicial Conduct, <https://cjc.ny.gov/General.Information/overview.html#:~:text=The%20New%20York%20State%20Commission,appropriate%2C%20renders%20public%20disciplinary%20Determinations.> (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁷² State of New York Commission on Judicial Conduct, on Gilbert L. Abramson, <https://cjc.ny.gov/Determinations/A/Abramson.Gilbert.2010.10.26.DET.pdf>. (Сүүлд үзсэн: 2024.12.05).

тоомсорлосон, эсхүл хэргийн холбогдогчийн үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэлээр шалгах, хууль зүйн алдаа нь ёс зүйн зөрчилтэй уялдаж байх зэрэг шалгуурыг тавьж байна.

Е. ПОЛЬШ УЛС

Шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой харилцааг Нийтлэг шүүхийн тогтолцооны хуулийн⁷³ 107-133а дугаар зүйлд зохицуулжээ. Тус хуулийн 107 дугаар зүйлийн 1.1-д "шүүгч нь хууль тогтоомжийг илтэд болон онц ноцтойгоор зөрчсөн"⁷⁴ гэж заасан нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах" гэж заасантай утгын хувьд адил агуулга бүхий байна.

Польш Улсын Нийтлэг шүүхийн тогтолцооны хуулийн 107 дугаар зүйлийн 1.1 дэх зохицуулалтыг хэрхэн тайлбарлаж хэрэглэх талаар Европын холбооны шүүхээс дараах байдлаар тайлбарласан байна:

Шигтгээ №14. Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7-р сарын 15 өдрийн С-791/19 дугаартай шийдвэр⁷⁵

Европын холбооны шүүхийн их танхимын хуралдаанаар Польш Улсын Нийтлэг шүүхийн тогтолцооны хуулийн 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Европын холбооны хуульд нийцэж эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэжээ.

Нийтлэг шүүхийн тогтолцооны хуулийн 107 дугаар зүйлийн 1.1-д "шүүгч нь хууль тогтоомжийг илтэд болон онц ноцтойгоор зөрчсөн" гэж заасныг Европын холбооны шүүхээс дараах байдлаар дүгнэсэн байна:

- Илтэд хууль зөрчсөн гэх агуулга нь хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй, илэрхий байдлаар хуулийг зөрчсөн үйлдлүүдийг хамруулахаар тайлбарласан байна.⁷⁶
- Хуулийг буруугаар, эсхүл хайхрамжгүй байдлаар ашиглахыг оролдсоныг хамааруулна⁷⁷ гэж тус тус тайлбарлажээ.

Эцэст нь, Европын холбооны шүүхээс Польш Улсын шүүх эрх зүйн тогтолцоонд авч хэрэгжүүлж буй энэхүү шинэчлэлд "шүүгч

⁷³ Poland act on common courts organisation, (2011).

⁷⁴ Poland act on common courts organisation, (2011), art. 107(1), 1), "an obvious and gross offence against the provisions of the law".

⁷⁵ Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн С-791/19 дугаартай шийдвэр, <https://curia.europa.eu/juris/document/document.jsf?text=&docid=244185 &pageIndex=0&doclang=EN&mode=lst&dir=&occ=first&part=1&cid=452586>. (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁷⁶ Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн С-791/19 дугаартай шийдвэрийн 141 дүгээр цогцолбороос харна уу.

⁷⁷ Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн С-791/19 дугаартай шийдвэрийн 144 дүгээр цогцолбороос харна уу.

нь хууль тогтоомжийг илтэд болон онц ноцтойгоор зөрчсөн" гэх зохицуулалт нь **шүүгчдийн хараат бус байдлыг алдагдуулах эрсдэлтэй гэж дүгнэсэн**⁷⁸-ийг дурдах нь зүйтэй.

2.3. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү хэсэгт МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1–50.1.40 дэх хэсэгт заасан үндэслэлүүдээс хэргийн оролцогч, илтгэгч гишүүн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний хамгийн түгээмэл ашигласан 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.18, 50.1.20, 50.1.27 дахь заалтуудыг үндэслэн шийдвэрлэсэн магадлалд дүн шинжилгээ хийнэ.

2.3.1. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.1 ДЭХ ЗААЛТ

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д шүүгч *"албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох"*-ыг хориглох бөгөөд хэрэв тус заалтыг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан 558 магадлалаас МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан зохицуулалттай холбоотойгоор шийдвэрлэсэн **нийт 71** магадлал байх бөгөөд дүн шинжилгээ хийж үзэхэд тухайн хэргүүд нь:

1) шүүгч нотлох баримтын шаардлага хангаагүй баримтыг үнэлсэн, шүүх хуралдаанд хөтөлж асуусан, шүүх хуралдааны тэмдэглэлд хэлсэн үгийг оруулаагүй, магадлалын хянавал хэсэгт огноо засварлаж бичсэн;

2) шүүгч шүүхийн шийдвэрийн үндэслэлээ огт тайлбарлаагүй, шийдвэр уншиж танилцуулснаас зөрүүтэй бичигдсэн;

3) шүүгч шүүх хуралдааныг даргалж явуулахдаа илт нэг талыг барьж, нэг талын байр суурийг хамгаалсан, 2 талын тайлбарыг сонсож мэтгэлцэх бололцоо өгөөгүй, шүүх хуралдаан эхлэхээс өмнө шийдвэрээ гаргасан байсан;

4) шүүгч нь илт басамжилсан биеийн хэлэмж үзүүлж, жуумалзаж инээсэн, гар утсаа нэг бус удаа оролдсон, маш бага хугацаагаар буюу гомдлыг бүрэн танилцуулах боломжгүй хугацааг санаатайгаар тогтоосон хэр нь уг хугацаанд өмгөөлөгчдийн тайлбарыг сонсолгүй нарийн бичгийн даргатай харилцан ярилцах зэргээр хүндэтгэлгүй хандаж байсан;

⁷⁸ Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн С-791/19 дугаартай шийдвэрийн 157 дугаар цогцолбороос харна уу.

5) шүүгч холбогдогчид хууль сануулсан хэр нь хохирогчид хууль сануулахгүйгээр ялгаварлан гадуурхаж хандсан зэрэг гомдлоор үүсжээ.

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан зохицуулалттай холбоотойгоор шийдвэрлэсэн магадлалуудын тухайд дийлэнх тохиолдолд ШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан зөрчилд ямар үйлдлүүд хамаарах, тус заалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар тайлбар өгөөгүй бөгөөд шүүгчийн үйлдэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд нийцсэн эсэх талаар дүгнэлтүүдийг хийжээ.

ШСХ-ны 2023.04.28-ны өдрийн 62 дугаартай магадлал⁷⁹

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д "Шүүх хуралдааныг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилсон шүүгч даргална", 81.2-т "Шүүх хуралдаан даргалагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, хэргийн болон бусад оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авна" гэж заасан бөгөөд даргалагч шүүгч нь хэргийн оролцогчдоос ямар асуулт асуух нь түүнд хуулиар олгосон бүрэн эрх.

Сахилгын хэрэгт нотлох баримтаар авагдсан 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэл болон дуу, дүрсний бичлэгээс үзэхэд шүүгч С.Г нь тухайн шүүх хуралдааныг дэгийн дагуу удирдан явуулж, нэхэмжлэгч болон хариуцагч талаас ээлжлэн нөхцөл байдлыг тодруулан асууж, тайлбар гаргах эрхээр бүрэн хангасан, мэтгэлцэх боломжийг олгосон гэж илтгэгч гишүүний дүгнэсэн нь үндэслэлтэй байх ба шүүгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодруулах шаардлагаар хэргийн оролцогчдын маргаж байгаа болон маргахгүй байгаа нөхцөл байдлыг тогтоох нь хуульд нийцнэ.

Иймд "та нар газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй нь үнэн үү", "та нар газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүйгээ хүлээн зөвшөөрч байна уу?" гэж хэд хэдэн удаа асуусныг нэг талд үйлчилсэн, урьдчилан шийдвэрээ гаргасан гэж дүгнэх үндэслэл болохгүй, МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.4, 50.1.20-д заасан зөрчил гэж үзэх боломжгүй.

2.3.2. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.18 ДАХЬ ЗААЛТ

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18-д шүүгч "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах"-ыг хориглох бөгөөд хэрэв тус заалтыг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна.

⁷⁹ ШСХ-ны 2023 оны 04 сарын 28-ны өдрийн 62 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/306.

2021.01.05-ны өдрийн УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалттай холбоотой тухайлан санал болон тайлбар гараагүй байдаг.

Тус судалгааны хамрах хугацаанд буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтыг үндэслэж шийдвэрлэсэн нийт **11** магадлал байх бөгөөд үүнээс хоорондоо төсөөтэй болон судалгаанд ач холбогдолтой гэж үзсэн дараах 4 магадлалыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Шүүгч Б.А-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2022.06.27-ны өдрийн 205 дугаартай магадлал⁸⁰

Магадлалд дурдсанаар шүүгч Б.А нь өөрийн хянан шийдвэрлэж буй хэргийн оролцогч болох Б.Б-тэй утсаар **холбогдож** "...чамтай эмэгтэй хүний ёсоор уулзмаар байна..." гэх зэргээр **ярьсан нь** Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.18-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах" гэж заасан сахилгын зөрчил гаргасан гэж үзэж бүрэлдэхүүн үзэж "шүүгчийн бүрэн эрхийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах" сахилгын шийтгэл оногдуулжээ. Ингэхдээ **"харилцах" гэснийг Монгол хэлний тайлбарт хүмүүс хоорондоо аливаа хэлбэрээр холбоо барихыг хэлнэ** гэж тайлбарласнаас үзвэл **холбогдох шүүгч нь ... нь дээрх хуулийн хэргийн оролцогчтой харилцах гэх заалтад хамаарч байна.** гэх дүгнэлтийг хийсэн байна.

Холбогдох шүүгч дээрх магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргаж, сахилгын хэргийг хянан үзэх хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дугаар хянан үзэх хуралдааны тогтоолоор шүүгч Б.А-н гаргасан зөрчлийн шинж чанар, хэр хэмжээ, анх удаа зөрчил гаргасныг тус тус харгалзан магадлалын 1 дэх заалтын "шүүгчийн бүрэн эрхийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах" гэснийг "нээлттэй сануулах" гэж өөрчилж, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

⁸⁰ ШСХ-ны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 111 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/393.

2. Шүүгч Ц.М-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2022.06.29-ний өдрийн 210 дугаартай магадлал⁸¹

Өргөдөл гаргагч Н.Д нь шүүгч Ц.М-д холбогдуулан шүүгч хэргийн нөгөө тал болох Б.О-той 15 цаг 15 минутад завсарласан өмнөх шүүх хуралдаан, 15 цаг 30 минутад эхлэх дараагийн шүүх хуралдааны хооронд уулзсан гэх агуулгаар өргөдөл гаргасан. Илтгэгч гишүүн холбогдох шүүгч Ц.М-ийг өмнөх шүүх хуралдаан дуусаж, дараагийн шүүх хуралдаан орох хүртэл хугацаанд **танхимд үлдэж хэргийн нөгөө талтай уулзсан болох нь гэрчүүдийн мэдүүлгээр тогтоогдсон** тул МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтад заасан зөрчил гаргасныг нотлох дүгнэлт үйлдсэн байна.

Харин ШСХ нь магадлалын үндэслэлдээ "... Өмнөх шүүх хуралд оролцсон хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.О- болон шүүгч Ц.М- нар нь эхний шүүх хуралдаан дуусахад буюу хуралдааны танхимаас гарах явцад таарсан гэх үйл баримт тогтоогдож байх бөгөөд энэ талаар өргөдөл гаргагч, шүүгч, гэрч,нар маргаагүй боловч тогтоолд дурдсанчлан шүүгч Ц.М- нь хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.О-той **ямар хугацаанд уулзсан, уулзахдаа хэрэг маргааны талаар ярилцсан талаарх үйл баримт** сахилгын хэрэг шалгах ажиллагааны явцад **нотлогдоогүй** байна." гэж дүгнээд илтгэгч гишүүний нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

⁸¹ ШСХ-ны 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 210 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/227.

3. Шүүгч Д.Б-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2024.06.20-ны өдрийн 76 дугаартай магадлал⁸²

Өргөдөл гаргагч Л.М-с шүүгч шүүгч Д.Б-д холбогдуулан ШСХ-нд гаргасан өргөдөлдөө шүүх хуралдаанд орсны дараа шүүгч өрөөндөө дуудан оруулан танай "...бэр чинь Т.Ц хоёр уяач, уяачийн малчин хоёртой хамт амьдардаг завхайраад хэвтэж байдаг шүү дээ..." гэх зэрэг зүйлсийг хэлсэн гэжээ. Гэрчүүдийн мэдүүлгүүдээр холбогдох шүүгч "...С.О болж бүтэхгүй хүнтэй нийлээд байна", "битгий нийлүүл", "мөнгө төгрөг хамт залилаад авсан юм биш биз дээ" гэх зүйлс ярьсан болох нь тогтоогдсон хэдий ч "танай бэр чинь Т.Ц хоёр уяач, уяачийн малчин хоёртой хамт амьдардаг завхайраад л хэвтэж байдаг шүү дээ" гэх агуулга бүхий зүйл ярьсан нь гэрч нарын мэдүүлгүүдээр тогтоогдоогүй тул холбогдох шүүгчийг МУШТХ 50 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил гаргасан гэж үзэх боломжгүй гэж илтгэгч гишүүн дүгнэжээ.

ШСХ нь "Тухайн уулзалтаар н.Ц гэх иргэн холбогдох шүүгч болон нэр бүхий прокурорын нэрийг барьж шүүгдэгч М.А-ийн ар гэрээс мөнгө нэхсэн үйлдэл болсон эсэх талаар асууж, залилах гэмт хэргийн хохирогч болж болзошгүйг тайлбарласан байх бөгөөд өргөдөлд бичсэн "шүүгдэгчийн эхнэрийн талаар шүүгч ярьсан" гэх үг тус уулзалтын тэмдэглэлд тусгагдаагүй, гэрч нарын мэдүүлгүүдээр тогтоогдоогүй ... тул шүүгчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.36-д заасан сахилгын зөрчил гаргасан гэж үзэх боломжгүй... Сахилгын хэргийн шалгах ажиллагааны явцад хэрэгт авагдсан баримт буюу уулзалтын тэмдэглэл, нөлөөллийн мэдүүлэг, шүүгчээс ... Прокурорын газар гаргасан гомдол зэргээс үзэхэд эрүүгийн **хэргийг хянан шийдвэрлэхэд шууд хамаарал бүхий асуудлаар бус** шүүгдэгчийн өмгөөлөгчөөс өгсөн мэдээллийн дагуу **гэмт хэргийн шинжтэй үйл баримт болсон эсэхийг тодруулахаар хэргийн оролцогч бус этгээд болох шүүгдэгчийн ар гэрийнхэнтэй уулзсан** энэхүү үйл баримт нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18-т "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах" гэж заасанд хамаарахгүй" гэж дүгнэжээ.

⁸² ШСХ-ны 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 76 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision/full/516>.

4. Шүүгч Д.Ч-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2024.03.28-ны өдрийн 35 дугаартай магадлал⁸³

Өргөдөл гаргагч Б.У нь шүүгч Д.Ч-д холбогдуулан "... таслан сэргийлэх арга хэмжээний хурлын явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүх хуралдааны нийтлэг журмыг баримтлаагүй, ... шүүх хуралдааны явцад прокуророос бичсэн саналыг шүүгчээс яахаараа ерөнхий ангийн заалтыг журамладаг юм гэх зэргээр таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох хурал хэлэлцэж байж гэм буруугийн шүүх хуралдаанд оролцож байгаа мэтээр асуулт асууж прокурортой дээрэнгүй, ёс зүй байхгүй, өндөр дуугаар хандсан, ...мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийг прокурорт буцааж өгөхгүйгээр өөрийн албан өрөө рүү авч явсан, ... шүүгч рүү залгаж хэргээ авъя гэхэд уурлаж дээрэнгүй үйлдэл гаргасан, ... шүүх хурлын явцад болон хурлын дараа прокурортой ёс зүйгүй өндөр дуугаар хандсан" гэх агуулга бүхий өргөдөл гаргажээ. Илтгэгч гишүүн болон ШСХ-ны бүрэлдэхүүн нь гэрч нарын мэдүүлэг, сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтуудыг үндэслэн холбогдох шүүгч сахилгын зөрчил гаргасан үйл баримт тогтоогдоогүй гэж үзсэн.

Харин тус магадлалд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтыг дараах байдлаар **тайлбарласан байна**. Тодруулбал, "...МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах"-ыг шүүгчид шууд хориглосон байдаг тул шүүгчийн хянан шийдвэрлэж буй хэргийн оролцогчид тус шүүгчтэй **гар утсаар харилцах, уулзах үйлдэл нь хуульд нийцэхгүй болохыг тайлбарлах нь зүйтэй...**" гэжээ.

Дээрхээс дүгнэхэд, 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 111 дүгээр магадлалд холбогдох шүүгчийн **утсаар ярьсан үйлдэл** нь МУШТХ-ийн 50.1.18 дахь заалтыг зөрчсөн гэж үзээд сахилгын шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн бөгөөд ингэхдээ Монгол хэлний тайлбарыг дурдсан байна. Харин 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 210 дугаар магадлалд илтгэгч гишүүн нь холбогдох шүүгчийг хэргийн нэг талтай уулзсан болох нь тогтоогдсон тул сахилгын зөрчил гаргасан гэж үзэж, нотлох дүгнэлт үйлдсэн. Гэвч ШСХ-ноос холбогдох шүүгч **хэргийн нэг талтай ямар хугацаанд уулзсан, уулзахдаа хэргийн талаар ярилцсан эсэх нь тогтоогдоогүй** гэх үндэслэлээр сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, 111 дүгээр магадлалд холбогдох шүүгч хэргийн оролцогчтой **холбоо тогтоосон үйлдэл хийсэн нь сахилгын зөрчилд хамаарахаар дүгнэсэн** бол 210 дугаар магадлалд холбогдох шүүгч хэргийн нэг талтай холбоо тогтоохдоо **хэрэг, маргааны талаар ярилцсан эсэх** буюу тухайн **харилцааны агуулга** дээр үндэслэн сахилгын зөрчил гаргаагүй гэж дүгнэжээ.

⁸³ ШСХ-ны 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 35 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/472.

Мөн 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 76 дугаар магадлалаар холбогдох шүүгч хэргийн оролцогчийн гэр бүлийн хүмүүсийг өрөөндөө дуудан хэргийн оролцогч буюу шүүгдэгчтэй холбоотой зүйл ярьсан хэдий ч **тухайн хянан шийдвэрлэж буй хэргийн талаар яриагүй** бөгөөд хэргийн оролцогчтой бус түүний хамаарал бүхий хүмүүстэй уулзсан тул МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь хэсэгт заасан сахилгын зөрчил гаргаагүй гэж шийдвэрлэжээ. Тодруулбал, **харилцааны агуулга нь тухайн шүүгчийн хянан шийдвэрлэж буй хэрэгт хамааралгүй байсан** тул сахилгын зөрчил гаргасан гэж үзээгүй байна.

Харин 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 35 дугаар магадлалд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтын "... хэргийн нэг талтай уулзах, харилцах" гэх зөрчилд **тайлбар** хийжээ. Үүнд: "... "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах"-ыг шүүгчид шууд хориглосон байдаг тул шүүгчийн хянан шийдвэрлэж буй хэргийн оролцогчид тус шүүгчтэй **гар утсаар харилцах, уулзах үйлдэл** нь хуульд нийцэхгүй болохыг тайлбарлах нь зүйтэй..." гэсэн байна. Өөрөөр хэлбэл, **шүүгчтэй харилцаа үүсгэсэн л бол тус сахилгын зөрчил гаргасанд тооцох буюу хуульд нийцэхгүй үйлдэл хийсэн** гэх агуулгаар тайлбарласан бөгөөд шүүгч хэргийн нэг талтай уулзахдаа хянан шийдвэрлэж буй хэрэг, маргааны талаар ярилцсан эсэх нь тус зөрчлийн шинжид хамаарах эсэх талаар тайлбартаа дурдаагүй байна.

Үүнээс үзэхэд, МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтад заасан "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах" гэх **зөрчлийн шинжийг тодорхойлохдоо** ШСХ нь шүүгч хэргийн нэг талтай, нөгөө талыг байлцуулахгүйгээр **"уулзах"**, эсхүл **"харилцах" үйлдлийг хийснээр** сахилгын зөрчил үйлдсэнд тооцох, эсхүл **"уулзах", "харилцах" үйлдлийг хийсэн хэдий ч хэргийн талаар ярилцсан** гэх үйл баримт тогтоогдсон байх гэж харилцан адилгүй дүгнэлт хийжээ.

2.3.3. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.20 ДАХЬ ЗААЛТ

Тус судалгааны хамрах хугацаанд буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан нийт магадлалуудыг нэг бүрчлэн уншиж хайлт хийж үзэхэд, МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад холбогдох **49** магадлал олдож, тэдгээрт дүн шинжилгээ хийв.

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад "хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх"-ийг хориглож, зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Тус зохицуулалтын нөхцөлд заасан хэсгийг задалж үзвэл, 1) шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, 2) шүүх хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх эс үйлдэхүй нь сахилгын зөрчилд хамаарахаар байна.

ШСХ-оос МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад үндэслэж хянан шийдвэрлэсэн 49 магадлалыг авч үзвэл, **46** тохиолдолд илтгэгч гишүүний саналыг хүлээн авч сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, **2** тохиолдолд илтгэгч гишүүний нотлох дүгнэлтийг хүлээн авч сахилгын шийтгэл оногдуулж, **1** тохиолдолд нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Хууль хэрэглээний хувьд ШСХ нийтлэг байдлаар "гомдолд дурдсан үйл баримт тогтоогдсон эсэх", "тогтоогдсон үйл баримт "зүй бус авирласан"-д хамаарах эсэх" талаар дүгнэлт хийх буюу тухайн сахилгын зөрчлийг тайлбарлаж, зүйлчлэл хийхгүйгээр сахилгын хэргийг шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

Дүн шинжилгээнд хамаарах 49 магадлалын 24 магадлалд, ШСХ шүүх хуралдааны дуу дүрсний бичлэг, мэдүүлэг зэрэгт үзлэг хийж, гомдол гаргагчийн дурдсан холбогдогч шүүгчийн зүй бус үйлдэл тогтоогдсон эсэхэд дүгнэлт хийсэн байна. Тухайлбал, "... шүүх хуралдааны дуу, дүрсний бичлэгт хийсэн үзлэг, гэрчийн мэдүүлэг зэргээс үзэхэд шүүгч хэргийн оролцогчийг загнасан, зандарсан, сүрдүүлсэн, зүй бус харьцсан болон сахилгын зөрчил гаргасан гэх байдал тогтоогдохгүй байна" гэх байдлаар дүгнэсэн байна. Мөн "зүй бус авирлах" гэдэгт ямар үйлдэл хамаарах эсэхэд дүгнэлт хийгээгүй байх ба гомдолд дурдсан бүх үйлдлийг (чанга дуугаар захирч харьцах, зандрах, сүрдүүлэх, доромжлох, яриа таслах, биеийн хэлэмж, үйлдэл, дохио зангаа гэх мэт) дуу дүрсний бичлэгээс шалгасан байна.

23 магадлалд, ШСХ үзлэгээр тогтоогдсон "чанга дуугарах, загнах, доромжлох, сүрдүүлэх" зэрэг гомдол гаргагчийн дурдсан үйл баримт сахилгын зөрчилд хамаарах эсэх асуудалд дүгнэлт хийжээ. Тухайлбал, холбогдогч шүүгч "зүгээр энгийн тооноор, ярьдгаараа ярь, ойлгосон

уу" гэх мэт үг ашигласныг ШСХ хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хуралдааны дэг сахиулах даргалагчийн үүрэгтэй холбон тайлбарлажээ.⁸⁴ Түүнчлэн холбогдогч шүүгчийн үйлдэл зохисгүй байгаа боловч **"ноцтой биш"**⁸⁵ гэж үзсэн магадлал тус тус байна.

Үлдэх 3 магадлалд, гомдлын агуулгад МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтыг дурдсан байх боловч ШСХ тухайн зөрчилтэй холбоотой дүгнэлт, тайлбар хийгээгүй байна.

Дээр дурдсан 49 магадлалаас сахилгын зөрчлийг тайлбарлаж, зүйлчлэл хийсэн **7** магадлал байх ба ШСХ нийтлэг байдлаар буюу 6 магадлалд **"зүй бус авирлах гэдэгт энгийн үг хэллэгээс өөр үг хэллэг хэрэглэж илтэд бүдүүлэг, догшин зан ааш гаргахыг ойлгоно"** гэж дүгнэлт хийжээ:

ШСХ-ны 2022.02.23-ны өдрийн 83 дугаартай магадлал⁸⁶:

"... Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.20-д "хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, ..." гэснийг **энгийн үг хэллэгээс өөр үг хэллэг хэрэглэж илтэд бүдүүлэг, догшин зан ааш гаргахыг ойлгохоор байх** ба Монгол хэлний их тайлбар тольд "зүй бус" гэдгийг **"жам ёсноос гадуур"** гэж, "авир" гэдгийг "хүний зан ааль аашлах ерөнхий байдал" гэж тайлбарласантай харьцуулбал **шүүгч чанга дугаар зандрангуй байдалтай харьцсаныг "зүй бус авирласан" зөрчил гаргасан гэж үзэх боломжгүй**. Иймд шүүгч Д.А-т холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргах нь зүйтэй" гэж илтгэгч гишүүн дүгнэснийг ШСХ хүлээн авсан байна.

ШСХ-ны 2022.04.19-ний өдрийн 150 дугаартай магадлал⁸⁷:

"... Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.20-д "хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, ..." гэснийг **энгийн үг хэллэгээс өөр үг хэллэг хэрэглэж илтэд бүдүүлэг, догшин зан ааш гаргахыг ойлгохоор байх** ба Монгол хэлний их тайлбар тольд "зүй бус" гэдгийг "жам ёсноос гадуур" гэж, "авир" гэдгийг "хүний зан ааль аашлах ерөнхий байдал" гэж тайлбарласантай харьцуулбал шүүгч **"муухай санагдаж байна"** гэж хэлсэн нь хэдийгээр тохиромжтой үг хэллэг биш ч **"зүй бус авирласан" гэх зөрчилд тооцогдохгүй байна**" гэж ШСХ дүгнэсэн байна.

⁸⁴ ШСХ-ны 2022.04.19-ний өдрийн 151 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/137, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁸⁵ ШСХ-ны 2023 оны 6 сарын 04-ний өдрийн 63 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/497, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁸⁶ ШСХ-ны 2022 оны 02 сарын 23-ны өдрийн 83 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/46, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁸⁷ ШСХ-ны 2022 оны 4 сарын 19-ний өдрийн 150 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/200, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

ШСХ-ны 2023.06.29-ний өдрийн 98 дугаартай магадлал⁸⁸:

"...Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.20-д "хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, ..." гэснийг **энгийн үг хэллэгээс өөр үг хэллэг хэрэглэж илтэд бүдүүлэг, догшин зан ааш гаргахыг ойлгохоор байх** ба Монгол хэлний их тайлбар тольд "зүй бус" гэдгийг **"жам ёсноос гадуур"** гэж, "авир" гэдгийг **"хүний зан аал аашлах ерөнхий байдал"** гэж тайлбарласантай харьцуулбал шүүгчийн ярианы өнгө, дууны түвшний хувьд өндөр дуугаар харьцсаныг "зүй бус авирласан" зөрчил гаргасан гэж үзэх боломжгүй,

... сахилгын хэрэгт цугласан баримт, гэрчийн мэдүүлгүүдээр шүүгч Б.Г нь прокурор Б.Э-тэй утсаар ярихдаа **зүй бус утга, агуулгатай үг хэллэг** хэрэглэсэн гэх байдал тогтоогдохгүй байна" гэжээ.

Харин 1 магадлалд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад заасан зөрчилд "амаар гаргаж буй тайлбар таслах, хөтөлсөн асуулт асуух, тайлбар хэлэх эрхийг хязгаарласан, ялгамжтай хандсан, хэргийн оролцогчийн аливаа үг, үйлдэлд дургүйцэл илэрхийлэх" зэрэг үйлдлүүд хамаарна гэж тайлбарлаж шийдвэрлэсэн байна.⁸⁹ Тодруулбал, **ШСХ тухайн дурдсан үйлдлүүдийг шүүгчийн төвийг сахих байдалд харшилж, шүүхийн шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан гэж үзэж, холбогдогч шүүгчийг "зүй бус авирласан" зөрчил гаргасан гэж дүгнэсэн байна.**

Дээрх хэсгийг дүгнэвэл, ШСХ-оос МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ нийтлэг байдлаар хэргийн үйл баримтыг сахилгын зөрчилд хамаарах эсэх талаар дүгнэлт хийсэн байх ба "зүй бус авирлах" гэдэгт энгийн үг хэллэгээс өөр үг хэллэг хэрэглэж илтэд бүдүүлэг, догшин зан ааш гаргахыг ойлгоно гэж тайлбарласан байна.

2.3.4. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.26 ДАХЬ ЗААЛТ

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26 дахь хэсэгт "шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих" гэж заажээ.

Хүндэтгэн үзэх шалтгааныг олон улсад "reasonable excuse", "justifiable important reason" гэх зэргээр томьёолдог. Харин монгол хэлний эрх зүйн толь бичигт "хуулийн эх бичвэрийн холбогдох

⁸⁸ ШСХ-ны 2023 оны 6 сарын 29-ний өдрийн 98 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/432, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁸⁹ ШСХ-ны 2023 оны 4 сарын 05-ны өдрийн 49 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/362, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

заалтын утга санаанд анхаарал хандуулах боловч хүндээр өвчилсөн, өвчтэй хүн асарсан, томилолтоор гадаад ба дотоодод ажилласан, сургалтад хамрагдсан, хорио цээр тогтоогдсон, гэнэтийн осолд орсон болон эдгээртэй адилтган үзэх бусад нөхцөл байдлыг хамааруулан үзнэ" гэж тайлбарлажээ⁹⁰.

Тус судалгааны хамрах хугацаанд буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26 дахь заалтыг үндэслэж шийдвэрлэсэн нийт **20** магадлал байх бөгөөд үүнээс хоорондоо төсөөтэй болон судалгаанд ач холбогдолтой гэж үзсэн дараах 2 магадлалыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

1. Шүүгч Д.У-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2022.05.04-ний өдрийн 174 дугаартай магадлал⁹¹

Шүүгч Д.У нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26-д заасан зөрчил үйлдсэн гэх сахилгын хэрэгт холбогджээ. ШСХ нь "... Сахилгын хэрэгт авагдсан баримтаар шүүгч Д.У- нь шүүхийн шийдвэр гаргах хугацааг 71 хоногоор хэтрүүлэхдээ хүндэтгэн үзэх шалтгаантай байсан гэх байдал тогтоогдоогүй тул түүнийг сахилгын зөрчил гаргасан гэж үзнэ..." гэж үзээд "бүрэн эрхийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах" сахилгын шийтгэл оногдуулжээ. Холбогдох шүүгч нь сахилгын хороонд гаргасан тайлбартаа тус шүүхийн шүүгчийн орон тоо дутуу, ажлын ачаалал өндөр, шүүгчийн туслах ажлаа хаяж явсан гэж тайлбарласан. ШСХ-ноос энэ нь тухайн шүүхийн тамгын газар, шүүгчийн ажлын зохион байгуулалттай холбоотой тул хүндэтгэн үзэх шалтгаанд хамаарахгүй бөгөөд мөн холбогдох шүүгч нь эрүүл мэндийн шалтгаантай байсан гэж тайлбарласан боловч баримтаар тогтоогдоогүй гэжээ.

Холбогдох шүүгч магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргасан бөгөөд ШСХ-ны хянан үзэх хуралдаанаар тус гомдлыг хэлэлцэн гомдлыг хангахаас татгалзаж, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

/Жич: Холбогдох шүүгч Д.У-д өмнө 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар магадлал, 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тус тус сахилгын шийтгэл оногдуулж байсан тухай дээрх 174 дугаар магадлалд дурдсан хэдий ч тус шийдвэрүүд нь хүчин төгөлдөр болсон эсэх, сахилгын шийтгэл оногдуулахдаа уг нөхцөл байдлыг харгалзаж үзсэн эсэх талаар ШСХ дүгнэлт хийгээгүй болохыг онцлох нь зүйтэй./

⁹⁰ Содовсүрэнгийн Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2015), 575 дахь тал.

⁹¹ ШСХ-ны 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 174 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision/full/237>.

2. Шүүгч Д.У-д холбогдох сахилгын хэрэг:

ШСХ-ны 2022.06.27-ны өдрийн 205 дугаартай магадлал⁹²

Өргөдөл гаргагч Д.Ш нь шүүгч Д.У-д холбогдуулан шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд бичгээр гаргахгүй удааж байгаа нь өмчлөгчийн эрхийг зөрчиж байх тул хариуцлага тооцож өгнө үү гэх агуулгаар ШСХ-нд өргөдөл гаргажээ. ШСХ-ноос холбогдох шүүгч Д.У нь хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс хойш 5 сар гаруй буюу 173 хоногийн хугацаагаар хэтрүүлсэн нь тогтоогдсон бөгөөд холбогдох шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгаан байгаа эсэх талаар тайлбар, нотлох баримт ирүүлээгүй тул "цалингийн хэмжээг гурван сарын хугацаанд 20 хувиар бууруулах" сахилгын шийтгэл оногдуулжээ.

Холбогдох шүүгч магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргасан бөгөөд ШСХ-ны хянан үзэх хуралдаанаар тус гомдлыг хэлэлцэн магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр илтгэгч гишүүнд буцаан шийдвэрлэсэн байна.

Дээрхээс дүгнэвэл, 2022.05.04-ний өдрийн 174 дүгээр магадлалаар холбогдох шүүгч нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.26 дахь заалтыг зөрчиж, шийдвэр гаргах хугацааг **71 хоног** хэтрүүлсэн тул **"бүрэн эрхийг гурван сарын хугацаанд түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах"** сахилгын шийтгэл оногдуулсан. Харин 2022.06.27-ны өдрийн 205 дугаар магадлалаар холбогдох шүүгч нь мөн МУШТХ-ийн 50.1.26 дахь заалтыг зөрчиж шийдвэр гаргах хугацааг **173 хоног** хэтрүүлсэн тул **"цалингийн хэмжээг гурван сарын хугацаанд 20 хувиар бууруулах"** сахилгын шийтгэл оногдуулжээ. Дээрх 2 тохиолдолд холбогдох шүүгч нар хугацаа хэтрүүлсэн нь **хүндэтгэн үзэх шалтгаантай байсан эсэх нь нотлогдоогүй** бөгөөд өмнө сахилгын **зөрчил гаргаж байсан эсэх нь хүчин төгөлдөр ШСХ-ны шийдвэрээр тогтоогдоогүй** /174 дүгээр магадлалын тухайд дээр жич дурдсан болно/ зэрэг ижил нөхцөлтэй хэдий ч ШСХ-ны оногдуулсан сахилгын шийтгэлийн хэмжээ нь харилцан адилгүй байна.

2.3.5. МУШТХ-ИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.1.27 ДАХЬ ЗААЛТ

МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.27 дахь заалтад **"шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон"** тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан нийт магадлалуудыг нэг бүрчлэн уншиж хайлт хийж үзэхэд, МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.27 дахь заалтад холбогдох **нийт 4** магадлал олдож, тэдгээрт дүн шинжилгээ хийв.

⁹² ШСХ-ны 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 205 дугаартай магадлал, <https://judiscom.mn/site/decision/full/190>.

ШСХ-ны 2022.02.14-ний өдрийн 60 дугаартай магадлал⁹³:

"... Шүүх хэрэгт цугларсан нотлох баримтуудаас шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн харилцааг зохицуулсан хуулийн заалтад нийцүүлэн **тайлбарлаж, хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгснөөр шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангадаг** бөгөөд ийнхүү хууль зүйн дүгнэлт огт хийгээгүйг **дээд шатны шүүх тогтоосон тохиолдолд** Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.27-д "шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон" гэж заасан зөрчил болно,

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 2021/ШЦТ/432 дугаар шийтгэх тогтоолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 3-т заасан шийтгэх тогтоолын **тодорхойлох хэсэгт тусгах зайлшгүй шаардлагатай үндэслэлүүдээс** 3.5-д "гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэрэгсэхгүй болгох, эсхүл хэлэлцэхгүй орхих тухай үндэслэл", 36.8 дугаар зүйлийн 1-д заасан шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт тусгах зайлшгүй шаардлагатай үндэслэлүүдээс 1.7-д "гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орхих үндэслэл" гэж заасныг зөрчсөн, **бусад үндэслэлийн талаар хууль зүйн дүгнэлт хийсэн байна. Иймд "шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй..."** гэж үзэх боломжгүй" гэжээ.

ШСХ-ны 2023.01.11-ний өдрийн 11 дугаартай магадлал⁹⁴:

"... шүүх хэрэгт цугларсан нотлох баримтуудаас шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн харилцааг зохицуулсан хуулийн заалтад нийцүүлэн **тайлбарлаж, хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгснөөр шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангадаг бөгөөд** ийнхүү хууль зүйн дүгнэлт огт хийгээгүйг **дээд шатны шүүх тогтоосон тохиолдолд** дээрх хуульд заасан зөрчил болно" гэжээ.

ШСХ-оос "дээд шатны шүүх тогтоосон" гэх нөхцөлийг дээрх тайлбараас ялгаатай шийдвэрлэсэн магадлалын жишээ:

⁹³ ШСХ-ны 2022 оны 02 сарын 14-ний өдрийн 60 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/66, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

⁹⁴ ШСХ-ны 2023 оны 01 сарын 11-ний өдрийн 11 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/280, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

ШСХ-ны 2023.02.15-ны өдрийн 28 дугаартай магадлал⁹⁵:

"...Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1136 дугаар захирамжийг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 1297 дугаар магадлалаар хүчингүй болгож, хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр дахин шийдвэрлүүлэхээр буцаахдаа "... **шүүгчийн захирамж хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй**, ... прокурорт буцаасан нь хууль зүйн үндэслэлгүй" гэж дүгнэсэн нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.27-д заасан "шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон" гэх **зөрчилд хамаарахгүй**,

... шүүх хэрэгт цугларсан нотлох баримтуудаас шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа баримтыг тал бүрээс нь **бүрэн бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн харилцааг зохицуулсан хуулийн заалтад нийцүүлэн тайлбарлаж, хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгснөөр шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангадаг** бөгөөд ийнхүү хууль зүйн дүгнэлт огт хийгээгүйг **дээд шатны шүүх тогтоосон тохиолдолд** дээрх хуульд заасан зөрчил болно" гэжээ.

Дээрх магадлалаас үзвэл, ШСХ нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.27 дахь заалтыг тайлбарлаж, хэрэглэхдээ "дээд шатны шүүх тогтоох" нөхцөлийг шалгаж тогтоохоос илүүтэйгээр "шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий" байх шалгуурыг хангасан эсэхэд түлхүү анхаарч байгаа нь ажиглагдлаа. Мөн "шүүгч нотлох баримтыг үнэлж, тэдгээрт үндэслэж шийдвэр гаргасан" нь сахилгын хариуцлага тооцох үндэслэл болохгүй гэж дүгнэж хэргийг шийдвэрлэсэн тохиолдлууд байв.

Дээрх хэсгийг дүгнэвэл, ШСХ-ноос МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.27 дахь заалтыг хэрэглэхдээ "шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага хангасан эсэх асуудлыг дээд шатны шүүх тогтоосон эсэх" тухай дүгнэлт хийж, нэгдмэл байдлаар хэрэглэж байгаа нь ажиглагдлаа. Мөн ШСХ-ноос тус зөрчлийг зүйлчлэхдээ шүүхийн шийдвэрт зайлшгүй тусгах шаардлагатай үндэслэлүүдээс дутуу тусгасан тохиолдолд "огт бичээгүй" гэх нөхцөлийг хангахгүй талаар дүгнэсэн байгааг дурдах нь зүйтэй.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий ШСХ хэмээх бие

⁹⁵ ШСХ-ны 2023 оны 02 сарын 15-ны өдрийн 28 дугаартай магадлал, https://judiscom.mn/site/decision_full/66, (Сүүлд үзсэн: 2024.12.05).

даасан, Үндсэн хуулийн байгууллагыг шинээр хуульчилсан. Улмаар ШСХ-ны бүтэц, бүрэлдэхүүн, эрх зүйн байдал, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зохицуулжээ.

Ийнхүү МУШТХ 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр ШСХ-г хуульд заасан үндэслэл, журмын дагуу байгуулж, ШСХ анхны хуралдаанаа 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн байна. ШСХ анхны хуралдаанаа хийж, албан ёсоор үйл ажиллагаа явуулснаас хойш 2025 оны 07 сарын 05-ыг хүртэлх өдөр хүртэл шийдвэрлэгдсэн нийт магадлал, тогтоол болон УДШ-ээр хянан шийдвэрлэгдсэн хяналтын тогтоолд дүн шинжилгээг хийлээ. Тодруулбал ШСХ болон УДШ-ийн цахим хуудсанд нээлттэй байршсан 558 магадлал, 31 тогтоол, УДШ-ийн 11 хяналтын тогтоол байгаа юм.

Судалгааны тоон мэдээллийн дүн шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтэд хүрлээ:

1. 2022–2025.07.05 хүртэлх хугацаанд ШСХ-д нийт 1269 өргөдөл, мэдээлэл ирснээс 706 буюу 56%-д нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, 563 буюу 44%-д нь сахилгын хэрэг үүсгэсэн байна.
2. Өргөдөл гаргагч, илтгэгч гишүүн, ШСХ-ны хууль зүйн үндэслэлийг судалж үзэхэд нийт 559 сахилгын хэргээс өргөдөл гаргагч, илтгэгч гишүүн, ШСХ-ноос огт МУШТХ-ийн үндэслэл дурдаагүй 163 магадлал байна. Үүнээс үлдэх 395 магадлалд дүн шинжилгээ хийж үзэхэд өргөдөл гаргагч хууль зүйн үндэслэл дурдаагүй 307 буюу нийт хэргийн 77.5%, илтгэгч гишүүний 219 буюу 55.3%, ШСХ-ны 232 буюу 58.6%-д нь МУШТХ-ийг үндэслээгүй байна. Харин хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хууль зүйн үндэслэл нь МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.20, 50.1.23 дахь заалтууд байна.
3. ШСХ-нд ирүүлсэн өргөдөл, мэдээлэлд илтгэгч гишүүний зүгээс 488 буюу 87.2%-д нь сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргаж, 70 буюу 12.5%-д нь шүүгчийг сахилгын зөрчил гаргасныг нотлох дүгнэлт үйлдэж ШСХ-нд ирүүлжээ. Тэдгээрээс ШСХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулсан 559 магадлалын шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон 515 магадлал буюу нийт магадлалын 92.1%, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан 43 буюу 7.69%, нууцалсан 1 магадлал байна. Нийт ШСХ-ноос гаргасан магадлалын 31 буюу 5.5% нь ШСХ-ны хянан үзэх хуралдаанаар,

11 буюу 1.9% нь УДШ-ийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаанаар шийдвэрлэгджээ.

Судалгааны хүрээнд ШСХ, УДШ-ийн шийдвэрлэсэн сахилгын хэргийн агуулгын хүрээнд дараах дүгнэлтэд хүрлээ:

1. ШСХ нь сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд өргөдөл гаргагч иргэн, илтгэгч гишүүн, өргөдлийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн гэх 3 субъектийн хууль зүйн үндэслэл хоорондоо нийцэж буй эсэх талаар дүн шинжилгээг хийлээ. Ингээд дараах үр дүнд хүрлээ. Үүнд:
 - а. Өргөдөл гаргагч иргэн, илтгэгч гишүүн нарын үндэслэл сонгон авсан нийт магадлалын 52.8%-д нь адил, 21.3%-д МУШТХ-ийг эшлээгүй, 25.9%-д нь өргөдөлд дурдсан заалтаас өөр заалтаар, эсхүл өөр заалтыг нэмж үндэслэл болгон сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл тухайн 2 субъектийн баримталж буй хуулийн үндэслэл адил бөгөөд бусад тохиолдолд МУШТХ-ийг эшлэхгүй байх, өөр зүйл заалтыг үндэслэн хэргийг шийдвэрлэж буй юм.
 - б. Илтгэгч гишүүн, өргөдлийг хянан шийдвэрлэж буй ШСХ-ны бүрэлдэхүүний хэргийг шийдвэрлэж буй хууль зүйн үндэслэл сонгон авсан нийт магадлалын 50.3%-д нь адил, 22%-д нь МУШТХ-ийг эшлээгүй, 27.7%-д нь өргөдөлд дурдсан заалтаас өөр заалтаар, эсхүл өөр заалтыг нэмж үндэслэл болгон сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс харвал илтгэгч гишүүн болон бүрэлдэхүүний хууль зүйн үндэслэл нь ихэнх тохиолдолд адил байх бөгөөд бусад тохиолдолд МУШТХ-ийг эшлээгүй, эсхүл өөр байна.
2. Дүн шинжилгээний хүрээнд статистик судалгаанд дурдагдсан хамгийн түгээмэл давтагдаж буй МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.18, 50.1.20, 50.1.27 дахь заалтуудад дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:
 - а. ШСХ-ны МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.1-д заасан зөрчилд холбогдуулан хэрэг үүсгэн шалгасан тохиолдлууд нь ихэнхдээ хэргийн оролцогчдын үзэмжтэй холбоотой гомдлууд байх бөгөөд ШСХ-ноос хэргийг шийдвэрлэхдээ тус зөрчилд хамаарах үйлдлүүдийг тодорхойлж, тайлбарлахгүй байгаа нь харагдаж байна.

- b. ШСХ-ноос МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18-д заасан сахилгын зөрчилд холбогдох хэргийг шийдвэрлэхдээ "шүүгч хэргийн нэг талтай уулзаж харилцсаныг хэргийн нөгөө тал мэдэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн" нь тус зохицуулалтын гол агуулга гэж үндэслэлээ тайлбарласан байна. Түүнчлэн хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр уулзах, харилцах үед шүүгчийн туслах тэмдэглэл хөтлөөгүй нь тус сахилгын зөрчлийг гаргасанд тооцох эсэх асуудалд ялгаатай тайлбар хийж, шийтгэл оногдуулсан болох нь ажиглагдлаа.
 - c. ШСХ-ноос МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20-ийн "хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх" гэх заалтыг хэрэглэж сахилгын хэрэг хянан шийдвэрлэхдээ "зүй бус авир" гэдгийг Монгол хэлний тайлбар толь ашиглан тайлбарлаж байна. Түүнчлэн шүүгчийн үйлдлийг дүгнэхэд шалгуур болгох тодорхой объектив шаардлага, үг хэллэг, үйлдлийн төрөл, жагсаалт байхгүйн улмаас сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний үзэмжээр шийдэгдэж байгаа нөхцөл ажиглагдлаа.
 - d. Хэдийгээр ШСХ-оос өөр хоорондоо илт зөрүүтэй дүгнэлт, шийдвэр гаргасан тохиолдол илрээгүй боловч шүүгчийг сахилгын зөрчил, ёс зүйн алдаа гаргасан эсэхийг тогтоохдоо тодорхой хуулийн үндэслэл, тайлбар бус Монгол хэлний тайлбар ашиглаж, шүүх бүрэлдэхүүний үзэмжээр шийдвэр гаргаж байгаа нь ШСХ-ны магадлалуудаас ажиглагдаж байгаа тул МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20 дахь заалтад холбогдуулан УДШ-ээс албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ шаардлага үүссэн байж болох юм.
 - e. Харин МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.27 дахь заалтын тухайд сахилгын хэрэг хянан шийдвэрлэсэн тоо харьцангуй цөөн бөгөөд одоогоор илт зөрүүтэй, маргаантай хэрэг хянан шийдвэрлэсэн байдал гараагүй байна.
3. ШСХ нь шүүгч нарт холбогдох хоорондоо төсөөтэй сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хуулийг нэг мөр хэрэглэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор судалгааны багийн зүгээс магадлалуудад дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтыг үндэслэж шийдвэрлэсэн

4 магадлал, мөн зүйлийн 50.1.26 дахь заалтыг үндэслэж шийдвэрлэсэн 2 магадлалыг сонгон авсан. Тус магадлалуудад МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.18 дахь заалтад заасан "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах" гэх сахилгын зөрчлийн шинжийг тодорхойлохдоо шүүгч хэргийн нэг талтай, нөгөө талыг байлцуулахгүйгээр "уулзах", "харилцах" үйлдлийг хийснээр сахилгын зөрчил үйлдсэнд тооцно гэж, эсхүл "уулзах", "харилцах" үйлдлийг хийсэн хэдий ч хэргийн талаар ярилцсан гэх үйл баримт тогтоогдсон байх гэж харилцан адилгүй дүгнэлт хийжээ. Харин МУШТХ-ийн 50.1.26 дахь заалтад заасан "шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих" гэх үндэслэлээр хэргийг шийдвэрлэсэн 2 тохиолдлыг харьцуулан судлахад тус 2 тохиолдолд холбогдох шүүгч нар хугацаа хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан эсэх нь нотлогдоогүй бөгөөд өмнө сахилгын зөрчил гаргаж байсан эсэх нь хүчин төгөлдөр ШСХ-ны шийдвэрээр тогтоогдоогүй зэрэг ижил нөхцөлтэй хэдий ч ШСХ-оос оногдуулсан сахилгын шийтгэлийн хэмжээ харилцан адилгүй байна. Тодруулбал, 2022.06.27-ны өдрийн 205 дугаар магадлалаар холбогдох шүүгч нь шийдвэр гаргах хугацааг 173 хоног хэтрүүлсэн гэж үзэн "цалингийн хэмжээг гурван сарын хугацаанд 20 хувиар бууруулах" сахилгын шийтгэл оногдуулсан бол, 2022.05.04-ний өдрийн 174 дугаар магадлалаар холбогдох шүүгч нь шийдвэр гаргах хугацааг 71 хоног хэтрүүлсэн тул "бүрэн эрхийг гурван сарын хугацаанд түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах" сахилгын шийтгэл оногдуулжээ.

4. МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтын хуулийн төслийг хэлэлцэх явцад Хууль зүйн байнгын хорооны гишүүд нэгдсэн ойлголтод хүрээгүй бөгөөд саналыг жишээтэйгээр дурдсан байх ба "Хуулийн илт тодорхой заалт" гэж юуг хэлэх, "Ноцтой зөрсөн" гэдэгт ямар үйлдэл, эс үйлдэхүй хамаарах талаар тодорхой зохицуулах шаардлагатай гэдгийг сануулж, ШСХ дээрх хуулийн заалтад холбогдох хэргийг шийдвэрлэхдээ "үзэмж"-ээр хандах аюултайг дурдсан байна. Үүнээс харвал МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтын талаар нэгдсэн үзэл баримтлалтай байгаагүй. Иймд судалгааны багийн зүгээс Монгол Улстай ижил хуулийн зохицуулалт бүхий

АНУ, ХБНГУ, Молдав, Испани улсыг харьцуулан судаллаа. Үр дүнд:

- а. АНУ болон ХБНГУ-д хуулийн илэрхий алдаа гаргасан тохиолдолд үүнийг шүүхэд **хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал шаардлагыг үл тоомсорлосон, эсхүл хэргийн оролцогчийн үндсэн эрхийг зөрчсөн эсэхэд голчлон анхаарч, шүүгчийн хууль зүйн алдаа нь түүний ёс зүйтэй шууд хамааралтай эсэхэд дүгнэлт өгч байна.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийг зөрчсөнөөр хуулийн илэрхий алдаа гаргасанд тооцох, тус тохиолдолд тухайн зөрчил нь хэргийн аль нэг талд ашигтай, эсхүл хохиролтой хууль бус шийдвэр гаргах бодит эрсдэлийг бий болгох юм. Өөрөөр хэлбэл хуулийн хэнд ч илэрхий, ойлгомжтой заалтыг зөрчсөн гэх үйлдэл нь процессын хуулийг удаа дараа, сануулга өгсөн ч үл хайхран ахин санаатай зөрчих замаар илрэх хандлага түлхүү ажиглагдаж байна. Молдав Улсын хувьд хуулийн илт, тодорхой заалтыг ноцтой, удаа дараа зөрчсөн зөрчлийг үүрэг хүлээлгэсэн, хориглосон, хатуу тогтоосон хэм хэмжээг зөрчих, мөн шүүгчид хэргийг шийдвэрлэх хэд хэдэн хувилбарыг заасан тохиолдол бус, **шууд нэг арга замыг үүрэг болгосон байхад санаатай, эсхүл хайхрамжгүйгээр зөрөх зэргээр тайлбарлан ашиглаж байна.** Өөрөөр хэлбэл хуулийн цар хүрээг давсан, хэтрүүлсэн шийдвэр гаргасан байхыг ойлгоно. Харин Испани Улсын Дээд шүүхээс хэрэг маргааныг **эрх зүйн үндэслэлгүй, дур зоргоороо, логикгүй байдлаар шийдвэрлэхийг хэлнэ** гэж тайлбарлажээ.
- б. Үүнийг дүгнэвэл МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь хэсгийн "хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах" гэж заасан зохицуулалттай **төсөөтэй зохицуулалт бүхий улсуудад тус заалтыг тайлбарлахдаа дараах зүйлүүд дээр анхаардаг байна.** Үүнд:
 - i. Шүүгч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал шаардлагыг хэрэгжүүлээгүй, үл тоомсорлосон, үүний улмаас хэргийн оролцогчдын аль нэгэнд ашигтай байдал эсхүл хохирол бий болсон байх;
 - ii. Шүүгчийн үйлдэл, эс үйлдэхүй нь хэргийн оролцогчийн үндсэн эрхийг зөрчсөн;

- iii. Хууль зүйн, мэргэжлийн алдаа гаргасан үйлдэл нь шүүгчийн баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээтэй хамааралтай байх;
- iv. Шийдвэр гаргахдаа хуулиар тогтоосон хязгаарыг зөрчсөн, өөрийн эрх хэмжээг хэтрүүлсэн;
- v. Хуулиар хүлээсэн бусад үүргээ удаадараа биелүүлээгүй, сануулга авсан ч тухайн зөрчлийг ахин давтах зэрэг үйлдэл, эс үйлдэхүй;

Сахилгын хэрэгт холбогдогч шүүгчийн хуулийн илэрхий алдаа гаргасан үйлдэл, эс үйлдэхүй нь **түүний санаа зорилгын дагуу, үр дагаврыг мэдэж байсны үндсэн дээр**, өөрөөр хэлбэл санаатай хийгдсэн байх нөхцөлийг харгалзан үздэг байна. Энэ нь шүүгчийн техникийн эсхүл хайхрамжгүй алдааг мэргэжлийн алдаатай андуурахгүй байх явдлаас сэргийлэх зорилготой гэж үзэж болно.

ГУРАВ | ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны багийн зүгээс эх газар, англо-саксоны эрх зүйн бүл болон пост социалист орнуудын төлөөлөл нийт 10 орныг сонгон харьцуулсан судалгаа хийлээ. Харьцуулсан судалгаа хийсэн улсыг сонгохдоо олон улсын V-Dem (Varieties of Democracy) байгууллагаас гаргадаг хууль дээдлэх ёсны индекс⁹⁶ (Rule of Law Index)-ийг ашигласан бөгөөд тус индексийг шүүхийн үйл ажиллагаа, доод болон дээд шатны шүүхийн хараат бус байдал, ил тод, шударга удирдлагын тогтолцоо, гүйцэтгэх засаглалын үндсэн хуулийг дээдэлдэг байдал, хууль тогтоомжийг урьдчилан таамаглах боломжтой байдал, шүүхийн хүртээмж, шүүхийн хариуцлага, шүүхийн болон төрийн байгууллагын авлига, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зэрэг мэдээллийг харгалзан боловсруулдаг байна.

2024 оны байдлаар дэлхийн хууль дээдлэх ёсны индексээр тэргүүлж буй улсуудаас Дани (1.00⁹⁷), ХБНГУ (0.99), Латви (0.97), АНУ (0.96), Франц (0.96), ИБУИНХУ (0.96), Испани (0.95), Итали (0.86), Молдав (0.81) улсуудыг сонгон судаллаа. Харин ОХУ-ын хувьд тус индекс доогуур (0.12) хэдий ч пост социалист улсын төлөөлөл болгож харьцуулан судалсан болно. Эдгээр 10 улс нь шүүгчид сахилгын хариуцлага оногдуулдаг субъектээрээ ялгаатай байх тул гурван ангилалд бүлэглэн авч үзье.

3.1. ШҮҮХЭЭС САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛАХ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД

3.1.1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

ХБНГУ-д шүүгчийн сахилгын хариуцлагатай холбоотой харилцааг Үндсэн хууль⁹⁸ болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд шүүгчийн сахилгын зөрчил хянан шийдвэрлэх чиг үүргийг Муж улсын албаны шүүх (гер. *Dienstgerichte der Länder*) болон Холбооны албаны шүүх (гер. *Dienstgericht des Bundes*) хэрэгжүүлдэг байна.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Муж улсын албаны шүүх нь мужийн шүүгчдийн сахилгын хэргийг

⁹⁶ Rule of Law Index, 2024 <https://ourworldindata.org/grapher/rule-of-law-index> (Сүүлд үзсэн: 2025.08.29).

⁹⁷ Тус индексийг бүхэл 1 онооноос тооцдог бөгөөд Дани улсын хувьд хууль дээдлэх ёсны индексээр бүх орныг тэргүүлдэг улс юм.

⁹⁸ Basic Law for the Federal Republic of Germany (1949).

анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Харин Холбооны шүүгчдийн сахилгын зөрчилтэй холбоотой маргааныг Холбооны дээд шүүх (англ. *German Federal Court of Justice*)-ийн дэргэдэх тусгай шүүх танхим (иргэний танхим) болох Холбооны албаны шүүх (англ. *Federal Service Court*) шийдвэрлэнэ.⁹⁹ Шүүхүүд нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэхдээ Холбооны сахилгын хууль¹⁰⁰ (англ. *Federal Disciplinary Act*) болон ХБНГУ-ын Шүүхийн тухай хууль¹⁰¹ (англ. *German Judiciary Act*)-ийн холбогдох зохицуулалтыг удирдлага болгодог.

Муж улсын албаны шүүх

(гер. *Dienstgerichte der Länder*)
Муж улсын шүүгчид холбогдох сахилгын хэргийг анхан болон давж заалдах шатны 2 шүүхээр хянан шийдвэрлэдэг.

Холбооны албаны шүүх

(гер.)
Холбооны улсын шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг.

Холбооны албаны шүүх

Холбооны албаны шүүхийн эрх зүйн үндсийг ХБНГУ-ын Шүүхийн тухай хуулийн 61–68 дугаар зүйлд хуульчилжээ. Холбооны албаны шүүх нь даргалагч шүүгч, байнгын 2 шүүгч, байнгын бус 2 шүүгчийн бүрэлдэхүүнтэй.¹⁰² Даргалагч шүүгч болон байнгын шүүгчид нь Холбооны дээд шүүхийн харьяаны шүүгчид байх ёстой бол, байнгын бус шүүгч нь тухайн сахилгын хэрэгт холбогдсон шүүгчийн харьяалагддаг шүүх эсхүл адил салбарын шүүхийн бүх насаараа томилогдсон шүүгч байх ёстой.¹⁰³ Холбооны дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон түүний байнгын орлогч нь Холбооны албаны шүүхийн бүрэлдэхүүнд орж болохгүй.¹⁰⁴ Холбооны дээд шүүхийн Тэргүүлэгчид (англ. *presidium*) нь Холбооны албаны шүүхийн танхимын даргалагч шүүгч, байнгын шүүгчид болон тэдний орлогчдыг таван жилийн хугацаагаар томилно.¹⁰⁵ Байнгын бус шүүгчдийг шүүх хуралдаанд оролцуулахад Ерөнхий зөвлөл нь Холбооны дээд шүүхүүдийн Ерөнхий зөвлөлөөс гаргасан нэр дэвшигчдийн жагсаалтын дарааллыг дагах

⁹⁹ German Judiciary Act (1972), sec. 61(1). https://www.gesetze-im-internet.de/englisch_drjg/index.html.

¹⁰⁰ Холбооны сахилгын хууль (гер. *Bundesdisziplinargesetz (BDG)*) нь ХБНГУ-ын төрийн албан хаагчдын сахилгын хариуцлагыг зохицуулдаг хууль юм.

¹⁰¹ German Judiciary Act (1972).

¹⁰² German Judiciary Act (1972), sec. 61(2) sentence 1.

¹⁰³ German Judiciary Act (1972), sec. 61(2) sentence 2.

¹⁰⁴ German Judiciary Act (1972), sec. 61(2) sentence 3.

¹⁰⁵ German Judiciary Act (1972), sec. 61(3) sentence 1.

үүрэгтэй.¹⁰⁶

Муж улсын албаны шүүх

ХБНГУ-ын Шүүхийн тухай хуулийн 71-84 дугаар зүйлд Муж улсын албаны шүүхийн эрх зүйн үндсийг хуульчилсан бөгөөд 77 дугаар зүйлд зааснаар муж улсын хэмжээнд Холбооны албаны шүүхтэй ижил чиг үүрэг бүхий тусгай шүүхүүдийг байгуулах эрх хэмжээг хуульчилж өгсөн. ХБНГУ-ын Шүүхийн тухай хуулиар сахилга, хариуцлагын талаарх нийтлэг харилцааг зохицуулдаг бол муж улсын хуулиар илүү нарийвчилсан харилцааг зохицуулдаг. Холбооны болон муж улсын шүүгчдэд хамаарах сахилгын хариуцлагатай холбоотой хуулийн зохицуулалт нь ижил агуулгатай байдаг.

Муж улс бүр Албаны шүүхтэй байх ба Муж улсын албаны шүүх нь 1 даргалагч шүүгч, тэнцүү тооны байнгын шүүгч болон байнгын бус шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Шүүх бүрэлдэхүүний гишүүдийн тоог хуулиар нарийн тогтоогоогүй байна.¹⁰⁷ Албаны шүүхийн бүрэлдэхүүн нь бүх насаараа томилогдсон шүүгчдээс бүрдэх бөгөөд байнгын бус шүүгч нь сахилгын хэрэгт холбогдсон шүүгч харьяалагдсан шүүх эсхүл адил шүүхийн салбар (гер. *Gerichtszweig*)-т харьяалагдсан байх ёстой. Албаны шүүхийн шүүгчдийг уг шүүх байгуулагдсан тухайн шүүхийн Тэргүүлэгчид (англ. *presidium*) томилно. Ерөнхий шүүгч болон түүний орлогч нь уг бүрэлдэхүүнд орж болохгүй. Албаны шүүхийн бүрэлдэхүүн нь насан туршийн шүүгч байх ёстой гэсэн үндсэн зарчмаас үл хамааран, муж улсын хуулийн дагуу өмгөөлөгчийг байнгын шүүгчээр томилж болно.¹⁰⁸ Тухайлбал, Берлин мужийн Шүүхийн тухай хууль¹⁰⁹ (гер. *Richtergesetz des Landes Berlin*)-аар байгуулагдсан албаны шүүх нь анхан болон давж заалдах шүүхийн тогтолцоотой. Үүнд:

- Анхан шатны албаны шүүх (гер. *Dienstgericht des Landes Berlin (Dienstgericht)*) нь Берлин мужийн Захиргааны шүүхэд байгуулагдсан бөгөөд шүүгчдийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэдэг. Даргалагч шүүгч, байнгын шүүгч (өмгөөлөгч), байнгын бус шүүгч гэсэн 3 гишүүнээс бүрдэнэ.
- Давж заалдах шатны албаны шүүх (гер. *Dienstgerichtshof des Landes Berlin (Dienstgerichtshof)*) нь Берлин-Бранденбург (гер. *Oberverwaltungsgericht Berlin-Brandenburg*)-ийн Захиргааны

¹⁰⁶ German Judiciary Act (1972), sec. 61(3) sentence 2.

¹⁰⁷ German Judiciary Act (1972), sec. 77(1).

¹⁰⁸ German Judiciary Act (1972), sec. 77(4) sentence 1.

¹⁰⁹ Richtergesetz des Landes Berlin (2011), <https://gesetze.berlin.de/bsbe/document/jlr-RiGBE2011V1P10>.

давж заалдах шатны шүүхэд байгуулагдсан. Уг шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол болон бусад хуулиар харьяалуулсан асуудлыг хянан шийдвэрлэнэ. Даргалагч шүүгч, 2 байнгын шүүгч (үүнээс нэг нь өмгөөлөгчийн эрхтэй байх), 2 байнгын бус шүүгч нийт 5 гишүүнтэй.¹¹⁰

Түүнчлэн, ХБНГУ-ын төрийн албанд Албан үүргийн гүйцэтгэлд тавих хяналт (гер. *Dienstaufsicht*)-ыг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдад сахилгын арга хэмжээ авахаас өмнөх шатанд дээд албан тушаалтан хяналт тавьдаг тогтолцоо юм. Шүүгч хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шүүгчийн хараат бус байдал болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөхийг хориглодог.¹¹¹ Холбооны болон муж улсын хууль зүйн сайд нь (гер. *Justizminister*) шүүгчийн ажлын цагийн бүртгэл болон хугацаа хэтрүүлэхгүй хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй эсэхэд хяналт тавина. Хяналтын явцад хууль зөрчсөн нөхцөл байдал илэрсэн тохиолдолд зэмлэх (гер. *Vorhalt*), мөн хуулийн хүрээнд албан үүргээ хугацаандаа гүйцэтгэхийг анхааруулах (гер. *Ermahnung*) арга хэмжээ авах эрхтэй.¹¹²

Албан үүргийн гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлсний дараагаар сахилга хариуцлагын асуудал яригддаг учир шүүгчийн сахилгын зөрчлийг хянахыг Чангатгасан албан үүргийн гүйцэтгэлд тавих хяналт (гер. *potenzierte Dienstaufsichtssachen*) гэж нэрлэдэг байна.

б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд шүүгчийг хэрхэн томилох, огцруулах, сахилгын хариуцлага хүлээлгэх онцгой журмыг хуульчилсан нь шүүхийн бие даасан байдлыг хамгаалах зорилготой. Шүүгчийн бие даасан байдал гэдэг нь ёс зүйн зөрчил, албан үүргийн ноцтой зөрчил, хайнга үйлдэл гаргасан шүүгчийг хариуцлагаас чөлөөлөх ойлголт биш тул ХБНГУ-ын шүүгчийн сахилгын хариуцлагын тогтолцоог бусад төрийн албан хаагчдынхаас ялгаатай байдлаар зохицуулдаг байна.

Төрийн албан хаагч **албан үүргийн зөрчил** (гер. *Dienstvergehen*) буюу санаатай болон хайхрамжгүй байдлын улмаас албан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд сахилгын хариуцлага хүлээдэг. Холбооны сахилгын хуульд зааснаар албан үүргээ зөрчсөн гэх бодит үндэслэл

¹¹⁰ 사법정책연구원, “각국 법관 징계제도에 관한 연구”, 2015, 184, <https://kiss.kstudy.com/Detail/Ar?key=4029275>, (2025.05.05. 확인).

¹¹¹ German Judiciary Act (1972), sec. 26(1).

¹¹² German Judiciary Act (1972), sec. 26(2).

байгаа тохиолдолд дээд шатны албан тушаалтан сахилгын хэрэг үүсгэх үүрэгтэй¹¹³ гэж заасан байдаг.

Харин Шүүгчийн тухай хуулийн 38-43 дугаар зүйлд шүүгчийн онцгой албан үүргийг хуульчилсан бөгөөд Холбооны төрийн албан хаагчийн хууль¹¹⁴ (англ. *Federal Civil Service Act*)-ийг дагаж мөрдөхөөр тусгасан байдаг. Үүний дагуу сахилгын зөрчил гаргасан эсэхийг тогтоохдоо Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан төрийн албан хаагчийн хууль дээр тулгуурладаг боловч, шүүгчийн албан үүрэгтэй холбоотой онцгой үүргийг эхлээд авч үзэх ёстой.

Төрийн албан хаагч нь санаатайгаар өөрийн үүргийг зөрчвөл энэ нь албан үүрэг зөрчсөн үйлдэл гэж тооцогдоно. Албан үүрэгтэй холбогдолгүй үйлдлүүд нь сахилгын зөрчилд тооцогдохгүй боловч тухайн зөрчлийн нөхцөл байдлаас хамааран албан тушаал эсхүл төрийн албаны нэр хүндэд ноцтойгоор халдах магадлалтай бол сахилгын зөрчил гэж үзэх боломжтой.¹¹⁵ Хуулийн энэ заалтыг үндэслэн шүүгч албан үүргээ гүйцэтгээгүй байх үедээ гаргасан үйлдэл нь шүүгчийн албан тушаалын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн бол үүнийг албан үүргийн зөрчил гэж үзнэ.

Товчхондоо шүүгч нь албан үүргийн болон хувийн амьдралын хүрээндээ олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг алдагдуулахгүйгээр, биеэ зөв авч явах ёстой гэж хуульд заажээ.¹¹⁶ Албан үүргээ биелүүлээгүй, хайнга хандах, албан тушаалаа урвуулан ашиглах, хууль бус шийдвэр гаргах, гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн тохиолдлууд нь сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл болно. Гэхдээ Холбооны дээд шүүхээс шүүгчийг гүйцэтгэж буй албан үүрэгтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл хүлээлгэх цар хүрээ хязгаарлагдмал байх ёстой гэж үздэг. Тухайлбал, шүүхийн шийдвэртэй холбоотой асуудалд ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 339 дүгээр зүйлд зааснаар зөвхөн **хууль гуйвуулсан** (гер. *Rechtsbeugung*) тохиолдолд л сахилгын арга хэмжээ авах боломжтой.

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Холбооны сахилгын хуульд холбооны харьяанд багтах төрийн албан хаагчийн сахилгын хариуцлагын төрлийг¹¹⁷ хуульчилсан. Холбооны сахилгын хуулийн үйлчлэлд шүүгчийн албан тушаал хамаардаг тул шүүгчдэд ч адил байдлаар оногдуулдаг. Үүнд:

¹¹³ Federal Disciplinary Act (2001), sec. 17(1).

¹¹⁴ German Judiciary Act (1972), sec. 41, 71.

¹¹⁵ Federal Civil Service Act (2009), sec. 77(3).

¹¹⁶ German Judiciary Act (1972), sec.39.

¹¹⁷ Federal Disciplinary Act (2001), sec. 5(1).

- **Сануулах** (гер. *Verweis*): Албан үүргийн зөрчил гаргасан шүүгчид бичгээр сануулж, дахин зөрчил гаргахгүй байхыг анхааруулсан шийтгэл.
- **Торгох** (гер. *Geldbuße*): Шүүгчийн цалин хөлснөөс нэг удаа эсвэл тодорхой хугацаанд суутгах мөнгөн шийтгэл. Тухайн зөрчил, учруулсан хохирлын хэмжээнээс хамаарч торгуулийн дүнг тогтооно. Энэ арга хэмжээ нь сануулах шийтгэлээс хүндэвтэр бөгөөд шүүхийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц зохисгүй үйлдэлд оногдуулж болно.
- **Цалин бууруулах** (гер. *Kürzung der Dienstbezüge*): Шүүгчийн үндсэн цалинг тодорхой хугацаанд (ихэвчлэн хэдэн сараас хэдэн жил хүртэл) тодорхой хувиар багасгах шийтгэл. Энэ нь сахилгын дунд түвшний шийтгэл бөгөөд шүүгчийн гаргасан зөрчлийг ноцтой гэж үзвэл цалин бууруулах шийтгэл оногдуулна. Мөн өндөр насны тэтгэвэр авагч шүүгчдийн хувьд тэтгэврийн хэмжээг бууруулах буюу тэтгэврийн эрхийг хасах шийтгэл оногдуулж болно.
- **Албан тушаал бууруулах, шилжүүлэх** (гер. *Zurückstufung/ Versetzung*): Шүүгчийг одоо байгаа шүүх, албан тушаалын түвшнээс нь доогуур түвшний шүүхэд шилжүүлэх буюу эрх зүйн байдлыг нь бууруулах шийтгэл. Германы зарим муж улсын хуульд, тухайлбал Баварид, шүүгчийг ижил ангиллын өөр газар, шүүхэд шилжүүлэх аргаар сахилгын шийтгэл оногдуулж болдог ба энэ тохиолдолд шилжин суурьших зардлыг нөхөн олгохгүй гэж хуульчилсан.¹¹⁸ Албан тушаал бууруулах шийтгэлийг ихэвчлэн ноцтой зөрчил гаргасан үед хэрэглэдэг бөгөөд зарим тохиолдолд цалин бууруулах сахилгын шийтгэлтэй давхар оногдуулдаг¹¹⁹ байна.
- **Төрийн албанаас халах** (гер. *Entfernung aus dem Beamtenverhältnis*): Энэ шийтгэлийг зөвхөн туйлын ноцтой, шүүхийн итгэл үнэмшил, шүүгчийн ажлын нэр төрд халдсан, сэргээгдэхгүй хохирол учруулсан зөрчилд оногдуулна.

Эдгээр 5 төрлийн сахилгын арга хэмжээ нь зөвхөн зарим холбооны шүүхүүд (Холбооны патентын шүүх, Цэргийн сахилгын шүүх) болон муж улсын шүүхүүдийн шүүгчдэд л хамааралтай. Харин **Холбооны дээд шүүхүүд болох** Холбооны дээд шүүх (BGH), Холбооны

¹¹⁸ Бавари муж улсын Шүүгч болон прокурорын тухай хууль – Bayerisches Richter- und Staatsanwaltsgesetz (BayRiStAG) (2018), sec. 58(3), <https://www.gesetze-bayern.de/Content/Document/BayRiStAG/true>.

¹¹⁹ Bayerisches Richter- und Staatsanwaltsgesetz (BayRiStAG)) (2018), sec. 58(3)

хөдөлмөрийн шүүх (BAG), Холбооны санхүүгийн шүүх (BFH), Холбооны нийгэм, халамжийн шүүх (BSG), Холбооны захиргааны шүүх (BVerwG))-ийн шүүгчдэд энэ хуулиар зөвхөн сануулах, торгох, төрийн албанаас халах сахилгын шийтгэлийг оногдуулж болдог.¹²⁰ Цалин бууруулах, албан тушаал бууруулах сахилгын шийтгэл оногдуулахыг зөвшөөрдөггүй байна.

d. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, давж заалдах эрх

ХБНГУ-ын шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд заасан нарийн процесс үе шаттай байдаг. Ерөнхий байдлаар авч үзвэл дараах үндсэн үе шатыг дамждаг. Үүнд:

1. **Сахилгын хэрэг үүсгэх, урьдчилсан шалгалт хийх:** Шүүгчийн зүгээс албан үүргийн зөрчил гарсан байж болзошгүй тухай мэдээлэл, гомдол хүлээн авсан, эсхүл зөрчил гаргасан байж болзошгүй тохиолдолд эрх бүхий этгээд (ихэвчлэн тухайн шүүхийн Ерөнхийлөгч (гер. *Präsident des Gerichts*), эсхүл сахилгын эрх бүхий байгууллага) тэр даруй **сахилгын хэрэг үүсгэх** үүрэгтэй.¹²¹ Энэ шатанд томилогдсон хянан шалгагч (зарим муж улсад туршлагатай, ахмад настай шүүгчийг хянан шалгагчаар томилох журамтай байдаг) баримт нотолгоо цуглуулах, шүүгчээс тайлбар авах, шаардлагатай бол гэрч нараас мэдүүлэг авах зэргээр урьдчилсан мөрдөн байцаалт явуулдаг.¹²² Мөн зөрчилд холбогдогч шүүгч өөрийн санаачилгаар гэм буруугүй гэдгээ нотлохын тулд дээд албан тушаалтандаа **сахилгын хэрэг үүсгэх хүсэлт гаргаж**¹²³ болно.
2. **Сахилгын шийтгэл оногдуулах шийдвэр (хэн шийдвэрлэх):** Урьдчилсан мөрдөн байцаалтаар тухайн зөрчил батлагдсан эсхүл үндэслэлтэй гэж үзвэл ямар сахилгын шийтгэл оногдуулах боломжтойг эрх бүхий байгууллага хэлэлцэнэ. Хэрэв зөрчил нь харьцангуй хөнгөн бөгөөд зөвхөн сануулах, торгох зэрэг шийтгэл тохирно гэж үзвэл эрх бүхий албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шууд сахилгын шийтгэлийг оногдуулж болно. Шүүхийн Ерөнхийлөгч эсхүл томилгооны эрх бүхий байгууллага нь **албан ёсны сануулга**

¹²⁰ German Judiciary Act (1972), sec. 64(2).

¹²¹ German Judiciary Act (1972), sec. 26(1).

¹²² Wolters Kluwer Deutschland GmbH, 2022, "§ 75 LRiG – Disziplinarverfahren gegen Richterinnen und Richter auf Probe und kraft Auftrags." Landesrichtergesetz (LRiG). <https://justiz-nrw.wolterskluwer-online.de/browse/document/ba50e711-52d2-3b67-8f30-ebd2fb7fab57#:~:text=,3%20entsprechend>, (Сүүлд үзсэн: 2025.05.23).

¹²³ Federal Disciplinary Act (2001), sec. 18(1).

өгөх буюу цалингийн тодорхой хувийг нэг удаа суутгах шийтгэлийг "сахилгын захирамж" гаргах замаар оногдуулах эрхтэй байдаг. Харин илүү хүнд сахилгын шийтгэл оногдуулах шаардлагатай (жишээлбэл цалинг бууруулах, албан тушаал бууруулах, огцруулах) гэж үзвэл, тухайн байгууллага өөрөө шийтгэл оногдуулах эрхгүй. Энэ тохиолдолд сахилгын зөрчлийн талаар гомдол гаргаж, холбогдох нотлох баримтын хамт Муж улсын албаны шүүхэд шилжүүлнэ. Өөрөөр хэлбэл, шүүгчид хүнд төрлийн сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэх субъект нь зөвхөн Муж улсын албаны шүүх байна.

3. Муж улсын албаны шүүх сахилгын хэрэг хянан шийдвэрлэх: Гомдол хүлээн авсан Муж улсын албаны шүүх нь сахилгын хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэнэ. Шүүгчийн сахилгын хэрэг нь нэг төрлийн мэргэжлийн шүүхийн процесс юм. Албаны шүүх нь хэрэг явдлын бодит байдлыг бүрэн шалгаж, шаардлагатай бол дахин нотлох баримт цуглуулж, гэрчийг дуудан асуулга хийж болно. Энэ шат нь үндсэндээ шүүн таслах ажиллагааны бүх шинжийг агуулна.
4. Шүүхийн шийдвэр, шийтгэл оногдуулах: Холбооны албаны шүүх сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэж шийдвэр гаргана. Нотлох баримт, хэлэлцүүлгийн үндсэн дээр тухайн шүүгч үнэхээр албан үүргийн ноцтой зөрчил гаргасан эсэхийг шүүх тогтооно. Хэрэв зөрчил гаргаагүй нь нотлогдвол сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгчийг цагаатгана. Харин зөрчил гаргасан нь тогтоогдвол шүүхээс тохирсон сахилгын шийтгэлийг оногдуулдаг.
5. Давж заалдах гомдол гаргах:
 - Холбооны шүүгчийн сахилгын тогтолцоо: Холбооны Албаны Шүүх (гер. *Dienstgericht des Bundes*) нь холбооны шүүгчидтэй холбоотой сахилгын хэргийг эцэслэн (гер. *endgültig*) шийдвэрлэх¹²⁴ тул холбооны шүүгчийн хувьд уг шийдвэрт эсэргүүцэл гаргах буюу давж заалдах боломжгүй.
 - Муж улсын шүүгчийн сахилгын тогтолцоо: Холбооны Шүүхийн тухай хууль 79 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "мужийн шүүгчдийн Албаны шүүхийн ажиллагаа нь дор хаяж хоёр үе шаттайгаар зохион байгуулагдсан байх ёстой" гэж зааснаас өөрөөр, давж заалдах ажиллагааны талаар тусгай

¹²⁴ German Judiciary Act (1972), sec. 62(1) sentence 1.

зохицуулалт тогтоогоогүй байна. Иймд муж бүр өөрийн хууль тогтоомжоо Холбооны хууль тогтоомжид нийцүүлэн албаны шүүхийн тогтолцоог хуульчилсан байдаг.

Дээрх шүүхийн үе шат нь ерөнхий загвар бөгөөд муж улс бүрт бага зэрэг ялгаатай байдлаар зохицуулсан байдаг.

е. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

ХБНГУ-д шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэсэн тохиолдол ховор боловч олон нийтийн анхаарлыг татсан цөөн тохиолдол бий. Эдгээрээс заримыг дурдъя.

Шигтгээ №15. ХБНГУ-ын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Шүүгч Кристиан Деттмарт холбогдох сахилгын хэрэг (2021-2023)¹²⁵

Тюринг муж улсын Веймар хотын гэр бүлийн шүүхийн шүүгч Кристиан Деттмарт (англ. *Christian Dettmar*) нь цар тахлын үед сургуулиудын халдвар хамгааллын дэглэм (маск зүүх, зай барих, сургуулийн орчинд түргэвчилсэн темт өгөх зэрэг) мөрдөхийг хориглосон шийдвэрийг 2021 оны 4 дүгээр сард гаргасан нь улс даяар дуулиан тарьсан юм. Шүүгч энэ шийдвэрийг гаргахдаа тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан захиргааны шийдвэрүүд нь Үндсэн хууль зөрчиж буй тул шүүх энэ шийдвэрийг дагахгүй гэжээ. Гэвч ХБНГУ-ын Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд "ердийн шүүх нь хууль, захиргааны акт нь Үндсэн хууль зөрчиж байна гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх ёстой" гэж заасан бөгөөд шүүгч уг заалтыг зөрчиж шийдвэр гаргажээ.

Деттмарын шийдвэр хууль эрх зүйн үндэслэлгүй, шүүхийн харьяаллын хүрээнд шийдэж болохгүй асуудлыг дур мэдэн шийдсэн гэж үзэн, давж заалдах шатны шүүх уг шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Улмаар Кристиан Деттмарт шүүгчийг эрх мэдлээ урвуулан ашигласан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн, 2022 онд яллах дүгнэлт үйлдэж шүүхээр хэлэлцэхээр болов. Мөн түүнтэй зэрэгцэн 2021 оны 8 дугаар сард тус шүүгчийн эсрэг тус шүүхийн Ерөнхийлөгч (гер. *Präsident des Gerichts*)-ийн шийдвэрээр сахилгын хэрэг үүсгэж, Тюрингийн албаны шүүхэд сахилгын хэргийг шилжүүлсэн байна. Хэдийгээр эрүүгийн хэргийн шүүх хурал удааширч, эцсийн шийдвэр гараагүй байсан ч 2023 оны 1 дүгээр сард албаны шүүх уг шүүгчийг ажил үүргээс нь түр түдгэлзүүлж, цалинг нь 25% хасах урьдчилсан арга хэмжээ авчээ. Албаны шүүхийн шийдвэрт, шүүгчийн санаатай үйлдэл нь шүүхийн бие даасан, шударга байдалд эргэлзээ төрүүлсэн тул албан тушаалаас нь огцруулах үндэслэлтэйг онцолсон байдаг.

¹²⁵ 2020 News, (2021, April 26). Search & seizure at home of judge who rendered the sensational Weimar mask-judgment, <https://2020news.de/en/house-warrant-executed-on-weimar-judge-for-political-reasons/>, (Сүүлд үзсэн: 2025.05.25).

Тохиолдол 2. Бенгт-Кристиан Фукс шүүгчид холбогдох сахилгын хэрэг¹²⁶

2024 онд Германы Тюринг муж улсын Гера хотын Захиргааны шүүхийн дэд Ерөнхийлөгч (rep. stellvertretender Präsident des Verwaltungsgerichts Gera) Бенгт-Кристиан Фукс (rep. Bengt-Christian Fuchs) нь нэгэн интернэт форумд хуурамч нэрээр, арьс өнгө, гарал үүсэл, орогнол хүсэгчдийн статус дээр үндэслэн ялгаварлан гадуурхсан сэтгэгдэл бичсэн гэх мэдээлэл гарчээ.

Фукс шүүгчийн гаргасан шийдвэрүүдийг судлахад, түүний шийдвэрүүд нь бусад шүүгчдийнхтэй харьцуулахад орогнол хүсэгчдэд сөргөөр нөлөөлсөн байж болзошгүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Үүний мөрөөр тус шүүхийн Ерөнхийлөгч нэн даруй сахилгын хэрэг үүсгэн шалгаж эхлэхийн зэрэгцээ тус хэргийн талаар прокурорт мэдэгдсэн байна. Шалгалтын үр дүнд тухайн бичвэрүүд нь түүний албан и-мэйлтэй холбоотой байсан нь илэрчээ.

Шүүгч нь улс төр, нийгмийн асуудлаар ил тод, нэг талыг барьсан байр суурь илэрхийлж болохгүй. Ялангуяа гадаадын иргэн, орогнол хүсэгчид, нийгмийн цөөнхүүдийг доош хийсэн үг хэллэг хэрэглэсэн нь сонирхлын зөрчил үүсгэх аюултай. Энэ нь шүүгчийн төвийг сахих, хөндлөнгийн хараат бус байдлыг алдагдуулж, шүүхийн нэр хүндэд сэв суулгасан гэж үзэж байгаа бөгөөд одоогийн байдлаар сахилгын хариуцлага тооцох эцсийн шийдвэр гаргаагүй байна.

Дээрх тохиолдлуудаас харвал ХБНГУ-д албан үүргийн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлийг өргөн хүрээнд тайлбарладаг болох нь харагдаж байна. Тухайлбал, шүүгчийн гүйцэтгэж буй албан үүрэг, ёс зүйгээс гадна хувь хүнийхээ хувьд ажил үүргээ гүйцэтгээгүй байхдаа ч ёс зүйтэй байхыг шаардаж байгаа бөгөөд эцсийн үр дүнд аливаа үйлдлээс шалтгаалан шүүхийн нэр хүндэд сэв суусан гэх ойлголтыг чухлаар авч үздэг болохыг дээрх тохиолдлоос харах боломжтой.

3.1.2. ДАНИЙН ХААНТ УЛС

Данийн хаант Улс (цаашид "Дани улс" гэх)-ын Үндсэн хуулийн¹²⁷ 64 дүгээр зүйлд *"Шүүгч гагцхүү хуульд захирагдана. Шүүхийг өөрчлөн байгуулахаас бусад тохиолдолд шүүгчийг зөвхөн шүүхийн шийдвэрийн дагуу албан үүргээс нь чөлөөлөх ба шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд шилжүүлж болохгүй"*¹²⁸ гэж заажээ. Мөн шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эсэх тухай асуудлыг шийдвэрлэх чиг үүргийг шүүх тогтолцоонд хамаарах этгээд буюу тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, Сахилгын давж заалдах тусгай

¹²⁶ Rath, C. (2024, June 28), Rassismus-Vorwürfe gegen den Vizepräsidenten des VG Gera: Derlei vulgäre Äußerungen habe ich nicht getan, <https://www.ito.de/recht/hintergruende/h/bengt-vorwufe-antifa-fallschirm>, (Сүүлд үзсэн: 2025.05.25).

¹²⁷ Данийн Хаант Улсын Үндсэн хууль (1953) – Danmarks Riges Grundlov, <https://www.retsinformation.dk/eli/lta/1953/169>.

¹²⁸ Данийн Хаант Улсын Үндсэн хууль (1953)-ийн 64 дүгээр зүйл – Danmarks Riges Grundlov § 64, <https://www.retsinformation.dk/eli/lta/1953/169>.

шүүх (дан. *Den Særlige Klageret*) болон Дээд шүүх (дан. *Højesteret*) тус тус хэрэгжүүлдэг ба оногдуулах хариуцлагын төрлөөрөө ялгаатай байдаг.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Ерөнхий шүүгч

Тус улсын 1986 оны Шүүхийн тухай хууль¹²⁹ (дан. *Retsplejeloven*)-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "шүүгч албан үүргээ хэрэгжүүлэхдээ хайнга, болгоомжгүй хандсан эсхүл ёс зүйгүй, зохисгүй авир гаргасан бөгөөд энэ үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй боловч зөрчилд тооцогдохуйц бол **сануулах**¹³⁰ **арга хэмжээ авч болно**" гэж заасан ба сахилгын хэргийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хянан шийдвэрлэдэг¹³¹ байна. Харин анхан болон давж заалдах шатны шүүх, далайн болон худалдааны шүүх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн шүүхийн Ерөнхий шүүгчид холбогдох сахилгын хэргийг дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгч хянан шийдвэрлэдэг¹³².

Гомдол гаргагчийн гаргасан гомдлыг Ерөнхий шүүгч хүлээн авснаар эсхүл Ерөнхий шүүгч өөрийн санаачилгаар сахилгын хэрэг үүсгэх ба гомдлыг 4 долоо хоногийн дотор гаргах зохицуулалттай¹³³. Өөрөөр хэлбэл, Ерөнхий шүүгч өөрийн санаачилгаар буюу шүүгчийг албан үүрэгтээ хайнга, болгоомжгүй, эсхүл ёс зүйгүй хандсан гэх үндэслэлээр хариуцлага оногдуулах эрхтэй.

Түүнчлэн, сахилгын зөрчилд холбогдох гомдлыг шийдвэрлэхэд дан ганц **сануулах арга хэмжээ авах тохиромжгүй** гэж Ерөнхий шүүгч үзвэл Сахилгын давж заалдах тусгай шүүх (цаашид "Тусгай шүүх" гэх)-д шилжүүлж болдог¹³⁴. Мөн сануулга авсан зөрчилд холбогдогч шүүгч 4 долоо хоногийн дотор Тусгай шүүхэд давж заалдах гомдол гаргах боломжтой¹³⁵ ба шүүхээс сануулах арга хэмжээ авсан

¹²⁹ Данийн Шүүхийн тухай хууль (1986) – Retsplejeloven, <https://www.retsinformation.dk/eli/ltg/2021/1835>.

¹³⁰ Ерөнхий шүүгч хянан шийдвэрлээд сануулах арга хэмжээ авсан талаарх мэдээллийг нийтэд ил мэдээлэхгүй байгаагаас үзвэл хаалттай сануулах шийтгэлийн төрөлд хамаарна боломжтой.

¹³¹ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – Retsplejeloven § 48 Satz 1.

¹³² Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг – Retsplejeloven § 48 S 3.

¹³³ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэг – Retsplejeloven § 48 S 2.

¹³⁴ Мөн тэнд.


¹³⁵ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48а дугаар зүйлийн 1 дэх хэсэг – Retsplejeloven § 48a S 1.

шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргадаг байна.¹³⁶

Сахилгын давж заалдах тусгай шүүх

Тусгай шүүх нь шүүгчийн сахилгын хэрэг, шүүхэд харьяалагдах өмгөөлөгчдийг ажлаас халах, зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх болон Данийн шүүхийн удирдах зөвлөлийн гишүүдийг огцруулахтай холбоотой хэрэг, эрүүгийн хэргийг сэргээх хүсэлт, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой давж заалдах гомдол зэргийг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй.¹³⁷

Тусгай шүүхийн бүрэлдэхүүний хувьд Улсын дээд шүүх, давж заалдах болон орон нутгийн шүүх, Данийн шүүгчдийн холбоо болон хуульчдын холбооноос тус тус санал болгосон дээд шүүхийн шүүгч, давж заалдах шатны шүүхийн шүүгч, анхан шатны шүүхийн шүүгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, өмгөөлөгчдийн төлөөллөөс бүрдсэн 5 гишүүнтэй ба тэдгээрийг Хууль зүйн сайд 10 жилийн хугацаатайгаар томилдог.¹³⁸ Тусгай шүүхээс сахилгын хэргийг хянан шийдвэрлээд, сануулах арга хэмжээ авсан шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх шийдвэр гаргасан тохиолдолд зөрчилд холбогдогч шүүгч Дээд шүүхэд гомдол гаргах эрхтэйг¹³⁹ мөн хуульчилжээ.



¹³⁶ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48а дугаар зүйлийн 5 дахь хэсэг – Retsplejeloven § 48a S 5.

¹³⁷ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 1а дүгээр зүйл – Retsplejeloven § 1a.

¹³⁸ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 1а дүгээр зүйлийн 3 дахь хэсэг – Retsplejeloven § 1a S 3.

¹³⁹ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 48а дугаар зүйлийн 6 дахь хэсэг – Retsplejeloven § 48a S 6.

б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэлийн тухайд, Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "шүүгч албан үүргээ хэрэгжүүлэхдээ ёс зүйгүй эсхүл зохисгүй авир гаргасны улмаас эрх, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж буй хэн боловч *Сахилгын давж заалдах тусгай шүүхэд гомдол гаргаж болно*" гэж заажээ. Мөн тус улсын Хууль зүйн сайд нь шүүгчийн аливаа үйлдлийг тухайн албан тушаалын нэр хүнд, итгэх итгэлд харшилж байна гэж үзвэл Тусгай шүүхэд гомдол гаргахыг *Улсын Ерөнхий Прокурорт даалгаж болдог байна*¹⁴⁰.

Цаашлаад, гомдол гаргагч нь гомдол гаргахад хүргэсэн нөхцөл байдлын талаар буюу зөрчлийг мэдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор гомдлоо гаргах ёстой ба хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хэтрүүлсэн гомдлыг хүлээн авах зохицуулалттай байна.¹⁴¹ Онцлог зохицуулалтын тухайд, Сахилгын давж заалдах тусгай шүүхэд гомдол гаргасан этгээд үндэслэлгүйгээр хэрэг үүсгэх нөхцөл байдлыг бий болгосон тохиолдолд торгуулийн шийтгэл хүлээх боломжтой байдаг.¹⁴²

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Сахилгын давж заалдах тусгай шүүх дээрх гомдлуудыг хянан шалгаад, зөрчил гаргасан нь тогтоогдвол шүүгчид дараах сахилгын хариуцлага оногдуулдаг:

- **Нээлттэй сануулах:** Зөрчилд холбогдогч шүүгчийн үйлдлийг зөвтгөх боломжгүй нөхцөл байдалд оногдуулдаг бөгөөд олон нийтэд нээлттэй байдлаар сануулга өгдөг сахилгын шийтгэлийн төрөл.
- **Албан тушаалаас нь огцруулах:**¹⁴³ Тухайн сахилгын зөрчил нь ноцтой эсхүл холбогдогч шүүгч удаа дараа үйлдэж байгаа эсэхээс хамаарч оногдуулна.

д. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Сахилгын давж заалдах тусгай шүүхийн цахим хуудаст байршуулсан статистик мэдээллээс үзвэл, сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 290

¹⁴⁰ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг – Retsplejeloven § 49 S 2.

¹⁴¹ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг – Retsplejeloven § 49 S 1.

¹⁴² Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг – Retsplejeloven § 49 S 5.

¹⁴³ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг – Retsplejeloven § 49 S 6.

гомдол ирснээс 278 гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзаж, 6 гомдлыг шалгаад сахилгын хэргийг буцааж эсхүл хэрэгсэхгүй болгож, үлдэх 6 гомдлыг шалгаад сануулах болон түдгэлзүүлэх¹⁴⁴ шийтгэл тус тус оногдуулж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №2. Сахилгын давж заалдах тусгай шүүхийн статистик¹⁴⁵

	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Шүүгчийн сахилгын хэрэгт холбогдох гомдлын тоо	90	64	30	73	33
1.Хэлэлцүүлэхээс татгалзсан	82	62	29	73	32
2.Сануулах болон түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авсан	3	1	1	0	1
3.Хэргийг буцаасан эсхүл хэрэгсэхгүй болгосон	5	1	0	0	0

Тус цахим хуудаст байршуулсан Сахилгын давж заалдах тусгай шүүхийн шийдвэрүүдээс үзвэл:

Шигтгээ №16. Дани Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Данийн Хаант Улсын Сахилгын давж заалдах тусгай шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №21/00229 дүгээр шийдвэр¹⁴⁶

Шүүгч А нь нэхэмжлэгчийн өмгөөлөгчид холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэх гомдол гаргасан боловч тус өмгөөлөгчийн оролцож буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үргэлжлүүлэн шүүгчээр оролцсон, шүүх хуралдааны явцад тайлбар гаргах боломж олгоогүй, бие дааж нотлох баримт цуглуулж, тэдгээрт зарим тохиолдолд буруу дүгнэлт хийсэн, Дээд шүүх болон Европын Холбооны шүүхийн шийдвэрээс өөрөөр дүгнэлт хийсэн, талуудыг андуурсан, буруу баримт дурдсан гэх агуулгаар гомдол гаргасан.

Шүүхийн тухай хууль (1986)-ийн 49 дүгээр зүйлд зааснаар Сахилгын давж заалдах тусгай шүүхэд шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад гаргасан зүй бус авирласан, доромжилсонтой холбоотой хэргийг хянан шалгах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн аливаа шийдвэрийн зөв эсэх талаарх хянан шалгах эрх олгогдоогүй гэж тайлбарласан.

¹⁴⁴ Данийн Шүүхийн тухай хууль (1986)-ийн 50 дугаар зүйлд заасны дагуу шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэсэн эсхүл шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдолд түдгэлзүүлж болдог.

¹⁴⁵ Den Særliche Klageret: Om Den Særliche Klageret, <https://www.domstol.dk/densaerligeklageret/om-den-saerlige-klageret/>, (abgerufen am 04.22.2025).

¹⁴⁶ Данийн Хаант Улсын Сахилгын болон давж заалдах тусгай шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №21/00229 дүгээр шийдвэр, <https://www.domstol.dk/densaerligeklageret/nyhedsartikler/2021/6/dom-10-juni-2021/>, (Сүүлд үзсэн: 2025.04.22).

Мөн гомдол гаргагч нь гомдол гаргах боломжит хугацааг хэтрүүлсэн тул NJORD хуулийн компанийн өмгөөлөгч Стефан Рейнелийн гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна.

Тохиолдол 2. Данийн Хаант Улсын Сахилгын давж заалдах тусгай шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн №095-20 дугаар шийдвэр¹⁴⁷

Шүүгч Б нь 2019 оны 12-р сарын 6-ны шүүх хуралдааны үеэр прокурорт хандаж "Ийм хэргийг цаг зарцуулж шүүхэд шийдэх нь зөв юм уу?" гэж асуусан нь гомдол гаргагчид хэрэгт ач холбогдол өгөхгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүлсэн байна. Мөн гэрч шүүх хуралдаанаас 8 минут хоцроход шүүгч "цагаа илүү үр дүнтэй ашиглая хэмээн шүүх хуралдааны танхимыг орхисон, гэрч оролцуулах, ослын газрын зураг харуулах, тайлбар гаргах зэрэг бүх хүсэлтийг хангаагүй хэмээн гомдол гаргасан байна.

Зөрчилд холбогдогч шүүгч тайлбартаа: Прокурорт хошигнож тухайн үгийг хэлсэн, доромжлох зорилго байгаагүй, гомдол гаргагчаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ямар нэг хүсэлт гаргаагүй, гаргасан ч татгалзах байсан, учир нь хэрэг "бүрэн ойлгомжтой" байсан хэмээн дурджээ.

Дээрх гомдлыг хүлээн авч шалгаад дараах агуулга бүхий дүгнэлтийг хийсэн байна: Зөрчилд холбогдогч шүүгчийн "Ийм хэргийг цаг зарцуулж шүүхэд шийдэх нь зөв юм уу?" гэх үг ашигласан нь шүүхэд итгэх итгэл болон шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхүйц байх ба хэргийн оролцогчийг үл хүндэтгэх хандлагатай байна гэж үзээд сануулах арга хэмжээ авсан байна.

Дани Улсын Сахилгын давж заалдах тусгай шүүхийн дээрх 2 тохиолдлоос үзэвэл тус шүүх нь сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүгчийн гаргасан ёс зүйн үйлдэл шүүхийн хараат бус байдал, шүүхийн нэр хүндэд хэрхэн нөлөөлж байгааг харгалзан үзэж, түүнд дүгнэлт өгч шийдвэрлэсэн байна. Харин хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгчийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй гэж үзжээ.

3.2. МЭРГЭШСЭН БАЙГУУЛЛАГААС САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛАХ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД

3.2.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын Холбооны Улс (цаашид "ОХУ" гэх)-ын шүүгчид сахилгын хариуцлага тооцох эрх бүхий субъект, түүнийг томилох журам, чиг үүргийг "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны

¹⁴⁷ Данийн Хаант Улсын Сахилгын болон давж заалдах тусгай шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн №095-20 дугаар шийдвэр, <https://www.domstol.dk/densaerligeklageret/nyhedsartikler/2020/11/dom-12-november-2020/>, (Сүүлд үзсэн: 2025.04.22).

хууль¹⁴⁸, "Дээд шүүхийн тухай" Холбооны Үндсэн хууль¹⁴⁹ зэрэгт тус тус зохицуулжээ. Тус улсын судлаачдын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах талаарх үзэл, хандлагаас танилцуулбал:

- Судлаач Шадрин Д.Н.-ий үзэж байгаагаар, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх орчин үеийн дотоодын тогтолцоо бол хамгийн хатуу тогтолцоо. Шүүгчийн үйлдлийг алдаатай зүйлчилсэн тохиолдолд **шүүгчийн халдашгүй байдлыг зөрчих сөрөг үр дагавартай** гэжээ.¹⁵⁰
- Харин Олон улсын хуульчдын комиссын гишүүдийн үзэж байгаагаар, ОХУ нь шүүгчдэд сахилгын хариуцлага оногдуулахдаа сахилгын хэргийг **шударгаар шийдвэрлэж чадвал** тус тогтолцоо нь **зөвхөн шүүгчдийн дунд төдийгүй иргэдийн дунд ч гэсэн тэдний шүүхийн тогтолцоонд итгэх итгэлийг бэхжүүлнэ** гэж үзсэн байна.¹⁵¹
- Мөн судлаач Туманова Л. В., Алешукина С. А. нарын үзэж байгаагаар, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх нь тэдний хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхгүй. Шүүхийн байгууллагууд бус **шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шүүгчид хариуцлага хүлээлгэж байгаа нь шүүгчдэд үндэслэлгүй хариуцлага оногдуулахаас хамгаалах ба шүүгчдийн хараат бус байдлын зарчмыг дагаж мөрдөхөд түлхэц болно** гэх байдлаар дүгнэжээ.¹⁵²

¹⁴⁸ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судебной системы в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710. // ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁴⁹ Федеральный конституционный закон от 5 февраля 2014 года № 3-ФКЗ "О Верховном Суде Российской Федерации" // "Собрание законодательства РФ", 10.02.2014, N 6, ст. 550. // "Оросын Холбооны Улсын Дээд Шүүхийн тухай" 2014 оны 02-р сарын 05-ны өдрийн № 3 Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2014.02.10, N 6, 550 х. // 1).

¹⁵⁰ Шадрин Д.Н. Неприкосновенность судей и особенности их привлечения к дисциплинарной ответственности // Matters of Russian and International Law. 2016. № 4. С. 49–50. // (Шадрин Д.Н. Шүүгчийн халдашгүй байдал болон тэдэнд сахилгын хариуцлага хүлээлгэх онцлог // Matters of Russian and International Law. 2016. № 4. Х. 49–50.).

¹⁵¹ Доклад миссии Международной комиссии юристов – https://www.icj.org/wp-content/uploads/2012/12/MISSION-RUSSIA-REPORT_rus.pdf // Олон улсын хуульчдын комиссын эрхэм зорилгын илтгэл – https://www.icj.org/wp-content/uploads/2012/12/MISSION-RUSSIA-REPORT_rus.pdf

¹⁵² Алешукина С. А., Туманова Л.В. Некоторые вопросы дисциплинарной ответственности судей // Вестник Московского университета имени С.Ю. Витте. Серия 2. Юридические науки. 2023. №4 (40). – С. 49–56. // (Туманова

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Тус улсад шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийг ОХУ-ын Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл (орс. *Квалификационная коллегия судей субъекта Российской Федерации*), ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл (орс. *Высшая квалификационная коллегия судей Российской Федерации*) болон ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхим (орс. *Дисциплинарная коллегия Верховного Суда Российской Федерации*) зэрэг байгууллагууд хянан шийдвэрлэдэг.

Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл

Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл нь "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад зааснаар холбогдох шүүхийн шүүгчдийн (дүүргийн шүүхүүдийн Ерөнхий шүүгч болон тэдгээрийн орлогч нар) сахилгын зөрчлийг хянан шалгаж, хариуцлага оногдуулдаг. Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл Холбооны улс болгонд байгуулагддаг бөгөөд зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох журмыг "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 5 болон 6 дахь хэсэгт заасны дагуу зохицуулдаг байна:

Шигтгээ №17. ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль

11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

ОХУ-ын холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийг төлөөллийн дараах журмын дагуу байгуулна¹⁵³:

- Бүгд найрамдах улсуудын дээд шүүхүүд, хязгаарын, мужийн шүүхүүд, холбооны ач холбогдол бүхий хотуудын шүүхүүд, өөртөө засах мужийн болон өөртөө засах тойргийн шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч;
- ОХУ-ын холбоодын арбитрын шүүхийн шүүгчдээс – 5 шүүгч;
- Гарнизоны цэргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- Дүүргийн шүүхүүдийн шүүгчдээс – 3 шүүгч;
- Энх тайвны шүүгчдээс – 1 шүүгч;
- Олон нийтийн 7 төлөөлөгч;
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1 төлөөлөгч;

Л.В., Алешукина С. А. Шүүгчийн сахилгын хариуцлагын зарим асуудал // С.Ю. Виттегийн нэрэмжит Москвагийн их сургуулийн мэдээллийн товхимол. Анги 2. Хууль зүйн шинжлэх ухаан. 2023. №4 (40). – С. 49–56.).

¹⁵³ (орос. *формируется по следующим нормам представительства*).

ОХУ-ын холбоодод энэ хэсгийн хоёроос – зургаа дахь заалтад заасан шүүхүүдийн нийт тоо нь 30-аас бага бол шүүгчдийн мэргэшлийн зөвлөл нь дараах төлөөллийн журмын дагуу 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдана:

- Бүгд найрамдах улсуудын дээд шүүхийн, хязгаарын, мужийн шүүхийн, холбооны ач холбогдол бүхий хотуудын шүүхүүдийн, өөртөө засах мужийн болон өөртөө засах тойргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- ОХУ-ын холбоодын арбитрын шүүхийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Гарнизоны цэргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- Дүүргийн шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч; ~~хүчингүй болсон~~
- Энх тайвны шүүгчдээс – 1 шүүгч;
- Олон нийтийн 2 төлөөлөгч;
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1 төлөөлөгч;

11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

Санкт-Петербург болон Ленинград мужийн Арбитрын шүүхийн шүүгчид Санкт-Петербургын шүүгчдийн мэргэшлийн зөвлөл болон шүүхийн нийгэмлэгийн бусад байгууллагуудын бүрэлдэхүүнд сонгогдоно.

Ленинград мужийн шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийг төлөөллийн дараах журмын дагуу байгуулна:

- Ленинград мужийн шүүхийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Гарнизоны цэргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- Ленинград мужийн дүүргийн шүүхүүдийн шүүгчдээс – 3 шүүгч; ~~хүчингүй болсон~~
- Энх тайвны шүүгчдээс – 1 шүүгч;
- Олон нийтийн 4 төлөөлөгч;
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1 төлөөлөгч;

Эвенкийн өөртөө засах тойргийн энх тайвны шүүгчид болон дүүргийн шүүхүүдийн шүүгчид Красноярскийн хязгаарын шүүгчдийн мэргэшлийн зөвлөл болон шүүхийн нийгэмлэгийн бусад байгууллагуудын бүрэлдэхүүнд сонгогдоно.

11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг

Шүүгчдийн конференцид ОХУ-ын холбоодын шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчдийг уг конференцийн тогтоосон журмын дагуу нууц санал хураалтаар сонгоно.¹⁵⁴

Хурлуудын хооронд ОХУ-ын холбоодын шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс гарсан шүүгчдийн оронд шүүгчдийг сонгох ажлыг ОХУ-ын холбоодын шүүгчдийн зөвлөл гүйцэтгэнэ.

ОХУ-ын холбоодын шүүгчдийн мэргэшлийн зөвлөлд олон нийтийн төлөөллийг ОХУ-ын холбоодын хууль болон бусад хэм хэмжээний актуудад тогтоосон журмаар ОХУ-ын холбоодын хууль тогтоох байгууллага томилно.¹⁵⁵

¹⁵⁴ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710. // ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁵⁵ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации.

Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл

"Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл нь:

- ОХУ-ын Дээд шүүхийн шүүгчид;
- Холбооны шүүхүүдийн (дүүргийн шүүхүүдээс бусад) Ерөнхий шүүгч, Ерөнхий шүүгчийн орлогчид;
- Ерөнхий харьяаллын хоёрдугаар давж заалдах шатны шүүхүүдийн шүүгчид;
- Ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхүүдийн шүүгчид;
- Тойргийн арбитрын шүүхүүдийн шүүгчид;
- Давж заалдах шатны арбитрын шүүхүүдийн шүүгчид;
- Оюуны өмчийн эрхийн шүүхийн шүүгчид;
- Цэргийн шүүхүүдийн шүүгчид;
- ОХУ-ын Шүүгчдийн зөвлөл ба ОХУ-ын шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн гишүүд;
- ОХУ-ын холбоодын (субъектүүдийн) шүүгчдийн зөвлөл болон шүүгчийн мэргэшлийн зөвлөлийн дарга, орлогч дарга нар сахилгын зөрчил үйлдвэл хянан шалгаж, сахилгын шийтгэл оногдуулдаг.

Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл нийт 29 гишүүдээс бүрдэх бөгөөд тэдгээрийг сонгох, томилох журмыг "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 болон 3 дахь хэсгүүдэд хуульчилжээ.

Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710.// ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

Шигтгээ №18. ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль

11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийг холбооны¹⁵⁶ шүүхүүдийн шүүгчид (орс. *судей федеральных судов*), ОХУ-ын холбоодын¹⁵⁷ шүүхийн шүүгчид (орс. *судей судов субъектов Российской Федерации*), олон нийтийн төлөөлөгчид, ОХУ-ын Ерөнхийлөгчийн төлөөлөгчид¹⁵⁸ дундаас байгуулна.

11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл 29 гишүүдээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүдийг шүүгчдийн дундаас төлөөллийг дараах журмын дагуу сонгоно:

- ОХУ-ын Дээд Шүүхийн шүүгчдээс – 4 шүүгч;
- Ерөнхий харьяаллын хоёрдугаар давж заалдах шатны шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Хоёрдугаар давж заалдах, давж заалдах шатны цэргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- Тойргийн арбитрын шүүхүүдийн, Оюуны өмчийн эрхийн шүүхийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Давж заалдах шатны арбитрын шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Бүгд найрамдах улсуудын дээд шүүхүүд, хязгаарын, мужийн шүүхүүд, холбооны ач холбогдол бүхий хотуудын шүүхүүд, өөртөө засах мужийн болон болон өөртөө засах тойргийн шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч;
- ОХУ-ын холбоодын арбитрын шүүхүүдийн шүүгчдээс – 2 шүүгч;
- Дүүргийн (тэнгисийн) цэргийн шүүхүүдийн шүүгчдээс – 1 шүүгч;
- Зөвлөлийн 10 гишүүд – олон нийтийн төлөөлөгчдийг ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөл томилно.
- Зөвлөлийн 1 гишүүн – ОХУ-ын Ерөнхийлөгчийн төлөөлөгчийг ОХУ-ын Ерөнхийлөгч томилно.

¹⁵⁶ Холбооны улс (орос. *Федерация*) гэдэг нь холбооны болон муж улсуудын засгийн газруудын хооронд эрх мэдлийг хуваасан, гэхдээ муж улс болгон өөрийн статусын хүрээнд хуулийн дагуу бүрэн эрх эдэлдэг улс төрийн систем.

¹⁵⁷ ОХУ-ын холбоод гэж ОХУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хэлнэ.

¹⁵⁸ "Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт "Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлд ОХУ-ын төрийн албанд албанд ажиллаж байгаа ОХУ-ын иргэн ОХУ-ын Ерөнхийлөгчийн төлөөлөгч байж болно" гэж заажээ.

11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчдийг холбогдох шүүхүүд өөрсдийн бүрэлдэхүүний хурлын төлөөлөгчдийн нууц санал хураалтаар, төлөөлөгчдийн тусдаа хурлаар сонгоно.¹⁵⁹

Санал хураалтад холбогдох шүүхүүдийн хурлын төлөөлөгчдийн талаас илүү хувь нь оролцсон тохиолдолд төлөөлөгчдийн тусдаа хуралд санал хураалтаас хамгийн олон санал авсан шүүгчид сонгогдсонд тооцно.

Хурлууд болох хооронд ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс гарсан шүүгчдийн оронд шүүгчдийг сонгох ажлыг ОХУ-ын Шүүгчдийн зөвлөл гүйцэтгэнэ.¹⁶⁰


ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхим

ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхим нь "Дээд шүүхийн тухай" Холбооны Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл болон Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдсан гомдлыг хянаж, эцсийн шийдвэрийг гаргадаг. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхимыг ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн орлогч тэргүүлж, үлдэх 6 гишүүнийг ОХУ-ын Ерөнхий шүүгчийн санал болгосон ОХУ-ын Дээд шүүхийн шүүгчдийн дундаас конкурсийн аргыг баримтлан саналын хуудас ашиглаж нууц санал хураалтаар, 3 жилийн хугацаагаар ОХУ-ын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар сонгоно"¹⁶¹ гэж заасан байна.

¹⁵⁹ Орос хэлээр. Судьи в состав Высшей квалификационной коллегии судей Российской Федерации избираются тайным голосованием на съезде делегатами съезда от соответствующих судов из своего состава на отдельных собраниях делегатов.

¹⁶⁰ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710. // ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁶¹ Федеральный конституционный закон от 5 февраля 2014 года № 3-ФКЗ "О Верховном Суде Российской Федерации" // "Собрание законодательства РФ", 10.02.2014, N 6, ст. 550. // "Оросын Холбооны Улсын Дээд Шүүхийн тухай" 2014 оны 02-р сарын 05-ны өдрийн № 3 Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2014.02.10, N 6, 550 х. // 1)



б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

ОХУ-ын Шүүгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт¹⁶² заасан сахилгын зөрчлийг үйлдсэн тохиолдолд хариуцлага оногдуулна. Тухайлбал, шүүгч албан үүргээ гүйцэтгэж байхдаа эсхүл ажлын бус цагаар сахилгын зөрчилд тооцогдох гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан болон ОХУ-ын Нийт шүүгчдийн хуралдаанаар (орос. Всероссийский съезд судей) батлагдсан Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн нь шүүх эрх мэдлийн хараат бус байдал, нэр төрд нөлөөлж, шүүгч албан тушаалын нэр хүндэд хохирол учруулсан, цаашлаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрхийг ноцтой зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл хүлээлгэхээр хуульчилжээ.

Мөн ОХУ-ын "Үндсэн хуулийн шүүхийн тухай" Холбооны Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн¹⁶³ 3 дахь хэсэгт зааснаар энэ хууль, "Шүүгчдийн эрх зүйн байдлын тухай" Холбооны хууль болон ОХУ-ын Нийт шүүгчдийн хуралдаанаар батлагдсан Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд мөн адил сахилгын шийтгэл оногдуулахаар заасан байна.

¹⁶² ОХУ-ын Шүүгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1 дүгээр зүйл. Шүүгчдийн сахилгын хариуцлага.

¹⁶³ "Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай" Холбооны Үндсэн хуулийн 15 дугаар зүйл. Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн халдашгүй байдал.

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Дээрх байдлаар сахилгын зөрчил гаргасан Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээс бусад шүүгчдэд:

- Анхааруулах;
- Сануулах;
- Мэргэшлийн зэрэг дэвийг бууруулах;
- Шүүгчийн бүрэн эрхийг нэн даруй дуусгавар болгох¹⁶⁴ зэрэг сахилгын шийтгэл оногдуулахаар зохицуулсан байна.¹⁶⁵

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд ОХУ-ын Үндсэн хуулийн¹⁶⁶ шүүхийн шийдвэрээр:

- Сануулах;
- Шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох зэрэг сахилгын шийтгэл оногдуулна.¹⁶⁷

д. Сахилгын хариуцлага оногдуулсан шийдвэрт давж заалдах эрх

ОХУ-ын Шүүгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар шүүгчийн бүрэн эрхийг нэн даруй дуусгавар болгох тухай Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл ОХУ-ын Дээд Шүүхийн Сахилгын танхимд давж заалдаж болно. Мөн ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 26 дугаар зүйлд Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрт хэрхэн давж заалдах

¹⁶⁴ "Шүүгчийн бүрэн эрхийг нэн даруй дуусгавар болгох" (орос. досрочное прекращение полномочий судьи) гэдэг үг сахилгын зөрчил үйлдсэн шүүгчийг "шүүгчийн үүрэгт ажлаас нь чөлөөлнө" гэсэн утгыг илэрхийлж байна.

¹⁶⁵ Закон Российской Федерации «О статусе судей в Российской Федерации» от 26.06.1992 г., № 3112-1 // Ведомости Съезда народных депутатов Российской Федерации и Верховного Совета Российской Федерации от 30 июля 1992 г., № 30, ст. 1792. // ("Оросын Холбооны Улсын шүүгчдийн эрх зүйн байдлын тухай" 1992.06.26 N 3132-1 Оросын Холбооны Улсын хууль // Оросын Холбооны Улсын ардын депутатуудын хурлын болон Оросын Холбооны Улсын Дээд Зөвлөлийн эмхэтгэл 1992.07.30, № 30, 1792 х.).

¹⁶⁶ Федеральный конституционный закон «О Конституционном Суде Российской Федерации» от 21 июля 1994 года № 1-ФКЗ // Собрание законодательства. 1994 г., № 13.// «Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай» 1994 оны 7-р сарын 21-ний өдрийн № 1 Холбооны Үндсэн хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга, 1994 он., №13.

¹⁶⁷ Федеральный конституционный закон «О Конституционном Суде Российской Федерации» от 21 июля 1994 года № 1-ФКЗ // Собрание законодательства. 1994 г., № 13.// «Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай» 1994 оны 7-р сарын 21-ний өдрийн № 1 Холбооны Үндсэн хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга, 1994 он., №13.

талаарх журмыг тусгасан байна. Тухайлбал:

Шигтгээ №19. ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хууль¹⁶⁸

26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Этгээдэд¹⁶⁹ гаргасан шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг (ОХУ-ын Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг) шүүхийн журмаар эсхүл ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлд тус этгээд давж заалдаж болно.

26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөл болон ОХУ-ын Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах тухай шийдвэрт сонирхогч¹⁷⁰ этгээдүүд¹⁷¹ холбогдох шийдвэрийн хуулбарыг хүлээн авсан өдрөөс хойш арван хоногийн дотор энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд давж заалдаж болно.

26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

ОХУ-ын Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах тухай шийдвэрт давж заалдах гомдлыг (шүүгчдийн сахилгын зөрчил үйлдсэний төлөө оногдуулсан шүүгчдийн бүрэн эрхийг нэн даруй дуусгавар болгох тухай шийдвэрээс бусад шийдвэрийг) холбогдох бүгд найрамдах улсуудын дээд шүүхэд, хязгаарын, мужийн шүүхүүдэд, холбооны ач холбогдол бүхий хотуудын шүүхэд, өөртөө засах мужийн болон өөртөө засах тойргийн шүүхэд гаргаж болно.

¹⁶⁸ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710. // ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁶⁹ Энэхүү "этгээд" (орос. *лицо*) гэсэн үгээр сахилгын зөрчил үйлдсэн шүүгчийг ойлгоно. Тайлбар. ОХУ-ын "Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" Холбооны хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүгч гэдэг үгийг биш, (орос. *лицо*) этгээд гэдэг үгийг ОХУ-ын хууль тогтоогчид ашигласан байна.

¹⁷⁰ Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710. // ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁷¹ Сонирхогч этгээдээр, ОХУ-ын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч байж болно. Тухайлбал, холбогдох шүүгчийн бүрэн эрхийг нэн даруй дуусгавар болгох тухай ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрийг ОХУ-ын Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл буруу шийдвэр гэж үзсэн тухай шийдвэр гаргасан бол уг ОХУ-ын Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ОХУ-ын Дээд Шүүхийн Сахилгын танхимд давж заалдаж болдог байна. Энэ зүйлд дурдсан сонирхогч этгээдүүдээр өөр хэнийг ойлгох талаар хүмүүсийн жагсаалт байхгүй байна.

Эх сурвалж: Камбегова, З. А. «Срок и порядок обжалования решений квалификационных коллегий судей Российской Федерации о привлечении судей к дисциплинарной ответственности: проблемы нормативного регулирования и

26 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

ОХУ-ын Шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн шүүгчдэд сахилгын хариуцлага оногдуулах тухай шийдвэрт давж заалдах гомдлыг ОХУ-ын Дээд шүүхэд гаргана.

26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг

"Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэр нь үүнийг уншиж сонсгосон мөчөөс эхлэн хүчинтэй болно. Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шийдвэрээ гаргасны дараа шууд уншиж сонсоно" гэж заажээ.¹⁷²

е. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

ОХУ-ын Холбооны шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэж, зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан жишээнээс дурдъя:

Шигтгээ №20. ОХУ-ын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол**Тохиолдол 1.¹⁷³**

Б. хотын Б. дүүргийн энх тайвны шүүгч С.Т. нь захиргааны зөрчлийн хэргийг шүүгчийн өмсгөл өмсөхгүйгээр хянан шийдвэрлэжээ. Шүүгч С.Т. тухайн өдөр өмсгөлөө оёдлын газарт янзлуулж оёулахаар өгсөн гэжээ.

Б. мужийн шүүгчдийн мэргэшлийн зөвлөл улсын эрх мэдлийн билэг тэмдгийг үл тоомсорлосон С.Т. шүүгчийн үйлдэл нь сахилгын зөрчлийн шинжийг агуулж байна гэсэн дүгнэлтэд хүрч, тус шүүгчид анхааруулах төрлийн сахилгын шийтгэл оногдуулжээ.

Тохиолдол 2.¹⁷⁴

О. хотын Т. дүүргийн шүүхийн шүүгч А.Р. нь ажлаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, шүүхийн Ерөнхий шүүгчид мэдэгдэлгүйгээр удаа дараа тасалжээ. Шүүгч ажлаа тасалсан болох нь хяналтын камерын бичлэгээр тогтоогдсон байна.

Шүүгч ажлаа тасалсан шалтгаанаа хүүхдээ цэцэрлэгээс авахаар явсан байсан гэж тайлбарлажээ. О. мужийн шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шүүгчийн эерэг зан байдлын тодорхойлолтыг харгалзан үзэж, түүнд сануулах төрлийн сахилгын шийтгэл оногдуулсан байна.

пути их решения». Вестник ТвГУ. Серия "Право", № 2 (2018): 62–72.

¹⁷² Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710.// ("Оросын Холбооны Улсын Шүүхийн нийгэмлэгийн байгууллагуудын тухай" 2002.03.14 N 30-XX (ред. от 13.12.2024) Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 2002. № 11. 1022 X; 2003. № 27 (2 х.). 2710 X.).

¹⁷³ Официальный сайт Высшей квалификационной коллегии судей Российской Федерации. – <https://www.vkks.ru/category/33/>.// (Оросын Холбооны Улсын шүүгчдийн дээд мэргэшлийн зөвлөлийн албан ёсны цахим хуудас. – <https://www.vkks.ru/category/33/>).

¹⁷⁴ Мөн тэнд.

ОХУ-ын хувьд шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхдээ эерэг зан байдлын тодорхойлолтыг харгалзан үзэж сахилгын шийтгэлийг оногдуулдаг болох нь харагдаж байна.

3.2.2. БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС

Бүгд Найрамдах Итали Улс (цаашид "Итали Улс" гэх) нь эх газрын эрх зүйн системтэй улс бөгөөд 1948 онд батлагдсан Үндсэн хууль¹⁷⁵ (англ. *Constitution of the Italian Republic*)-ийн 101–113 дугаар зүйлүүдэд шүүх засаглалын эрх зүйн байдлын талаар хуульчилжээ. Үндсэн хуулиар шүүх засаглалыг улс төрийн эрх мэдлээс ангид байлгах (эрх мэдэл хуваарилалтын зарчим) зорилгоор Шүүхийн дээд зөвлөлийг бие даасан хараат бус байгууллага болгосон. Тухайлбал, 105 дугаар зүйлд зааснаар Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын танхим (англ. *The C.S.M. Disciplinary Division*) (цаашид "Сахилгын танхим" гэх)-д **шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг олгосон** бол 107 дугаар зүйлд Хууль зүйн сайд шүүгчид сахилгын хэрэг үүсгэх хүсэлтийг Сахилгын танхимд гаргах эрхтэйг заасан байна.¹⁷⁶

Итали Улс эх газрын эрх зүйн системтэй бусад улс орнуудын адилаар "шүүх засаглал" гэх ойлголтод зөвхөн шүүгчийг төдийгүй прокурорын байгууллагыг хамааруулдаг. Иймд Шүүхийн дээд зөвлөл нь нийтдээ 9,000 орчим шүүгч, прокурорыг төлөөлөн, удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж, шүүгчдийн томилгоо зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Сахилгын танхимын шийдвэрт давж заалдсан гомдлыг Итали Улсын Дээд шүүх (итл. *Corte di Cassazione*) хянаж, эцсийн шийдвэрийг гаргадаг. Уг байгууллагын үйл ажиллагааг 1958 онд батлагдсан Шүүхийн дээд зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм¹⁷⁷ (англ. *Rules on the constitution and functioning of the Superior Council of the Judiciary*)-ээр зохицуулдаг байна.¹⁷⁸

Итали болон Ирланд улсын шүүхийн сахилгын зөрчлийн талаар судлаач Силвио Роберто Винсети (англ. *Silvio Roberto Vinceti*) өөрийн "Шүүхийн сахилгын зөрчил дэх стандартчилал, бүрэн эрх: Итали, Ирланд улсуудын туршлага" өгүүлэлдээ дурдсанаар:

¹⁷⁵ Constitution of the Italian Republic (1948).

¹⁷⁶ Giacomo Oberto, "The Italian experience in the field of judicial ethics and judicial discipline", *biblioteca.cejamerica.org*, 7, <https://biblioteca.cejamerica.org/bitstream/handle/2015/3565/italian-exp-ethics.pdf?sequence=1&isAllowed=y>, (Сүүлд үзсэн: 2025.05.22).

¹⁷⁷ Rules on the constitution and functioning of the Superior Council of the Judiciary (Act Nr. 195, 24 March 1958).

¹⁷⁸ Giacomo Oberto, *supra* note 174, 8.

Шигтгээ №21. Силвио Роберто Винсетийн "Шүүхийн сахилгын зөрчил дэх стандартчилал, бүрэн эрх: Итали, Ирланд улсуудын туршлага" өгүүлэл¹⁷⁹

2006 оны багц шинэчлэлийн гол үндэслэл бол сахилгын хэрэг хянан шийдвэрлэх буй байгууллага нь шүүгчийн сахилгын зөрчлийн шалгуур үзүүлэлтүүдийг бодитоор тогтоож, материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэхэд чиглэж байв. Шууд хэлэхэд энэхүү зорилго нь шүүхийн сахилгын асуудлыг дотоод хяналтаас илүүтэй жинхэнэ шүүх ажиллагаатай төстэй болгоход оршиж байсан. Энэ утгаараа, тус салбарын бүхий л эрдэмтэд 2006 оны багц шинэчлэлийг оройтсон ч гэсэн сахилгын хариуцлагад татагдсан шүүгчийн эрхийг илүү сайн хамгаалахад шаардлагатай алхам байсан гэдэг дээр санал нэгддэг. Каваллини (англ. Cavallini) өөрийн судалгаандаа "2006 оны шинэчлэл нь илүү үр ашигтай, ил тод сахилгын тогтолцооны чиглэлд хийгдсэн чухал алхам байсан боловч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанарт өөрчлөлт оруулж чадаагүй. Сахилгын харилцаа нь зөвхөн гурван этгээдийн хооронд явагддаг хэвээр байна: Ерөнхий Прокурор, сахилгын хэрэгт холбогдсон шүүгч (эсвэл прокурор), Сахилгын танхим. Хувь хүний гаргасан гомдолд анхаарал хандуулдаггүй. Гомдол гаргагчид шийдвэрийн талаар мэдээлдэггүй, мөн түүнд ямар нэг байдлаар оролцох боломж олгодоггүй" гэж дүгнэсэн. Каваллинигийн энэхүү үгс нь Италийн шүүхийн сахилгын тогтолцооны жинхэнэ асуудлыг илтгэж байдаг.

Дээрхээс үзэхэд, хуулиар иргэдэд шүүгчийн сахилгын зөрчилд холбогдуулан гомдол гаргах эрхийг олгосон боловч, гомдол гаргасан иргэн нь уг сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, эсвэл түүний үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжгүй байдаг нь тогтолцооны нэгэн ноцтой сул тал болохыг хөндөн гаргаж иржээ.

Масарикийн их сургууль (англ. *Masaryk University*)-ийн Хууль зүйн факультетийн Шүүх судлалын хүрээлэнгийн ахлах судлаач Симон Бэнбэнути (англ. *Simone Benbenuti*) "Итали дахь шүүгчийн хариуцлагын тогтолцооны улс төржилт: Тэнцвэрийг шилжүүлэх нь" хэмээх өгүүлэлдээ шүүхийн сахилгын хариуцлагын талаарх зохицуулалт хэт ерөнхий утгатай байхын сөрөг талыг дүгнэжээ:

¹⁷⁹ Silvio Roberto Vinceti, "Standardisation and authority in judicial discipline: a comment on Italy and Ireland's experiences", *Irish Judicial Studies Journal* Vol.6(1), 2022, 63.

Шигтгээ №22. Симон Бенвенутийн "Итали дахь шүүгчийн хариуцлагын тогтолцооны улс төржилт: Тэнцвэрийг шилжүүлэх нь" өгүүлэл¹⁸⁰

1946 оны №511 дугаартай хуулийн 18 дугаар зүйлд шүүгчийг албан үүргээсээ ухарсан, итгэл алдахуйц, эсхүл хайхрамжгүй зан авир гаргасан, эсхүл шүүх эрх мэдлийн нэр хүндийг унагасан тохиолдолд сахилгын хариуцлагад татаж болно хэмээн ерөнхий байдлаар заасан байв. Гэвч практикт, мэргэжлийн ур чадварын хамгийн ноцтой зөрчлүүд хүртэл хэрэв гадагш ил болоогүй л бол ач холбогдол багатай гэж үзэгдэж, эсрэгээрээ харьцангуй жижиг зөрчлүүд шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэх зэргээр ноцтойд тооцогдож байжээ. Шүүхийн дээд зөвлөлийн Сахилгын танхим нь "албан үүрэг", "итгэл алдахуйц зан авир", "шүүхийн нэр хүнд" гэх мэт маш бүдэг, тодорхой бус ойлголтуудыг өөрийн дотоод ойлголт, хандлагад тулгуурлан тодорхойлох үүрэгтэй байсан нь хоёр үр дагаврыг дагуулсан юм. Нэгдүгээрт, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулсан. Хоёрдугаарт, шүүгчдийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүн сахилгын зөрчлийг хөнгөвтрөөр зүйлчлэх чиг хандлагыг барьж, улмаар сахилгын хариуцлагын тогтолцоог үр нөлөөгүй болгож, хэрэгжүүлэлтийг ноцтой сулруулсан. Эдгээрээс шалтгаалан Италийн парламент 2005–2006 онд сахилгын зөрчлийн тодорхойлолтуудыг хуульчлан тогтоосон. Энэхүү шинэчлэл нь Европын Хүний эрхийн шүүхийн 2001 оны шийдвэр, үр дагавартай салшгүй уялдаатай юм. Тухайн шийдвэрт шүүгчдийн сахилгын зөрчлийг тодорхой хэмжүүргүй, урьдчилан мэдэх, таамаглах боломжгүй байдалтай байгааг шүүмжилсэн нь анхаарал татахуйц юм.

Сахилгын зөрчлийг хуульд хэт өргөн агуулгаар тусгах нь эрх зүйн зохицуулалтыг олон янзаар тайлбарлах нөхцөл бүрдүүлж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулан, шүүгчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна сахилгын хариуцлагын тогтолцооны үр нөлөөг сулруулах, хуулийн хэрэгжилтийг хангахад хүндрэл учруулах зэрэг сөрөг үр дагавартай байдгийг онцолжээ. Мөн сахилгын зөрчил туйлын тодорхой бус байх нь шүүгчийн зүгээс сахилгын зөрчлөөс сэргийлэх, урьдчилсан арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлдэггүй гэж дүгнэж болохоор байна.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект


Шүүхийн дээд зөвлөл нь нийт 27 гишүүнээс бүрдэх ба 16 гишүүнийг шүүгчдийн дундаас, 8 гишүүнийг парламентаас тус тус сонгон томилж, үлдэх 3 гишүүн нь Итали Улсын Ерөнхийлөгч, дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон дээд шүүхийн Ерөнхий прокурор (англ. *Attorney General at the Court of Cassation*)-оос бүрддэг.

Харин Сахилгын танхим нь 6 гишүүнтэйгээр сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг ба танхимыг Шүүхийн дээд зөвлөлийн

¹⁸⁰ Simone Benvenuti, "The Politics of Judicial Accountability in Italy: Shifting the Balance", *European Constitutional Law Review*, 2018, 386.

дэд Ерөнхийлөгч тэргүүлдэг.¹⁸¹ Шүүхийн дээд зөвлөлийн дэд Ерөнхийлөгчийг Парламентаас томилогдсон гишүүдийн дундаас Ерөнхийлөгч сонгон томилдог. Үлдэх 6 гишүүн нь Парламентаас сонгогдсон 1 гишүүн, Дээд шүүхийн шүүгч, прокуроруудын дундаас сонгогдсон 1 гишүүн, анхан болон давж заалдах шатны шүүхэд албан үүргээ гүйцэтгэж буй прокурорууд дундаас сонгогдсон 1 гишүүн, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нараас сонгогдсон 2 гишүүдээс бүрддэг байна.¹⁸²

Сахилгын танхимын шийдвэрийг тухайн сахилгын хэрэгт холбогдогч шүүгч, Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн Ерөнхий прокурорт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (англ. *Code of Criminal Procedure*)-д заасан хугацаа, журамтай нийцүүлэн давж заалдах эрхийг олгосон байна. Ингэхдээ давж заалдах гомдлыг Дээд шүүхэд гаргах бөгөөд гомдол гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэхээр заажээ.¹⁸³



б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Итали Улсад фашист дэглэм нуран унасны дараахан 1948 оны Үндсэн хууль батлагдахаас 2 жилийн өмнө буюу 1946 онд батлагдсан Шүүхийн суурь хууль¹⁸⁴ (итл. *Guarentigie della magistratura*) (англ. *Guarantees of the Judiciary*) нь шүүх засаглалын хараат бус байдлын баталгаа болсон ба өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хуулийн 17 болон 18 дугаар зүйлд шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах эрх зүйн гол үндэслэлийг зохицуулсан байдаг.

¹⁸¹ Giacomo Oberto, *supra* note 174, 8.

¹⁸² Giacomo Oberto, *supra* note 174, 23.

¹⁸³ Act Nr. 109, 23 February 2006, art. 24.

¹⁸⁴ Guarantees of the Judiciary (Act (*regio decreto legislativo*) Nr. 511, 31 May 1946).

Шигтгээ №23. Шүүхийн суурь хууль (Act (regio decreto legislativo) Nr. 511, 31 May 1946)**II хэсэг – Шүүгч, прокурорын сахилгын хариуцлага****17 дугаар зүйл. Ерөнхий зохицуулалт**

Шүүгч, прокурорыг зөвхөн энэ хуульд заасан тохиолдол болон журмын дагуу сахилгын хариуцлагад татаж болно.

18 дугаар зүйл. Шүүгч, прокурорын сахилгын хариуцлага

Хэрэв шүүгч, эсхүл прокурор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл ажил үүргээ гүйцэтгэж байхдаа болон албан үүргээс гадуур ёс зүйн шаардлагад үл нийцэх, эсвэл шүүх засаглалын нэр хүндийг гутаах үйлдэл гаргасан бол тэрээр дараах зүйлүүдэд заасны дагуу сахилгын шийтгэл хүлээнэ.

Хэдийгээр дээрх 18 дугаар зүйлээр шүүгчийн сахилгын зөрчилд шийтгэл оногдуулах эрх зүйн гол үндэслэлийг зохицуулж байсан боловч хэт ерөнхий байдлаар тайлбарласан гэсэн шүүмжлэлийг дагуулдаг байсан.¹⁸⁵ Ингээд 2006 оны "Кастеллигийн шинэчлэл" (англ. *Castelli reform*)-ээр шүүгчийн сахилгын зөрчлийг илүү нарийн төрөлжүүлэн №109 дугаартай хуулиар¹⁸⁶ зохицуулан, үндсэн гурван бүлэгт ангилах болсон. Үүнд:

- Нэгдүгээр бүлэгт шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад хориглох сахилгын зөрчлийн төрлүүд;¹⁸⁷
- Хоёрдугаар бүлэгт шүүгчийн албан үүргээс гадуурх харилцаанд хориглох сахилгын зөрчлийн төрлүүд;¹⁸⁸
- Гуравдугаар бүлэгт шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэсэнтэй холбоотойгоор сахилгын зөрчил гаргасанд¹⁸⁹ тооцох.

Нэгдүгээр бүлэг нь хамгийн өргөн хүрээг хамардаг ба дээрх 2006 оны №109 дугаартай хуулийн 2 дугаар зүйлд сахилгын зөрчлийн төрлүүдийг нэг бүрчлэн хуульчилжээ. Тухайн сахилгын зөрчлүүдээс жишээ болгон дурдвал:

¹⁸⁵ Marco Fabri, "Regulating Judges in Italy", 10.

¹⁸⁶ Act Nr. 109, 23 February 2006, <https://leg13.camera.it/parlam/leggi/deleghe/testi/06109dl.htm>, (Сүүлд үзсэн: 2025.05.22).

¹⁸⁷ Act Nr. 109, 23 February 2006, art. 2.

¹⁸⁸ Act Nr. 109, 23 February 2006, art. 3.

¹⁸⁹ Act Nr. 109, 23 February 2006, art. 4.

Хүснэгт №3. 2006 оны №109 дугаартай хуулийн 2 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил¹⁹⁰

№	Шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад гаргасан сахилгын зөрчлийн төрөл
1.	Шүүгч өөрт хуваарилагдсан хэрэгт ашиг сонирхлын зөрчил байгааг мэдүүлээгүй, хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд татгалзан гарах үүргээ биелүүлээгүй
2.	Хэрэг маргааны талууд, тэдгээрийн өмгөөлөгч, гэрч болон шүүхэд ирсэн иргэд, бусад шүүгч, захиргааны ажилчидтай зүй бусаар харьцах
3.	Бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тухайн зөрчлийн талаар мэдэгдээгүй
4.	Хууль хэрэглээний ноцтой алдаа гаргах, хэргийн үйл баримтыг хөнгөмсгөөр, хайхрамжгүйгээр буруу дүгнэх
5.	Үндэслэлгүй шийдвэр гаргах, эсхүл хэрэгтэй холбоотой бодит байдлыг огт харгалзахгүйгээр шийдвэр гаргах
6.	Шүүх байгууллагын дотоод журам, мэдээллийн системийн зохицуулалтыг удаа дараа, ноцтой зөрчих
7.	Өөрт хамаарах чиг үүргийг бусдад үндэслэлгүйгээр шилжүүлэн даалгах; зөвшөөрөлгүйгээр шүүхийн байгууллага байрлаж буй нутаг дэвсгэрийн гадна амьдрах
8.	Шаардлагатай үед үргэлж бэлэн байх үүргээ биелүүлээгүй; нууцлалын зэрэгтэй баримт бичгийг задруулах
9.	Шүүхийн шийдвэр гарахаас өмнө, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад олон нийтийн өмнө зохисгүй мэдэгдэл хийх; шүүхийн үйл ажиллагааг зүй бусаар сурталчлах

Хоёрдугаар бүлэг буюу албан үүргээс гадуурх сахилгын зөрчлийн төрлүүдийг дээрх хуулийн 3 дугаар зүйлд заасан. Үүнд:

Хүснэгт №4. 2006 оны №109 дугаартай хуулийн Хоёрдугаар бүлгийн 3 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил¹⁹¹

№	Шүүгч албан үүргээс гадуур гаргасан сахилгын зөрчлийн төрөл
1.	Өөрийн эрх мэдлийг ашиглан хувийн ашиг хонжоо олох, бусдад давуу байдал олгох
2.	Өөрийн хянан шийдвэрлэж буй хэрэгт хамааралтай хүмүүстэй харилцаа тогтоох, бизнес хийх, гэмт хэрэг тогтмол үйлддэгийг мэдсээр байж, эсхүл ноцтой гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдтэй холбоо тогтоох
3.	Шүүхийн дээд зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр шүүхээс гадуурх ажил, албан тушаал хаших

¹⁹⁰ Silvio Roberto Vinceti, "Standardisation and authority in judicial discipline: a comment on Italy and Ireland's experiences", *Irish Judicial Studies Journal* Vol.6(1), 2022, 61.

¹⁹¹ *Ibid*, 62.

4.	Хянан шийдвэрлэж буй хэрэг, маргааны талуудаас зээл авах, тусгай нөхцөл бүхий тусламж, хөнгөлөлт авах
5.	Шүүхийн үйл ажиллагаатай зөрчилддөг эсвэл хууль бус нууц нийгэмлэг, бүлэглэлд гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцох
6.	Улс төрийн намд элсэх, үйл ажиллагаанд нь тогтмол идэвхтэй оролцох

Гуравдугаар бүлэг буюу дээрх хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар шүүгчид дараах эрүүгийн хариуцлага оногдуулсан бол сахилгын зөрчил гаргасанд тооцогдоно:

Хүснэгт №5. 2006 оны №109 дугаартай хуулийн

Гуравдугаар бүлгийн 4 дугаар зүйлд заасан сахилгын зөрчил¹⁹²

№	Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэсэнтэй холбоотой сахилгын зөрчил
1.	Хорих ял (эсвэл хорих ялыг мөнгөн торгуультай хавсруулан) оноохоор хуульчилсан санаатай болон санамсаргүй гэмт хэрэгт холбогдож шүүхийн шийтгэх тогтоол гарсан
2.	Болгоомжгүйгээр үйлдсэн гэмт хэрэгт холбогдуулан хорих ял оноосон бөгөөд хэргийн үйлдлийн хэлбэр болон үр дагаврын хувьд онцгой ноцтой шинжтэй байх
3.	Баривчлах ял оноосон шүүхийн шийтгэх тогтоол гарсан
4.	Шүүхийн нэр хүндэд хохирол учруулах аливаа гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан (хэрэгсэхгүй болсон, эсхүл хэрэг үүсгэх, үргэлжлүүлэн шалгах боломжгүй болсон тохиолдлууд мөн хамаарна)

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

2006 оны №109 дугаартай хуулийн 5 дугаар зүйлд сахилгын зөрчил гаргасан шүүгчид оногдуулах сахилгын хариуцлагын төрлүүдийг хуульчилсан байдаг.¹⁹³ Үүнд:

- **Сануулах:** Сануулга нь сахилгын хэргийн шийдвэрт дурдагдсан шүүгчийн үйлдсэн зөрчилтэй холбоотой үүргээ биелүүлэхийг сануулах.¹⁹⁴
- **Анхааруулах:** Сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг бичгээр мэдэгдэх.¹⁹⁵
- **Албан тушаалын зэрэглэл бууруулах:** 2 сараас 2 жил хүртэлх хугацаанд доод шатны шүүх рүү шилжүүлэх.¹⁹⁶
- **Удирдах болон хагас удирдах албан тушаал хаших эрхийг түр**

¹⁹² Act Nr. 109, 23 February 2006, art. 4.

¹⁹³ Act Nr. 109, 23 February 2006, art. 5.

¹⁹⁴ Act Nr. 109, 23 February 2006, art. 6.

¹⁹⁵ Act Nr. 109, 23 February 2006, art. 7.

¹⁹⁶ Act Nr. 109, 23 February 2006, art. 8.

хугацаагаар хязгаарлах: Тодорхой хугацаанд удирдах албан тушаал хаших эрхийг хасах.¹⁹⁷

- **Албаны чиг үүргээс түдгэлзүүлэх:** Зөрчил гаргасан шүүгчийн цалинг 3 сараас 2 жил хүртэлх хугацаанд тодорхой хувиар бууруулан шүүгчээр ажиллах эрхийг түдгэлзүүлнэ.¹⁹⁸
- **Үүрэгт ажлаас чөлөөлөх:** Үүрэгт ажлаас бүрмөсөн чөлөөлөх шийтгэл нь Ерөнхийлөгчийн зарлигаар хэрэгждэг.¹⁹⁹

d. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Зөрчил гаргасан шүүгчид холбогдуулж сахилгын хэрэг нээх эрх хэмжээг Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн Ерөнхий прокурорт олгосон байх ба Хууль зүйн сайд нь энэхүү эрх хэмжээгээ Дээд шүүхийн Ерөнхий прокурорт сахилгын хэрэгтэй холбоотойгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргаснаар хэрэгжүүлэх юм. Хууль зүйн сайд ямар үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэх хүсэлт гаргаж буй талаарх товч тайлбараа Шүүхийн дээд зөвлөлд албан ёсоор хүргүүлэх шаардлагатай байдаг.²⁰⁰

Харин иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн Ерөнхий прокурор хоёул хүлээж авах эрхтэй ба жилд дунджаар шүүгчийн сахилгын хэрэгтэй холбоотой 150 орчим сонсгол явагддаг. Энэ нь шүүхийн нээлттэй байдлын илрэл, мөн шүүх засаглал хийгээд иргэд хоорондын холбоог бэхжүүлэх арга зам юм гэжээ.²⁰¹

Дээд шүүхийн Ерөнхий прокурор урьдчилсан мөрдөн шалгалтын дүн, эсхүл Хууль зүйн сайдаас ирүүлсэн дэлгэрэнгүй тайлан, мэдэгдэлд тулгуурлан сахилгын хэргийг хүлээн авснаас хойш нэг жилийн дотор үүсгэх ёстой байдаг байна.²⁰² Хэрэг үүсгэснээс хойш Дээд шүүхийн Ерөнхий прокурор мөрдөн шалгах ажиллагааг явуулж дууссаны дараа зөрчилд холбогдуулан дүгнэлт гарган, сахилгын хэрэгт холбогдогч шүүгчид мэдэгдэж дараачаар нь сахилгын хэргийн материалыг Сахилгын танхимд илгээн сонсголын товыг зарлуулдаг.²⁰³

¹⁹⁷ Act Nr. 109, 23 February 2006, art. 9.

¹⁹⁸ Act Nr. 109, 23 February 2006, art. 10.

¹⁹⁹ Act Nr. 109, 23 February 2006, art. 11.

²⁰⁰ Act Nr. 109, 23 February 2006, art. 14.2.

²⁰¹ Acquaviva Naïs, Castagnet Florence and Evangelou Morgane, "A comparative analysis of Disciplinary Systems for European judges and prosecutors", For the 7th edition of the THEMIS Competition, 2012, 11.

²⁰² Act Nr. 109, 23 February 2006, art. 15.

²⁰³ Act Nr. 109, 23 February 2006, art. 17.

Сонсголын үеэр Ерөнхийлөгчийн томилсон Сахилгын танхимын гишүүн хэргийг илтгэгч гишүүний хувиар танилцуулна. Харин Хууль зүйн сайдын төлөөлөгч нь хэргийн талаар товч танилцуулга тавих, гэрч, шинжээч болон зөвлөхүүдээс асуулт асуух, сахилгын хэрэгт холбогдогч шүүгчийг байцаах зэргээр сонсголд оролцох эрхтэй. Мөн сонсголыг хуульд зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулахаар заасан. Тухайлбал, 1) маргаантай асуудлаар, эсхүл сахилгын хэрэгт холбогдогч шүүгчийн албан тушаалтай холбоотойгоор шүүх засаглалын нэр хүндийг хамгаадах шаардлага гарсан; 2) гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах шаардлага байгаа гэх үндэслэлээр талуудын гаргасан хүсэлтийг харгалзан сонсголыг хаалттай явуулах юм.²⁰⁴

Сахилгын танхим нотлох баримтыг шинжлэн судалж, Дээд шүүхийн Ерөнхий прокурор, Хууль зүйн сайдын төлөөлөгч, сахилгын хэрэгт холбогдогч шүүгчийн өмгөөлөгчийн тайлбарыг сонссоны дараа нэн даруй зөвлөлдөж сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл хангалттай нотлох баримт байхгүй бол буруутгах үндэслэл тогтоогдоогүй буюу хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргана. Ингэхдээ, Дээд шүүхийн Ерөнхий прокурорыг шийдвэр гаргах зөвлөлдөөнд оролцуулдаггүй.²⁰⁵

е. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Итали Улсын Шүүхийн дээд зөвлөлийн Сахилгын танхимын шийдвэрт давж заалдаж Дээд шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн тохиолдлуудыг доор танилцуулъя:

Шигтгээ №24. Итали Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Итали улсын Наплес хотын давж заалдах шатны шүүхэд, дараачаар Ром хотын давж заалдах шатны шүүхэд шүүгчээр ажиллаж байсан шүүгч Р.-ийг албан үүргээс гадуур орлого олох зорилгоор хувиараа багшилсантай холбоотой сахилгын хэрэг²⁰⁶

Шүүгч Р. нь 2006 оны №109 дугаартай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн d-д заасан сахилгын зөрчил гаргасан гэж тогтоогдож Сахилгын танхимаас түүнд "сануулах" шийтгэл оногдуулжээ. Тухайлбал, 2007–2011 онуудад шүүгчийн сонгон шалгаруулалтад бэлтгэх сургалтыг бие даан, тогтмол, төлбөртэйгөөр явуулж, нэг удаад 20–60 орчим хүн сургалтад хамрагдсан байдаг. Шүүгч Р. Тухайн шийдвэрийг эсэргүүцэж Дээд шүүхэд давж заалдсан байна.

²⁰⁴ Act Nr. 109, 23 February 2006, art. 18.

²⁰⁵ Act Nr. 109, 23 February 2006, art. 19.

²⁰⁶ Judge P. v. Italian Supreme Judicial Council, 27493/2013, (Court of Cassation, 2013), https://cjc.eui.eu/data/data/print_trial_pdf?idPermanent=913, (Сүүлд үзсэн: 2025.05.26).

Дээд шүүхээс Шүүхийн дээд зөвлөлийн Сахилгын танхимын шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэхдээ Шүүхийн журмын тухай хууль (англ. Law on the Judicial Order)-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг хориглосон заалтыг үндэслэл болгосон. Шүүхээс үзэхдээ: 1) шүүгчээр ажиллахтай зэрэгцэн өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарласан нь зөвхөн төрийн албан хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой асуудлаар бус, шүүгчид Үндсэн хуулиар олгогдсон чиг үүргийг шударгаар, зөв зохистой гүйцэтгэхэд нөлөөлж болох аливаа хүчин зүйлээс сэргийлэхэд чиглэгдсэн гэж онцолсон. Энэхүү хязгаарлалт нь шүүх эрх мэдлийн хараат бус, төвийг сахисан байдлыг хангах үндэс болдог гэжээ; 2) шүүгчийн багшлах үйл ажиллагаа нь суралцагчдыг хуульч мэргэжилд бэлдэх зорилготой, төлбөртэй, системтэй, тогтмол явагдаж, шүүгч өөрөө биечлэн зохион байгуулж байсан нь Шүүхийн журмын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгээр "хориглосон мэргэжлийн үйл ажиллагаа" мөн гэж үзсэн. Шүүгч нь өөр мэргэжлийн үйл ажиллагаа тогтмол эрхэлж, орлого болон эдийн засгийн ашиг хүртэж байгаа нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны ач холбогдлыг алдагдуулсан. Цаашлаад шүүхийн үйл ажиллагаа тогтмол байх талаарх нийтийн итгэлийг алдагдуулж, шүүгчийн бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлнө гэжээ. Үүнээс гадна Дээд шүүхээс дээрх тохиолдлыг сургуульд багшлах үйл ажиллагаатай харьцуулан дүгнэхдээ "Үндсэн хуульд заасан шүүгчийн хараат бус, төвийг сахисан байдлыг хадгалах үүднээс сургуульд багшлах шүүгч нарт илүү өндөр, нарийн шаардлага тавьдаг" талаар тайлбарласан. Мөн дээрх зөрчил нь шүүгчийн албаны чиг үүрэгтэй зөрчилдсөнөөр оюуны болон соёлын үйл ажиллагаанд оролцох эрхийн хүрээнд явуулсан үйл ажиллагаа биш гэж үзжээ.

Тохиолдол 2. Шүүгчийн ажил үүргээ хүлээлгэж өгсөн шүүгч улс төрийн үйл ажиллагаанд оролцсонтой холбоотой сахилгын хэрэг²⁰⁷

Шүүгчийн ажил үүргээ хүлээлгэн өгч, шүүхийн үйл ажиллагаанаас чөлөөлөгдсөн шүүгч Итали улсын томоохон улс төрийн намын сонгуулийн ажилд оролцож, захиргааны албан тушаал хашиж байжээ. Эдгээр албан тушаал нь намын гишүүнчлэл шаардахын сацуу улс төрийн үйл ажиллагаанд тогтмол оролцохыг шаарддаг байна. Энэхүү нөхцөл байдал нь 2006 оны №109 дугаартай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн h-д "улс төрийн намд элсэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох ..." гэж шүүгчид хориглосон хэм хэмжээг зөрчсөн. Мөн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад Шүүхийн дээд зөвлөл 2006 оны №109 дугаартай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн h заалт нь Үндсэн хуулийн 2, 3, 18, 49, 98 дугаар зүйлүүдтэй нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн асуудлыг хөндсөн. Тухайлбал, чөлөөнд байгаа шүүгчдийн улс төрийн намын гишүүнчлэл, эсхүл тогтмол оролцоог сахилгын зөрчил гэж үзэх нь Үндсэн хууль зөрчиж байна уу гэсэн асуудлыг дэвшүүлсэн. Улмаар 2018 оны 170 дугаар шийдвэрээр Үндсэн хуулийн шүүх уг асуудлыг үндэслэлгүй гэж үзсэн. Иймээс Шүүхийн дээд зөвлөл 2019 оны 30 дугаар шийдвэрээр тухайн шүүгчийг сахилгын зөрчил гаргасан гэж үзжээ. Сахилгын хэрэгт холбогдогч шүүгч уг шийдвэрийг эсэргүүцэж Дээд шүүхэд давж заалдсан байна.

²⁰⁷ Judge (unknown) v. Italian Supreme Judicial Council, 8906, (Court of Cassation, 2020), <https://cjc.eui.eu/data/data/data?idPermanent=916&trial=1>, (Сүүлд үзсэн: 2025.05.26).

Дээд шүүхээс Үндсэн хуулийн шүүхийн 2018 оны 170 дугаар шийдвэрийг иш татан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгосон. Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүхээс тайлбарлаж буйгаар шүүгч сонгох эрхээ хэрэгжүүлж, улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох боломжтой, гэхдээ тухайн оролцоо нь тогтмол байж болохгүй гэжээ. Мөн шүүгчийн албан үүргээ хүлээлгэж өгсөн ч хараат бус, төвийг сахисан байр сууриа хадгалж, эдгээр зарчмуудыг хүндэтгэн, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй. 2006 оны №109 дугаартай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн h заалт нь хоёр өөр нөхцөлийг сахилгын зөрчилд тооцдог, үүнд: "улс төрийн намын гишүүнчлэл" болон "улс төрийн намын үйл ажиллагаанд тогтмол оролцох". Эдгээр үйлдлүүд нь шүүх засаглалын төвийг сахисан байдал, хараат бус байдал, нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг гэжээ.

Тохиолдол 3. Шүүгч олон нийтийн форум дээр мэтгэлцээн өрнүүлсэнтэй холбоотой сахилгын хэрэг²⁰⁸

Сахилгын хэрэгт холбогдогч шүүгч олон нийтийн форум дээрх хэлэлцүүлэгт төрийн захиргааны албаны байр суурийг хамгаалан оролцохдоо "бэлтгэл сайтай, чадварлаг өмгөөлөгчдийг жинхэнэ маанагуудаас ялгалгүйгээр бүх өмгөөлөгчдийг наци-фашист, дарангуйлагч, зөвхөн өөрийгөө л хардаг системийн гэнэн золиос" мэтээр сөргөөр дүрсэлсэн орчныг бий болгосон. Тухайн орон нутгийн Хуульчдын холбооны зөвлөл дээрх үг хэллэгийг буруушаасан бөгөөд холбооны дарга "гишүүдэд рүү нь үндэслэлгүй дайрсан" гэж гомдол мэдүүлсэн байна. Сахилгын танхим уг шүүгчийг шүүх засаглалын нэр хүндэд хохирол учруулсан, мөн шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад нийтлэг бөгөөд ноцтой ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж, 2006 оны №109 дугаартай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн d, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн d заалтуудад үндэслэн хариуцлага тооцсон.

Шүүх давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэхдээ хамгийн түрүүнд гүтгүүлсэн гэж үзсэн хохирогчийн асуудлыг авч үзсэн байна. Шүүхийн практикт гэмт хэрэг нь тодорхой нэг этгээдийн эсрэг чиглэсэн байх ёстой бөгөөд энэ нь шууд заагаагүй ч тодорхойлох боломжтой байх ёстой. Гэвч тухайн тохиолдолд хохирогчийг тодорхойлох боломжгүй байсан тул гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаагүй гэж үзжээ. Мөн шүүх тухайн шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх асуудлыг авч үзсэн бөгөөд тухайн үйлдлийг шүүхийн ажил үүрэгтэй холбоотой гэж үзэх боломжгүй, тэр дундаа шүүхийн захиргаатай холбоотой асуудал байсан ч ялгаагүй гэв. Үүнээс гадна шүүгчдийн гүйцэтгэж ажил үүрэг нь тэднийг олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох эрх чөлөөг хэт хязгаарлах үндэслэл болж болохгүй гэдгийг онцолсон. Зөвхөн шүүгчийн үүргийг хэрэгжүүлж буй тодорхой тохиолдолд л энэ эрх чөлөөг хязгаарлаж болно, гэхдээ хэт өргөн хүрээнд тайлбарлаж хязгаарлах ёсгүйг сануулжээ.

Итали Улсын хувьд шүүгчийн сахилгын зөрчил нь харьцангуй өргөн хүрээг хамардаг. Дээрх тохиолдлоос харвал шүүгч нь албан тушаалаасаа чөлөөлөгдсөн ч шүүхийн хараат бус байдал, шүүхэд итгэх итгэлийг алдагдуулсан үйлдэл гаргавал сахилгын хариуцлага хүлээж болох нь харагдаж байна. Мөн хэдийгээр шүүгч нь их

²⁰⁸ Judge (unknown) v. Italian Supreme Judicial Council, 6965, (Court of Cassation, 2017), <https://cjc.eui.eu/data/data/data?idPermanent=156&trial=1>, (Сүүлд үзсэн: 2025.05.26).

сургуулийн багшаар ажиллаж болох боловч өөр байдлаар буюу өөр зорилгоор багшлах үйл ажиллагаа явуулбал энэ нь сахилгын зөрчилд тооцогдож болохоор байна.

3.2.3. ИСПАНИЙН ХААНТ УЛС

Испанийн Хаант Улс (цаашид "Испани Улс" гэх)-ын хувьд 1985 оны Шүүхийн тухай хуулиар²⁰⁹ бүх шатны шүүхийн бүтэц, эрх, үүрэг, хэргийн харьяалал, Шүүхийн ерөнхий зөвлөл, түүний хороодын үйл ажиллагааг нарийвчлан хуульчилжээ. Тус хуулийн 4 дүгээр дэвтрийн 414–427 дугаар зүйлд "Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа"-г, 8 дугаар дэвтрийн 603–608 дугаар зүйлд "Сахилгын хорооны бүтэц, бүрэлдэхүүн, томилгоо"-г тус тус зохицуулсан байна. Испани Улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл (англ. *General Council of the Judiciary*) болон түүний харьяанд байдаг Сахилгын хороо (англ. *The disciplinary committee*) хэрэгжүүлдэг.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Шүүхийн ерөнхий зөвлөлийн нийт гишүүдээс бүрдсэн хурлыг Нэгдсэн хуралдаан (англ. *The Plenary Session*) гэдэг. Испани Улсын Үндсэн хуулийн²¹⁰ 122 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд Хаанаас 5 жилийн хугацаагаар томилсон 20 гишүүнээс бүрддэг. Үүнээс 12 гишүүн нь бүх шатны шүүхийн 1 шүүгч байх бол, хуульч мэргэжлээр 15-аас дээш ажилласан 4 гишүүнийг Конгрессоос, эрх зүйч мэргэжлээр 15-аас дээш жил ажилласан 4 гишүүнийг Сенатаас тус тус тавны гурвын саналаар нэр дэвшүүлнэ" гэж заажээ. Мөн Үндсэн хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосны дагуу Хаан томилно" гэж заасан. Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10-аас дээш гишүүн оролцсон Нэгдсэн хуралдааныг хүчин төгөлдөрт тооцох бөгөөд шүүгчийн сахилгын хариуцлагатай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

- Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилох;
- Шүүгчийн албан тушаалаас огцруулахтай холбоотой сахилгын

²⁰⁹ Organic law 6/1985, of 1 July, on the Judiciary (1985), <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/DOCUMENTACION%20DEL%20CPGJ/COMPENDIO%20DE%20DERECHO%20JUDICIAL/FICHERO/20160125%20LOPJ%20ingl%C3%A9s%2012-2015.pdf>.

²¹⁰ Constitution of Spain, (1978), https://www.constituteproject.org/constitution/Spain_2011.

хэрэг маргааныг хянан шийдвэрлэх;

- Шүүхийн сахилгын хорооны шийтгэх тогтоолын эсрэг давж заалдсан хэрэг маргааныг хянан шийдвэрлэх зэрэг орно.²¹¹

Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг шүүгч болон хуульчдаас бүрдсэн Үндсэн хуулийн бие даасан байгууллага юм.²¹² Шүүхийн ерөнхий зөвлөл нь өөрийн бүрэн эрхийг Нэгдсэн хуралдаан болон хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Үүнд Эдийн засгийн хороо (англ. *The economic affairs committee*), Тэгш байдлын хороо (англ. *The equality committee*), Шүүхийн сахилгын хороо болон Байнгын хороо (англ. *The permanent committee*)-д багтдаг байна.

Эдийн засгийн хороо нь Нэгдсэн хуралдаанаас сонгогдсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Нэгдсэн хуралдаанаас даалгасан санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой төслийг судлах, хяналт тавих болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн жилийн төсвийг боловсруулж Нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх чиг үүрэгтэй.

Тэгш байдлын хороо бол Шүүхийн ерөнхий зөвлөл хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүйсийн тэгш байдлыг хэрхэн ханган ажиллах, хүчирхийллээс ангид байх нөхцөл бололцооны талаар Нэгдсэн хуралдаанд шаардлагатай зөвлөгөөг хүргэж ажиллах үүрэгтэй. Мөн жил бүр хүйсийн нөлөөллийн тухай тайланг бэлтгэж, шүүгчийн мэргэжлийн чиг үүргийг дэмжин ажилладаг.


Харин **Байнгын хорооны** хувьд дээрх гурван хороодын хэрэгжүүлж буй чиг үүргээс бусад Шүүхийн тухай хуулийн 560 дугаар зүйлд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Шүүхийн тухай хуулийн 603 дугаар зүйлд зааснаар **Шүүхийн сахилгын хороо** нь нийт 7 гишүүнтэй ба үүний 4 гишүүн нь шүүгчдээс, 3 гишүүн нь хууль зүйн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн хуульчдаас бүрддэг. Шүүхийн сахилгын хороог гишүүд дотроосоо хууль зүйн салбарт хамгийн удаан ажилласан ахмад гишүүн даргалдаг бөгөөд бүх гишүүдийн бүрэн ирцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байна. Нэгдсэн хуралдаанаар Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг 5 жилийн хугацаагаар томилдог. Шүүхийн сахилгын хорооны

²¹¹ Organic law 6/1985, of 1 July, on the Judiciary (1985).

²¹² "General Council of the Judiciary", Judiciary of Spain, <https://www.poderjudicial.es/cgpj/en/Judiciary/General-Council-of-the-Judiciary/>, (Сүүлд үзсэн:2025.04.25).

гишүүдээс хэн нэгэн хөдөлмөрийн чадвараа түр алдах, эсхүл тодорхойгүй хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахааргүй болсон тохиолдолд Байнгын хорооноос тухайн гишүүнийг ижил албан тушаал бүхий этгээдээр сольж болно.



б. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Испани Улсын Шүүхийн тухай хуулийн 604, 605 болон 606 дугаар зүйлд Шүүхийн сахилгын хорооноос шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэлийг хуульчилжээ. Шүүхийн сахилгын хороо нь шүүгчийг албан тушаал огцруулахаас бусад ноцтой, онц ноцтой зөрчил гаргасан сахилгын хэргийг хянан шийдвэрлэж, тохирох шийтгэлийг оногдуулдаг. Хэрэв Шүүхийн сахилгын хорооны шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл зөрчилд холбогдогч шүүгч 1 сарын дотор давж заалдах гомдлыг Нэгдсэн хуралдаанд гаргах эрхтэй.

Сахилгын зөрчлийн талаарх гомдлыг Сахилгын эрх бүхий төлөөлөгч (англ. *The Ombudsman for Disciplinary Action*)-д гаргах бөгөөд гомдлын дагуу хэрэг үүсгэж, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хуралд яллах чиг үүрэгтэйгээр оролцдог. Сахилгын эрх бүхий төлөөлөгчөөр улсын дээд шүүхийн шүүгч, эсхүл шүүгч мэргэжлээр 25-аас дээш жил ажилласан хүнийг Нэгдсэн хуралдаанаар сонгон томилдог.

Шүүхийн тухай хуулийн 416 дугаар зүйлд зааснаар шүүгчийн үйлдсэн сахилгын зөрчлийг онц ноцтой зөрчил (англ. *very serious infraction*), хүнд зөрчил (англ. *major infraction*), хөнгөн зөрчил (англ. *minor infraction*) гэж 3 ангилдаг. Мөн онц ноцтой зөрчил 2 жил, хүнд зөрчил 1 жил, хөнгөн зөрчил 6 сарын тус тус хөөн хэлэлцэх хугацаатай бөгөөд зөрчил үйлдсэн үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолдог.

Шүүхийн тухай хуулийн 417 дугаар зүйлд онц ноцтой зөрчил, 418 дугаар зүйлд хүнд зөрчил, 419 дүгээр зүйлд хөнгөн зөрчлүүдийг тус тус хуульчилсан байна:

Хүснэгт №6. Испани Улсын Шүүхийн тухай хуулийн 417,418 болон 419 дүгээр зүйл²¹³

Онц ноцтой зөрчил	Хүнд зөрчил	Хөнгөн зөрчил
• Үндсэн хуульд үнэнч байх үүргээ зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон; • Улс төрийн нам болон үйлдвэрчний эвлэлд нэгдсэн, үүрэг гүйцэтгэсэн; • Шүүгч, шүүгчийн эрх бүхий албан тушаалтанд шүүгчийн үүргээс бусад шалтгаанаар нөлөөлөх гэж оролдсон; • Бусад шүүгч, шүүгчийн чиг үүрэгт хөндлөнгөөс оролцох гэж оролдсон; • Шүүхийн Ерөнхий Зөвлөл энэ хуулийн 296 дугаар зүйлийн 2-т заасны хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлээгүй; • Энэ хуулийн 418 дугаар зүйлд заасан хүнд зөрчилд тооцогдоогүй байхад энэ хуулийн 388 дугаар зүйлд заасны дагуу шүүгчийн эрх хасах үйл ажиллагааг явуулсан; • Хэрэв шүүгч хуулийн хүрээнд тухайн хэрэг маргааныг үндэслэлгүйгээр зогсоосон, хянан шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй; • Шүүх хуралдааны хуваарийг үндэслэлгүйгээр удаа дараа хойшлуулсан;	• Дээд шатны шүүхийн албан тушаалтантай биечлэн болон олон нийтийн харилцаа холбоогоор үл хүндэтгэн харилцсан; • Бусад шүүгч, шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон; • Шүүгчийн байр сууринаас аливаа эрх бүхий албан тушаалтан, нийтийн байгууллагыг дэмжих, эсхүл шүүмжлэх; • Доод шатны шүүх хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд хууль эрх зүйн тогтолцоо, хэрэглээнд өөрчлөлт оруулах; • Шүүгч эрх мэдлээ хэрэгжүүлэн ажиллахдаа иргэн, хуулийн этгээд, шүүхийн нарийн бичгийн дарга, улсын яллагч, хуульч, өмгөөлөгч, цагдааг доромжлох; • Шүүгч шийдвэрийнхээ хууль эрх зүйн дүгнэлтийг хэт үндэслэлгүй, доромж утга агуулга бүхий үг хэллэг хэрэглэж гаргасан. Үүнийг зөвхөн давж заалдах болон дээд шатны шүүхийн мэдэгдлийн үндсэн дээр Шүүхийн Ерөнхий Зөвлөл хянан шалгана.	• Дээд шатны шүүхийг үл хүндэтгэсэн нь хүнд зөрчилд тооцоогдоогүй; • Ижил шатны болон доод шатны шүүхийг үл тоомсорлох, иргэн, хуулийн этгээд, шүүхийн нарийн бичгийн дарга, улсын яллагч, хуульч, өмгөөлөгч, цагдааг доромжилсон үйлдэх гаргасан; • Шүүгч хэргийг хянан шийдвэрлэх хуулийн хугацааг удаа дараа үндэслэлгүйгээр зөрчсөн; • Шүүгч нь албан үүргээ үндэслэлгүйгээр 1-3 хоногоор орхин явсан; • Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Дээд шатны шүүхийн Ерөнхийлөгчийн хуулийн дагуу гаргасан мэдэгдлийг зөрчих, мөрдөн байцаалт явуулахад саад уруулсан

²¹³ Organic law 6/1985, of 1 July, on the Judiciary (1985).

• Шүүгч нь албан үүргээ үндэслэлгүйгээр 7 ба түүнээс хоногоор орхин явсан; • Шүүгч тэтгэмж авах зорилгоор буруу мэдээлэл гаргаж өгсөн; • Шүүхийн хуралдааны явцад олж авсан мэдээллийг задруулж хэн нэгэн этгээдэд хохирол учруулсан; • Эрх бүхий албан тушаалтанд давуу эрх олгох зорилгоор эрх мэдлээ урвуулан ашигласан; • Шүүгчийн үүргээ гүйцэтгэхдээ ноцтой алдаа гаргасан; • Шүүхийн шийдвэрийг дутуу, үндэслэлгүй гаргасан нь эцсийн шүүхээр тогтоогдсон болно шүүхийн шийдвэрт давж заалдах боломжийг гомдол гаргагч талд олгоогүй; • Энэ хуулийн 427 дугаар зүйлд заасны дагуу хүнд зөрчил үйлдсэн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад ахин хүнд зөрчил үйлдсэн	• Шүүгч нь сахилгын зөрчил гаргасан шүүхийн хэрэг бүртгэгч, өөрийн харьяа албан тушаалтныг сахилгын шийтгэлээс чөлөөлөх; • Шүүх хуралдааны явцад мэдээлэл олж авсан, задруулсан үйлдэл нь энэ хуулийн 417 дугаар зүйлд заасан онц ноцтой зөрчил биш бол; • Шүүгч нь албан үүргээ үндэслэлгүйгээр 3-7 хоногоор орхин явсан; • Шүүх хуралдааны хуваарийг үндэслэлгүйгээр удаа дараа хойшлуулсан үйлдэл нь энэ хуулийн 417 дугаар зүйлд заасан онц ноцтой зөрчил биш бол; • Шүүгч шүүх хуралдаанаар гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр түр зогсоосон үйлдэл нь энэ хуулийн 417 дугаар зүйлд заасан онц ноцтой зөрчил биш бол; • Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Дээд шатны шүүхийн Ерөнхийлөгчийн хуулийн дагуу гаргасан мэдэгдлийг зөрчих, мөрдөн байцаалт явуулахад саад уруулсан; • Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан шүүхийн нэрийн жагсаалт, хэлэлцэх асуудлын жагсаалт гаргах журмыг зөрчсөн • Энэ хуулийн 389 дүгээр зүйлийн 5-д заасныг зөрчсөн, эсхүл хууран мэхлэх замаар үйлдсэн;	
--	--	--

	· Энэ хуулийн 221 дүгээр зүйлийн 3-т заасан журмын дагуу үндэслэлгүйгээр Удирдах зөвлөлийн шийдвэрээс татгалзсан; · Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баталсан жишиг үнэлгээний аргыг дагаагүй, процессын илт алдаатай шийдвэр гаргасан; · Хяналт, шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан; · Энэ хуулийн 427 дугаар зүйлд заасны дагуу хөнгөн зөрчил үйлдсэн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад ахин хөнгөн зөрчил үйлдсэн	
--	---	--

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Шүүхийн тухай хуулийн 420 дугаар зүйлд²¹⁴ шүүгчид оногдуулах хариуцлагын төрлийг дараах байдлаар хуульчилжээ:

- Анхааруулах;
- 6,000 хүртэлх еврогоор торгох;
- Одоо ажиллаж буй шүүхээс дор хаяж 100 километрийн зайтай өөр шүүх рүү албадан шилжүүлэх;
- Албан тушаалаас нь 3 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;
- Шүүгчийн албан тушаалаас огцруулах зэрэг хариуцлагын төрлүүдтэй.

Сахилгын хөнгөн зөрчилд анхааруулах болон 500 хүртэлх еврогоор торгох, эсхүл хоёр шийтгэлийг хамтад нь оногдуулдаг бол хүнд зөрчилд 501–6,000 хүртэлх еврогоор торгодог. Харин онц ноцтой зөрчилд албан тушаалаас нь түдгэлзүүлэх, албадан шилжүүлэх, эсхүл албан тушаалаас нь огцруулах шийтгэл оногдуулдаг.

Шүүхийн тухай хуулийн 421 дүгээр зүйлд²¹⁵ зааснаар хөнгөн зөрчилд Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн Удирдах зөвлөл (англ. *The Boards of Governance of the Supreme Court*), тухайн шатны шүүхийн Ерөнхийлөгч нар сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй. Хүнд зөрчилд Шүүхийн сахилгын хороо сахилгын шийтгэлийг

²¹⁴ *Ibid.*

²¹⁵ *Ibid.*

оногдуулдаг. Харин онц ноцтой зөрчилд Шүүхийн сахилгын хорооны саналыг үндэслэн Нэгдсэн хуралдааны шийдвэрээр сахилгын шийтгэлийг оногдуулдаг.

d. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Шигтгээ №25. Испани Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Испани Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэр²¹⁶

Эрүүгийн хэрэгт хянан шалгагдаж байх хугацаандаа яллагдагч нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан бөгөөд яллагдагчийн зүгээс гадуур мөрдөн байцаалт өгөх хүсэлтийг шүүхэд гаргажээ. Гэтэл шүүхийн зүгээс уг хүсэлтийг хүлээн авч шийдвэрлээгүй бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэвээр үлджээ. Испани улсын хуулиар мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад яллагдагч шүүхэд хууль ёсны дагуу үндэслэлтэй хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.

Иймд шүүгч хуульд заасан тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр Шүүхийн сахилгын хороонд гомдол гаргасан байна. Шүүхийн сахилгын хорооноос шүүгчид Шүүхийн тухай хуулийн 417.9-т заасны дагуу шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед үүргээ үл тоомсорлож онц ноцтой зөрчил гаргасан тул 5 сарын хугацаагаар үүрэгт ажлаас түр түдгэлзүүлэх сахилгын шийтгэл оногдуулжээ.

Эрх зүйн үндэслэл: Шүүгч нь өөрийн үүргээ биелүүлээгүй бөгөөд хууль эрх зүйн үндэслэлгүйгээр, холбогдох талуудын хүсэлтийг шийдвэрлэлгүйгээр хорих төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлсэн нь өөрөө онц ноцтой зөрчил гэж дүгнэжээ.

Тохиолдол 2. Испани Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2019 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр²¹⁷

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэгчтэй шүүгч нь хүндэтгэлгүй харилцсан бөгөөд удаан хугацааны туршид доромжилж, түрэмгий үг хэллэг ашиглаж, олон нийтийн дунд доромжилсон утга бүхий үг, үйлдлийг гаргажээ. Шүүхийн сахилгын хорооны зүгээс энэхүү үйлдлийг дан ганц хувийн харилцаа, хандлагын асуудал бус, харин шүүхийн тогтолцоо дахь шүүхийн нэр хүндэд заналхийлж буй үйлдэл гэж дүгнэсэн байна.

Шүүхийн сахилгын хороо нь энэхүү сахилгын хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ Испани улсын Үндсэн хуульд заасан хүний нэр төрийг гутаан доромжлохыг хориглох тухай зохицуулалтыг эш татаж, ажлын байранд зөрчил гаргасан шүүгчийн үйлдлийг холбогдох нотлох баримтаар бүрэн баримтжуулжээ. Шүүхийн сахилгын хороо зөрчил гаргасан шүүгчийг Шүүхийн тухай хуулийн 418.5-д заасны дагуу эрх мэдлээ ашиглаж шүүхийн захиргааны ажилтан, албан тушаалтныг доромжилж хүнд төрлийн зөрчил гаргасан гэж үзэн 6,000 еврогийн торгууль оногдуулжээ.

²¹⁶ Испани улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэр, 53 дахь тал. <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/ATENCION%20AL%20JUEZ/FICHERO/20210513%20Resumen%20sistematizado%20de%20resoluciones%20CGPJ%20materia%20disciplinaria%2011.2018%2012.2020.pdf> (Сүүлд үзсэн:2025.04.25).

²¹⁷ Испани улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны

Тохиолдол 3. Испани Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2018 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэр²¹⁸

Зөрчилд холбогдогч шүүгч нь хэд хэдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хууль зүйн үндэслэлгүйгээр удаашруулсан гэх зөрчилд холбогджээ. Уг сахилгын зөрчлийг Шүүхийн хяналтын ерөнхий зөвлөлийн тайланд үндэслэсэн бөгөөд шүүгчид хуваарилагдсан хэрэг маргааны тоо бага байсныг нотолсон байна. Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа удаашруулсан нөхцөл байдал нь дараагийн хэрэг маргааны шүүхийн шийдвэрийн чанарт нөлөөлж байсан ба хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 16 хэрэг маргаан байжээ.

Иймд Шүүхийн сахилгын хороо зөрчилд холбогдогч шүүгчийг Шүүхийн тухай хуулийн 418.11-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр удаашруулж хүнд зөрчил гаргасан гэж үзэн 1,000 еврогийн торгууль оногдуулжээ.

Дээрхээс харвал Испани Улсад шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэж байх явцдаа хууль зүйн үндэслэлгүйгээр, эсхүл хуулийн тодорхой зохицуулалтыг зөрчиж шийдвэр гаргасан тохиолдолд сахилгын зөрчил гаргасан хэмээн үзэж сахилгын шийтгэл оногдуулсан байна. Мөн шүүхийн албан ажилчидтай албаны хүрээнд ёс зүйгүй харилцсан тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулж болох нь ажиглагдлаа.

3.2.4. БҮГД НАЙРАМДАХ МОЛДАВ УЛС

Бүгд Найрамдах Молдав Улс (цаашид "Молдав Улс" гэх)-ын Үндсэн хуулийн²¹⁹ 116 дугаар зүйлийн 116.6 дахь хэсэгт "хуульд заасан үндэслэлээр шүүгчид хариуцлага оногдуулна" гэж заасан байх ба шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах харилцааг 2014 оны Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хууль²²⁰ (рум. *cu privire la*

2019 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр, 104 дэх тал. <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/ATENCION%20AL%20JUEZ/FICHERO/20210513%20Resumen%20sistematizado%20de%20resoluciones%20CGPJ%20materia%20disciplinaria%2011.2018%2012.2020.pdf> (Сүүлд үзсэн: 2025.04.25).

²¹⁸ Испани улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2018 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэр, 115 дахь тал. <https://www.poderjudicial.es/stfls/CGPJ/ATENCION%20AL%20JUEZ/FICHERO/20210513%20Resumen%20sistematizado%20de%20resoluciones%20CGPJ%20materia%20disciplinaria%2011.2018%2012.2020.pdf> (Сүүлд үзсэн: 2025.04.25).


²¹⁹ Конституция Республики Молдова: № 1 от 29 июля 1994 г. // Официальный монитор Республики Молдова. – 2016. – 29 марта. – № 78. – Ст. 140. // (Бүгд Найрамдах Молдав Улсын Үндсэн хууль: 1994 оны 7-р сарын 29-ний өдрийн №1 // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2016. – Гуравдугаар сарын 29. – № 78. – Х. 140), https://www.legis.md/cautare/getResults?doc_id=111918&lang=ro.

²²⁰ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей» // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587.), https://www.legis.md/cautare/getResults?doc_id=144930&lang=ro.

răspunderea disciplinară a judecătorilor)-аар нарийвчлан зохицуулсан байна. Тус улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг Сахилгын зөвлөл (рум. *Colegiului disciplinar*) болон Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл (рум. *Consiliul Superior al Magistraturii al Republicii Moldova – Colegiul disciplinar*)-д олгосон.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Сахилгын зөвлөл нь шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад болон огцорсны дараагаар үйлдсэн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэж, сахилгын шийтгэл оногдуулдаг.²²¹ Харин давж заалдах журмаар Сахилгын зөвлөлийн шийдвэрийг Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл хянаж эцсийн шийдвэрийг гаргадаг байна.



Сахилгын зөвлөл нь 4 шүүгч, 3 иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй²²² бөгөөд 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилогддог²²³. Сахилгын зөвлөлд

²²¹ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 8.1 ст. 8 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²² Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 9.1 ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²³ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 9.4 ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246.

Дээд шүүхийн шүүгч, Шүүгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн, Шүүгч-шалгагч (рум. *cu calitatea de inspector-judecător*), шүүхийн Ерөнхий шүүгч, дэд Ерөнхий шүүгч²²⁴ болон хууль тогтоох байгууллагын гишүүн, орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгч²²⁵ нар ажиллахыг хуулиар хориглодог.

Шүүгчдийн дундаас сонгогдох гишүүний хувьд 2-оос доошгүй жил шүүгчээр ажилласан тохиолдолд Сахилгын зөвлөлд нэр дэвших эрх нээгдэж, сонгуульт үйл ажиллагаа буюу сурталчилгаа явуулах боломж бий болдог ба Шүүгчдийн нэгдсэн чуулганы нууц санал хуралтаар хамгийн олон санал авсан шүүгчийг гишүүнээр сонгодог.²²⁶ Харин иргэний нийгмийн байгууллагаас сонгогдох шүүгч бус гишүүний хувьд, хууль зүйн салбарт 7-оос доошгүй жил ажилласан, нэр хүнд бүхий, нийгэмд танигдсан байх шалгуур хангасан этгээд²²⁷

– Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁴ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 9.2 ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁵ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 9.3 ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁶ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. ст. 10 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 10 дугаар зүйл // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁷ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 9.3 ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг

Шүүхийн дээд зөвлөл, Хууль зүйн яамны төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах хорооноос зарласан нээлттэй сонгон шалгаруулалт оролцох ба шалгарсан этгээдийг Хууль зүйн сайд томилдог байна²²⁸. Гэвч Сахилгын зөвлөлд нэр дэвшигчдийг хараат бус ёс зүйн хорооны үнэлгээнд хамруулах ба уг үнэлгээнд тэнцээгүй нэр дэвшигчийг томилох боломжгүй болдог²²⁹.

Б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуульд жагсаан хуульчилсан 14 төрлийн сахилгын зөрчлийг үйлдвэл шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл болох бөгөөд дараах зөрчлүүд хамаарна:

// Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁸ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 10.3 ст. 10 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²²⁹ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 10.3¹ ст. 10 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹ дахь хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

Хүснэгт №7. 2014 оны Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуульд заасан сахилгын зөрчил²³⁰

№	Шүүгчийн сахилгын зөрчлийн төрөл
1.	Хуульд заасан үндэслэлийн дагуу татгалзан гарах үүрэгтэй болохыг мэдэж байсан буюу мэдэх боломжтой байхад санаатайгаар болон хайхрамжгүй хандаж энэ үүргээ биелүүлээгүй, эсхүл удаа дараа үндэслэлгүйгээр татгалзаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах
2.	Шүүгч аливаа шийдвэр гаргахдаа Молдав улсын Үндсэн хууль болон тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод заасан иргэн, хуулийн этгээдийн үндсэн эрх, эрх чөлөөг зөрчих
3.	Бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох
4.	Бусад төрийн болон хувийн байгууллага, албан тушаалтантай харилцахдаа шүүгчийн албан тушаалын байдал, эрх нөлөөгөө хууль бусаар ашиглаж хүсэлт гаргах, өөртөө болон бусдад давуу байдал олгохыг шаардах
5.	Зөвлөлдөх тасалгааны нууц болон албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн нууцыг задруулах
6.	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг зөрчих
7.	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил таслах, хоцрох зэрэг нь шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх
8.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зайлшгүй мөрдөх хэм хэмжээг зөрчих
9.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогч болон шүүхийн ажилтан, бусад шүүгч нартай харилцахдаа зүй бус, зохисгүй хандлага гаргах
10.	Хэргийн оролцогчтой гадуур уулзах, аливаа хэлбэрээр харилцах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэмдэглэл үйлдэж хэргийн материалд хавсаргах
11.	Ёс зүйн үнэлгээнд хамрагдаагүй (ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үнэлгээ)
12.	Шүүгч-шалгагчийн үйл ажиллагаанд саад учруулах
13.	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдахаас үндэслэлгүйгээр татгалзах
14.	Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эсхүл бусад тохиолдолд шүүгчийн нэр хүндэд ноцтойгоор халдсан үйлдэл гаргах

Дээрх зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг 1) шүүгчийн үйлдлээс шалтгаалж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж буй этгээд, 2) Шүүхийн дээд зөвлөлийн гишүүн, 3) Шүүгчийг сонгон шалгаруулах хороо, 4) Шүүгч-шалгагч, 5) Хууль зүйн яамны төлөөлөл тус тус гаргаж болдог.²³¹

²³⁰ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», ст. 9 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238-246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380-382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 9 дүгээр зүйл // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238-246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380-382. – Х. 587).

²³¹ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной

Сахилгын зөрчлийг зүйлчлэхдээ тухайн шүүгч сахилгын зөрчил үйлдэх болсон зорилгыг тодорхойлох буюу санаатай²³² болон хайхрамжгүй²³³ үйлдлийг ялгана. Ингэснээр шүүгчийн үйлдсэн сахилгын зөрчлийн ноцтой байдал болон түүний хувийн нөхцөл байдал зэргийг харгалзаж сахилгын шийтгэлийг оногдуулах²³⁴ буюу шүүгчийн ажлын ачаалал, шүүгчид туслах хүний нөөцийн хомсдол, шүүгчийн ажиллах нөхцөл, үйлдсэн үйлдлийн шинж чанар, учруулсан үр дагавар зэргийг тодорхойлох замаар шийтгэл оногдуулах эсэхийг шийднэ.²³⁵

Сахилгын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн оролцогч 15 хоногийн дотор Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөлд давж заалдах гомдол гаргах ба тус зөвлөл гомдлыг хянан шалгаад шийдвэрийг хэвээр үлдээх эсхүл өөрчлөн шийдвэрлэнэ.²³⁶ Хөөн хэлэлцэх хугацааны тухайд, тухайн зөрчил гарснаас хойш 3 жилийн дотор Сахилгын зөвлөлд гомдол, мэдээлэл гаргах ёстой ба

ответственности судей», ст. 19 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 19 дүгээр зүйл // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²³² Санаатай үйлдэл гэдэгт: шүүгч материаллаг болон процесс хуулийн хэм хэмжээг зориуд зөрчих буюу тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь сөрөг үр дагавар үүсгэх болохыг ухамсарласан атлаа уг үр дагаврыг зориуд бий болгохыг эрмэлзсэн үйлдлийг хэлнэ.

²³³ Хайхрамжгүй үйлдэл гэдэгт: шүүгч материаллаг болон процесс хуулийн хэм хэмжээг зөрчсөн боловч түүний үйлдэл, эс үйлдэхүй нь сөрөг үр дагавар үүсгэх болохыг ухамсарлаагүй, гэхдээ тус нөхцөл байдлыг урьдчилан таамаглах боломжтой, үүрэгтэй байсан эсхүл тухайн сөрөг үр дагавар бий болохгүй гэж үзэж хийсэн үйлдлийн хэлнэ.

²³⁴ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 7.2 ст. 7 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²³⁵ Мөн тэнд.

²³⁶ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», ст. 39 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 39 дүгээр зүйл // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

холбогдогч шүүгчийг сахилгын зөрчил гаргасан болохыг дотоодын болон олон улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон тохиолдолд шийдвэр гарснаас 1 жилийн дотор эсхүл зөрчил үйлдэгдсэнээс хойш 5 жилийн дотор сахилгын хариуцлага тооцож болно гэж хуульчилжээ.²³⁷

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Шүүгч нь дээрх сахилгын зөрчлийн төрлүүдээс аль нэгийг үйлдсэн тохиолдолд гэм буруугийн хэлбэр болон зөрчлийн хэр ноцтой байдлаас хамааран дараах сахилгын шийтгэлийг оногдуулдаг:

- Анхааруулах (рум. *avertismentul*);
- Сануулах;
- Шүүгчийг албан тушаалаас огцруулах зэрэг юм.²³⁸

д. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Дээр дурдсанчлан тус улсад шүүгчийн сахилгын хэрэгт холбогдох асуудлыг Сахилгын зөвлөл хянан шийдвэрлэдэг ба тус улсын Шүүхийн дээд зөвлөлийн цахим хуудаст байршуулсан 2024 оны үйл ажиллагааны тайлангаас үзвэл, нийт 1357 гомдол ирснээс, оны төгсгөлд 186 гомдлын үлдэгдэлтэй, 1171 гомдлыг хэрэгсэхгүй болгож, мөн 14 гомдлыг шалгаад сахилгын хэрэг үүсгэж, 1 тохиолдолд анхааруулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.²³⁹ Сахилгын зөвлөлийн цахим хуудаст байршуулсан шийдвэрүүдээс үзвэл:²⁴⁰

²³⁷ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», ст. 5 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 5 дугаар зүйл // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²³⁸ Республика Молдова. Закон № 178 от 25.07.2014 «О дисциплинарной ответственности судей», п. 6.1 ст. 6 // Monitorul Oficial al R.M. – 2014. – № 238–246. – Ст. 557. С изм.: Закон № 226 от 31.07.2024 // Monitorul Oficial al R.M. – 2024. – № 380–382. – Ст. 587. // (Бүгд Найрамдах Молдав Улсын 2014.07.25-ны өдрийн № 178 «Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай» хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин – 2014. – № 238–246. – Х. 557. 2024.07.31 өдрийн № 226 нэмэлт, өөрчлөлт // Бүгд Найрамдах Молдав Улсын албан ёсны сонин. – 2024. – № 380–382. – Х. 587).

²³⁹ Молдав улсын Шүүхийн дээд зөвлөлийн 2024 оны тайлан, https://www.csm.md/files/RAPOARTE/2024/final_Raport_CSM_2024.pdf, (Сүүлд үзсэн: 2025.05.16).

²⁴⁰ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, “МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20, 50.1.23, 50.1.27, 50.1.40 дэх заалтуудад холбогдох судалгаа”, 2024, 4 дэх талд орчуулсан Молдав улсын Сахилгын зөвлөлийн шийдвэрийг эшлэв.

Шигтгээ №26. Молдав Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол**Тохиолдол 1. Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл (давж заалдах шат)-ийн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 189/6 дугаар шийдвэр²⁴¹**

Молдав Улсын шүүгч Andrei Niculcea нь 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр ІІІ Sor-д холбогдох эрүүгийн хэргийг хэлэлцэж, Эрүүгийн хуулийн 196 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж шийдвэрлэж, 7.5 жилийн хорих ял оноожээ. Молдав Улсын Эрүүгийн хуульд зааснаар шүүгч нь шийтгэх тогтоолыг 30 хоногийн дотор уншиж танилцуулж, шийтгэх тогтоол (эх хэл, шаардлагатай бол орчуулга)-ыг гардуулах үүрэгтэй бөгөөд хэргийн нарийн байдлаас шалтгаалан шийтгэх тогтоолыг товлосон хугацаанд гаргах боломжгүй онцгой нөхцөл байдал байгаа бол 15 хоногоос илүүгүй хугацаагаар шийтгэх тогтоол гаргах хугацааг хойшлуулдаг байна. Тус шүүгч нь 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдөр шийтгэх тогтоолыг уншиж танилцуулсан байна. 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн дотор хэргийг давж заалдах шатны шүүхэд явуулах ёстой байсан боловч 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр буюу 150 гаруй хоногийн хоцролттойгоор давж заалдах шатны шүүхэд хэргийг хүргүүлсэн байна. Шүүгч нь тус алдааг тайлбарлахдаа орчуулга хийхэд хугацаа алдсан гэсэн байна.

Сахилгын зөвлөлөөс хэргийг хянаад: Эрүүгийн хуульд заасан хэргийн нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан шийтгэх тогтоолыг товлосон хугацаанд гаргах боломжгүй онцгой нөхцөл байдал гэдэгт орчуулга хийхэд хүндрэл гарсан гэдэг нь хамаарах бөгөөд хуульд шүүгч шийтгэх тогтоолыг уншиж танилцуулж, шийтгэх тогтоол (орчуулга мөн хамаарна)-ыг гардуулах дээд хугацааг заасан байхад Andrei Niculcea нь хуульд заасан хугацааг хэтрүүлсэн байна гээд сахилгын хариуцлага оногдуулжээ.

Давж заалдах шатны шүүхээс хянаад: 4(1) i-д заасан зөрчлийг тогтоохдоо шүүгчийн хууль бус үйлдэл нь хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл болон хохирол хооронд шалтгаант холбоотой байх ёстой. Шүүгч нь үйлдлээ гэм буруутай буюу санаатай үйлдсэн байх зэргийг харгалзана. Энэ тохиолдолд Andrei Niculcea нь сахилгын зөрчил үйлдсэн байна гэжээ.

Тус улсын хувьд шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүгчийн гаргасан сахилгын зөрчил болон хохирол хоорондын шалтгаант холбоог нягтлан шалгасны үндсэн дээр сахилгын шийтгэлийг оногдуулдаг болох нь харагдаж байна.

3.2.5. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС


Бүгд Найрамдах Латви Улс (цаашид "Латви Улс" гэх)-ын хувьд шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх журам, сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэлийг Шүүхийн сахилга,

²⁴¹ Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл (давж заалдах шат)-ийн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 189/6 дугаар шийдвэр, https://www.csm.md/files/Hotarirele_CDisciplinar/2018/CA2/06/189-6.pdf, (Сүүлд үзсэн: 2025.05.15).

хариуцлагын тухай хуулиар²⁴² (цаашид "ШСХтХ" гэх) зохицуулж байна. Түүнчлэн, уг хуулиар прокурорын албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулахтай холбоотой асуудлыг зохицуулсан байдаг. ШСХтХ-ийн хуульд зааснаар шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг Шүүхийн сахилгын хороо (англ. *Judicial Disciplinary Committee*) болон Улсын дээд шүүхийн дэргэдэх Сахилгын шүүх (англ. *Disciplinary Court*)-д олгожээ.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

ШСХтХ-ийн 2 дугаар зүйлд зааснаар Шүүхийн сахилгын хороо нь анхан шатны журмаар дүүргийн шүүх, бүс нутгийн шүүх, дээд шүүхийн шүүгчдийн сахилгын зөрчилтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг. Харин давж заалдах шатны журмаар 2010 онд Шүүх эрх мэдлийн тухай хуулийн²⁴³ 48¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу байгуулагдсан Улсын дээд шүүхийн дэргэдэх Сахилгын шүүх хянаж эцсийн шийдвэрийг гаргадаг байна.²⁴⁴



Шүүхийн сахилгын хороо

Шүүхийн сахилгын хороо нь ШСХтХ-ийн 2 дугаар зүйлд зааснаар Улсын дээд шүүхийн Захиргааны танхимаас 1 шүүгч, Иргэний хэргийн танхимаас 1 шүүгч, Эрүүгийн хэргийн танхимаас 1 шүүгч, Бүс нутгийн шүүхийн Захиргааны хэргийн танхимаас 1 шүүгч, Иргэний хэргийн танхимаас 1 шүүгч, Эрүүгийн хэргийн танхимаас 1 шүүгч, Дүүргийн захиргааны хэргийн шүүхээс 1 шүүгч, Бүс нутгийн Захиргааны хэргийн шүүх бүрэлдэхүүнээс 1 шүүгч, Дүүргийн (хотын) эрүүгийн шүүхээс 1 шүүгч, иргэний шүүхээс 1 шүүгч буюу нийтдээ 10 шүүгчийн

²⁴² Judicial Disciplinary Liability Law (1994), <https://likumi.lv/ta/en/en/id/57677-judicial-disciplinary-liability-law>.

²⁴³ On Judicial Power (1992), <https://likumi.lv/ta/en/en/id/62847-on-judicial-power>.

²⁴⁴ "Disciplinary Court", Republic of Latvia Supreme Court Senate, <https://www.at.gov.lv/en/par-augstako-tiesu/disciplinartiesa>, (Сүүлд үзсэн: 2025.04.21).

бүрэлдэхүүнтэй.

Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүгчдийн бага хурлаар дөрвөн жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно. ШСХТХ-ийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Шүүхийн сахилгын хорооны дарга болон дэд даргыг гишүүд дундаас сонгоно. Мөн тус хорооны хуралдаанд Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор, шүүгчдийн зөвлөгөөнөөс болон эдгээр субъектээс эрх хэмжээ олгогдсон этгээд нь зөвлөхөөр оролцож болно.

Сахилгын хороо нь шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шалгаад дараах шийдвэрийн аль нэгийг гаргана²⁴⁵:

- Сахилгын шийтгэл оногдуулах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхээр сахилгын хэргийн материалыг Ерөнхий прокурорын албанд хүргүүлэх;
- Шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөхийг санал болгох;
- Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох.

Улсын дээд шүүхийн дэргэдэх Сахилгын шүүх

Сахилгын шүүх нь ШСХТХ-ийн 2¹ дугаар зүйлд зааснаар Улсын дээд шүүхийн Захиргааны танхимаас 2 шүүгч, Иргэний танхимаас 2 шүүгч, Эрүүгийн танхимаас 2 шүүгч буюу нийт 6 шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Сахилгын шүүхийн бүрэлдэхүүн болон даргыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан (англ. *Plenary Session*)-аас 5 жилийн хугацаагаар, нууц санал хураалтаар сонгож, томилдог. Сахилгын шүүхийн бүрэлдэхүүнд буй шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл түүнд сахилгын шийтгэл оногдуулсан бол Сахилгын шүүхийн шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шинэ гишүүнийг нөхөн сонгоно. Мөн Сахилгын шүүхийн шүүгчид сахилгын хэрэг, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэсэн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуустал түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхээр зохицуулжээ.

Сахилгын шүүх нь дараах тохиолдолд хуралдаж шийдвэр гаргана:

- Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт давж заалдах гомдол гаргасан;
- Шүүхийн мэргэшлийн хорооноос²⁴⁶ шүүгчдийн мэргэшлийн

²⁴⁵ Judicial Disciplinary Liability Law, Section 7 (2).

²⁴⁶ Латви улсын Шүүхийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 1-д зааснаар Шүүхийн мэргэшлийн хороо нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх чиг үүрэгтэй.

үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг баталгаажуулах;

- Шүүхийн ерөнхий зөвлөл (англ. *The Judicil Council*)-ийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан маргааныг хянах;²⁴⁷
- Улсын ерөнхий прокурорын сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах гомдол гаргасан зэрэг асуудлыг хянан шийдвэрлэнэ.²⁴⁸

В. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэлийг ШСХтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгчид дараах тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэж болно" гэж хуульчилсан. Үүнд:

- Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийг санаатай зөрчсөн;
- Шүүгчийн үүргийг биелүүлээгүй, эсхүл аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хайхрамжгүй хандсан;
- Хүний нэр төрд халдсан, эсхүл Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг (Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээгээр шүүгчийн хараат бус байх, шударга, эрх тэгш хандах, шүүгчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн талаар зохицуулсан байдаг)²⁴⁹ зөрчсөн;
- Улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзээгүй;
- Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд²⁵⁰ заасан хязгаарлалт, хориглолтыг зөрчсөн зэрэг тохиолдлуудыг тус тус хамруулжээ.

ШСХтХ-ийн 3 болон 4 дүгээр зүйлд зааснаар Улсын дээд шүүхийн Ерөнхийлөгч, Хууль зүйн сайд, Бүс нутгийн шүүхийн Ерөнхийлөгч, Дүүргийн (хотын) шүүхийн Ерөнхийлөгч, Шүүхийн ёс зүйн комиссоос урьдчилсан хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдогч шүүгчээс бичгээр тайлбар мэдүүлэг авсны дараа сахилгын хэрэг үүсгэх эрхтэй. Түүнчлэн, холбогдогч шүүгчид сахилгын хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 3 сарын дотор, сахилгын зөрчил үйлдсэнээс хойш 4 жилийн

²⁴⁷ Латви улсын Шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн тогтолцооны бодлого, стратеги боловсруулах, мөн шүүхийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг хэрэгжүүлдэг хамтын эрх бүхий байгууллага бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргасан тохиолдлыг хамруулна.

²⁴⁸ Мөн тэнд.

²⁴⁹ Code of Judicial Ethics (2021), https://www.at.gov.lv/files/uploads/files/9_Tieslietu_padome/Dokumenti/CODE%20OF%20JUDICIAL%20ETHICS_EN.pdf.

²⁵⁰ Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials (2002), [https://likumi.lv/google_search.php?cx=007602629882570581132%3Af2wua_haduq&cof=F](https://likumi.lv/google_search.php?cx=007602629882570581132%3Af2wua_haduq&cof=FORID%3A11&sa=Mekl%C4%93t&num=20&lang_ui=lv&q=Law+on+Prevention+of+Conflict+of+Interest+in+Activities+of+Public+Officials) ORID%3A11&sa=Mekl%C4%93t&num=20&lang_ui=lv&q=Law+on+Prevention+of+Conf

дотор сахилгын шийтгэл оногдуулж болох ба Шүүхийн сахилгын хороо сахилгын хэргийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хянан шийдвэрлэхээр заасан байна.

Сахилгын хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны талаар ШСХтХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулжээ. Тус зүйлд зааснаар сахилгын хэргийг Шүүхийн сахилгын хорооны дарга эсхүл түүний орлогч болон 4 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх бөгөөд нэг талаас сахилгын хэрэг үүсгэсэн албан тушаалтан эсхүл түүний төлөөлөгч, нөгөө талаас холбогдогч шүүгч шүүх хуралдаанд оролцоно. Холбогдогч шүүгч сахилгын шүүх хуралдаанд ирээгүй, эсхүл түүний эзгүйд хянан шийдвэрлэх тухай хүсэлт гаргасан бол Шүүхийн сахилгын хороо түүний эзгүйд сахилгын хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй.

c. Сахилгын хариуцлагын төрлүүд

ШСХтХ-ийн 7 дугаар зүйлд шүүгчид оногдуулах сахилгын хариуцлагын төрлүүдийг хуульчилсан байх ба үүнд:

- Тэмдэглэл үйлдэх (англ. *Annotation*);
- Сануулах (англ. *Reprimand*);
- Цалингийн хэмжээг 1 жил хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах
- Ажлаас чөлөөлөх зэрэг сахилгын шийтгэлийн төрөлтэй.

Шүүхийн сахилгын хороо холбогдогч шүүгчид дээрх сахилгын шийтгэлийг оногдуулахдаа сахилгын зөрчлийн шинж чанар, түүний үр дагавар, гэм буруугийн хэлбэр, шүүгчийн албан тушаал хашиж байх үеийн зан байдал, үйлдлүүдийг харгалзан үзэхээр хуульчилжээ. Мөн нэг сахилгын зөрчилд давхар сахилгын шийтгэл оногдуулдаггүй.

d. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

"Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд санаатайгаар (англ. *intentional*) хуулийг зөрчсөн" гэх үндэслэлээр сахилгын хариуцлага оногдуулсан жишээг дурдвал:

Шигтгээ №27. Латви Улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Шүүгч Валдис Муйжниекс-д холбогдох сахилгын хэрэг²⁵¹

Нэгэн эрэгтэй эхнэртээ бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэргээр сэжиглэгдэн, хоригдсон. Шүүхээс сэжигтнийг цагдан хорьсон боловч, цагдан хориог сунгахгүйгээр сулласан. Сэжигтэн хохирогчтой уулзахыг хориглох тухай захирамжийг 5 удаа зөрчсөн тул, цагдаагийн байгууллага түүнийг дахин цагдан хорих хүсэлт гаргасан. Гэвч шүүгч Валдис Муйжниекс нь өмнөх шүүхийн шийдвэрээр тогтоосон хүчирхийллээс хамгаалах түр арга хэмжээг цуцалсан бөгөөд тухайн өдөр сэжигтэн нь хохирогчийг хулгайлахыг завдсан байна.

Шүүгч Валдис Муйжниекс нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө хүчирхийллээс хамгаалах түр арга хэмжээг авах ба шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд шүүгч нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн хүсэлтийн дагуу түр арга хэмжээг хүчингүй болгох шийдвэр гаргана гэх заалтыг үндэслэн хүчирхийллээс хамгаалах түр арга хэмжээг цуцалсан.

Гэвч шүүгч шийдвэр гаргахдаа шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэл гаргасан эсэх, хүсэлтэд ямар үндэслэлүүд байгаа эсэх, хохирогч нь аливаа аюулд байгаа эсэхийг харгалзан үзээгүй бөгөөд хүчирхийллээс хамгаалах түр арга хэмжээ авагдсан байх үед хохирогчид халдсан удаа дараагийн үйлдэл, сэжигтэн нь хэд хэдэн гэмт хэрэгт сэжиглэгдсэн байгаа зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэхгүйгээр дүгнэлт гаргасан. Эдгээр мэдээлэл нь хэргийн материал болон Шүүхийн мэдээллийн системд байсан боловч шийдвэр гаргахдаа ашиглаагүй байна. Энэ нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүчирхийллээс хамгаалах түр арга хэмжээг цуцлах тухай зүйл заалтыг санаатай зөрчсөн хэмээн үзсэн байна.

Дээрх тохиолдлоос харвал шүүгч хэргийг хянан шийдвэрлэхдээ нягтлан шалгах ёстой байсан баримтуудтай гүйцэт танилцаагүй, бусад нөхцөл байдлыг харгалзан үзэлгүйгээр шийдвэр гаргасан гэх үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулсан байна.

3.2.6. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Бүгд Найрамдах Франц Улс (цаашид "Франц Улс" гэх)-ын Үндсэн хууль²⁵²-ийн 64 дүгээр зүйлд Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь шүүх эрх мэдлийн хараат бус байдлын баталгаа бөгөөд Шүүхийн дээд зөвлөл (фр. *Le Conseil supérieur de la magistrature*) түүнд тус үүргийг хэрэгжүүлэхэд тусална гэж Үндсэн хуулийн байгууллагын статустайгаар²⁵³ хуульчилжээ. Мөн 65 дугаар зүйлд Шүүхийн дээд

²⁵¹ Judge Viesturs Muižnieks – Domestic Violence Case, https://eng.lsm.lv/article/society/society/06.03.2024-judges-decision-under-scrutiny-in-domestic-violence-case.a545692/?utm_source=chatgpt.com, (Сүүлд үзсэн: 2025.07.04)

²⁵² Constitution du 4 octobre 1958, <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000571356/>

²⁵³ Шүүхийн дээд зөвлөлийн албан ёсны цахим хуудас, <https://www.conseil-superieur->

зөвлөлийн эрх зүйн үндсийг дэлгэрэнгүй зохицуулсан буюу тус зөвлөл нь шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангах; шүүгч, прокурорыг томилох; шүүгч, прокурорт холбогдох сахилгын асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Шүүхийн дээд зөвлөл нь шүүгчдийн болон прокурорын гэсэн 2 хэсгээс бүрдэх²⁵⁴ бөгөөд Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хууль (Loi organique n° 94-100 du 5 février 1994 sur le Conseil supérieur de la magistrature)²⁵⁵-аар тус зөвлөлийн эрх зүйн байдал, үйл ажиллагааг дэлгэрэнгүй хуульчилсан байна.

Шигтгээ №28. Франц Улсын Үндсэн хууль, VIII гарчиг

Шүүх эрх мэдэл

65 дугаар зүйл

Шүүхийн дээд зөвлөл нь шүүгчдийг харьяалах магистратуудын²⁵⁶ бүрэлдэхүүн болон прокуроруудыг харьяалах магистратуудын бүрэлдэхүүнээс бүрдэнэ.

Шүүгчдийг харьяалах магистратуудын бүрэлдэхүүн (цаашид "Шүүгчдийн суудал" гэх)-ийг Хяналтын шүүх (фр. *La Cour de Cassation*)-ийн Ерөнхий шүүгч (фр. *Le premier président*) даргална. Үүнээс гадна, 5 шүүгч, 1 прокурор, Захиргааны дээд шүүхээс томилогдсон гишүүн (фр. *un conseiller d'État désigné par le Conseil d'État*), Үндэсний хуульчдын зөвлөлөөс томилогдсон хуульч (фр. *un avocat*) болон парламент, шүүх, захиргааны эрх мэдэл (байгууллага)-ийн гишүүн биш, мэргэшсэн 6 иргэн байна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч (фр. *Le Président de la République*), Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч (фр. *Le Président de l'Assemblée nationale*), Сенатын Ерөнхийлөгч (фр. *Le Président du Sénat*) тус бүр 2 мэргэшсэн иргэнийг томилно. Мэргэшсэн иргэнийг томилоход 13 дугаар зүйлийн сүүлийн хэсэгт заасан журмыг мөрдөнө.²⁵⁷ Ерөнхийлөгчийн хийсэн томилгоог парламентын танхим бүрийн холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлнэ.

Прокуроруудыг харьяалах магистратуудын бүрэлдэхүүн (цаашид "Прокуроруудын суудал" гэх)-ийг Хяналтын шүүхийн Ерөнхий прокурор (фр. *Le procureur général*) даргална. Үүнээс гадна, 5 прокурор, 1 шүүгч, Захиргааны дээд шүүхээс томилогдсон гишүүн, мөн 2 дахь хэсэгт дурдсан хуульч болон мэргэшсэн 6 иргэн байна.

...

magistrature.fr/le-csm/composition-et-organisation

²⁵⁴ Article 65. The High Council of the Judiciary shall consist of a section with jurisdiction over judges and a section with jurisdiction over public prosecutors. <https://www.conseil-constitutionnel.fr/en/constitution-of-4-october-1958>

²⁵⁵ Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хууль, <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000364282/2025-08-18/>

²⁵⁶ Франц Улсын хувьд шүүгч болон прокурорыг хамтад нь магистрат (фр. *magistrats*) гэж нэрлэдэг.

²⁵⁷ Тус зүйлд заасны дагуу томилох процесс нь Ерөнхийлөгч нэр дэвшигчийг сонгож, нэрийг Үндэсний Ассамблей болон Сенатын холбогдох байнгын хороонд хүргүүлэх бөгөөд хоёр хорооны саналын нийлбэрийн тавны гурваас дээш нь сөрөг байвал тухайн нэр дэвшигчийг томилохгүй. Харин сөрөг саналын тоо

Шүүгчдийн суудал нь шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Ингэхдээ хоёр дахь хэсэгт заасан гишүүдээс гадна Прокурорын суудалд харьяалагддаг шүүгч багтана.

Прокурорт хүлээлгэх сахилгын арга хэмжээний талаар Прокурорын суудал дүгнэлт гаргана. Ингэхдээ гурав дахь хэсэгт заасан гишүүдээс гадна Шүүгчдийн суудалд харьяалагддаг прокурор багтана.

Шүүхийн дээд зөвлөл нь 64 дүгээр зүйлд заасны дагуу Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн гаргасан санал хүсэлтэд хариу өгөхөөр нэгдсэн хуралдаан (фр. *La formation plénière*)-аараа хуралдана. Шүүгчийн ёс зүйтэй холбоотой асуудал болон Хууль зүйн сайдын хандсан шүүхийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мөн хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Нэгдсэн хуралдаанд хоёр дахь хэсэгт дурдсан таван шүүгчийн гурав, гурав дахь хэсэгт дурдсан таван прокурорын гурав, Захиргааны дээд шүүхээс томилогдсон гишүүн, хуульч, хоёр дахь хэсэгт заасан эрх бүхий зургаан хүн багтана. Тус хуралдааныг Хяналтын шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлдэг бөгөөд түүнийг тухайн шүүхийн Ерөнхий прокуророор сольж болно.

Хууль зүйн сайд сахилгын асуудлаас бусад Шүүхийн дээд зөвлөлийн бүх хуралдаанд оролцож болно.

...

Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хууль²⁵⁸-д Шүүгчдийн суудал болон Прокурорын суудалд хамаарах бүрэлдэхүүнийг томилох журмыг үе шат бүрээр дэлгэрэнгүй хуульчилсан ба үүнээс шүүгч, прокурор бус гишүүд буюу Захиргааны дээд шүүхээс томилогдсон гишүүн, хуульч, мэргэшсэн 6 иргэний тухайд дараах байдлаар хуульчилжээ.

- Хуулийн 5 дугаар зүйлд, Захиргааны хэргийн дээд шүүхээс томилох гишүүнийг тус шүүхийн ерөнхий зөвлөлөөс сонгоно;
- Хуулийн 5-1 дүгээр зүйлд, Шүүхийн дээд зөвлөлийн бүрэлдэхүүнд орох хуульчийг Үндэсний хуульчдын зөвлөл (фр. *Le Conseil national des barreaux*)-ийн нэгдсэн чуулганаар батлуулсны дараа тус зөвлөлийн Ерөнхийлөгч томилно.
- Хуулийн 5-2 дугаар зүйлд, Үндсэн хуулийн 65 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага бүрээс томилогдох мэргэшсэн гишүүд (иргэд)-ийн томилгоо нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөллийг хангаж байх ёстой.

Мөн хуулийн 6 дугаар зүйлд зааснаар дээд зөвлөлийн гишүүдийг нэг удаа, 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд аль ч гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд захиргааны байгууллага болон нийтийн эрх мэдлийн байгууллагад ажиллаж болохгүй. Дээд зөвлөлийн гишүүд

хүрээгүй бол Ерөнхийлөгчийн зарлигаар томилох эрхтэй болно.

²⁵⁸ Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хууль, <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000364282/2025-08-18/>

нь бие даасан, хараат бус, шударга, нэр төртэй байх шаардлагыг биелүүлж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэн даруй таслан зогсоход анхаарч ажиллах үүргийн талаар тус органик хуулийн 10-1 дүгээр зүйлд заасан ба мөн зүйлд "Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь тухайн чиг үүргийг бие даан, хараат бус, бодитой хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсвэл нөлөөлж байгаа мэт харагдах нийтийн болон хувийн ашиг сонирхлын хооронд хөндлөнгөөс оролцох аливаа нөхцөл байдлыг хэлнэ" гэж хуульчилжээ.

Харин хуулийн хоёрдугаар хэсгийн 18 дугаар зүйлд Шүүхийн дээд зөвлөлийн сахилгын чиг үүрэг хэрэгжүүлэх бүрэлдэхүүний талаар зохицуулсан байна. Тус зүйлд зохицуулсны дагуу Шүүхийн дээд зөвлөлийн дэргэд иргэд (оролцогч)-ийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор "Гомдол (өргөдөл) хүлээн авах комисс" байгуулах бөгөөд комисс нь хоёр магистрат, мэргэшсэн хоёр иргэн, нийт дөрвөн гишүүнээс бүрдэнэ. Нэгдсэн хуралдааны тэргүүн (Хяналтын шүүхийн Ерөнхий шүүгч эсхүл Ерөнхий прокурор) комиссын дарга болон бүрэлдэхүүнийг жил бүр томилно.

Комиссын хурал 3 гишүүн оролцсоноор хүчинтэй болох ба олонхын саналаар шийдвэрээ гаргана. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд гомдлыг Шүүхийн дээд зөвлөлийн эрх бүхий байгууллага буюу Магистратуудын сахилгын зөвлөл (фр. *Le conseil de discipline des magistrats*)-д шилжүүлнэ. Мөн хуулийн 19 дүгээр зүйлд Шүүхийн эрх зүйн байдлын тухай органик хуульд магистратуудад хамаарах сахилгын арга хэмжээ, шийтгэлийн талаар зохицуулна гэж заасан байна.

В. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль²⁵⁹-ийн VII бүлэгт Магистрат (шүүгч, прокурор)-ын сахилга (фр. *Discipline*)-ын талаар зохицуулсан бөгөөд 1-р хэсэгт шүүгчийн сахилга, 2-р хэсэгт прокурорын сахилгын талаар дэлгэрэнгүй хуульчилжээ.

²⁵⁹ Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль, <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000339259>

Шигтгээ №29. Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль

43 дугаар зүйл

Магистрат нь албан үүргээ гүйцэтгэхдээ хараат бус (фр. *l'indépendance*), төвийг сахисан (фр. *l'impartialité*), ёс зүйд нийцсэн (фр. *l'intégrité*), шударга (фр. *la probité*), үнэнч байдал (фр. *la loyauté*), мэргэжлийн ухамсар (фр. *la conscience professionnelle*), нэр төр (фр. *l'honneur*), алдар хүнд (фр. *la dignité*)-ийг сахих, анхаарал болгоомжтой байх, нууц хадгалах үүргээ зөрчсөн аливаа үйлдэл нь сахилгын зөрчил (фр. *la faute disciplinaire*)-д тооцогдоно.

Түүнчлэн, хэрэв магистрат нь талуудад олгогдсон үндсэн эрхийн баталгааг хангахад зайлшгүй шаардлагатай процессын дүрмийг санаатайгаар, ноцтой зөрчсөн бөгөөд энэ нь эцсийн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол, уг үйлдэл албан үүргийн зөрчилд тооцогдоно.

...

Дээрх хуульд магистратуудад сахилгын хариуцлага оногдуулах журам, процессыг дэлгэрэнгүй хуульчилж, мөн 43 дугаар зүйлд "сахилгын зөрчил"-ийн талаарх тодорхойлолтыг хийсэн байдаг. Харин Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хуулийн 20-2 дугаар зүйлд Шүүхийн дээд зөвлөл нь магистратуудын ёс зүйн дүрмийн эмхэтгэлийг боловсруулж, нийтлэх үүргийг хуульчилсны дагуу Магистратуудын ёс зүйн дүрмийн эмхэтгэл²⁶⁰ (фр. *Recueil des obligations déontologiques des magistrats*)-ийг баталсан байна.

Тус ёс зүйн дүрмийн эмхэтгэл нь магистратуудын дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг тодорхойлсон албан ёсны баримт бичиг(удирдамж) бөгөөд тус эмхэтгэлийг магистратын үйлдэл сахилгын зөрчилд хамаарах эсэхийг тодорхойлох шалгуур, лавлах эх сурвалж болж хэрэглэгддэг. Тус ёс зүйн эмхэтгэлд тодорхойлсон ёс зүйн үүргийг сахин биелүүлэх нь магистратад албан тушаалын үүрэг, хариуцлагаа зөрчихөөс сэргийлэхийн тулд "болгоомжтой байх" ерөнхий зарчим (фр. *principe de prudence générale*)-ыг агуулдаг. Болгоомжтой байх зарчмын агуулга нь магистрат хууль зөрчөөгүй ч гэлээ тухайн нөхцөл байдлыг талууд болон олон нийт хэрхэн хүлээн авч ойлгож болохыг харгалзан үзэж, шүүхийн тогтолцооны нэр хүнд, эрх мэдлийг хамгаалж байх ёстой ба энэ хүрээнд олон нийт, оролцогч талууд түүнийг сэжигтэй, шударга бус гэж хүлээн авах эрсдэлтэй бол шүүгч тухайн үйлдлийг хийхээс татгалзах ёстой юм.

²⁶⁰ Магистратуудын ёс зүйн дүрмийн эмхэтгэл, https://www.courdecassation.fr/files/files/D%C3%A9ontologie/CSM_recueil_des_obligations_deontologiques_des_magistrats.pdf

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хуулийн 45 дугаар зүйлд магистратад оногдуулах сахилгын шийтгэлийг дараах байдлаар хуульчилсан байна.

Шигтгээ №30. Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль, 45-р зүйл

Магистратад оногдуулах сахилгын шийтгэл нь:

1. Сануулга өгч, хувийн хэрэгт тэмдэглэх;
2. Албадан шилжүүлэх (харьяалагдах шүүхийг өөрчлөх);
3. Таваас дээшгүй жилийн хугацаанд шүүгчийн зарим чиг үүргийг хязгаарлах;
- 3¹. Арваас дээшгүй жилийн хугацаанд шүүгчийн албан тушаалд томилохыг хориглох;
4. Шүүгчийн зэргийг бууруулах;
- 4¹. Хоёроос доошгүй жилийн хугацаанд цалинг бүхэлд нь болон хэсэгчлэн хасаж, албан тушаалаас түр чөлөөлөх;
5. Албан тушаал бууруулах
6. Магистрат нь тэтгэвэрт насанд хүрээгүй бол албадан тэтгэвэрт гаргах эсхүл шүүгчийн үйл ажиллагааг дуусгавар болгох;
7. Ажлаас халах.

Түүнчлэн тус хуулийн 44 дүгээр зүйлд аливаа сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхгүй ч Хууль зүйн хяналтын ерөнхий газар²⁶¹-ын Ерөнхий байцаагч (фр. *L'inspecteur général*), Хууль зүйн хяналтын ерөнхий газрын дарга (фр. *chef de l'inspection générale de la justice*), аливаа шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурорууд болон харьяалах тамгын газрын дарга нар чиг үүргийнхээ хүрээнд шүүгчдэд сануулга (фр. *l'avertissement*) өгөх эрхтэй гэж хуульчилжээ.

Сануулга өгснөөс хойш 5 жилийн хугацаанд дахин сануулга эсхүл сахилгын шийтгэл хүлээгээгүй тохиолдолд сануулгыг магистратын

²⁶¹ Франц улсад Хууль зүйн хяналтын ерөнхий газар (фр. *L'inspection générale de la justice*) гэж байдаг ба тус газар нь Хууль зүйн яамны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй, эсхүл Хууль зүйн яамны төсвөөс санхүүждэг, төрийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг нийтийн хуулийн этгээд, хувийн хуулийн этгээдэд хяналт шалгалт явуулах, судалгаа хийх, зөвлөгөө, дүгнэлт өгөх байнгын ажиллагаатай байгууллага юм. Тус газар нь чиг үүргийн хүрээндээ өөрийн хяналтад хамаарах байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлийг үнэлдэг. Дэлгэрэнгүйг Франц улсын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас дахь танилцуулга <https://www.justice.gouv.fr/ministere-justice/missions-organisation/inspection-generale-justice-aas-uzne-yu>.

хувийн хэргээс автоматаар устгана.

Мөн тус хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу магистрат нь хэд хэдэн сахилгын зөрчил гаргасан тохиолдолд тэдгээр зөрчлийг тус бүрд үнэлж, харин шийтгэлийг нэгтгэн оногдуулахаар зохицуулсан байна.

Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу шүүгчид холбогдох сахилгын хэргийн хувьд "Сахилгын зөвлөл шийдвэрээ захиргааны шийдвэрийн хэлбэрээр магистратад мэдэгдэх бөгөөд мэдэгдсэн өдрөөс эхлэн шийдвэр хүчин төгөлдөр болно. Харин прокурорт холбогдох сахилгын хэргийн хувьд Сахилгын зөвлөл дүгнэлт гаргах эрхийг хэрэгжүүлэх бөгөөд эцсийн шийдвэрийг Хууль зүйн сайд гаргадаг байна. Сахилгын зөвлөлийн шүүгчид холбогдох шийдвэр болон Хууль зүйн сайдын прокурорт холбогдох шийдвэрийг гомдол гаргасан этгээд "фр. *L'auteur de la plainte*" давж заалдах эрхгүй (фр. *n'est susceptible d'aucun recours*)" гэж хуульчилжээ.

Харин сахилгын хэрэгт холбогдсон шүүгч сахилгын шийдвэрийг давж заалдах талаар дээрх хуулиудад шууд зохицуулаагүй боловч Захиргааны шүүхийн хууль²⁶²-аар зохицуулсан захиргааны шийдвэрийн хууль ёсны байдлыг хянуулах гомдол (фр. *Le recours pour excès de pouvoir*) гаргаж болдог байна.

d. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Шүүх эрх мэдлийн байгууллагын тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу Франц улсын Шүүхийн дээд зөвлөлийн Сахилгын зөвлөлийн шийдвэрүүдийг тус зөвлөлийн албан ёсны цахим хуудсанд 1959 оноос хойш байршуулжээ.

Шигтгээ №31. Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль

57 дугаар зүйл

Сахилгын зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулна. Хэрэв нийтийн хэв журам, хувийн нууцыг хамгаалах зайлшгүй шаардлагатай, эсхүл эрх, ашиг сонирхолд аюул учрах онцгой нөхцөл байдал байгаа тохиолдолд Сахилгын зөвлөлийн шийдвэрээр шүүх хуралдааныг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хаалттай явуулж болно.

Сахилгын зөвлөл шийдвэрээ хаалттай хэлэлцэнэ.

Шийдвэр нь үндэслэлтэй бүхий байх ба нийтэд мэдээлнэ.

²⁶² Захиргааны шүүхийн хууль, https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070933/LEGISCTA000006150399/#LEGISCTA000006150399

Тус сахилгын зөвлөлийн шийдвэрүүдээс шүүгч болон прокурорт хамаарах жишээг авч үзье.

Шигтгээ №32. Франц Улсын шүүгчид хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Шүүхийн дээд зөвлөлийн шүүхийн Сахилгын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн S270 дугаар шийдвэр²⁶³

Шүүгч Х нь 1) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчид дуугүй байх эрхийн талаар санаатайгаар мэдэгдээгүй бөгөөд энэ талаар шүүгч Х-д удаа дараа анхааруулсан боловч хуульд нийцсэн, шударга байх үүргээ хэрэгжүүлээгүй; 2) 2021, 2022 оны дугаар шийдвэрүүдийн үндэслэлд хувийн бодол, үнэлэмжийн талаар дурдаж, хариуцагч болон өмгөөлөгчийн гутаан доромжилсон; 3) гэр бүлийн маргааныг шийдвэрлэх явцдаа өмгөөлөгчдийн тайлбарыг үл тоомсорлож, тайлбарыг тасалж байсан нь оролцогчдын тайлбараас үл шалтгаалан шүүгч шийдвэрээ аль хэдийн гаргасан мэт сэтгэгдлийг бий болгосон бөгөөд шударга, эелдэг байх үүргээ биелүүлээгүй; 4) шүүх хуралдааны үеэр хэргийн оролцогчид болон шүүхийн ажилтнуудтай зохимжгүй харилцдаг нь эелдэг, нэр төртэй байх үүргээ зөрчсөн; 5) шүүгдэгчийг шүүх хуралд хоцорч ирсэн гэх шалтгаанаар тайлбар хэлүүлээгүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, албан тушаалын үүргээ зөрчсөн; 6) шүүгч нь дээрх үйлдлүүдийг удаа дараа гаргаж, тогтолцооны нэр хүндийг унагаасан гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шалгажээ.

Шүүхийн дээд зөвлөлөөс гомдлын үндэслэл, холбогдох нотлох баримтуудыг үнэлээд дараах байдлаар дүгнэжээ:

- Шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулсан Үндсэн хуулийн зарчмын дагуу шүүхийн шийдвэрийн үндэслэл, шийдвэрлэх хэсгийг зөвхөн хуульд заасан тохиолдолд хянаж болно. Харин шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой, санаатай зөрчсөн тохиолдолд шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох акт (шийдвэр)-ыг хянан үзэж болно. Оролцогчдын эрхийн баталгаа болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг санаатай, ноцтой зөрчих нь албан тушаалын үүргийн зөрчил мөн. Гэсэн хэдий ч шүүхийн эцсийн шийдвэрээр тус зөрчил тогтоогдоогүй тул шүүгчийг үүргээ зөрчсөн гэж үзэх боломжгүй.
- Бусдыг хүндэтгэх, нэр төрд хүндэтгэлтэй хандах, хүнлэг байх нь шүүгчийн үүрэг хариуцлага юм. Хуульчдын холбооны хэд хэдэн хуульч Шүүгч Х-ийн зүгээс байнга хүндрэл, бэрхшээл учруулдаг, түүний зан авир үл хүлээн зөвшөөрөхүйц байгаа талаар мэдэгдэж байжээ. Шүүгч Х-ийн гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэдэг жишгээс харахад шүүх хуралдааныг идэвхтэй удирддаг, ингэхдээ талуудын хувьд тэгш бус нөхцөл үүсгэдэг, өмгөөлөгч болон оролцогчдын тайлбарыг сонсдоггүй, үл тоомсорлодог, зарим тохиолдолд шууд бусаар тайлбар сонсохоос татгалзсан болох нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдсон байна. Энэ талаар түүний шүүх хуралд оролцож байсан зарим хуульчид "шүүгч Х-ийн шүүх хуралд хандаж байгаа тус байдал нь шүүгч хэргийн талаар урьдчилсан дүгнэлттэй байгаагийн илрэл гэж ойлгогдоог бөгөөд шүүгч Х хувийн бодол, үнэлэмжээ нуудаггүй байсан" гэжээ. Цаашлаад шүүгч Х нь гэр бүлийн маргааны шүүх хурлын үеэр оролцогчдын эсрэг зохисгүй өнгө, аястай, ялангуяа маргааны үйл баримттай холбоотой хүнд хэцүү, эмзэг байдлыг гутаан доромжилсон, тохуурхсан үг хэллэг ашигладаг болох нь мөн шалгалтын явцад тогтоогдсон байна.

²⁶³ Франц улсын Шүүхийн дээд зөвлөлийн шүүхийн Сахилгын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн S270 дугаар шийдвэр, <https://www.conseil-superieur->

Дээрх байдлуудаар шүүгч Х нь шүүх байгууллагын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан байх ба дээрх үйлдлүүд нь сахилгын зөрчил мөн гэж шийдвэрлэжээ. Гэсэн хэдий ч шүүгч Х нь тус шийдвэр гарахаас тэтгэвэрт гарсан тул сахилгын шийтгэл оногдуулах боломжгүй тул шүүхийн Сахилгын зөвлөлөөс "хүндэт шүүгч (фр. *Le magistrat honoraire*)" цол олгохоос татгалзахыг Хууль зүйн сайд (фр. *Ministre de la justice*)-д зөвлөжээ.

Тохиолдол 2. Шүүхийн дээд зөвлөлийн прокурорын Сахилгын зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн P107 дугаар шийдвэр²⁶⁴

Прокурор Х нь 1) хэргийн оролцогч, шүүх байгууллагын эмэгтэй ажилчдын холбоо барих мэдээллийг олж авах зорилгоор шүүгчийн туслахад нэр дэвшигчийн анкет, жижүүрийн бүртгэл, эрүүгийн хэргийн мэдүүлэгт тусгагдсан хувийн мэдээлэл зэргийг урвуулан ашиглаж, хууль бус үйлдэл хийсэн; 2) шүүх байгууллагын эмэгтэй ажилчид болон хэргийн оролцогч эмэгтэйчүүд рүү ажлын утас болон и-мэйл хаягнаас холбогдож, мэргэжлийн харилцаанаас хэтэрсэн, зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн гадаад төрх, хувцаслалттай холбоотой уруу татсан агуулга бүхий харилцан яриа үүсгэдэг, эмэгтэйчүүд рүү удаан хугацаагаар ширтэх зэрэг үйлдлүүдийг удаа дараа гаргаж, тогтолцооны нэр хүндийг унагаасан, ёс зүйн үүргээ зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шалгажээ.

Шүүхийн дээд зөвлөлөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдолд дурдагдсан үйлдлүүд холбогдох нотлох баримтуудаар тогтоогдсон тул прокурор Х нь мэргэжлийн нэр хүндийг алдагдуулж, мэргэжлийн ёс зүйн үүргээ зөрчсөн сахилгын зөрчил мөн гэж дүгнэжээ.

Прокурор Х-ийн мэргэжлийн ур чадварыг шат шатны удирдлагууд нь үнэлдэг бөгөөд Х нь өөрийн үйлдлийн гэм буруугаа хүлээн зөвшөөрч байгаа тул түүнд шүүгчийн зэргийг бууруулах болон түүнийг албадан шилжүүлэх сахилгын шийтгэл оногдуулах дүгнэлт гаргажээ.

Дээрх тохиолдлоос харвал сахилгын зөрчилд холбогдогч шүүгчид шүүхийн нэр хүндийг унагаасан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, хэргийн оролцогч нартай хүндэтгэлгүй харилцсан гэх үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулсан. Гэвч тухайн шүүгч нь албан үүргээсээ чөлөөлөгдсөн байсан тул хүндэт шүүгч олгохоос татгалзах байдлаар сахилгын шийтгэлийг оногдуулсан байна. Эндээс зөрчилд холбогдогч шүүгч ажлаа өгсөн байсан ч сахилгын хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэдгийг харуулсан жишээ болжээ.

3.2.7. ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

2024 оны байдлаар ИБУИНХУ нь хараат бус шүүхийн индексээр 1-ээс 0.78 оноо авч дэлхийд 15 дугаар байранд бичигдэж байна. Энэхүү индексийн нэг хүчин зүйл нь төрийн эрх мэдлийн хязгаарлалт

magistrature.fr/missions/discipline/s270 (Сүүлд үзсэн: 2025.08.25).

²⁶⁴ Франц улсын Шүүхийн дээд зөвлөлийн прокурорын Сахилгын зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн P107 дугаар шийдвэр, <https://www.conseil-superieur-magistrature.fr/missions/discipline/p107> (Сүүлд үзсэн: 2025.08.25).

гэж тодорхойлсон.²⁶⁵ Тус улсын хувьд шүүхийн хараат бус байдалд ихээхэн анхаардаг, тиймдээ ч шүүгчид сахилгын шийтгэл оногдуулахад төрийн байгууллагын нөлөөг хязгаарласаар ирсэн бөгөөд уг асуудалд тун болгоомжтой ханддаг. Энэ нь олон баримтаас харагддаг, тухайлбал 1701 онд "Act of Settlement" батлагдсанаас хойш нэг ч дээд шатны шүүгчийг парламентын 2 танхимаар хэлэлцүүлж огцруулсан тохиолдол 300 жилийн түүхэнд байдаггүй. Түүнчлэн доод шатны шүүгчдийн хувьд зөвхөн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд л огцруулах шийтгэлийг оноох бөгөөд тухайн шийтгэл нь тун хязгаарлагдмал юм. Өөр нэг жишээ дурдвал JCIO-ийн цахим хуудсанд сахилгын хэргийн талаар нийтэлдэг боловч нууцлалыг маш сайн хийдэг.

Нөгөө талаас сахилгын хариуцлагын тогтолцоо нь бие шүүхийн даасан байдлыг алдагдуулахгүйгээр шүүгчийг ёс зүйтэй, хариуцлагатай байлгаснаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хангахад зайлшгүй шаардлагатай. Тиймдээ ч тус улсад 2005 онд Үндсэн хуулийн шинэчлэлийн хуулийг баталж, Англи Уэльсэд 2006 онд JCIO байгуулагдах гэх мэт шинэчлэлүүд хийгдсэн. Зарим тоо баримтуудаас үзвэл JCIO-д 2022–2023 онд 1620 гомдол ирсэн бол 2023–2024 онд 2394 гомдол ирж өмнөх онуудаас ихэссэн байгаагаас²⁶⁶ шүүгчийн сахилгын зөрчлийг хянуулахаар иргэдийн оролцоо ихсэж буйг харуулж байна.

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

ИБУИНХУ-д шүүхийн тогтолцоо нь Англи Уэльс, Шотланд, Умард Ирланд гэх 3 салангид хэсгээс бүрддэг.²⁶⁷ Гэхдээ судалгааны энэхүү хэсэгт Англи Уэльсийн эрх зүйн тогтолцоонд голчлон тулгуурлаж, Шотланд, Умард Ирландын эрх зүйн тогтолцооны зарим хэсгийг авч үзсэн болно.

ИБУИНХУ-ын парламентаас 2005 онд Үндсэн хуулийн шинэчлэлийн хууль (англ. *The Constitutional Reform Act 2005*)²⁶⁸-ийг баталсан. Тус хуулийн 4 дүгээр бүлэг шүүгчийн томилгоо болон хариуцлага (англ. *Judicial appointments and discipline*) хэсгийн 108–115 дугаар зүйлд шүүгчид хариуцлага оноох субьектийн талаар хуульчилжээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

²⁶⁵ World Justcie project website "Rankings" section, <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/global/2024/>.

²⁶⁶ JCIO Annual Report, 2023–2024, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/reportsandpublications/>

²⁶⁷ Шүүхийн академи, Гадаадын зарим орны шүүхийн тогтолцоо, (Улаанбаатар: Сэлэнгэпресс ХХК, 2024), 53–55 дахь тал.

²⁶⁸ Constitutional Reform Act (2005), <https://www.legislation.gov.uk/ukpga/2005/4/contents>.

Шигтгээ №33. ИБУИНХУ-ын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн шүүгчийн сахилгын шийтгэлтэй холбоотой зарим заалт

108-р зүйл. Сахилгын шийтгэл оногдуулах эрх

1. Хууль зүйн сайд нь Хавсралт 14-д жагсаасан албан тушаалтныг огцруулах эрх мэдлийг зөвхөн тогтоосон журам болон бусад шаардлагыг биелүүлсний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2. Шүүхийн ерөнхий шүүгч дараах эрх мэдлийг хэрэгжүүлж болох боловч зөвхөн Хууль зүйн сайдын зөвшөөрөлтэйгөөр, мөн тогтоосон журмыг дагаж мөрдсөний дараа хэрэгжүүлнэ.

3. Шүүхийн ерөнхий шүүгч нь шүүгчид албан ёсны зөвлөгөө, сануулга өгөх, анхааруулах эрхтэй (гэхдээ энэ хэсэг нь албан бус байдлаар эсвэл тодорхой албан тушаалтан руу хандуулаагүй зөвлөгөө, сануулгад хязгаарлалт тогтоохгүй).

4. Ерөнхий шүүгч дараах нөхцөл байдалд байгаа үед шүүгчийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болно:

- (а) эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа;
- (b) эрүүгийн хэрэгт ял авсан бөгөөд ялаа эдэлж байгаа;
- (c) гэмт хэрэгт буруутай нь тогтоогдсон бөгөөд тухайн үйлдэлтэй холбоотой тогтоосон журмын дагуу хянан шийдвэрлэгдэж байгаа.

5. Ерөнхий шүүгч дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд шүүгчийг түдгэлзүүлж болно:

- (а) гэмт хэрэгт буруутай нь тогтоогдсон;
- (b) тогтоосон журмаар албан тушаалаас чөлөөлөх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн;
- (c) шүүхийн нэр хүндийг хадгалахын тулд түдгэлзүүлэх шаардлагатай гэж Шүүхийн ерөнхий шүүгч болон Хууль зүйн сайд үзсэн бол.

109-р зүйл. Сахилгын шийтгэл оногдуулах эрх – Тайлбар

1. Энэ зүйл нь 108-р зүйлийн хэрэгжилтэд хамаарна.

2. Хэрэв тухайн этгээд Их Британийн аль нэг хэсэгт гэмт хэрэгт холбогдон эрүүгийн хэрэг үүссэн бөгөөд хэрэг дуусаагүй бол тэр хүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэж тооцно. Хэрэг эхлэх болон дуусах хугацааг тогтоох журмыг тусад нь зааж болно.

3. Хэрэв тухайн шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай хүсэлтийн санал тус бүрийг Парламентын хоёр танхимд мэдэгдсэн бол, дараах аль нэг үйл явдал болох хүртэл тэр этгээд хэргийг шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэж тооцно:

- (a) Аль нэг санал буцаагдсан;
- (b) Аль нэг санал өөрчлөгдөж, албан тушаалаас чөлөөлөх тухай санал биш болсон;
- (c) Аль нэг санал буцаагдсан, хүчингүй болсон эсвэл дэмжигдээгүй;
- (d) Хоёр танхим хоёулаа огцруулах тухай өргөн барьсан бөгөөд Хаанаас хариу мэдэгдэл ирсэн.

4. "Шүүхийн албан тушаал" гэдэг нь:

- (a) Ахлах шүүгчийн албан тушаал;
- (b) Хавсралт 14-д жагсаасан албан тушаалууд;

"Шүүхийн албан тушаалтан" гэдэг нь дээрх албан тушаалыг хашиж буй этгээдийг хэлнэ.

115-р зүйл. Процессын талаарх зохицуулалт

1. Ерөнхий шүүгч (англ. The Lord Chief Justice) Хууль зүйн сайдтай зөвшилцсөнөөр дараах процессын талаарх дараах зохицуулалтыг хийж болно.

- (a) шүүгчийн ёс зүйн алдаа гаргасан аливаа этгээдийн гомдлыг шалгаж тогтоох;
- (b) 110–112 дугаар зүйлд заасны дагуу хянан шалгах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах (өргөдөл, лавлагаа хийх гэх мэт).

Англи, Уэльсэд хууль зүйн сайд болон ерөнхий шүүгч сахилгын хариуцлага хүлээлгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй субъектүүд гэдэг нь хуулийн дээрх зохицуулалтаас харагдаж буй юм. Харин Шотландын хувьд Тэргүүн сайд (англ. *First Minister*) Шүүхийн ерөнхийлөгч (англ. *Lord President of the Court of Session*) гэх субъектүүд шүүгчийн сахилгын хэргийг хянадаг.²⁶⁹

Шигтгээ №33-д заасан хуулийн зохицуулалтаас үзвэл зөвлөгөө өгөх, сануулах, анхааруулах сахилгын шийтгэлийг оноох процесс харьцангуй энгийн байгаа нь харагдана. Харин шүүгчийг огцруулах нь онцгой асуудал бөгөөд тус улсын дээд шүүхийн шүүгчид (англ. *senior judge*) болон бусад доод шатны шүүхийн шүүгчдэд (англ. *lower-level judge*) ялгамжтай байдаг. Орон тооны шүүгчид буюу ИБУИНХУ-ын Дээд шүүх, Англи, Уэльсийн дээд шүүх, Англи Уэльсийн давж заалдах шатны шүүх зэрэг шүүхийн шүүгчдийг (англ. *senior judge*) парламентын танхим огцруулахыг хүлээн зөвшөөрснөөр тус улсын

²⁶⁹ "Complaining about personal conduct of judicial office-holders" article, <https://commonslibrary.parliament.uk/complaining-about-personal-conduct-of-judicial-office-holders/>

хаан огцруулна. Эсрэгээрээ хагас цагийн шүүгч буюу (англ. *fee-paid judges and tribunal members*)-ийг ерөнхий шүүгчийн зөвшөөрснөөр хууль зүйн сайд огцруулж болно.

Хуулийн дээрх заалт буюу Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн 115, 116, 117, 120, 121 дэх заалтуудад үндэслэн Англи, Уэльсэд 2023 онд Шүүхийн сахилгын хариуцлагын журмыг (англ. *The Judicial Discipline (Prescribed Procedures) Regulations*)²⁷⁰ батлан гаргасан. Энэхүү журамд Шүүхийн ёс зүйн мөрдөн шалгах газар буюу Хууль зүйн яамны дэргэд ажилладаг JCIO (англ. *The Judicial Conduct Investigations Office*)-ын эрх зүйн байдлыг зохицуулсан байна. Тус журамд зохицуулснаар Англи, Уэльсэд JCIO буюу шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага байх бөгөөд энэ нь тус улсын Хууль зүйн сайд, Ерөнхий шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд туслах, процессын шинжтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага гэж ойлгож болно. Гэхдээ энэхүү байгууллага нь Монгол Улсын ШСХ-той адил Үндсэн хууль, органик хуулиар хуульчлагдсан орон тооны байгууллага биш юм.

Б. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

ИБУИНХУ нь англо-саксоны эрх зүйн бүлд харьяалагддаг учраас бичмэл хууль тогтоомжид нарийвчилсан шинжтэй зохицуулалтыг төдийлөн сайн тусгаж өгөөгүй байдаг. Тиймдээ ч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан шиг нөхцөл бүрээр хуульчлаагүй. Харин тухайн улсад "зохисгүй үйлдэл" (англ. *misconduct*) гэсэн ерөнхий зарчим дээр тулгуурлан шүүгчийн шударга, хараат бус байдлыг алдагдуулж, шударга ёсонд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулах аливаа зан үйлийг зөрчвөл сахилгын шийтгэл оноох юм.

Англи Уэльсийн JCIO-ийн албан ёсны цахим хуудсанд дурдсанаар тухайн байгууллага нь зөвхөн шүүгчийн хувийн зан үйлийн талаарх гомдлыг хүлээж авах бөгөөд шүүгчийн шийдвэрлэж буй хэргийн талаар гомдол хүлээж авах боломжгүй гэсэн. Цаашлаад ямар асуудалд гомдол гаргаж болох, болохгүй зарим жишээг дурджээ. Эдгээрийг хүснэгтээр харуулбал:

²⁷⁰ The Judicial Discipline (Prescribed Procedures) Regulations, (2023), <https://www.legislation.gov.uk/ukxi/2023/1005/made>.

Шигтгээ №34. JCIO-д гомдол гаргах болон гаргаж болохгүй асуудлын жагсаалт²⁷¹

Гомдол гаргаж болох асуудал	Гомдол гаргаж болохгүй асуудал
- Нэхэмжлэгч, хуулийн этгээдийг дээрэлхэх (англ. <i>bullying</i>), дарамтлах (англ. <i>harassment</i>); - Арьс өнгө, хүйсээр ялгаварлан гадуурхсан эсвэл доромжилсон үг хэллэг ашигласан; - Уурлах, бүдүүлэг байдал гаргах, түрэмгийлэх, жишээ нь хашхирах; - Шүүгчийн статусаа буруугаар ашиглах, жишээлбэл хувийн ашиг сонирхлын үүднээс хувь хүн, байгууллагад нөлөөлөхийг оролдох; - Цахим орчныг зүй бусаар ашиглах, тухайлбал доромжилсон агуулга, эсвэл төрийн бодлогын талаарх мэдэгдэл зэрэг шүүхийн шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулах контент нийтлэх; - Иргэний, эрүүгийн болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хувийн оролцоотойгоо мэдээлэхгүй байх; - Шүүхийн шийдвэр гаргах хугацааг хойшлуулах; - Нэхэмжлэлийг шийдвэрлэх хугацааг хойшлуулах нь ихэвчлэн үндэслэлгүй, гурван сараас дээш хугацаагаар хойшлуулах; - Шүүх хурлын үеэр унтах.	- Шүүгчийн шийдвэр, тогтоол; - Шүүгчийн шийдвэр гаргахад нөлөөлөх хандлага; - Шүүгчийн нэг талд илүү удаан хугацаагаар өгсөн боломж; - Шүүгч гэрчийг мэдүүлэг өгөх, зарим баримт бичгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах; - Шүүгч нэг хүний нотлох баримтад нөгөө хүнийхээс илүү нааштай хандах; - Гомдол гаргагч нь шүүх өргөдлийг шүүгчид хуваарилсан эсэхийг тогтоогоогүй тохиолдолд өргөдлийг хянан шийдвэрлэх хугацааг хойшлуулахад; - Шүүгч нотлох хүний нотлох баримтад итгэхгүй байна гэж хэлэх, итгэл үнэмшилд эргэлзэх, үйлдлийг шүүмжлэх; - Шүүгч процессын журам зөрчих; - Шүүгч хэлэлцэж буй хэрэгтэй холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлэх; - Шүүгчийн тогтоосон зардал, хохирлын хэмжээ; - Шүүгчийн хэргийг өөр шүүгч, шүүхэд шилжүүлэхээс татгалзал; - Шүүгч хэргийг өөртөө үлдээх; - Шүүгч хэргийн оролцогчтой харилцахаас татгалзсан; - Залилан болон бусад эрүүгийн гэмт хэрэг; - Шүүхийн ажилтан, үйлчилгээтэй холбоотой асуудал; - Цагдаагийн, прокурорын байгууллага; - Хуульч, өмгөөлөгч.

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

Тус улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн 108 дугаар зүйлд шүүгчид оногдуулах шийтгэлийн төрлийг хуульчилсан. Үүнд:

²⁷¹ JCIO's website "What can I complain about?" section, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/what-can-i-complain-about/>.

- Албан ёсны зөвлөгөө өгөх (англ. *Formal advice*);
- Албан ёсоор сануулах (англ. *Formal warning*);
- Анхааруулах (англ. *Reprimand*);
- Огцруулах (англ. *Removal*) зэрэг хариуцлагууд багтаж буй юм. Тухайн шийтгэлийн төрлийг тус бүрээр нь онцлогийг нь авч үзье.

Шийтгээ №35. Сахилгын шийтгэлийн ноцтой байдлын түвшин ²⁷²			
№	Ноцтой байдлын түвшин (англ. <i>level of seriousness</i>)	Шийтгэл	Холбогдох ердийн хүчин зүйлүүд (англ. <i>typical relevant factors</i>)
1.	Зүй бус үйлдэл (англ. <i>misconduct</i>)	Албан ёсоор зөвлөгөө өгөх, сануулах	· Тогтсон зан үйлийн стандартыг зөрчсөн; · Зөрчлийн мөн чанар нь харьцангуй бага; · Хуулийн бүхэллэг байдал (англ. <i>law integrity</i>) бага хэмжээний ач холбогдолтой; · Хохирол, хохирлын эрсдэлийн хэмжээ бага, жишээлбэл нэр хүндэд хохирол учруулах.
2.	Ноцтой зүй бус үйлдэл (англ. <i>serious misconduct</i>)	Анхааруулах	· Тогтсон зан үйлийн стандартыг зөрчсөн; · Зөрчлийн мөн чанар нь ноцтой; · Хуулийн бүхэллэг байдал (англ. <i>law integrity</i>) чухал ач холбогдолтой; · Хохирол, хохирлын эрсдэлийн хэмжээ их, жишээлбэл сэтгэл санааны хямралд хүргэх.

²⁷² Judicial Discipline Misconduct and recommending sanctions, guideline, pp. 12–14, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/rulesandregulations/MisconductandRecommendingSanctions>.

3.	Маш ноцтой зүй бус үйлдэл (англ. <i>gross misconduct</i>)	Огцруулах	· Тогтсон зан үйлийн стандартыг зөрчсөн; · Зөрчлийн шинж чанар нь маш ноцтой; · Хуулийн бүхэллэг байдал (англ. <i>law integrity</i>) их хэмжээний ач холбогдолтой. Жишээлбэл шүүгчийн зан үйл болох хэд хэдэн зарчмыг мэдсээр байж эсхүл хайхрамжгүй үйлдлээр зөрчсөн; · Хохирол, хохирлын эрсдэлийн хэмжээ их, жишээлбэл бусдад их хэмжээний хохирол учруулах, эсвэл тухайн шүүгч ажиллах нь олон нийтийн итгэлийг алдуулах гэх мэт.
----	--	-----------	--

1.3.1. Албан ёсны зөвлөгөө өгөх – Хууль зүйн сайд болон Ерөнхий шүүгч нар ноцтой биш ч ёс зүйн зөрчилд хүргэх хангалттай зохисгүй үйлдэл байсан гэдэгт итгэлтэй байгаа тохиолдолд албан ёсны зөвлөгөө өгөх бөгөөд албан ёсны хариу өгөхийг бичгээр баталгаажуулж, тэмдэглэл хөтөлдөг байна.²⁷³

1.3.2. Албан ёсны сануулга өгөх – Шүүгч нь цаашид зохисгүй үйлдэл гаргавал илүү хатуу шийтгэл ногдуулах болно гэдгийг албан ёсоор мэдэгдэх шаардлагатай тохиолдолд албан ёсны сануулгыг ихэвчлэн өгдөг. Шүүгчийн зан авир нь хүлээн зөвшөөрөгдөхгүй, шүүх эрх мэдлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэдгийг мэдэж байх ёстой тохиолдолд уг шийтгэлийг онооно.²⁷⁴

1.3.3. Анхааруулга – Ноцтой зөрчил гаргасан боловч албан тушаалаас нь огцруулах босгыг хангаагүй тохиолдолд анхааруулга өгөх нь зүйтэй. Ийм тохиолдлуудад зохисгүй үйлдлүүдийн давтан тохиолдлууд эсвэл нэг онцгой ноцтой үйлдэл багтаж болно. Шүүхийн нэр хүндэд их хэмжээний хохирол учруулах эрсдэлтэй хэргүүдийг үйлдсэн бол мөн адил энэ ангилалд хамаарна. Нэгэнт шүүгчид анхааруулах шийтгэлийн хэрэг үүсвэл, цаашид буруутай үйлдлүүд илэрсэн тохиолдолд түүнийг огцруулах томоохон үндэслэл бий болно.²⁷⁵

²⁷³ *Ibid.*

²⁷⁴ *Ibid.*

²⁷⁵ *Ibid.*

1.3.4. Огцруулах – Албан тушаалаас огцруулах нь ихэвчлэн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд хэрэглэгдэх бөгөөд шүүгчийн хувьд ноцтой үр дагаварт хүргэнэ. Энэхүү шийтгэлийг санал болгож байгаа нь шүүгчийг шударга бус үйлдэл гаргаж шүүгч байх боломжгүй болгох ноцтой зөрчил гаргасан тохиолдолд ашиглах ёстой. Тус шийтгэлийг шүүгч ажлаас үргэлжлүүлэн хийх нь олон нийтийн өмнө өргөн хүрээний шүүхийн нэр хүнд, байр суурийг унагах ноцтой зөрчил гаргасан тохиолдолд огцруулах нь зүйтэй гэж үздэг.²⁷⁶

ИБУИНХУ-д Монгол Улстай нэгэн адил шүүгчид оноосон сахилгын хэргийг давж заалдаж, дахин хянуулах боломжгүй.²⁷⁷ Харин процессын шинжтэй зарим алдаа, дутагдлыг хянуулах эрхтэй бөгөөд хязгаарлагдмал хүрээнд л байдаг. Харин Умард Ирландын хувьд арай өөр процесстой бөгөөд 10 хоногийн дотор гарсан шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах боломжтой. Гэхдээ энэ нь гомдлыг хянан шалгах л процесс бөгөөд давж заалдах шинжтэй процесс биш.²⁷⁸

d. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Англи, Уэльсэд Монгол Улстай адилаар JCIO-ийн цахим хуудсанд шүүгчид оногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх тоймыг оруулдаг. Үүнээс сахилгын шийтгэлийн дөрвөн төрлийг оногдуулсан жишээг тус бүр авч үзье.

²⁷⁶ *Ibid.*

²⁷⁷ Minimum Judicial Standards V, Disciplinary proceedings and liability of judges, ENCJ Report 2014–2015, pp.172–176, https://www.encj.eu/images/stories/pdf/GA/Hague/encj_report_minimum_standards_v_adopted_ga_june_2015.pdf.

²⁷⁸ *Ibid.*

Шигтгээ №36. JCIO-ийн албан ёсны зөвлөгөө өгсөн шийтгэлийн жишээ²⁷⁹**Шүүгч Майкл Николсонд холбогдох хэрэг (2024 оны 11 сарын 12)****JCIO-ийн илтгэгч гишүүний мэдэгдэл:**

Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд зөвшөөрснөөр дүүргийн шүүгч Майкл Николсонд ёс зүйн алдаа гаргасан учраас "албан ёсны зөвлөгөө өгөх" шийтгэл оногдуулжээ.

Баримт

JCIO нь Хууль зүйн сайд болон Ерөнхий шүүгчид дараах тохиолдолд албан ёсны зөвлөгөө өгөх эсвэл албан ёсны анхааруулга өгөхийг зөвлөдөг. Үүнд:

(а) гомдолд дурдсан баримтын талаар маргаан байхгүй;

Шүүгчийн ёс зүйн гарын авлагад шүүгч өөрийн үүргээ биелүүлэхдээ хичээнгүй, анхааралтай байх ёстой гэж заасан байдаг.

2024 оны 1-р сард болсон шүүх хуралдааны дараа шүүгч захирамж гаргаагүй гэж гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гомдол гаргажээ.

Шүүгчийн тайлбар

Шүүгч захирамж гаргахдаа удсанаа зөвшөөрч, уучлалт гуйсан. Тэрбээр уг гомдлын талаар мэдэгдсэн даруйд мэдэгдсэн даруйд гомдлыг талуудад хүргүүлсэн. Шүүгчийн хувьд тэтгэвэрт гарсан ч хэсэг хугацаанд шүүхэд ажилладаг тул шүүхийн материалд хандах боломж нь хязгаарлагдмал байсныг тайлбарласан. Мөн шийдвэр гаргахаас өмнө их хэмжээний баримт бичиг судлах шаардлагатай байсан бөгөөд өөртөө сануулахаа мартсан гэжээ.

Шийдвэр

Ерөнхий шүүгч болон Канцлер нар JCIO-гийн зөвлөмжийг хүлээн авч, шүүх хуралдаанаас хойш таван сарын дараа шийдвэр гаргасан нь ёс зүйн зөрчил гэж үзсэн. Шүүгчийн алдаа хүлээн зөвшөөрсөн байдал, уучлал хүссэн нь, мөн асуудлыг шуурхай зассан нь шийтгэлийн хэлбэрийг тодорхойлоход харгалзан үзсэн.

²⁷⁹ Judicial Conduct Investigations Office. *Statement on District Judge Michael Nicholson*, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/disciplinarystatements/Statement7024/>.

Шигтгээ №37. JCIO-ийн албан ёсны сануулга өгсөн шийтгэлийн жишээ²⁸⁰**Шүүгч Рассел Блейкд холбогдох хэрэг (2025 оны 03 сарын 21)****JCIO-ийн илтэгч гишүүний мэдэгдэл:**

Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд зөвшөөрснөөр Рассел Блейк-д ноцтой ёс зүйн зөрчил гаргасны улмаас "албан ёсны сануулах" шийтгэл оноожээ.

Баримт

Шүүгч нар хуулийг үргэлж дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд өөрсдийн болон нийт шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдлээс зайлсхийх ёстой.

2024 оны 8-р сард ноён Блейк нь гэр бүлийнхээ өсвөр насны гишүүний дээд гарын хэсэгт алгадсан хэргээр цагдаагийн анхааруулга авсан.

Шүүгчийн тайлбар

Тэрээр үйлдлээ бүрэн хүлээн зөвшөөрч, үйлдлийн хариуцлагыг хүлээсэн. Тухайн шүүгчийн гэр бүлийн гишүүн түүн рүү хашхирч, орилж, нулимсан үед сэтгэл хөдлөлөө барьж чадаагүйгээ тайлбарласан. Тэрээр үйлдэлдээ маш их харамссан бөгөөд тухайн үед өөрт болон гэр бүлд нь хүнд нөхцөл байдал үүссэн байжээ.

Хорооны гишүүний дүгнэлт

2023 оны Шүүхийн Ёс Зүйн Дүрмийн дагуу Уэльсийн Ёс Зүйн Зөвлөх Хорооны томилогдсон гишүүн нь ноён Блейкийн үйлдлийг ноцтой ёс зүйн зөрчил гэж үзэж, огцруулах шийтгэлийн өмнөх шийтгэл болох "анхааруулах" шийтгэл өгөхийг зөвлөсөн.

Шийдвэр

Ерөнхий шүүгч болон хууль зүйн сайд нар хорооны гишүүний дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн ч бүх нотлох баримтыг нягтлан үзсэний үндсэн дээр "албан ёсны сануулах" шийтгэл өгөх шийдвэр гаргасан. Энэ шийтгэлийг өгөхдөө хэд хэдэн хөнгөвчлөх нөхцөлийг харгалзан үзсэн. Үүнд:

- Үйлдэл гаргах болсон нөхцөл байдал.
- Тухайн хүний агшин зуурын хариу үйлдэл байсан.
- Тухайн үед шүүгч Блейк нь эрүүл мэнд болон гэр бүлийн хүндрэлийг даван туулж байсан.
- Үйлдлээ шууд хүлээн зөвшөөрсөн, гүн харамссан байдал.
- Шүүгчийн хувьд урт хугацааны, өө сэвгүй ажиллаж байсан түүх, мөн тухайн үйлдэл нь түүний зан чанараас гадуур үйлдэл байсныг нотолно.

²⁸⁰ Judicial Conduct Investigations Office. *Statement on Mr Russell Blake JP*, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/disciplinarystatements/Statement11224/>.

Шигтгээ №38. Анхааруулга өгсөн шийтгэлийн жишээ²⁸¹**Шүүгч Адриан Жонсод холбогдох хэрэг (2025 оны 03 сарын 12)****ЈСЮ-ийн илтэгч гишүүний мэдэгдэл:**

Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд зөвшөөрснөөр Адриан Жонсыг магистратын шүүгчийн үүргээ биелүүлээгүй, үндэслэлтэй тайлбаргүйгээр жилд шаардагдах хамгийн бага хугацаанд шүүх хуралдаанд оролцоогүй тул "анхааруулах" шийтгэл оноосон байна.

Баримт

Магистратын шүүгчээр томилогдох үед тухайн хүн жилд дор хаяж 13 бүтэн өдөр (эсвэл 26 хагас өдөр) шүүх хуралдаанд суух үүрэг бүхий тангараг өргөдөг. Мөн шүүхийн бүрэлдэхүүнтэй тогтмол холбоотой байж, шүүгчийн үүрэгтээ үнэнч байгаагаа харуулах ёстой.

2023 оны Шүүхийн Ёс Зүйн Дүрэмд зааснаар, тухайн шүүгч шаардлагатай хугацаанд шүүх хуралдаанд суух үүргээ биелүүлээгүй бол бүс нутгийн ёс зүйн зөвлөх хорооны нарийн бичгийн дарга нь нэмэлт мөрдөн шалгалтгүйгээр албан тушаалаас нь чөлөөлөхийг санал болгож болно.

Шүүгч Жонс өмнөх гурван жилийн хоёрт нь шаардлагатай хугацаанд шүүх хуралдаанд сууж чадаагүй бөгөөд дүрэмд заасан хугацаанд тайлбар ирүүлээгүй тул Лондонгийн Ёс Зүйн Зөвлөх Хорооны орлогч нарийн бичгийн дарга түүнийг албан тушаалаас чөлөөлөхийг санал болгосон.

Шүүгчийн тайлбар

Шүүгч ирүүлсэн тайлбартаа ноён Жонс сүүлийн жилүүдэд хувийн хүндрэлийн улмаас шүүх хуралдаанд суух боломжгүй байсан гэдгээ тайлбарласан. Тэрээр 2005 оноос хойш шүүгчээр ажиллаж ирсэн бөгөөд цаашид магистратын шүүгчийн үүргээ биелүүлэхийн тулд зохицуулалт хийнэ гэж амласан.

Шийдвэр

Шүүгч Жонсийн тайлбарыг анхааралтай авч үзсэний үндсэн дээр Ерөнхий шүүгч болон Канцлер нар түүнийг албан тушаалаас огцруулахын оронд "анхааруулах" шийтгэл өгөх шийдвэр гаргасан. Энэ нь албан тушаалаас чөлөөлөхөөс өмнөх хамгийн хатуу шийтгэл юм.

²⁸¹ Judicial Conduct Investigations Office. *Statement on Mr Adrian Jones JP*, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/disciplinarystatements/Statement10524/>.

Шийтгээ №39. Огцруулсан шийтгэлийн жишээ²⁸²**Шүүгч Марк Хардингд холбогдох хэрэг (2025 оны 05 сарын 02)****JCIO-ийн илтэгч гишүүний мэдэгдэл:**

Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд зөвшөөрснөөр Марк Хардингийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлсөн. Учир нь тэрээр үндэслэлгүйгээр албан тушаалынхаа шаардлагатай хамгийн бага хугацаанд шүүх хуралдаанд суух үүргээ биелүүлээгүй байна.

Баримт

2023 оны Шүүхийн Ёс Зүйн Дүрэмд зааснаар, тухайн шүүгч шаардлагатай хугацаанд шүүх хуралдаанд суух үүргээ биелүүлээгүй бол Шүүхийн Ёс Зүйн Мөрдөн Шалгах Алба (JCIO) нь нэмэлт мөрдөн шалгалтгүйгээр албан тушаалаас чөлөөлөхийг санал болгож болно.

Хардинг нь 2018 оноос хойш шүүх хуралдаанд суухгүй, 2019 оноос хойш сургалтад хамрагдаагүй бөгөөд Англи, Уэльсийн Хөдөлмөрийн Шүүхийн Ерөнхийлөгч болон бүс нутгийн хөдөлмөрийн шүүгчдийн олон удаагийн холбоо барих оролдлогод хариу өгөөгүй байна.

Шүүгчийн тайлбар

JCIO-гийн тайлбар ирүүлэх хүсэлтэд хариу ирүүлээгүй.

Шийдвэр

Ерөнхий шүүгч болон Хууль зүйн сайд нар Хардингийг албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэр гаргасан. Учир нь тэрээр шүүгчийн үүргээ биелүүлээгүй, тайлбар ирүүлээгүй, шүүхийн үйл ажиллагаанд оролцохгүй удаан хугацаа өнгөрөөсөн байна.

Тус улсын шүүгчид холбогдох сахилгын хэрэг хянан шийдвэрлэж буй практикаас харвал, сахилгын зөрчил гаргасан нь тогтоогдсон, холбогдогч шүүгч өөрөө хүлээн зөвшөөрсөн, уучлал хүссэн болон бусад хөнгөрүүлэх нөхцөл байдал байгаа эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр шүүгчид сахилгын шийтгэл оногдуулдаг болох нь харагдаж байна.

3.3. ХОЛИМОГ ТОГТОЛЦООТОЙ УЛС**3.3.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС**

Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх)-ын хувьд шүүхийн тогтолцоо нь холбооны шүүхийн тогтолцоо болон муж улсын шүүхийн тогтолцоонд хуваагддаг ба муж улс бүр өөр өөрийн гэсэн

²⁸² Judicial Conduct Investigations Office. *Statement on Mr Mark Harding*, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/disciplinarystatements/Statement0725/>.

шүүхийн тогтолцоотой.²⁸³ Иймд шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо, процесс ч мөн адил холбооны болон муж улсын тогтолцооны дагуу харилцан адилгүй байдаг.

Холбооны шүүхийн шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах тогтолцоог Шүүхийн шинэчлэлийн тухай хуульд²⁸⁴ зохицуулсан. Энэ хуулийн дагуу холбооны шүүгчид холбогдох сахилгын хэргийг Холбооны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч (англ. *Chief judge of Federal circuit court*), Тусгай хороо (англ. *Special committee*), Холбооны тойргийн шүүхийн зөвлөл (англ. *Judicial Council of Circuit*) болон АНУ-ын шүүхийн бага хурал (англ. *Judicial Conference of the U.S. Courts*) тус тусын чиг үүргийн хүрээнд хяналт, шалгалтыг явуулж шийдвэр гаргадаг байна. Холбооны тойргийн шүүх (англ. *Federal circuit court*) бүр шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх Холбооны тойргийн шүүхийн зөвлөлийг байгуулан ажилладаг.

Харин муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо нь 20 дугаар зууны дунд үеэс эхлэн боловсронгуй болж, орчин үед бүх муж улсуудад ижил зарчмаар хэрэгжиж байна. 1960 онд Калифорни муж улс анх удаа шүүгчдийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгаж, шийтгэл оногдуулах эрх бүхий байгууллагыг байгуулсан ба түүнээс хойш 1980 он гэхэд бүх 50 муж улс ижил төстэй комиссуудыг өөр өөрийн муж улсын шүүхийн тогтолцоондоо бий болгожээ.²⁸⁵

Шүүгчдийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгаж, сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий байгууллага буюу Шүүгчийн ёс зүйн комисс (англ. *Judicial Conduct Commission*) нь муж улс бүрд өөр өөр нэршилтэй (англ. *commission, board, council, court, committee*) бөгөөд тэдгээрийн үүргийг тайлбарлахад олон төрлийн нэр томьёо (англ. *conduct, inquiry, discipline, qualifications, disability, performance, review, tenure, retirement, removal, responsibility, standard, advisory, and investigation*) ашиглагддаг.²⁸⁶ Шүүгчийн ёс зүйн комисс (цаашид "Комисс" гэх) байгуулах эрх зүйн үндэслэлийг тухайн муж улсын үндсэн хууль (28 муж улс), хууль тогтоомж (16 муж улс), шүүхийн

²⁸³ Шүүхийн академи, Гадаадын зарим орны шүүхийн тогтолцоо, (Улаанбаатар: Сэлэнгэпрэсс ХХК, 2024), 57 дахь тал.

²⁸⁴ "28 U.S.C. Chapter 16 §§ 351-364"-ийг нийтэд нь "Шүүхийн шинэчлэлийн тухай хууль, 2002 он" (англ. *Judicial Improvements Act of 2002*) гэж нэрлэдэг.

²⁸⁵ Charles Gardner Geyh, (Dec. 14, 2023), "Judicial Ethics and Discipline in the States", *State Court Report*, <https://statecourtreport.org/our-work/analysis-opinion/judicial-ethics-and-discipline-states>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

²⁸⁶ Gray, C. (2007), "How judicial conduct commissions work", *The Justice System Journal*, 28(3), 405. <https://www.tandfonline.com/toc/ujsj20/28/3?utm>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

дүрэм (7 муж улс) зэргээс харах боломжтой.²⁸⁷

а. Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъект

Холбооны шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо

1. Холбооны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч²⁸⁸

Холбооны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч сахилгын зөрчил гаргасан тухай гомдлыг шуурхай хянаж үзээд тухайн гомдол нь үндэслэлтэй эсэхийг тогтоох бөгөөд тийнхүү тогтоохын тулд хязгаарлагдмал шалгалтыг (англ. *limited inquiry*) явуулна.²⁸⁹ Ерөнхий шүүгч:

- Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлгүй;
- Зөрчилд холбогдсон шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн шүүхийн шийдвэр болон процесс (англ. *the merits of a decision or procedural ruling*)-той шууд холбоотой;
- Сахилгын зөрчил гаргасан тухай гомдол нь хэтэрхий жижиг (англ. *frivolous*) эсхүл хянан шалгахад зөрчил гаргасан нь тогтоогдоогүй;
- Хянан шалгахад сахилгын зөрчил гаргаагүй болох нь нотлох баримтаар нотлогдсон зэрэг тохиолдолд сахилгын зөрчил гаргасан тухай гомдлыг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгох шийдвэр²⁹⁰ эсхүл зохистой арга хэмжээ авсан болон нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гомдлыг шалгах шаардлагагүй болсон бол гомдлыг хаах²⁹¹ шийдвэр гаргана.

2. Тусгай хороо²⁹²

Хэрэв Ерөнхий шүүгч дээр дурдсан гомдлыг хүлээн авахаас татгалзаж хэрэгсэхгүй болгох, гомдлыг хаах шийдвэр гаргаагүй тохиолдолд Тусгай хороо байгуулах шийдвэр гаргана. Энэ хороо нь 5-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд Холбооны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч болон Холбооны тойргийн шүүх, Холбооны дүүргийн шүүхийн тэнцүү тооны шүүгчдээс бүрдэнэ. Тусгай хороо нь сахилгын зөрчил гаргасан тухай гомдол үндэслэлтэй эсэхийг тогтоохын тулд нарийвчилсан, өргөн хүрээ (англ. *investigation as extensive*)-тэй хяналт шалгалт хийх бөгөөд хянан шалгах ажиллагаа дууссан бол гаргасан зөрчил болон оногдуулах сахилгын шийтгэлийн тухай

²⁸⁷ *Ibid*, 406.

²⁸⁸ 28 U.S.C. 352: Review of complaint by chief judge.

²⁸⁹ Rules for Judicial-Conduct and Judicial-Disability Proceedings (2008), Article III. 11.(b).

²⁹⁰ 28 U.S.C. § 352(b).

²⁹¹ 28 U.S.C. § 352((b) 2).

²⁹² 28 U.S.C. § 353. Special committees.

тусгасан тайлангаа Холбооны тойргийн шүүхийн зөвлөлд хүргүүлнэ.

3. Холбооны тойргийн шүүхийн зөвлөл²⁹³ (цаашид "Шүүхийн зөвлөл" гэх)

Шүүхийн зөвлөлийн гишүүдийн тоог нарийвчлан хуульчлаагүй бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн тойргийн Ерөнхий шүүгч (англ. *Chief judge*) болон тухайн тойрогт ажилладаг адил тооны тойргийн шүүхийн шүүгч (англ. *Circuit judges*) болон дүүргийн шүүхийн шүүгчид (англ. *District judges*)-ээс бүрдэнэ.²⁹⁴ Тусгай хорооны тайланг Шүүхийн зөвлөл хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

- Шаардлагатай гэж үзвэл нэмэлт судалгаа хийх;
- Гомдлыг хэрэгсэхгүй болгох;
- Сахилгын шийтгэл оногдуулах шийдвэр гаргах (сахилгын шийтгэл оногдуулах шүүгчид тогтоосон хугацаанд хэрэг хуваарилахгүй байх, хаалттай болон нээлттэй сануулах);
- АНУ-ын шүүхийн бага хуралд шилжүүлэх.

Шүүхийн зөвлөл нь дээрхээс бусад төрлийн сахилгын шийтгэл оногдуулах тэр дундаа шүүгчийг огцруулах сахилгын шийтгэл оногдуулах эрхгүй²⁹⁵ бөгөөд шүүгчийг огцруулах нөхцөл байдал тогтоогдвол АНУ-ын шүүхийн бага хуралд сахилгын зөрчлийн хэргийг шилжүүлнэ.²⁹⁶ Гэхдээ Дампуурлын шүүхийн шүүгч болон магистрат шүүгчид огцруулах сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй.²⁹⁷ Шүүхийн зөвлөлийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдлыг АНУ-ын шүүхийн бага хуралд гаргана.

4. АНУ-ын шүүхийн бага хурал²⁹⁸

АНУ-ын шүүхийн бага хурал нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг холбооны шүүн таслах байгууллагын хамтын зөвлөл юм. Шүүхийн бага хурлын тэргүүлэгч нь АНУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч бөгөөд Холбооны тойргийн шүүхүүдийн Ерөнхий шүүгчид (13), Холбооны дүүргийн шүүхүүдийн Ерөнхий шүүгчид (12), Олон улсын худалдааны шүүхийн Ерөнхий шүүгч гэсэн нийт 27 шүүгчийн

²⁹³ 28 U.S.C. § 354. Action by judicial council.

²⁹⁴ 28 U.S.C. § 332(a)(1).

²⁹⁵ Насан туршдаа шүүгчээр ажиллахаар томилогдсон шүүгчийг огцруулах эрхгүй.


²⁹⁶ 28 U.S.C. § 354 (b).

²⁹⁷ Gray, C. (2015, May 19), "Federal judicial discipline", *Judicial ethics and discipline*, National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2015/05/19/federal-judicial-discipline/>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

²⁹⁸ 28 U.S.C. §355. Action by Judicial Conference.

бүрэлдэхүүнтэй.²⁹⁹ Шүүхийн бага хурал нь холбооны шүүхүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, шүүн таслах ажлыг сайжруулах зорилго бүхий хамгийн дээд түвшний зөвлөлдөх байгууллага болохын хувьд олон төрлийн чиг үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүний нэг нь сахилгын шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр болох шүүгчийг огцруулах шийдвэр гаргах бүрэн эрх юм. Уг бага хурлаас гаргасан шийдвэр эцсийн байна.

Шүүхийн бага хурал нь Шүүхийн зөвлөлөөс ирүүлсэн тайланд тусгасан шийдвэр гаргах процессыг хянан шалгаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт судалгаа хийсний дараагаар бага хурлын гишүүдийн олонхын саналыг үндэслэн тохиромжтой сахилгын шийтгэлийг оногдуулдаг. Шүүгч болон магистрат шүүгч хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхийн эцсийн шийдвэр гарсан тохиолдолд Шүүхийн зөвлөлийн шийдвэрээс үл хамааран Шүүхийн бага хурлын гишүүдийн олонхын саналаар шүүгчийг огцруулах шийдвэр гаргана. Шүүгчийг албан ажлаас нь огцруулах шийдвэр гаргасан бол шийдвэрээ Парламентын доод танхим (англ. *House of Representatives*)-д уламжилж шийдвэрлүүлэх үүрэгтэй.



²⁹⁹ 28 U.S.Code § 331. Judicial Conference of the United States.

Муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо

Муж улсын шүүгчийн сахилгын хэргийг тухайн муж улсын шүүхээс байгуулсан комисс хянан шийдвэрлэдэг бөгөөд комиссын бүрэлдэхүүн нь **шүүгч, өмгөөлөгч болон иргэдийн төлөөлөл** гэсэн холимог бүтэцтэй байдаг.³⁰⁰ Ингэснээр сахилгын хэргийг шийдвэрлэх үйл явцыг зөвхөн шүүгчдэд даатгахгүй, олон нийтийн төлөөллийн оролцоог хангаж **ил тод, хүлээн зөвшөөрөгдөхүйц** болно гэж судлаачид үздэг.³⁰¹

Зарим муж улсын комиссын бүрэлдэхүүний талаар нарийвчлан авч үзвэл, **Техас муж улсын Шүүгчийн ёс зүйн комисс** (англ. *State of Texas Commission on Judicial Conduct*) нь **13 гишүүнтэй бөгөөд гишүүдийг 4 жилийн хугацаагаар томилдог**. Энэ хорооны гишүүдийн 6 нь муж улсын шүүхийн шүүгч, 2 нь муж улсын хуульчдын холбооноос санал болгосон өмгөөлөгч, 5 нь муж улсын Ерөнхий сайдын санал болгосон иргэдийн төлөөлөгчдөөс бүрддэг.³⁰²

Харин **Пенсилвани муж улсын Шүүгчийн ёс зүйн комисс** (англ. *Judicial Conduct Board of Pennsylvania*) нь **12 гишүүнтэй бөгөөд гишүүдийг 4 жилийн хугацаагаар** томилдог. Үүнээс 6 гишүүнийг муж улсын Дээд шүүх, 6 гишүүнийг муж улсын Ерөнхий сайд томилдог. Одоогийн байдлаар 3 шүүгч, 3 өмгөөлөгч, 6 иргэдийн төлөөлөгчдөөс бүрдэж байна.³⁰³

Тухайн муж улсын комисс нь сахилгын хэргийг хянан шалгах ажиллагаа болон сахилгын шийтгэл оногдуулах ажиллагаа явуулдаг эсэхээс хамааран дараах хоёр төрлийн тогтолцоонд хуваагддаг. Үүнд:


1. Комисс нь сахилгын хэргийг хянан шалгах (мөрдөн шалгах) болон сахилгын шийтгэл оногдуулах ажиллагааг хамтад нь хэрэгжүүлдэг тогтолцоо. Энэхүү тогтолцоог шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах ач холбогдолтой гэж үздэг. Комисс нь сахилгын зөрчлийг шалгаж, үнэн бодит байдлыг тодорхойлсны үндсэн дээр шүүгчид сахилгын шийтгэлийг шууд оногдуулах эрхтэй байдаг. Зарим муж улсад комиссоос муж улсын Дээд шүүхэд сахилгын шийтгэл оногдуулах санал гаргах бөгөөд муж улсын Дээд шүүхээс эцэслэн шийдвэрлэнэ.

³⁰⁰ Model Rules for Judicial Disciplinary Enforcement (1994), Section I. Rule 3.


³⁰¹ Gray, C., *supra* note 295.

³⁰² **Texas Constitution, (1948), Article 5, Section 1-a**, *State Commission on Judicial Conduct*, <https://statutes.capitol.texas.gov/docs/CN/htm/CN.5.htm>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

³⁰³ Judicial Conduct Board of Pennsylvania, (2023), "Current board members", <https://judicialconductboardofpa.org/current-board-members/>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).



2. Комисс нь дотроо хоёр шатлалтай тогтолцоо. Комиссын хуульч биш гишүүд нь зөрчлийн хэргийг хянан шалгаж (мөрдөн шалгах) сахилгын шийтгэл оногдуулах санал гаргана. Харин Комиссын үлдсэн хуульч гишүүд нь саналыг хэлэлцээд сахилгын шийтгэл оногдуулах эсэх шийдвэрийг гаргадаг байна. Энэхүү тогтолцооны онцлог нь Комисс сахилгын зөрчлийг муж улсын Дээд шүүхээс бие даан, хараат бус байдлаар шийдвэрлэх боломжийг олгодог.



Холбооны болон муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцооны ялгаа

Хүснэгт №8. Холбооны болон муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцооны ялгаа

	Холбооны шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо	Муж улсын шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцоо
Бүрэн эрх	Холбооны шүүх нь улсын хэмжээнд ажиллах бөгөөд зөвхөн Холбооны хууль, ёс зүйн дүрмүүдийг баримталдаг. Холбооны шүүхийн сахилгын хороод нь шүүгчдийг төвлөрсөн төв байгууллагаар хянаж, сахилгын хариуцлага оногдуулах шийдвэрийг гаргадаг.	Муж улсын шүүхийн сахилгын тогтолцоо нь тухайн муж улсын хуулийн дагуу ажилладаг бөгөөд муж улс бүр бие даасан сахилгын тогтолцоотой байдаг. Муж улсын шүүхийн ёс зүйн комисс нь зөвхөн тухайн муж улсын шүүгчдэд сахилгын хариуцлага оногдуулах эсэхийг шийдвэрлэдэг.
Гишүүд	Гомдол хүлээн авахаас эхлээд эцсийн шийдвэр гарах хүртэл зөвхөн шүүгчдээс бүрдэнэ.	Хуульч, зарим муж улсад (өмгөөлөгч) шүүгч, иргэдийн төлөөлөгчдөөс бүрдсэн холимог гишүүдийн тогтолцоотой.
Шүүгчийг огцруулах	Бүх насаар томилогддог шүүгчийг огцруулахдаа Парламентын төлөөлөгчдийн танхимын гуравны хоёрын саналаар шүүгчийг огцруулна.	Тухайн муж улсын тогтолцооноос хамаараад ёс зүйн комисс эсхүл муж улсын Дээд шүүх шүүгчийг огцруулна.

б. Шүүгчид хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл

АНУ-ын шүүхийн тогтолцоо нь холбооны болон муж улсын түвшинд өөр өөр байдаг тул эдгээр олон төрлийн тогтолцоонд нийтлэг стандарт тогтоохын тулд Америкийн хуульчдын холбоо (цаашид "АХХ" гэх) (англ. *American Bar Association*) нь бүх муж улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц шүүгчийн ёс зүйн загвар дүрмийг боловсруулжээ.³⁰⁴ АХХ нь анх 1924 онд Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ (англ. *The Canons of Judicial Ethics*)-г боловсруулсан бол цаашлаад 1972 онд Шүүгчийн ёс зүйн дүрэм (англ. *Code of Judicial Conduct*), 1990 онд Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэм (англ. *Model Code of Judicial Conduct*) зэргийг тус тус батлан гаргасан байна.

³⁰⁴ 이헌환, "미국의 법관윤리장전(모델) 연구(I) - 기구와 적용범위를 중심으로", 2005, 161-162, <https://www.dbpia.co.kr/journal/articleDetail?nodeId=NODE00718632>, (2025.05.05. 확인).

Үүний дараагаар 2007 онд АНУ-ын Дээд шүүхийн “*Minnesota v. White*, 535 U.S. 765 (2002)”³⁰⁵ шийдвэртэй уялдуулан АХХ жишиг дүрмээ дахин шинэчилсэн байна. Ингэснээр 2007 оны 2 дугаар сард АХХ-ны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэм (англ. *ABA Model Code of Judicial Conduct February 2007*)-ийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд энэ нь одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувилбар юм.³⁰⁶

АХХ-ны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэмд шүүгчийн үйл ажиллагааг зохицуулах **ерөнхий зарчим** болон **нарийвчилсан дүрмийг** хослуулан тусгасан байдаг. Энэ нь тухайн цаг үеийн шүүгчдийн ёс зүйн асуудлуудыг олон нийтийн зөвшилцөлд тулгуурлан системтэйгээр шийдвэрлэх боломжийг олгосон.³⁰⁷

1990-ээс 2007 он хүртэлх 17 жилийн хугацаанд эрх зүй, нийгэм, улс төрийн орчин асар хурдтай өөрчлөгдөж, шүүгчид эдгээр өөрчлөлтүүдийн хүрээнд өөрсдийн зан үйлээ тодорхойлохын зэрэгцээ мэргэжлийн үйл ажиллагаагаа олон нийтээр үнэлүүлэх болсон. Энэхүү хөгжлийн үр дүнд шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө өргөжсөн, муж улсын шүүхийн тогтолцоо улс төржсөн, шүүгчийн чиг үүргийн талаарх нийгмийн ойлголт өөрчлөгдсөнөөс гадна өмгөөлөгчийн оролцоогүйгээр шүүхэд өөрийгөө төлөөлөх тал (англ. *pro se litigants*)-ын тоо өссөн байна.³⁰⁸

Шүүхийн шинэчлэлийн тухай хуульд (2002) сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг тодорхой заагаагүй. Харин АХХ-ны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэм, Холбооны шүүгчийн ёс зүйн дүрэм (англ. *Code of Conduct for U.S. Judges*) болон Шүүгчийн ёс зүй, зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх журам (англ. *Rules for Judicial Conduct and Judicial Disability Proceedings*)-д тулгуурлан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг тодорхойлдог. АХХ-ны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэмд заасан зарим сахилгын зөрчлийн тухай авч үзье. Холбооны шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан сахилгын зөрчлүүд доорх хүснэгтэд дурдсантай адилхан гэж хэлж болно.

³⁰⁵ “*Minnesota v. White*, 536 U.S. 765 (2002): “Миннесота муж улсын шүүгчийн ёс зүйн дүрэм (англ. *Minnesota Code of Judicial Conduct*)” шүүгч болон шүүгчид нэр дэвшигчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан заалтыг Үндсэн хуульд нийцээгүй хэмээн зарласан АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр юм, <https://supreme.justia.com/cases/federal/us/536/765/>, (Сүүлд үзсэн: 2025.03.24).

³⁰⁶ American Bar Association, “*Judicial ethics & regulation*”, <https://www.americanbar.org/>, (Сүүлд үзсэн: 2025.03.24).

³⁰⁷ 사법정책연구원, “각국 법관 징계제도에 관한 연구”, 2015, 40, <https://kiss.kstudy.com/Detail/Ar?key=4029275>, (2025.05.05. 확인).

³⁰⁸ Mark I. Harrison, “The 2007 ABA Model Code of Judicial Conduct: Blueprint for a Generation of Judges”, 28 *The Justice System Journal*, 257 (2007), 257, <https://www.jstor.org/stable/27977349>, (Сүүлд үзсэн: 2025.03.24).

Хүснэгт №9. Америкийн хуульчдын холбооны Шүүгчийн ёс зүйн жишиг дүрэмд заасан зарим сахилгын зөрчил³⁰⁹

№	Сахилгын зөрчлийн төрөл	Дүрмийн зүйл, заалт
	Шүүгч шүүхийн нөлөө, эрх мэдлийг өөрийн болон эсхүл бусдын хувийн ашиг, эдийн засгийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор урвуулан ашиглах, эсвэл бусдад ийм ашиг хүртэх боломж олгох	Rule 1.3
	Шүүгч албан үүргээ гүйцэтгэхдээ туйлшрах, ялгаварлах, доромжлох, дарамт бүхий үг хэллэг, зан үйл гаргах (арьс өнгө, хүйс, шашин, гарал угсаа, үндэс, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлага, гэрлэлтийн байдал, нийгэм-эдийн засгийн статус, улс төрийн байр суурь гэх мэт)	Rule 2.3
	Шүүгч хэргийн оролцогчид болон өмгөөлөгчид шүүхийн өмнө үг хэлэх боломж олгохгүй байх, эсвэл эвлэрлийг хүчээр тулгах	Rule 2.6
	Шүүгч өөрөө татгалзах шаардлагагүй хэргээс үндэслэлгүйгээр зайлсхийж, "шүүгчийн татгалзах" ажиллагааг буруугаар ашиглах	Rule 2.7 + Comment
	Шүүгч хэргийн оролцогчид, иргэдийн төлөөлөгч, гэрч, өмгөөлөгч, шүүхийн ажилтантай ажил үүргийн хувьд зүй бус зохисгүй хандсан	Rule 2.8
	Шүүгч аль ч шүүхэд хэлэлцэгдэж байгаа эсвэл хэлэлцэгдэх дөхөж буй хэрэгтэй холбоотойгоор түүний шийдвэрт нөлөөлөх эсхүл шүүхийн шударга байдлыг алдагдуулсан гэж үзэх болохуй нээлттэй эсвэл нууц хэлбэрээр ямар нэгэн байр суурь илэрхийлсэн	Rule 2.10
	Шүүгч албан үүргээс гадуурх үйл ажиллагаа явуулахдаа албан үүргээ гүйцэтгэхэд саад болох үйлдэл, шүүгчийг татгалзах үндэслэл үүсгэх, энгийн иргэний нүдээр харахад шүүхийн хараат бус, шударга, тэгш байдалд сэв суулгахуйц үйл ажиллагаанд оролцох, бусдад дээрх үйлдлийг хийхийг тулгасан мэт харагдахуйц үйлдэл гаргасан	Rule 3.1
	Шүүгч арьс өнгө, хүйс, шашин, гарал угсаа, үндэс, бэлгийн чиг хандлага зэрэг шалтгаанаар ялгаварлал хийдэг байгууллагад гишүүнээр элсэх	Rule 3.6
	Шүүгч хуульд хориглосон, эсвэл энгийн иргэний нүдээр харахад шүүхийн хараат бус, шударга, тэгш байдалд сэв суулгахуйц бэлэг, зээл, ашиг болон бусад эд хөрөнгөөр үнэлэгдэх үнэ бүхий эд зүйл хүлээн авсан	Rule 3.13
	Шүүгч улс төрийн байгууллагын төлөөлөгч болох, нэр дэвшигчийг ил дэмжих эсхүл эсэргүүцэх, улс төрийн хандив цуглуулах (хуулиар тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдол)	Rule 4.1

³⁰⁹ ABA Model Code of Judicial Conduct (2007, February 12).

Хүснэгт №10. Шүүгчийн ёс зүй, зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх журамд заасан зарим зөрчил³¹⁰

Ангилал	Сахилгын зөрчлийн төрөл	Дүрмийн зүйл, заалт
Хөдөлмөрийн чадваргүй болох (Disability)	Шүүгч ажил үүргээ гүйцэтгэх чадвараа алдах тохиолдлууд: - Хар тамхи, согтууруулах бодисоос хараат болох - Шүүх хуралдааны үед сэрүүн байх чадвараа алдах (нойрмоглох) (inability to stay awake during court proceedings) - Оюуны чадавхын ноцтой алдагдал	Rule 3, Definition (e)
Зохисгүй үйлдэл (Misconduct)	Шүүгч дараах үйлдлийг гаргасан тохиолдолд зөрчилд тооцогдоно. Үүнд: - Найз, хамаатан садандаа тусгай хангамж үзүүлэх зорилгоор албаны өрөөгөө ашиглах; - Хахууль авах, албан үүрэгтээ холбоотой бэлэг авах эсхүл хувийн хонжоо, давуу байдал үүсгэх; - Хэргийн оролцогч, өмгөөлөгчидтэй зохисгүй харилцаа, нууц яриа өрнүүлэх; - Хэргийн оролцогч, өмгөөлөгчтэй дээрэнгүй, дайсагнасан байдлаар харьцах; - Тодорхой улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох, хэт улс төржсөн мэдэгдэл хийх; - Ямар нэг байгууллагын өмнөөс хандив цуглуулах; "Шүүгчийн ёс зүйн дүрэм"-д заасан аливаа орлого, эд хөрөнгөө тайлагнахтай холбоотой үүрэг болгосон заалтыг зөрчих.	Rule 3, Definition (h)(1)(A)-(G)

Мөн АНУ-ын холбооны шүүхийн шүүгчдийн зүй бус үйлдэлд хариуцлага тооцох боломжийг 1980 онд батлагдсан *Шүүгчийн ёс зүй, зөрчлийн тухай хууль* (англ. *Judicial Conduct and Disability Act*, 28 U.S.C. § 372(c)) олгосон. Энэ хууль нь шүүхийн шийдвэр, тогтоолоос бусад асуудлаар холбооны шүүгчийн үйлдэлд гомдол гаргах эрхийг иргэдэд олгожээ.³¹¹ Улмаар шүүхийн сахилгын хариуцлага хүлээлгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх мэдлийн хэмжээ болон сахилгын хэргийг хэрхэн шийдвэрлэх асуудлыг зохицуулах зорилгоор Шүүхийн сахилгын шийдвэр гүйцэтгэх загвар дүрэм³¹² (англ. *Model Rules for Judicial Disciplinary Enforcement*)-ийг 1994 оны 8 дугаар сарын 9-нд АХХ-ийн Төлөөлөгчдийн танхим (англ. *House of Delegates*) баталсан байна.

Үүний дараагаар, 2002 онд уг хуулийг шинэчлэн *Шүүгчийн зохисгүй үйлдэлтэй холбоотой сахилгын арга хэмжээ* (англ. *Complaints Against Judges and Judicial Discipline*) гэсэн зохицуулалтыг АНУ-ын

³¹⁰ United states courts, "Judicial Conduct & Disability", <https://www.uscourts.gov/administration-policies/judicial-conduct-disability>, (Сүүлд үзсэн: 2025.05.05).

³¹¹ *Ibid.*

³¹² Model rules for judicial disciplinary enforcement, (1994, August 9).

холбооны хуулийн 16 дугаар бүлгийн 351–364 дүгээр зүйл (англ. 28 U.S.C Chapter 16 §§351–364)-д хуульчилж өгсөн.³¹³ Харин [Шүүгчийн сайн дураар огцрох, тэтгэвэрт гарах журам](#) (англ. *Resignation and Retirement of Justices and Judges*)-ыг 28 U.S.C. 17 дугаар бүлгийн зарим хэсэгт нэгтгэсэн байна.

Дээрхээс гадна, 2004 оны 1 дүгээр сард нэгэн холбооны Дээд шүүхийн шүүгч илт зохисгүй авир гаргаснаас үүдэн тухайн үеийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Уильям Ренквист [Шүүгчийн ёс зүй, зөрчлийн асуудлыг судлах хороо](#) (англ. *Judicial Conduct and Disability Act Study Committee*) түгээмэл нэршлээр Брайерийн хороо³¹⁴ (англ. *Breyer Committee*)-г байгуулахыг даалгажээ. Брайерийн хорооны тайлангийн саналд тулгуурлан АНУ-ын шүүхийн бага хурал³¹⁵ 2008 оны 3 дугаар сарын 11-нд шүүгчид гомдол гаргах, түүнийг хэлэлцэн шалгах нарийвчилсан журам болох [Шүүгчийн ёс зүй, зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх журам](#) (англ. *Rules for Judicial Conduct and Judicial Disability Proceedings*)-ыг баталж³¹⁶, өнөөг хүртэл мөрдөж байна.³¹⁷

с. Сахилгын хариуцлагын төрлүүд

АНУ-д шүүгчийн гаргасан ёс зүйн зөрчил, алдаа дутагдалд тохируулан сахилгын шийтгэл оногдуулахдаа зөрчлийн хэр ноцтой байдлаас хамааран хөнгөнөөс хүнд хүртэлх дараах хариуцлагын төрлүүдтэй.³¹⁸

- [Хаалттай сануулах](#) (англ. *private admonition*): Шүүгчийн гаргасан ялимгүй зөрчил, анх удаагийн алдаанд оногдуулдаг хаалттай сануулга буюу албан бус шийтгэл. Зөвхөн тухайн шүүгчид хувьчлан сануулж, дахин давтахгүй байхыг анхааруулдаг арга хэмжээ юм.
- [Нээлттэй сануулах](#) (англ. *public reprimand/censure*): Шүүгчийн зөрчил харьцангуй ноцтой эсвэл давтан гаргасан тохиолдолд

³¹³ "28 U.S.C. Chapter 16 §§ 351–364"-ийг нийтэд нь **"Шүүхийн шинэчлэлийн тухай хууль, 2002 он"** (*Judicial Improvements Act of 2002*) гэж нэрлэдэг.

³¹⁴ **"Брайерийн хороо"** нь тухайн хорооны дарга **Стивен Брайер** (англ. *Stephen Breyer*) шүүгчийн овгоор нэрлэгдсэн болно.

³¹⁵ 28 U.S.Code § 331: Judicial Conference of the United States, <https://www.law.cornell.edu/uscode/text/28/331#:~:text=The%20Chief%20Justice%20of%20the,places%20as%20he%20may%20designate>, (Сүүлд үзсэн: 2025.05.16).

³¹⁶ United states courts, (2008, March 11), "Rules for Judicial-Conduct and Judicial-Disability Proceedings", <https://www.uscourts.gov/administration-policies/judicial-conduct-disability>, (Сүүлд үзсэн: 2025.05.05).

³¹⁷ Хамгийн сүүлд 2019 оны 3-р сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

³¹⁸ Model Rules for Judicial Disciplinary Enforcement (1994), Section II. Rule 6.

олон нийтэд нээлттэй сануулж, шүүгчийн гаргасан зөрчлийг буруушаан, зэмлэдэг. Ийнхүү олон нийтэд нээлттэй сануулах нь шүүгчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх бөгөөд тухайн зөрчил дахин гарахаас сэргийлэх сануулга болно. Тухайлбал, 2023 онд муж улсуудад нийт 16 шүүгчид нээлттэй сануулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.³¹⁹

- **Түр түдгэлзүүлэх** (англ. *suspension*): Шүүгчийг тодорхой хугацаанд албан үүргээ гүйцэтгэхийг хориглоно. Ноцтой зөрчил гаргасан ч огцруулах хүртэлх хэмжээнд хүрээгүй тохиолдолд оногдуулдаг. 2023 онд АНУ-ын муж улсын 10 орчим шүүгчид 7 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар албан үүргээс нь түр түдгэлзүүлэх сахилгын шийтгэл оногдуулжээ. Зарим тохиолдолд нэмэлтээр мөнгөн торгууль, хяналтын гэрээ, дахин сургалтад хамруулах арга хэмжээг хамтатган авчээ.³²⁰
- **Огцруулах** (англ. *removal from office*): Шүүгчийн гаргасан зөрчил нь шударга шүүхийн зарчимд ноцтойгоор харшилсан эсхүл гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон бол тухайн зөрчил гаргасан шүүгчид огцруулах шийтгэлийг оногдуулдаг.

Дээрх хариуцлагын төрлүүдээс гадна зарим тохиолдолд өөр зөрчлийн арга хэмжээ авдаг. Тухайлбал, шүүгчийг тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэхээс хасах, эрх хэмжээг нь хязгаарлах (зөвхөн шүүхийн захиргааны ажил хийлгэх) шийдвэр гаргах эсхүл сургалт, зөвлөгөөн, мэргэжлийн ёс зүйн хөтөлбөрт хамруулах зэрэг сахилгын шийтгэлийг оногдуулж болдог байна.³²¹

d. Сахилгын хариуцлага оногдуулсан шийдвэрт давж заалдах эрх

Холбооны шүүхийн шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцооны хувьд зөрчил гаргасан шүүгчид холбогдох гомдлыг хүлээн аваад шийдвэрлэх хүртэлх бүх үе шатанд зөвхөн шүүгч оролцдог байна. Гомдол гаргагч эсхүл зөрчилд холбогдогч шүүгч нь Холбооны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан шийдвэрийг дахин хянуулахаар Тусгай хороонд гомдол гаргах эрхтэй бөгөөд Тусгай хорооноос гаргасан шийдвэрийг Шүүхийн зөвлөлд, Шүүхийн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг АНУ-ын шүүхийн бага хуралд давж

³¹⁹ Gray, C. (2024, February 6), "State judicial discipline in 2023", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2024/02/06/state-judicial-discipline-in-2023/>, (Сүүлд үзсэн: 2025.05.16).

³²⁰ *Ibid.*

³²¹ *Ibid.*

заалдах гомдол гаргах эрх нь нээлттэй байдгаараа онцлог байна.

Муж улсын шүүхийн шүүгчид сахилгын хариуцлага тооцох тогтолцооны хувьд шүүгчийг огцруулах, удаан хугацаагаар албан үүргээс түдгэлзүүлэх сахилгын шийтгэл оногдуулах тохиолдолд тухайн муж улсын Дээд шүүх эцэслэн шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, муж улсын Дээд шүүх нь тухайн сахилгын хэргийг бүх нотлох баримтын хамт дахин хэлэлцэж, Комиссоос гаргасан саналыг харгалзан шүүгчийг огцруулах, түдгэлзүүлэх эсхүл өөр тохиромжтой шийдвэр оногдуулах эсэхийг эцэслэн тогтоодог байна. Энэ процесс нь сахилгын хэрэгт холбогдогч шүүгчид давж заалдах эрх олгож буй нэг хэлбэр гэж үзэж болно.³²²

е. Сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

1. Холбооны шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Холбооны түвшинд жил бүр холбооны шүүгчдийн эсрэг олон тооны гомдол гардаг ч дийлэнх хувийг нь мөрдөн шалгасны эцэст хангалттай үндэслэл тогтоогдоогүй, эсхүл шүүгчийн шийдвэрийн агуулгатай холбоотой гэж үзэн хэрэгсэхгүй болгодог байна. Холбооны шүүгчдэд огцруулах сахилгын шийтгэлийг ховорхон оногдуулдаг бөгөөд 2025 оны байдлаар холбооны шүүхийн 15 шүүгчид огцруулах сахилгын шийтгэл оногдуулах санал гарч байсан ба тэднээс 8 нь буруутгагдан огцорсон байна.³²³ Бусад шүүгчийн хувьд цагаатгагдсан эсхүл огцруулахаас өмнө сайн дураар огцорсон байна.

Холбооны шүүгчдэд огцруулах сахилгын шийтгэл оногдуулсан жишээнээс дурдвал, Харри Клейборн (англ. *Harry E. Claiborne*) 1986 онд татвараас зайлсхийсэн гэм буруутайд, Алси Хастингс (англ. *Alcee L. Hastings*) 1989 онд авлигын хэргээр, Уолтер Никсон (англ. *Walter L. Nixon*), Хэлстед Риттер (англ. *Halsted L. Ritter*) зэрэг хэд хэдэн шүүгчдийг огцруулж байсан ба сүүлд 2009 онд шүүгч Самуэл Кент (англ. *Samuel B. Kent*) ёс зүйн ноцтой зөрчил гарган шалгагдаж байх үедээ сайн дураараа огцорсон, 2010 онд Томас Портеус (англ. *G. Thomas Porteous, Jr*) авлига авсан болон худал мэдүүлэг өгөх гэм буруутайд тооцогдож огцорсон³²⁴ тохиолдлууд гарч байжээ.

³²² Model Rules for Judicial Disciplinary Enforcement (1994), Section I. Rule 2.

³²³ Stening, T. (2025, March 19), "Bribery, corruption and intoxication: Here are some of the ways federal judges have been impeached", *Northeastern University News*, <https://news.northeastern.edu/2025/03/19/federal-judge-impeachment-history/#:~:text=In%20U,about%20one%20every%2014%20years>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

³²⁴ Impeachments of Federal Judges, <https://www.fjc.gov/history/judges/impeachments-federal-judges#:~:text=Harry%20E,from%20office%2C%20>

Холбооны шүүхийн шүүгч сахилгын ноцтой зөрчил гаргасан сүүлийн үеийн тохиолдлыг танилцуулъя.

Шигтгээ №40. АНУ-ын холбооны шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 1. Холбооны шүүгч Карлос Мургуиа-д холбогдох сахилгын хариуцлага³²⁵

Канзас муж улсын Холбооны дүүргийн шүүгч Карлос Мургуиа (англ. *Carlos Murguia*) нь 2020 оны 2 дугаар сарын 18-нд Дональд Трампд огцрох өргөдлөө гаргаж, 4 дүгээр сарын 01-нд огцорчээ. Тэрээр шүүхийн ажилтнуудад бэлгийн дарамт үзүүлэх, хар тамхи хэрэглэдэг, урьд ял шийтгэгдэж байсан этгээдтэй олон жил гэр бүлээс гадуурх харилцаа (англ. *extramarital*) үүсгэсэн, шүүх хуралдаанд тогтмол хоцрох зэрэг үйлдлүүд гаргасан хэмээн буруутгагджээ. Эдгээр зөрчлүүд нь 2016 оноос эхлэн илэрсэн бөгөөд тэрээр үйлдлүүдээ хүлээн зөвшөөрч, эмчийн хяналтад эмчилгээ хийлгэсэн байна. 2017 онд Ерөнхий шүүгч Карлос Мургуиагийн үйлдсэн илүү олон хэрэг ил болсон тул Тусгай хороог байгуулжээ. Тусгай хорооноос тайлангаа Шүүхийн зөвлөлд хүргүүлсэн бөгөөд түүнд нээлттэй сануулах шийтгэл оногдуулсан байна. Үүний дараагаар 2020 онд нэмэлт зөрчил илэрч шалгалт хийж байх явцад Карлос Мургуиа сайн дураар огцорсноор сахилгын хэргийг хаажээ.

Тохиолдол 2. Холбооны шүүгч Рожер Бенитез-д холбогдох сахилгын хариуцлага³²⁶

Рожер Бенитез (англ. *Roger T. Benitez*) нь АНУ-ын Холбооны шүүхийн шүүгч бөгөөд 2004 оноос эхлэн Калифорни муж улсын Холбооны өмнөд дүүргийн шүүхэд ажиллаж эхэлсэн байна. Тэрээр 2023 оны 2 дугаар сарын 13-нд болсон шүүх хуралдааны үеэр гэмт хэрэгт холбогдсон этгээдийн 13 настай охины гарыг гинжлэхийг тушаасан. Түүний зорилго нь охиныг мансууруулах бодис хэрэглэхээс зайлсхийхийг ухааруулах байсан ч энэ үйлдэл нь олон нийтийн шүүмжлэлийг дагуулжээ. Үүний үр дүнд, 2024 оны 5 дугаар сарын 1-нд 9-р тойргийн шүүхийн зөвлөлөөс шүүгч Бенитезийг ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж, нээлттэй сануулах сахилгын шийтгэл оногдуулж, эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцох эрхийг 3 жилийн хугацаагаар хасжээ. Шүүхийн зөвлөлөөс "охин шүүх хуралдаанд оролцогчдыг занал хийлээгүй, эмх замбараагүй үйлдэл гаргаагүй байхад гавласан нь шүүгчийг эрх мэдлээ хэтрүүлсэн үйлдэл мөн" гэж үзсэн. Бенитезийн гаргасан ёс зүйн зөрчлийн улмаас олон нийтийн шүүхэд итгэх итгэл буурсан гэж дүгнэсэн байна.

[October%209%2C%201986](#), (Сүүлд үзсэн: 2025.05.17).

³²⁵ Gray, C. (2020, April 7), "Sexual harassment and fidelity to procedures", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts. <https://ncscjudicialethicsblog.org/2020/04/07/sexual-harassment-and-fidelity-to-procedures/>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

³²⁶ Rector, K, (2024, May 2), "Judge in major gun cases reprimanded after 13-year-old girl handcuffed in court", *Los Angeles Times*, <https://www.latimes.com/california/story/2024-05-02/judge-in-major-gun-cases-reprimanded-after-13-year-old-girl-handcuffed-in-court?utm>, (Сүүлд үзсэн: 2025.05.17).

2. Муж улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Муж улсын шүүхүүдийн үндэсний төв (англ. *National Center for State Courts*)-өөс гаргадаг шүүгчдийн сахилгын талаарх статистик мэдээллээс харвал сүүлийн жилүүдэд жилд дунджаар 100 гаруй шүүгчид ямар нэг байдлаар сахилгын шийтгэл хүлээж байна. Тухайлбал, 2023 онд муж улсуудын Шүүхийн ёс зүйн комисс нийт 121 хэргийг олон нийтэд зарлаж шийдвэрлэснээс 7 шүүгчид огцруулах сахилгын шийтгэл оногдуулсан бол үлдсэн тохиолдолд хөнгөн сахилгын шийтгэлүүд оногдуулжээ.³²⁷ 2024 онд 131 шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах санал гарснаас 10 шүүгчид огцруулах сахилгын шийтгэл оноожээ.³²⁸ Муж улсын шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан сүүлийн үеийн тохиолдлыг доор танилцуулъя.

Шийтгээ №41. АНУ-ын муж улсын шүүгчид сахилгын хариуцлага оногдуулсан тохиолдол

Тохиолдол 3. Дэвид Бретт Вудс-т холбогдох шүүгчийн сахилгын хариуцлага³²⁹

Денвер хотын өсвөрийн шүүх (англ. *Denver Juvenile Court*)-ийн Ерөнхий шүүгч Дэвид Бретт Вудс (англ. *David Brett Woods*)-т Колорадо муж улсын Дээд шүүхээс архи уусан үедээ албан үүргээ гүйцэтгэсэн, энэ талаар мэдэгдсэн ажилтнаа хууль бусаар ажлаас халсан гэх үндэслэлээр 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр нээлттэй сануулах сахилгын шийтгэл оногдуулжээ.

Тохиолдол 4. Самуэл Перри Суэнберг-т холбогдох шүүгчийн сахилгын хариуцлага³³⁰

2024 оны 11 дүгээр сарын 06-нд Вашингтон муж улсын Шүүхийн ёс зүйн комисс (англ. *Washington State Commission on Judicial Conduct*) шүүгч Самуэл Перри Суэнберг (англ. *Samuel Perry Swanberg*)-ийг албан тушаалаас нь огцруулах тухай санал гаргасан байна. Энэ саналыг 2024 оны 11 дүгээр сарын 07-нд Вашингтон муж улсын Дээд шүүх хүлээн авч, шүүгчийг албан тушаалаас нь огцруулах шийдвэр гаргажээ. Тэрээр олон жилийн турш гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, өөрийн эхнэртээ бие махбодын болон сэтгэл санааны дарамт үзүүлсэн байна. Үүний зэрэгцээ, дотно харилцаатай байсан шүүхийн ажилтанд эрх мэдлээ ашиглан дарамт үзүүлдэг байжээ.

³²⁷ Gray, C., *supra* note 323.

³²⁸ Gray, C. (2025, January 28), "State judicial discipline in 2024", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2025/01/28/state-judicial-discipline-in-2024/>, (Сүүлд үзсэн: 2025.05.18).

³²⁹ Gray, C. (2025, March 4), "Both illegal and unethical", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2025/03/04/both-illegal-and-unethical/>, (Сүүлд үзсэн: 2025.05.18).

³³⁰ Gray, C. (2024, December 17), "Recent cases", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2024/12/17/recent-cases-103/>, (Сүүлд үзсэн: 2025.05.18).

Тохиолдол 5. Сюзанна Пинеда-д холбогдох шүүгчийн сахилгын хариуцлага³³¹

Аризона муж улсын Марикопа тойргийн Дээд шүүхийн шүүгч Сюзанна Пинеда (англ. *Susanna C. Pineda*) 2023 оны 10 дугаар сарын 07-нд Израилийн эсрэг халдлагаас хойш Израиль болон Газийн зөрчил, өмнөх түүхийн талаар олон нийтийн хэвлэл мэдээлэл (facebook)-д үзэл бодлоо илэрхийлсэн контент байршуулсан байна. Эдгээр постууд нь 2023 оны 10 дугаар сарын дунд үеэс 12 дугаар сарын эхэн хүртэл шүүгчийн хувийн аккаунт дээр нийтлэгдсэн байжээ. Шүүгч Пинедагийн хувийн аккаунтаас түүнийг шүүгч гэдгийг амархан мэдэх боломжтой байсан бөгөөд түүний постууд нь бусад шүүгчид, шүүхийн ажилтнууд болон зарим танилууддаа зориулсан байжээ. Нэрээ нууцалсан 2 гомдол гаргагчаас түүнийг ёс зүйн зөрчил гаргасан тухай мэдээлсэн байна. Пенсильвани муж улсын ёс зүйн комисс шүүгчийг 8 сар ажлаас нь түдгэлзүүлжээ. Комисс нь шүүгчийн нийтэлсэн мэдээллийг зөвхөн хувийн үзэл бодол гэж үзэх боломжгүй, зарим бүлгийн гишүүд уншиж болохоор хаалттай пост нийтэлсэн ч нийтэлсэн мэдээлэл ил тод, олон нийтэд хүрэх боломжтой гэж дүгнэсэн байна. Улмаар шүүгчийн гаргасан үйлдэл нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж, шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн гэж үзжээ.

Дээрх тохиолдлуудаас харвал холбооны болон муж улсын шүүхийн шүүгчдийн сахилгын хэргийг ёс зүйн зөрчил гаргасан эсэх, албан тушаалаа урвуулан ашигласан эсэх, эрх мэдлээ хэтрүүлсэн эсэх хүрээнд хянан шийдвэрлэж байна. Хэрэв зөрчилд холбогдогч шүүгч сахилгын хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байвал түүнд сахилгын шийтгэл оногдуулахгүйгээр хэргийг хаадаг байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Гадаадын зарим улс орон шүүгчийн сахилга, хариуцлагын харилцааг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулж байгааг судлах зорилгоор эх газрын болон жишгийн эрх зүйн бүлийн орнууд болох АНУ, ИБУИНХУ, ХБНГУ, ОХУ, Дани Улс, Франц Улс, Латви Улс, Молдав Улс, Испани Улс, Итали Улсуудыг сонгон авч, харьцуулсан судалгаа хийж гүйцэтгэлээ. Харьцуулсан судалгааны хүрээнд тухайн улс орны шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий субьектийн бүтэц, бүрэлдэхүүн, томилгоо, сахилгын зөрчил оногдуулах эрх зүйн үндэслэл, сахилгын хариуцлагын төрөл, судлаачдын үзэл хандлага болон шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн тохиолдлуудыг нарийвчлан судалсан болно. Судалгааны үр дүнг нэгтгэвэл:

³³¹ Gray, C. (2024, October 22), "Social media appearances", *Judicial ethics and discipline*, Center for Judicial Ethics of the National Center for State Courts, <https://ncscjudicialethicsblog.org/2024/10/22/social-media-appearances/>, (Сүүлд үзсэн: 2025.05.18).

• **Шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий субъектийн тухайд**

ОХУ, Дани Улс, Франц Улс, Молдав Улс, Испани Улс, Итали Улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүгч болон олон нийтийн төлөөллөөс бүрдсэн холимог шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг байна. Түүнчлэн, Итали, Испани, Молдав, Латви улсуудын шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага (Сахилгын шүүх, Сахилгын зөвлөл зэрэг) нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн дээд зөвлөл, Улсын дээд шүүх зэрэг байгууллагын "дэргэдэх байгууллага" гэсэн эрх зүйн статустай байдаг.

Харин АНУ, ОХУ, ХБНГУ нь холбооны болон муж улсын шүүхийн тогтолцоотой тул шүүгчид хариуцлага оногдуулах сахилгын тогтолцоо ч мөн адил холбооны болон муж улсын тогтолцоонд хуваагддаг. Тус улсуудын хувьд муж улс бүр шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах, сахилгын хэрэг шийдвэрлэх зөвлөл эсхүл комисстой байдаг. Мөн АНУ болон ХБНГУ-ын холбооны шүүгчдийн сахилгын хэргийг шүүгчдээс бүрдсэн төлөөлөл хянан шийдвэрлэдэг бол Латви Улсад зөвхөн шүүгчдээс бүрдсэн төлөөлөл хянан шийдвэрлэдгээрээ онцлог байна.

• **Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэл, сахилгын хариуцлагын төрлүүдийн тухайд**

Харьцуулан судалсан нийт улсуудын хувьд шүүгчид оногдуулах сахилгын шийтгэл нийтлэг төсөөтэй буюу шүүгчид анхааруулах, сануулах, цалин бууруулах, шүүгчийн албан тушаалыг бууруулах, шүүгчийг албан үүргээс нь чөлөөлөх гэсэн төрлүүдтэй байна. Харин Испани улсын хувьд шүүгчийн сахилгын зөрчлийг онц ноцтой, хүнд, хөнгөн гэж 3 бүлэглэн ангилдаг ба аль төрлийн сахилгын зөрчлийг үйлдсэнээс нь хамааруулан анхааруулах, торгох, өөр шүүх рүү албадан шилжүүлэх, албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах сахилгын шийтгэлийг оногдуулдаг байна.

Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах эрх зүйн үндэслэлийн хувьд Испани Улс, Латви Улс, Молдав Улс, ИБУИНХУ, АНУ нь хууль болон холбогдох журамдаа шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарах (сахилгын шийтгэл оногдуулах) үйлдлийг тухайлан жагсаасан бол бусад улсуудын хувьд шүүгчийн ёс зүйн зөрчлийг хууль, холбогдох эрх зүйн актад ерөнхий байдлаар тодорхойлж, тухайн ёс зүйн зөрчилд хамаарах аливаа үйлдлийг шалган тогтоохоор хуульчилжээ.

- **Сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг давж заалдах эрхийн тухайд**

Франц Улс болон ИБУИНХУ-ын хувьд сахилгын зөвлөлийн шийдвэрийг дээд шатанд давж заалдах эрхгүй байхаар хуульчилсан боловч шийдвэрийн хүчин төгөлдөр байдал, шийдвэр гаргах ажиллагааны алдаатай холбоотой асуудлаар захиргааны шүүхэд хандах боломжтой байна. Мөн ХБНГУ-ын холбооны тогтолцоонд шүүгчдийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах эрх байхгүй ба Холбооны дээд шүүх эцэслэн шийдвэр гаргадгаараа онцлог байна.

Тус гурван улсаас бусад улсын хувьд давж заалдах эрхийг хуульчилж өгсөн байна. АНУ, ОХУ-ын хувьд давж заалдах гомдлыг Холбооны эсхүл Улсын дээд шүүхэд гаргадгаараа онцлог байх ба муж улсад хууль тогтоох бүрэн эрх байдаг тул зарим тохиолдолд зохицуулалт, процессын ялимгүй ялгаатай байгаа нь ажиглагдлаа. Мөн АНУ, Дани, Итали, Испани улсад тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн сайд зэрэг зарим эрх бүхий албан тушаалтан шүүгчид сануулах, анхааруулах зэрэг сахилгын зарим арга хэмжээ авах эрхийг олгожээ.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/, 2021 он.
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2002 он.
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 1993 он.
4. Шүүхийн захиргааны тухай хууль, 2012 он.
5. Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2021 он.
6. Шүүгчийн ёс зүйн дүрэм, 2014 он.
7. УДШ-ийн цахим хуудсан дахь 2022.11.01–2024.07.05-ны өдрийг хүртэлх нээлттэй байршуулсан 11 хяналтын тогтоол.
8. ШСХ-ны цахим хуудсан дахь 2021.01.10–2025.07.05-ны өдрийг хүртэлх нээлттэй байршуулсан 559 магадлал.
9. ШСХ-ны цахим хуудсан дахь 2021.01.10–2025.07.05-ны өдрийг хүртэлх нээлттэй байршуулсан 31 тогтоол.
10. УИХ-ын чуулган, 2021.01.07-ны өдрийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэл.
11. УИХ-ын ХЗБХ, 2020.04.28-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.
12. УИХ-ын ХЗБХ, 2021.01.05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, 4 дүгээр боть, 2010 он.
2. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, 2015 он.
3. Шүүхийн хүрээлэн, Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэх нь: Монгол Улс ба гадаадын зарим улсын зохицуулалт, 2023 он.
4. Шүүхийн академи, Гадаадын зарим орны шүүхийн тогтолцоо, 2024 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Б.Сугар, "Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны түүхэн хөгжил", *Монголын төр, эрх зүй сэтгүүл*, №1 (107), 2024 он.
2. О.Мөнхсайхан, "Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам", *legaldata.mn*, 2016 он.
3. О.Мөнхсайхан, "Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал", *legaldata.mn*, 2020 он.
4. Т.Мөнх-Эрдэнэ, "Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдал (харьцуулалт)", *legaldata.mn*, 2020 он.
5. Г.Цэрэндэжид, "Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэлдэхүүн ба шүүгчийн хараат бус байдал", *legaldata.mn*, 2021 он.
6. Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоон дахь Улсын Дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь", *legaldata.mn*, 2022 он.
7. Х.Сэлэнгэ, "Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хууль хэрэглээний нэгдмэл байдалд дүн шинжилгээ хийх нь", *legaldata.mn*, 2023 он.
8. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, "МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.20, 50.1.23, 50.1.27, 50.1.40 дэх заалтуудад холбогдох судалгаа", 2024 он.

Г. Бусад

1. Шүүхийн сахилгын хороо, "Үйл ажиллагааны тайлан", 2022 он.
2. Шүүхийн сахилгын хороо, "Үйл ажиллагааны тайлан", 2023 он.
3. Шүүхийн сахилгын хороо, "Үйл ажиллагааны тайлан", 2024 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. Act Nr. 109, 23 February, 2006.
2. Basic Law for the Federal Republic of Germany, 1949.
3. Code of Judicial Ethics of Latvia, 2021.
4. Constitution of the Italian Republic, 1948.

5. Constution of Spain, 1978.
6. Federal Civil Service Act, 2009.
7. Federal Disciplinary Act, 2001.
8. Federal Judiciary Act, 1972.
9. Judicial Disciplinary Liabiity Law, 1994.
10. Judicial Improvements Act of 2002.
11. Judiciary act of Spain, 1985.
12. On Judicial Power, 1992.
13. Judicial Conduct Board of Pennsylvania, 1993.
14. Rules on the constitution and functioning of the Superior Council of the Judiciary, Act Nr. 195, 24 March 1958.
15. Mark I. Harrison, "The 2007 ABA Model Code of Judicial Conduct: Blueprint for a Generation of Judges", 2007.
16. Model Rules for Judicial Disciplinary Enforcement, 1994.
17. Rules for Judicial-Conduct and Judicial-Disability Proceedings, 2008.
18. Texas Constitution, 1948.
19. Organic Law 6/1985, of 1 July, on the Judiciary, 1985.
20. Poland act on common courts organisation, 2011.
21. Poland act on Supreme court, 2017.
22. ABA Model Code of Judicial Conduct February 2007.
23. Acquaviva Naïs, Castagnet Florence and Evanghelou Morgane, "A comparative analysis of Disciplinary Systems for European judges and prosecutors", For the 7th edition of the THEMIS Competition, 2012.
24. Activity report of the disciplinary board, 2022.
25. Minnesota v. White, 536 U.S. 765 2002.
26. Rule of Law Index, World Justice Project, April 23, 2025.
27. Charles Gardner Geyh, "Judicial Ethics and Discipline in the States", 2023.
28. Gray, C. "Both illegal and unethical", 2025.

29. Gray, C. "How judicial conduct commissions work", 2007.
30. Gray, C. "Recent cases", 2024.
31. Gray, C. "Sexual harassment and fidelity to procedures", 2020.
32. Gray, C. "Social media appearances", 2024.
33. Gray, C. "State judicial discipline in 2023", 2024.
34. Gray, C. "State judicial discipline in 2024", 2025.
35. Stening, T. "Bribery, corruption and intoxication: Here are some of the ways federal judges have been impeached", 2025.
36. Silvio Roberto Vinceti, "Standardisation and authority in judicial discipline: a comment on Italy and Ireland's experiences", Irish Judicial Studies Journal Vol.6(1), 2022.
37. Simone Benvenuti, "The Politics of Judicial Accountability in Italy: Shifting the Balance", European Constitutional Law Review, 2018.
38. CCJE, The Role of Courts with Respect to the Uniform Application of the Law, Opinion №20, 2017.
39. Ex Parte Communications, Hosto buchan law firm, September 09, 2024.
40. Cynthia Gray, "Judicial Conduct Commissions, How Judicial Conduct Commission work," The justice system journal, vol. 28, 2007.
41. Hugo Rialland, "Judging the judiciary, responding to judicial misconduct without threatening independence," Themis competition Semi-final D • Judicial ethics and professional conduct, 2021.
42. Judge (unknown) v. Italian Supreme Judicial Council, 6965, (Court of Cassation, 2017), [https://cjc.eui.eu/data/data/data/data?idPermanent=156&trial=1](https://cjc.eui.eu/data/data/data?idPermanent=156&trial=1).
43. Judge (unknown) v. Italian Supreme Judicial Council, 8906, (Court of Cassation, 2020), <https://cjc.eui.eu/data/data/data/data?idPermanent=916&trial=1>.
44. Judge P. v. Italian Supreme Judicial Council, 27493/2013, (Court of Cassation, 2013), [https://cjc.eui.eu/data/data/print trial.pdf?idPermanent=913](https://cjc.eui.eu/data/data/print%20trial.pdf?idPermanent=913).
45. Испани Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн

шийдвэр.

46. Испани Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2019 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр.
47. Испани Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сахилгын хорооны 2018 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэр.
48. Латви Улсын Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2002 он.
49. State of New York Commission on Judicial Conduct, on Gilbert L. Abramson, Нью-Йорк мужийн комиссын шийдвэр.
50. BGN 5 StR 39/21 – Judgment of August 18, 2021 (LG Kiel), ХБНГУ-ын шүүхийн шийдвэрийн тойм.
51. Bundesgerichtshof Beschluss 4 StR 149/22, ХБНГУ-ын Холбооны шүүхийн шийдвэр.
52. Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 27/9 дугаар шийдвэр.
53. Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл (давж заалдах шат)-ийн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 189/6 дугаар шийдвэр.
54. Европын холбооны шүүхийн их танхимын 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн C-791/19 дугаартай шийдвэр.
55. Constitutional Reform Act (2005).
56. The Act of Settlement (1701).
57. The Judicial Discipline (Prescribed Procedures) Regulations, (2023).
58. Judiciary UK website, "Overview of the Judiciary" article.
59. Geoffrey Rivlin, Understanding the Law, Oxford, 2004 болон Theodore FT Plucknett, A Concise History of the Common Law, Butterworth & Co, 1956 Judy Hodgson (ed), The English Legal Heritage, Oyez Publishing, 1979.
60. Judiciary UK website "Complaining about personal conduct of judicial office-holders" article.
61. JCIO's website "What can I complain about?" section.

62. Judicial Discipline Misconduct and recommending sanctions, guideline, (2024).
63. World Justcie project Rankings, (2024).
64. JCIO Annual Report, (2023–2024).
65. Judicial Conduct Investigations Office. Statement on District Judge Michael Nicholson.
66. Judicial Conduct Investigations Office. Statement on Mr Russell Blake JP.
67. Judicial Conduct Investigations Office. Statement on Mr Adrian Jones JP.
68. Judicial Conduct Investigations Office. Statement on Mr Mark Harding.
69. Minimum Judicial Standards V, Disciplinary proceedings and liability of judges, ENCJ Report, (2014–2015).

Б. Герман хэл дээр

1. Bayerisches Richter- und Staatsanwaltsgesetz (BayRiStAG), 2018.
2. Landesrichtergesetz (LRiG), 2022.

В. Орос хэл дээр

1. Алешукина С. А., Туманова Л.В. Некоторые вопросы дисциплинарной ответственности судей // Вестник Московского университета имени С.Ю. Витте. Серия 2. Юридические науки. 2023. №4 (40). – С. 49–56.
2. Астапов А.М. и Малякин А.В., интервью, IC-Iskra, 2017, <https://goo.su/n95UT>
3. Закон Российской Федерации «О статусе судей в Российской Федерации» от 26.06.1992 г., № 3112–1 // Ведомости Съезда народных депутатов Российской Федерации и Верховного Совета Российской Федерации от 30 июля 1992 г., № 30, ст. 1792.
4. Камбегова, З. А. «Срок и порядок обжалования решений квалификационных коллегий судей Российской Федерации о привлечении судей к дисциплинарной ответственности: проблемы нормативного регулирования и пути их решения». Вестник ТвГУ. Серия "Право", № 2 (2018): 62–72.
5. Официальный сайт Высшей квалификационной коллегии судей

Российской Федерации. – <https://www.vkks.ru/category/33/>.

6. Федеральный закон от 14 марта 2002 г. № 30-ФЗ «Об органах судейского сообщества в Российской Федерации» // Собрание законодательства Российской Федерации. 2002. № 11. Ст. 1022; 2003. № 27 (ч. 2). Ст. 2710.
7. Шадрин Д.Н. Неприкосновенность судей и особенности их привлечения к дисциплинарной ответственности // Matters of Russian and International Law. 2016. № 4. С. 49–50.

Г. Дани хэл дээр

1. Данийн Хаант Улсын Үндсэн хууль (1953) – Danmarks Riges Grundlov.
2. Данийн Хаант Улсын Шүүхийн тухай хууль (1986) – Retsplejeloven.
3. Den Særlige Klageret: Om Den Særlige Klageret, <https://www.domstol.dk/densaerligeklageret/om-den-saerlige-klageret/>.
4. Данийн Хаант Улсын Сахилгын болон давж заалдах тусгай шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №21/00229 дүгээр шийдвэр, <https://www.domstol.dk/densaerligeklageret/nyhedsartikler/2021/6/dom-10-juni-2021/>.
5. Данийн Хаант Улсын Сахилгын болон давж заалдах тусгай шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн №095–20 дугаар шийдвэр, <https://www.domstol.dk/densaerligeklageret/nyhedsartikler/2020/11/dom-12-november-2020/>.

Д. Молдав хэл дээр

1. Бүгд Найрамдах Молдав Улсын Үндсэн хууль – Constituția Republicii Moldova: 1994.
2. Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хууль – cu privire la răspunderea disciplinară a judecătorilor: 2014.
3. Шүүхийн дээд зөвлөлийн 2024 оны тайлан, https://www.csm.md/files/RAPOARTE/2024/final_Raport_CSM_2024.pdf.
4. Молдав Улсын Сахилгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 27/9 дугаар шийдвэр, https://www.csm.md/files/Hotarirele_CDisciplinar/2022/Sesizari/09/27-9.pdf.
5. Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн дэргэдэх Сахилгын зөвлөл (давж заалдах шат)-ийн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 189/6 дугаар шийдвэр, https://www.csm.md/files/Hotarirele_CDisciplinar/2018/CA2/06/189-6.pdf

Е. Румын хэл дээр

1. Raport de activitate al colegiului disciplinar pentru anul, 2022.

Ё. Испани хэл дээр

1. Resumen sistematizado de resoluciones en materia disciplinaria, Poder Judicial Espana, 2021.

Ж. Солонгос хэл дээр

1. 이현환, "미국의 법관윤리장전(모델) 연구(I) - 기구와 적용범위를 중심으로", 2005.
2. 사법정책연구원, 각국 법관 징계제도에 관한 연구, 2015.

З. Франц хэл дээр

1. Constitution du 4 octobre, 1958.
2. Шүүхийн дээд зөвлөлийн тухай органик хууль
3. Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдлын тухай органик хууль
4. Захиргааны шүүхийн хууль
5. Франц Улсын Шүүхийн дээд зөвлөлийн шүүхийн Сахилгын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн S270 дугаар шийдвэр
6. Франц Улсын Шүүхийн дээд зөвлөлийн прокурорын Сахилгын зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн P107 дугаар шийдвэр
7. Магистратуудын ёс зүйн дүрмийн эмхэтгэл, https://www.courdecassation.fr/files/files/D%C3%A9ontologie/CSM_recueil_des_obligations_deontologiques_des_magistrats.pdf.

3. Цахим эх сурвалж

1. АНУ-ын Northeastern их сургуулийн цахим хуудас: <https://news.northeastern.edu/>.
2. АНУ-ын Лос-Анжелес өдөр тутмын сонин: <https://www.latimes>.
3. АНУ-ын муж улсуудын дээд шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://statecourtreport.org/>.
4. АНУ-ын Холбооны шүүхийн судалгаа, боловсролын үндэсний төвийн цахим хуудас: <https://www.fjc.gov/>.

5. АНУ-ын холбооны шүүхийн цахим хуудас: <https://www.uscourts.gov/>.
6. АНУ-ын хууль зүйн мэдээллийн цахим хуудас: <https://www.law.cornell.edu>.
7. АНУ-ын хуульчдын холбооны цахим хуудас: <https://www.americanbar.org/>.
8. АНУ-ын цахим судалгааны сан: <https://www.jstor.org>.
9. АНУ-ын шүүгчийн ёс зүйн төвийн албан ёсны блог хуудас: <https://ncscjudicialethicsblog.org/>.
10. АНУ-ын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://supreme.justia.com/>.
11. БНСУ-ын судалгааны сан: <https://kiss.kstudy.com/>.
12. БНСУ-ын цахим өгүүллийн сан: <https://www.dbpia.co.kr/>.
13. Бүгд Найрамдах Молдав Улсын хууль, тогтоомжийн цахим сан: <https://www.legis.md/>.
14. Бүгд Найрамдах Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн цахим хуудас: <https://www.csm.md/ro/>.
15. Данийн Хаант Улсын Сахилгын болон давж заалдах тусгай шүүхийн цахим хуудас: <https://www.domstol.dk/densaerligeklageret/>.
16. Данийн Хаант Улсын хууль, тогтоомжийн цахим сан: <https://www.retsinformation.dk/>.
17. Испани Улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.poderjudicial.es/cgpj/en/Judiciary>.
18. Латви Улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.at.gov.lv/>.
19. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
20. Нью-Йорк мужийн комиссын цахим хуудас: <https://cjc.ny.gov/#gsc.tab=0>
21. Пенсильвани муж улсын Шүүгчийн ёс зүйн комиссын хорооны цахим хуудас: <https://judicialconductboardofpa.org/>.
22. Техас муж улсын хууль тогтоомжийн цахим хуудас: <https://statutes.capitol.texas.gov/>.
23. УИХ-ын Тамгын газрын цахим хуудас: <https://www.parliament.mn/>.
24. Франц Улсын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас:

<https://www.justice.gouv.fr/ministere-justice/missions-organisation/inspection-generale-justice>.

25. ХБНГУ-ын Бавари муж улсын засгийн газрын цахим хуудас: <https://www.bayernportal.de>.
26. ХБНГУ-ын хууль зүйн мэдээллийг цахим сан: <https://www.gesetze-im-internet.de>.
27. ХБНГУ-ын хууль зүйн мэдээний цахим хуудас: <https://www.lto.de>.
28. ХБНГУ-ын цахим мэдээллийн хуудас: <https://2020news.de>.
29. Хууль дээд ёсны индекс: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/>.
30. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим хуудас: <https://legaldata.mn/>.
31. Цахим судалгааны сан: <https://www.tandfonline.com>.
32. Шүүхийн дээд зөвлөлийн албан ёсны цахим хуудас: <https://www.conseil-superieur-magistrature.fr/le-csm/composition-et-organisation>.
33. Шүүхийн сахилгын хорооны цахим хуудас: <https://judiscom.mn/site/>.
34. ИБУИНХУ-ын шүүхийн цахим хуудас, <https://www.judiciary.uk/>.
35. ИБУИНХУ-ын парламентын цахим хуудас <https://www.parliament.uk/>.
36. ИБУИНХУ-д үйлчилдэг хууль, тогтоомжийн цахим хуудас, <https://www.legislation.gov.uk/>.
37. ИБУИНХУ-ын Шүүхийн ёс зүйн мөрдөн шалгах газрын цахим хуудас, <https://www.complaints.judicialconduct.gov.uk/>.
38. World Justice Project-ийн цахим хуудас, <https://worldjusticeproject.org/>.
39. Rule of Law Index, 2024 <https://ourworldindata.org/grapher/rule-of-law-index>